


ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2 тоот тогтоолоор тус компани дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн билээ. Мөн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №ТО-18-18 тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй нэгж хувьцааны санал болгох доод үнийг 850 төгрөгөөр тогтоож, нэмж гаргаж буй хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэн, нэмж гаргаж буй хувьцааны Үнэт цаасны танилцуулгыг үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1, 5.2 дахь хэсэг, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4, 17 дугаар зүйл, 16.7 –д заасны дагуу бэлтгэв.

Үнэт цаас гаргагчийн нэр:	“Хөвсгөл алтан дуулга” ХК
Нэмж гаргаж буй хувьцааны тоо, ширхэг:	4,405,600
Нэмж гаргаж буй хувьцааны эзлэх хувь:	28%
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны тоо, ширхэг	3,228,600
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо, ширхэг	1,177,000
Нэмж гаргаж буй хувьцааны худалдах доод үнэ:	850 төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох:	Стратегийн хөрөнгө оруулагчын захиалгыг андеррайтер хүлээн авч, хуваарлана.
Олон нийтэд санал болгох арга:	Захиалгын бүртгэл
Хувьцааны төрөл:	Энгийн хувьцаа
Татан төлөврүүлэх санхүүжилтийн доод хэмжээ:	3,744,760,000 төгрөг
Үнэт цаасны гаргагчийн бүртгэлтэй бирж:	Монголын Хөрөнгийн Бирж
Үнэт цаас гаргагчийн үсгэн болон тоон код:	ADU/402

АНДЕРРАЙТЕР





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу нэмэлт хувьцаа гарган, стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож байна.


Энэхүү үнэт цаасны танилцуулгыг үнэт цаас гаргагчаас 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд худалдан борлуулахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болон түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер "Бумбат Алтай ҮЦК" ХХК-д хандаж тодруулна уу.





Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР..... 7

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР..... 7

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД..... 9

Нэг. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ..... 10

1.1 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл..... 10

1.2 Компанийн товч танилцуулга..... 10

1.3 Компанийн эрхлэж буй үйл ажиллагаа..... 11

1.4 Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх, өмнө гаргасан үнэт цаасны тухай 17

1.5 Компанийн бүтэц зохион байгуулалт..... 23

1.6 Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл: 28

1.7 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл 29

1.8 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаар мэдээлэл 29

1.9 Компанийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагын гаргасан дүгнэлт 32

1.10 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай 36

1.11 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн мэдээлэл 38

1.12 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл 39

1.13 Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого..... 43

1.14 Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө 45

Түүхий эд материал 63


Хүлээгдэж буй санхүүгийн үр дүнгүүд 68

1.15 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдлийн удирдлагын төлөвлөгөө 70

1.16 Хөрөнгийн үнэлгээ..... 72

1.17 Бизнесийн үнэлгээ 73

1.18 Хууль зүйн дүгнэлт 74





Хоёр. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ	75
2.1 Үнэт цаасны тухай	75
2.2 Нэмж гаргаж буй хувьцааны тухай	76
2.3 Эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэр	77
2.4 Нэмж гаргаж буй хувьцааны үнэ тогтоосон үндэслэл, тооцоолол	78
2.5 Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг	82
2.6 Нэмж гаргаж буй хувьцаатай холбоотой үүсэх хувьцаа эзэмшигчийн эрх, уг эрхийг хэрэгжүүлсэн байдал	86
2.7 Нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгох, анхдагч зах зээлд байршуулах 87	
Гурав. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДҮҮДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ	90
3.1 Үнэлгээний компанийн мэдээлэл	90
3.2 Үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл:	91
3.3 Аудитын компанийн мэдээлэл	93
3.4 Аудитын байгууллагатай байгуулсан гэрээний эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл:	94
3.5 Хуулийн компанийн мэдээлэл	97
3.6 Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл	98
3.7 Андеррайтерийн компанийн мэдээлэл	99
3.8 Андеррайтерийн гэрээний эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл:	100





Хавсралт

- Хавсралт 1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар нотариатаар баталгаажуулсан
- Хавсралт 2. Компанийн дүрмийн хуулбар /1994он, 2000 он, 2006 он, 2012 он/
- Хавсралт 3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийн мэдээ
- Хавсралт 4. 2015,2016,2017 онуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт
- Хавсралт 5. Хөрөнгийн үнэлгээ
- Хавсралт 6. Бизнесийн үнэлгээ
- Хавсралт 7. Хуулийн дүгнэлт
- Хавсралт 8. 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалууд, хувьцаа нэмж гаргах төсөл, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудасны хуулбар, хурлын тогтоол шийдвэрийн хамт
- Хавсралт 9. Компанийн эрх бүхий албан тушаалтануудын анкет, компанийн засаглалын гэрчилгээний хуулбарууд.
- Хавсралт 10. Компанийн үйл ажиллагаандаа мөрдөж буй журмын хуулбарууд
- Хавсралт 11. Аудитын компанийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 12. Үнэлгээний компанийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн хуулбар,
- Хавсралт 13. Эм ди эс энд хаанлекс ХХН-ийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хуульчийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 14. Андеррайтерийн компанийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн хуулбар
- Хавсралт 15. Шаардах эрх хэрэгжүүлсэн тухай, түүнтэй холбоотой материалууд

Хүснэгт

- Хүснэгт 1. Компанийн дүрмийн сан, хувьцаа талаар мэдээлэл..... 18
- Хүснэгт 2. 2000 онд компанийн дүрмийн сан, хувьцаа талаар мэдээлэл 20
- Хүснэгт 3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл..... 24
- Хүснэгт 4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн 24
- Хүснэгт 5. ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл..... 25
- Хүснэгт 6. Гүйцэтгэх захирлын боловсрол, ажлын туршлага 27
- Хүснэгт 7. Эрх бүхий албан тушаалтан, эрхэлж буй албан тушаал, тэдгээрийн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшдэг эсэх, компанийн засаглалын гэрчилгээтэй эсэх тухай мэдээлэл..... 28
- Хүснэгт 8. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл 29
- Хүснэгт 9. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны мэдээлэл 30
- Хүснэгт 10. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид 31
- Хүснэгт 11. Сүүлийн 3 жилийн санхүүгийн байдлын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр 32
- Хүснэгт 12. Сүүлийн 3 жилийн орлогын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр 33
- Хүснэгт 13. Сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайлан зэрэгцүүлсэн дүнгээр 34
- Хүснэгт 14. Сүүлийн 3 жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан зэрэгцүүлсэн дүнгээр 35





Хүснэгт 15. Эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдийн мэдээлэл..... 38

Хүснэгт 16. Улаанбаатар хотын гурилын хэрэглээ..... 41

Хүснэгт 17. Гурилын үйлдвэрийн үнэ..... 42

Хүснэгт 18. Хангай бүсийн зах зээл..... 42

Хүснэгт 19. Бизнес төлөвлөгөөний хүлээгдэж буй үр дүн..... 45

Хүснэгт 20. Улаан буудайн тариалалт ба ургац хураалт, импортын хэмжээ..... 47

Хүснэгт 21. Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ..... 48

Хүснэгт 22. Компанийн үр тарианы гүйцэтгэл болон төсөөлөл..... 51

Хүснэгт 23. Хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт..... 61

Хүснэгт 24. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гүйцэтгэл болон төсөөлөл..... 64

Хүснэгт 25. Төсөвлөгдсөн орлого үр дүн..... 65

Хүснэгт 26. Төсөвлөгдсөн мөнгөн гүйлгээ..... 67

Хүснэгт 27. Тайлан тэнцлийн төсөөлөл..... 67

Хүснэгт 28. Хүлээгдэж буй санхүүгийн үр дүнгүүд..... 68

Хүснэгт 29. Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл..... 72

Хүснэгт 30. Бизнесийн үнэлгээний дүн..... 73

Хүснэгт 31. Хувьцаа эзэмшигчдийн бүтэцийн өөрчлөлт..... 76

График

График 1. Үйлдвэрлэлийн хэмжээ, тонн..... 15

График 2."Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн бүтэц, зохион байгуулалт..... 23

График 3. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн хувьцааны арилжаа..... 30

График 4. Хөвсгөл аймгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ..... 39

График 5. Хөвсгөл аймгийн гурил үйлдвэрлэл, тонноор..... 40

График 6. Хөвсгөл аймгийн гурил нийлүүлэлт..... 40

График 7. Улаан буудайн үйлдвэрлэл, зорилтод түвшин..... 47

График 8. 2018-2022 оны үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ..... 55

График 9. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн хувьцааны хувь, хэмжээ..... 80

Зураг

Зураг 1. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн тариалангийн талбай..... 11

Зураг 2. Тариалангийн талбай..... 12

Зураг 3. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн үйл ажиллагааны процесс..... 12

Зураг 4. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн..... 13

Зураг 5. Үр тарианы босоо агуулах..... 14

Зураг 6. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд..... 14

Зураг 7. Лаборатори..... 15

Зураг 8. Бэлэн бүтээгдэхүүний агуулах..... 16

Зураг 9. Чулуу түүгч.....

Зураг 10. Бодис цацагч.....





ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДХ	Ардын депутатын хурал
БДК	Брокер дилерийн компани
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИХ	Иргэний хууль
КТХ	Компанийн тухай хууль
Мян.төг	Мянган төгрөг /Монгол Улсын мөнгөн тэмдэгт/
МУ	Монгол Улс
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
УБ	Улаанбаатар хот
ҮЦК	Үнэт цаасны компани
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн их сургууль
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

"Үнэт цаас гаргагч"	гэж "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийг
"Компанийн тухай хууль"	2011 оны 10-р сарын 6-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	2013 оны 5 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг
Захиалгын бүртгэл	гэж МХБ –ийн ТУЗ-ийн 2009 оны 11 сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3-т "Тодорхой хугацаанд харилцагчдын ирүүлсэн захиалгын саналд үндэслэн үнэт цаас гаргагчаас тогтоосон үнээр арилжих үйл ажиллагаа" гэж томъёолсон байна.





ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч нь 1994 оны 5 сарын 4-ны өдрийн 402 дугаар зөвшөөрлийн дагуу хувьцаат компани болон бүртгэгдсэн. Компанийн тухай хуулийн 31, 32, 33, 62 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн №ТО-18-18 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн нэмж хувьцаа гаргаж байгаа бөгөөд хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж олон нийтэд санал болгох замаар нэмэлт хөрөнгө татан төвлөрүүлэх болно.

Үнэт цаас гаргагч	"Хөвсгөл Алтан Дуулга" ХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	11,328,600 ширхэг
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	4,405,600 ширхэг
Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	15,734,200 ширхэг
Нэмж гаргаж буй хувь	28.0%
Стратегийн хөрөнгө оруулагч санал болгох хувьцааны тоо, ширхэг	3,228,600
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо	1,177,000
Нэгж хувьцааны санал болгох доод үнэ	850 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ	3,744,760,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Газар тариалан болон гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, зээлийн эх үүсвэрийг бууруулах, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтанд зарцуулагдана.
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох	Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер хүлээн авч, хуваарлана.
Олон нийтэд санал болгох арга хэлбэр	Захиалгын бүртгэлийн аргаар олон нийтэд санал болгон худалдана
Андеррайтер	"Бумбат Алтай ҮЦК" ХХК
Төлбөр, тооцоо	"Арилжааны Төлбөр Тооцоо" ХХК
Үнэт цаасны хадгаламж	"Үнэт Цаасны Төвлөрсөг" ХХК
Арилжаалах зах зээл	"Монголын Хөрөнгийн Бирж"



"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үнэт цаас гаргагчийн үнэлгээг : "БДО- Аудит" ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнеско-гийн гудамж, Нарны зам-62, Юнион Бюлдинг, В блок, 15-р давхар, 1502 тоот

Холбоо барих утас: 77404040

Вэб сайт: www.bdo.mn

И-мэйл хаяг: bdoaudit@bdo.mn

Үнэт цаас гаргагчийн хууль зүйн дүгнэлтийг: Өмгөөллийн Эм ди эс энд

Хаанлекс ХХН

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай, Централ тауэр, 13 давхар, 1301 тоот

Холбоо барих утас: 976-11330048, 99119181

Вэб сайт: www.mdsa.mn

И-мэйл хаяг: info@mdsa.mn

Үнэт цаас гаргагчийн аудитыг : "Од Бүртгэл Аудит" ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 7/3, Цэлмэг тауэр, 7 давхар

Холбоо барих утас: 70150003

Вэб хуудас: www.odburtgel.mn

И-мэйл хаяг: info@odburtgel.mn


Андеррайтераар: "Бумбат Алтай ҮЦК" ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Хот айл 4 давхар, 41 тоот

Холбоо барих утас: 99022166

Вэб сайт: www.bumbat.mn

И-мэйл хаяг: bumbataltai_21@yahoo.com





Нэг. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1 Үнэт цаас гаргагчийн хүүлийн этгээдийн бүртгэл

Үнэт цаас гаргагчийн нэр:	"Хөвсгөл алтан дуулга"ХК
Улсын бүртгэлийн дугаар:	1710001001
Регистрийн дугаар:	2034565
Үүсгэн байгуулагдсан огноо:	1996.04.25
Үйл ажиллагааны чиглэл:	- Үр тариа үйлдвэрлэл - Гурил үйлдвэрлэл - Малын тэжээлийн үйлдвэрлэл - Хүнсний ногоо тариалах - Гадаад дотоод худалдаа - Малын аж ахуй - Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа
Хувь нийлүүлсэн хөрөнгө:	113,286 мянган төгрөг
Компанийн хаяг:	Хөвсгөл, Тариалан, 1-р баг, Мандал
Холбоо барих утас:	70386030, 70386055
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	171 хувьцаа эзэмшигчидтэй. /2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн тархалтын судалгаагаар/

1.2 Компанийн товч танилцуулга

"Хөвсгөл алтан дуулга" ХК нь 1943 онд Хөвсгөл аймгийн Тариалангийн САА-н суурин дээр үүсгэн байгуулагдсан. Тус САА нь 1994 онд өмч хувьчлалд хамрагдаж, төрийн өмч давамгайлсан Хөвсгөл алтан дуулга хувьцаат компани байгуулагдсан ба 1998 онд компанийн төрийн өмчид байсан 70.7 хувийг "Тэс трейд" ХХК хувьчилж авсан. Үйлдвэрлэл нь бараг зогссон, өртэй, тус компанийг "Тэс трейд" ХХК хөл дээр нь босгож Хөвсгөл аймагтаа газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх эхлэлийг тавьсан.

"Хөвсгөл алтан дуулга" ХК нь үр тариа тариалалт, гурил үйлдвэрлэл, тэжээл үйлдвэрлэл, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2011-2015 онд нийт 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь техник тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагааг ханган үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлсэн.

Одоо тус компани 7045 га эргэлтийн талбайд үр тарианы үйлдвэрлэл эрхэлж John Deere, New Holland, Flexi Coli, Borgault зэрэг дэлхийн нэртэй үйлдвэрлэгчдийн трактор комбайн, үрлэгч, тоног төхөөрөмж худалдан авч, үр тарианы үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлтийг хийсэн. Энэхүү технологи нь хөрсний үржил шимийг хамгаалах, хөрсийг элэгдлээс хамгаалах, байгальд ээлтэй, бага зардалтай, өндөр бүтээмжтэйгээрээ давуу талтай. Тариалалтад шинэ техник технологийг ашигласнаар ажлын бүтээмж нэмэгдэн, богино хугацаанд тариалалт, хураалтын ажлыг гүйцэтгэх боломж бүрдсэн.

2012 онд 4000 тн үр тариа хадгалах хатаалгатай иж бүрэн механикжсан байгууламж, хоногт 100тн буудай тээрэмдэх хүчин чадалтай гурилын үйлдвэрийн хамт барьж





ашиглалтанд оруулсан. Уг үйлдвэр ашиглалтанд орсноор чанартай, олон нэр төрлийн буудайн бүтээгдэхүүнийг өртөг багатай үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна.

Компани бүсийн хэмжээнд үр тариа эрхэлдэг бусад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, тэдний ургацыг худалдан авч орон нутагт хамтын ажиллагааны сайн жишиг тогтоосон.

Мөн мэргэжилтэй боловсон хүчнийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан ажлын байран дээр бэлтгэн ажиллуулж байгаа нь үр дүнд хүрч, 60 шахам мэргэшсэн ажилтантай болсон байна.

1.3 Компанийн эрхлэж буй үйл ажиллагаа

Газар тариалан

Компани нийт 7045 га талбайтайгаас 3000-4000 га-д улаан буудай, 50-500 га-д овъёос, тосны ургамал, арвай тариалдаг. Улаан буудай нь голлох тариалалтыг эзэлдэг бөгөөд жилд га-гаас 12 центнэр буюу улсын дунджийн хэмжээний ургац авдаг. Улаан буудайн зөөлөн, durum төрөлд хамаарах 7-8 төрлийн сортыг тариалдаг. Овьёосоо жилд 20-30 га-д тариалдаг бөгөөд одоогоор өөрийн малд тэжээлийн зориулалтаар ашиглаж байна. Цаашид хүнсний овъёос тариалж овъёосны гурил, нэвс үйлдвэрлэх боломжтой. Жилд арвай (халтар арвай) 30 га орчимд тариалж, 25 орчим тн арвайн гурил үйлдвэрлэдэг. 2013 оноос эхлэн таримал сэлгээнийн зориулалтаар 500-800 га-д тосны ургамал тариалж байна. Газар тариалангийн үйлдвэрлэлийн инженер техникийн болон гүйцэтгэх ажилтнаар бүрэн хангагдсан, нийт 12 ажилтан тогтвор суурьшилтай ажиллаж байна. Тариалалтыг технологийн богино хугацаанд орчин үеийн өндөр хүчин чадал бүхий John Deere 82-95R, John Deere 83-30, New Holland T90-40 агрегатаар цомхотгосон технологийн дагуу усалгаагүй нөхцөлд тариалалт хийдэг.

Зураг 1. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн тариалангийн талбай






Зураг 2. Тариалангийн талбай


Гурил, тэжээлийн үйлдвэр

2000 онд хоногт 26 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай гурилын үйлдвэр байгуулсан. 2011-2012 онд 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гурилын үйлдвэрээ шинэчилснээр өдөрт 100 тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай болсон.

Зураг 3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үйл ажиллагааны процесс



Үйлдвэрийг шинэчилж өргөжүүлснээс хойш хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг таниулах, чанар болон технологид анхаарч ажиллаж байсан ба буудайн нөөц хангалтгүйгээс үүдэн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашигладаггүй байсан. 2018 онд борлуулалтыг



нэмэгдүүлэх үе шаттай зорилт тавьсан бөгөөд энэ хүрээнд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай болсон юм. Үр дүнд нь ирэх 3 жилд үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг 80 хувьд хүргэх боломжтой гэж тооцоолсон болно. Бүтээгдэхүүнийг Хөвсгөл, Булган, Архангай аймгуудад борлуулдаг бөгөөд хэрэглэгчдийн дунд "чанар сайтай гурил" гэдгээр танигдаад байна. Улаанбаатарт хүргэлтээр бага хэмжээний борлуулалт хийж байгаад 2018 оны 3 дугаар сараас бөөний худалдааны төв болон сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж эхэлсэн. Цаашид бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, УБ дахь борлуулалтыг өргөжүүлэхээр төлөвлөж, 2018 оны 4 сараас эхлэн цогц маркетинг, идэвхижүүлэлтийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Тус компани нутгийн иргэдийг үйлдвэр дээрээ сургаж, дадлагажуулах ажиллагааг тогтмолжуулснаар, ажиллах хүчнээр хангагдан, хөдөө орон нутагт ажлын байр бий болгож, хадгалахад хувь нэмрээ оруулж байна.

Үйлдвэрээс гарсан дайвар бүтээгдэхүүн буюу хивэг, ногоон тэжээл зэргийг ашиглан багахан хэмжээний малын тэжээл үйлдвэрлэж орон нутгийн малчдад нийлүүлж байна.

Зураг 4. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



Үндсэн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт

Компани 2013-2017 онд нийт 19.7 мянган тонн буудайг тээрэмдэж үйл ажиллагаанд ашигласны 87.8%-ийг өөрийн тариалсан буудайнаас, 12.2%-ийг бусад тариалан эрхлэгчдээс худалдан авч байсан. Буудайгаа хадгалах 6.5 мянган тонн-ын багтаамж бүхий агуулахтай. Ойролцоох бүс нутгийн тариалан эрхлэгчид буудайгаа компанид нийлүүлэх сонирхолтой бөгөөд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлснээр авах улаан буудайн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой. Ингэснээр үйлдвэрлэлийн хүчин

2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2018.06.29 өдөр

ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216 2034565

чадал ашиглалт нэмэгдэн тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжоор хангагдах давуу талтай. Мөн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд ч ихээхэн ач тустай юм.

Зураг 5. Үр тарианы босоо агуулах



Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Зураг 6. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд



Үйлдвэр нь одоогоор дээд гурил, 1-р гурил, 3-р гурил, хивэг, хүүхдийн будаа, арвайн гурил үйлдвэрлэн борлуулдаг. Борлуулалт хийгдэж буй бүс нутгийн хэрэглэгчдэд чанараар танигдсан бөгөөд бүтээгдэхүүний үлдэгдэл маш бага байдаг. Хүүхдийн будааг 650 гр, бусад бүтээгдэхүүнийг 2кг - 40кг савлагаатайгаар үйлдвэрлэдэг. Олон улсын чанарын тогтолцоо, чанар эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх суурь бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээг шат


2087103
ПНОНСЗЗО

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХК
ГЭРЭЭНИЙ
ТБ3216 2034565

дараатайгаар хийж 2015 оны 7 сард Монгол улсын хэмжээнд анх удаа буудайн гурил бүтээгдэхүүнд чанарын тохиролын тэмдэг хэрэглэх эрхийг хүлээн авсан.

Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний төрөл, тэдгээрийн борлуулалт 2013-2017 онд дараах байдалтай байна.

График 1. Үйлдвэрлэлийн хэмжээ, тонн



Монгол улс даяар 2015 оноос гантай байснаас компанийн өөрийн хураасан болон бүс нутгаас худалдан авсан улаан буудайн хэмжээ эрс багассан, үүнээс үүдэн үйлдвэрлэлийн хэмжээ буурахад нөлөөлсөн.

Лаборатори

Компани бүтээгдэхүүний чанарт байнга анхаарч, үйлдвэрийн лабораторыг шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангаж, түүхий эдийг хүлээн авахаас эхлэн үйлдвэрлэлийн шат бүрд бүтээгдэхүүнээс тогтмол дээж авч шинжилдэг.

Зураг 7.Лаборатори





Бэлэн бүтээгдэхүүний агуулах

Бэлэн бүтээгдэхүүний агуулах нийтдээ 700-800 тн багтаамжтай. Хэрэв поддонтой хураавал 500 тн багтаамжтай. 1 поддон дээр 2 тн гурил ачиж хураадаг.

Зураг 8. Бэлэн бүтээгдэхүүний агуулах



Тэжээлийн үйлдвэр

Сүүлийн жилүүдэд тохиолдсон ган зудын бэрхшээл, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эхлэлүүд бий болж байгаатай уялдан хүчит тэжээлийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, малчид иргэдийн захиалга хүсэлт нэмэгдэж байна. Иймд компанийн гол үйлдвэрлэл болох үр тариа, гурилын үйлдвэрээс гарах хагас боловсруулсан болон хаягдал бүтээгдэхүүнд түшиглэн БНХАУ-ын байгальд хор нөлөөгүй, эдийн засгийн хэмнэлттэй орчин үеийн технологитой тэжээлийн үйлдвэрийг 50 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр барьж байгуулсан. Уг үйлдвэр ашиглалтанд орсноор өөрийн аймгийн болон хил залгаа аймгуудад чанартай, хямд үнэтэй тэжээл нийлүүлэх боломжтой болсон. Тус компанийн бүтээгдхүүн УСТ-1077-85 стандартын шаардлагыг бүрэн хангасан, экологийн цэвэр түүхий эдээр үйлдвэрлэгдэж байгаагаараа онцлог юм. Хорголжин тэжээлийн орцонд тэжээлийн буудай, бог будаа, тэжээлийн сүрэл, хивэг, давс хужир, эрдэс түүхий эд ордог.

Цаашид мал амьтны ашиглах төрөл, зориулалтанд тохирсон хүчит, эрдэст болон төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх зорилт тавин ажиллаж байна.





1.4 Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх, өмнө гаргасан үнэт цаасны тухай

Бүртгэлтэй хувьцааны талаар мэдээлэл:

"Хөвсгөл алтан дуулга" ХК нь Хөвсгөл аймгийн Тариалан САА-н суурин дээр 1943 онд үүсгэн байгуулагдсан. Тус САА нь 1994 онд өмч хувьчлагдаж, төрийн өмч давамгайлсан алтандуулга хувьцаат компани байгуулагдсан ба 1998 онд компанийн төрийн өмчид байсан 70.7 хувийг "Тэс трейд" ХХК хувьчилж авснаар компани 100% хувийн өмчит компани болсон байна.

Хөвсгөл аймгийн Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргааны өмч хувьчлалын комиссын "Тариалан сумын "Тариалан" сангийн аж ахуйг хувьчлах тухай" 1994 оны 03 сарын 02 –ны 06 тоот тогтоолоор Тариалан сум "Тариалан" сангийн аж ахуйг "Алтандуулга", "Дулаанхаан", "Баян хошуу" хувьцаат компани, "Одос", "Алтан эмээлт" бүрэн бус хариуцлагатай компани болгон хувьчлахаар төслийг баталжээ. Уг тогтоолын 2-т аж ахуй нэгжүүдэд үлдэх бүх хөрөнгийг 31,803.6 мянган төгрөг, гаргах бүх хувьцаа ногдол хувийг 318036 ширхэгээр, үүнээс "Алтан дуулга" компанийн гаргах хувьцааг 128253 ширхэг, "Дулаанхаан" компанийн гаргах хувьцааг 65094 ширхэг, "Баянхошуу" компанийн гаргах хувьцааг 61419 ширхэг, "Одос" компанийн гаргах ногдол хувийг 50988 ширхэг, "Алтан эмээлт" компанийн гаргах ногдол хувийг 12282 ширхэгээр, ажиллагсадын давуу эрхээр авах хувьцаа, ногдол хувийг "Алтандуулга" хувьцаат компанид 22050 ширхэг, "Дулаанхаан" хувьцаат компанид 13440 ширхэг, "Баянхошуу" хувьцаат компанид 18550, "Одос" бүрэн бус хариуцлагатай компанид 21000 ширхэг, "Алтан эмээлт" бүрэн бус хариуцлагатай компанид 1330 ширхэгээр тус тус тогтоож компаниудын хувьцаа, ногдол хувийг зохих журмын дагуу арилжаалахыг "Хөвсгөл" брокерын пүүс-т зөвшөөрсөн шийдвэрийг гаргасан байна.

1994 оны 3 дугаар сарын 16-ны өдөр МХБ-д үнэт цаасаа бүртгүүлэхийг хүссэн өргөдлийг Алтандуулга ХК гаргасан байна. Уг өргөдөлд дүрмийн сан 12825,2 /мянган төгрөг/, бүртгүүлэх үнэт цаасны тоо 128252 ширхэг, нэрлэсэн үнэ 100 төгрөг, бүртгүүлэх үнэт цаасны төрөл нь хувьцаа, Компанийн ажиллагчид давуу эрхээр үнэт цаас эзэмшинэ, давуу эрх эдлэх ажилтны тоо 315, давуу эрхээр олгогдох үнэт цаасны тоо 22050 ширхэг гэж тусгасан байна.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар "Компаниудыг нэгтгэн зохион байгуулах тухай" 5 тоот тогтоолыг 1995 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр баталсан байна. Уг тогтоолд Алтандуулга ХК-д Баянхошуу хувьцаат компани, Алтан эмээлт ББХКомпанийг 1994-04-10-ны өдрөөс нэгтгэн зохион байгуулах арга хэмжээ авахыг сумын засаг дарга /О.Гунаажав/-д зөвшөөрсүгэй гэжээ.

1995 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар, зарим аж ахуйн нэгжийг нэгтгэх тухай 6 тоот тогтоолыг баталсан байна. Тус тогтоолын 1-рт Алтан дуулга ХК-ны төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны протокол, ногоо бригадын хамт олны хурлын протокол, сум, аймгийг төмс хүнсний ногоогоор хангах зорилтыг хэрэгжүүлэх үндэслэлээр ногоо бригадыг Алтан дуулга хувьцаат компанид 1995-5-1 ний өдрөөс эхлэн нэгтгэх аж ахуйн зохион байгуулалтын арга хэмжээ авахыг сумын Засаг дарга /О.Гунаажав/-д зөвшөөрсүгэй гэжээ.





Хөвсгөл алтан дуулга ХК нь Монгол Улсын Үнэт цаасны хороонд 1996 оны 6 сарын 10-д өргөдөл гаргасан байна. Тус өргөдөлд Хөвсгөл аймгийн Тариалан суманд газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байсан Баянхошуу ХК, Алтан эмээлт ББХК, Ногоо хоршоо нь бие дааж үйлдвэрлэл явуулах чадваргүй болсон тул ХХААЯ-ны захирамж, Аймгийн засаг даргын захирамж, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 1995-4-8- ны 05 тоот, 1995-5-1-ний 06 тоот тогтоолуудын дагуу бүх аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигчдийн 1996-6-8-ны хамтарсан хурлаар хэлэлцээд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа Алтан дуулга ХК-д хөрөнгөө нэгтгэн төрийн өмч дамгайлсан "Хөвсгөл алтан дуулга" ХК болж зохион байгуулагдсан тул дээрхи нэгдсэн аж ахуйн нэгжүүдийн үнэт цаасыг хүчингүй болгож шинэ аж ахуйн нэгжийн нэрээр хувьцааг бүртгэх өргөдөл гаргасан байна.


1. Үнэт цаас гаргагчийн:
 - а. Оноосон нэр Хөвсгөл алтан дуулга ХК
 - б. Хаяг Хөвсгөл аймаг тариалан сум
 - в. Орших газар Тариалан сумын 1-р баг
 - г. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 17/120
регистр 2034565
2. Үнэт цаасны нэр Хувьцаа / Хөвсгөл алтан дуулга ХК/
Тоо 113010
Нийлсэн аж ахуйн хувьцааг 1-р хавсралтаар гаргав.
Нэрлэсэн үнэ 100
3. Хөрөнгийн хэмжээ
Дүрмийн сан 11301014=43
Үүнээс: Төрийн өмч 7997234=43
Хувийн 2995380
Хамтын сан 308400
4. Хувьцаа эзэмшигчдийн нэр, хувьцааны тоо, 1995 оны ногдол ашгийн тооцоог хавсралтаар гаргав гэжээ.

Алтан дуулга ХК анх байгуулагдахад 128,253 ш хувьцаа гаргаж хувьцаа эзэмшсэн. 1994-10-24 нд бүх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн хувьцаа эзэмшигч малчид, тэдгээрийн ар гэрийн нийт хүний хувьцаанд нь мал олгож гаргахаар шийдвэрлэсний дагуу 45125 ш хувьцаанд 4512500 мянган төгрөгний малыг малчдад олгосон. Энэ онд Баянхошуу ХК, Алтан эмээлт ББХК, Одос ББХК, Ногоо бригад-ууд малыг их хувьчлалд оруулж хувьцаа эзэмшигчиддээ баталгаажуулан өгч гаргасан ба сумын Тамгын газрын үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор бригадууд, төвийн барилга байгууламж, тэнд ашиглах эд хогшил, хээлтүүлэгч, шилмэл омог үүлдрийн болон мал хөрөнгө балансаас балансад шилжүүлж дүрмийн санг бууруулсан. Хавсралтад гаргасан дүрмийн сангийн тайлан нь үлдэгдэл хөрөнгөөр гаргасан болно.

Хүснэгт 1. Компанийн дүрмийн сан, хувьцаа талаар мэдээлэл

Компаниудын нэр	Анхны дүрмийн сан хувьцааны тоо			Хувьцаа эзэмшигчдэд өгсөн хөрөнгө		Алтан дуулга ХК-д хөрөнгө	
	Дүрмийн сан	Хувьцаа	Төрийн хувьцаа	Хөрөнгийн дүн	Хувьцааны тоо	Дүрмийн сан	Бүх хувьцаа
Баянхошуу ХК	6141,9	61419	11229	4638,5	46385	1503,4	15034





Алтан дуулга ХК	12825,3	128253	59233	5551	55510	7274,3	71743
Алтан эмээлт	1228,2	12282	6263	321,1	3211	907,1	9071
Одос ББХК	5098,8	50988	5551	3482,6	34826	1616,2	16162
Дүн	25294,2	252942	82276	13993,2	139932	11301,0	113010

Монголын Улсын төрийн өмчийн хорооны 1998 оны 4 сарын 17-ний өдрийн 240 тоот тогтоолоор нийтийн дуудлага худалдааны ялагч Хөвсгөл аймгийн "Тэс трейд" ХХК нь "Алтан дуулга" ХК-ийн нийт хувьцааны 70.7 хувь буюу төрийн мэдлийн 79972 ширхэг нэг багц хувьцааны үнэ 56,200,000 /Тавин зургаан сая хоёр зуун мянган/ төгрөгийг хуульд заасан хугацаанд бүрэн төлсөн тул "Тэс трейд" ХХК-д Хөвсгөл аймгийн "Алтан дуулга" ХК-ийн нийт хувьцааны 70.7 хувь буюу төрийн мэдлийн 79972 ширхэг хувьцааг өмчлөх эрхийг шилжүүлэн олгохоор шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Төрийн Өмчийн Хорооноос Монголын Хөрөнгийн биржид хаягласан 1998 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Төрийн өмчийн хувьцааг худалдан авагчид шилжүүлэх тухай 14 тоот мэдэгдлийг хүргүүлсэн байна. Үүнд: Төрийн өмчийн хорооноос 1998 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан нийтийн дуудлагын худалдаанд ялж "Алтан дуулга" ХК-ний дүрмийн сангийн 70,7% болох төрийн мэдлийн 79972 /далан есөн мянга есөн зуун далан хоёр/ ширхэг хувьцааг багцлан худалдан авч нийт үнэ 56200000 /тавин зургаан сая хоёр зуун мянган/ төгрөгийг хуульд заасан хугацаанд бүрэн төлсөн тул бүгд 79972 /далан есөн мянга есөн зуун далан хоёр/ ширхэг хувьцааг "Тэс трейд" ХХК-д шилжүүлж бичилт хийж, зохих баримт олгохыг мэдэгдсэн ба хувьцааны өмчлөгч солигдсонтой холбогдлуулан зохих бичилт хийхийг мэдэгдсэн байна.


Монгол Улсын Үнэт цаасны хорооны 2000 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хасах, өөрчлөлт оруулах тухай тогтоол. Уг тогтоолоор дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн "Алтан дуулга" ХК, "Баянхошуу" ХК, "Алтан эмээлт" ББХК, "Одос" ББХК-иуд нь тус тусын бүх гишүүдийн хурлаараа хоорондоо нийлэх шийдвэр гаргаж "Алтан дуулга" ХК болон хувь нийлүүлэгчдийн хурлаа хийсэн байна.

"Алтан дуулга" ХК, "Баянхошуу" ХК-ийн зарим гишүүн өөрийн эзэмшлийн хувьцаандаа мал авч гарчээ. Хувьцааны тоонд зөрүү гарч шийдвэрлэгдээгүй байсныг Монголын Хөрөнгийн Бирж хянаж шалгаад тус компанийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Хороонд ирүүлсэн байна.

"Алтан дуулга" ХК, "Баянхошуу" ХК, "Алтан эмээлт" ББХК, "Одос" ББХК-ийн анх хувьчлагдах үеийн нийт хувьцааны болон ногдол хувийн тоо болон төрийн өмчийн хувь, компаниас мал авч гарсан гишүүдийн эзэмшиж байсан хувьцааны тоо зэргийг аймгийн ӨХК-ын 1994 оны 6 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж байгаа хувьцааны тоо зэрэгтэй гишүүн тус бүрээр тулгалт хийж хувьцааны тооны зөрүүг арилгажээ.

"Алтан дуулга" ХК-ийн 81034 ширхэг, "Баянхошуу" ХК-ийн 14348 ширхэг хувьцаа, "Алтан эмээлт" ББХК-ийн 11023 ширхэг, "Одос" ББХК-ийн 6881 ширхэг ногдол хувийг тус бүр 1:1 хувьцаагаар хувьцаанд шилжүүлж нийлсэн "Алтан дуулга" ХК-ийн дүрмийн санг бүрдүүлсэн байна.





Хөвсгөл аймгийн Засаг даргын шийдвэрээр 1996 онд "Алтан дуулга" ХК-иас 2043 ширхэг хувьцаанд ногдох хөрөнгийг Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн байна.

Нэгдсэн компанийн нийт хувьцааны тоо 113286 ширхэг болж, үүнээс төрийн мэдлийн хувьцаа 79972 ширхэг, олон нийтэд 33314 ширхэг хувьцаа арилжаалагдсан байна.

Тус компанийн төрийн мэдлийн хувьцааг "Тэс трейд" ХХК дуудлага худалдаагаар худалдаж авсныг Төрийн өмчийн хорооны 1998 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

"Алтан дуулга" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дах заалт, Компанийн тухай хуулийн 19 дүгээр заалтыг үндэслэн Монгол Улсын Үнэт цаасны хорооноос тогтоох нь:

1. "Алтан дуулга" ХК-ийн нийт хувьцааны тоог 113286 ширхгээр тогтоосугай.
2. "Алтан дуулга" ХК-ийн Хөрөнгийн бирж дээрх арилжааг 2000 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
3. "Баянхошуу" ХК-ийн Хөрөнгийн бирж дээрх үнэт цаасны арилжааг зогсоож, тус үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хассугай.
4. "Алтан дуулга" ХК-ийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл болон Хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламж дах бүртгэлд зохих өөрчлөлт хийхийг Ажлын алба /Ж.Жадамбаа/, Хөрөнгийн бирж /О.Батбилэг/-д зөвшөөрсүгэй.
5. Энэ тогтоолыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлэхийг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д даалгасугай гэжээ.

Тус тогтоолын хавсралтаар хувьцааг дэлгэрэнгүй харуулсан байна.

Хүснэгт 2. 2000 онд компанийн дүрмийн сан, хувьцаа талаар мэдээлэл

		Анх дүрмийн сан			Мал авч гарсан	Одоогийн дүрмийн сан		
		Нийт	Төрд	Олон нийтэд		Нийт	Төрд	Олон нийтэд
1	Алтан дуулга	128253	59233	69020	44915	83338	59233	24105
2	Баянхошуу	61419	11229	50190	47071	14348	11229	3119
3	Алтан эмээлт	12282	6263	6019	1259	11023	6263	4760
4	Одос	50988	5551	45437	44107	6681	5551	1330
	Дүн	252942	82276	170666	137352	115590	82276	33314

Төрийн хувьцаанаас хасагдах: 2304 / засаг даргын шийдвэрээр/ Эцсийн байдлаар

Нийт	113286
Төрд	79972
хувиар	71
Олон нийтэд	33314

Монголын Хөрөнгийн биржийн 2000 оны 7-р сарын 21-ний өдрийн Төлбөр тооцоо, хадгаламжийн албанд үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл № 402-т өөрчлөлт оруулах тухай шийдвэр. Уг шийдвэрт Монгол Улсын Үнэт цаасны Хорооны 2000 оны 7-р сарын 20-ны өдрийн №29 тоот тогтоолыг үндэслэн "Үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл №402"-т дараах өөрчлөлт оруулахыг Төлбөр тооцоо хадгаламжийн албанд зөвшөөрсөн байна.



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК



Үнэт цаасны нэр	“Алтан дуулга” ХК
Компанийн код	VK.ADU.C
Үнэт цаасны төрөл	Хувьцаа
Үнэт цаасны тоо /ширхэг/	113286
Төрийн эзэмшлийн үнэт цаасны тоо /ширхэг/	79972

Монголын Хөрөнгийн биржийн 2000 оны 8-р сарын 21-ний өдрийн Төлбөр тооцоо, хадгаламжийн албанд үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл № 402-т өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг дахин гаргасан байна. Уг шийдвэрт Монгол Улсын Төрийн Өмчийн Хорооны 1998 оны 4-р сарын 17-ны өдрийн 240 тоот тогтоолыг үндэслэн “Үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл №402”-т дараах өөрчлөлт оруулахыг Төлбөр тооцоо хадгаламжийн албанд зөвшөөрсөн байна.

Үнэт цаасны нэр	“Алтан дуулга” ХК
Компанийн код	VK.ADU.C
Үнэт цаасны төрөл	Хувьцаа
Үнэт цаасны тоо /ширхэг/	113286
Төрийн эзэмшлийн үнэт цаасны тоо /ширхэг/	0

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн нийт гаргасан 113,286 ширхэг энгийн хувьцаатай, МХБ болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг байсан бол компанийн 2006 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэрлэсэн үнийг 1000 төгрөг тогтоож, компанийн дүрэм улсын бүртгэлээр баталгаажсан байв. Компанийн санхүүгийн тайлан болон 1998 оны өмч хувьчлалын тооллогын комиссын тайланд тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 102,225 мянган төгрөгөөр тусч иржээ.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас компанийн хувьцааг хуваах, нэрлэсэн үнийг тогтоох, хувь нийлүүлсэн хөрөнгийн зөвтгөх тухай асуудлыг хэлэлцэн, 1 тоот тогтоолыг баталсан билээ. Тус тогтоолд компанийн МХБ-д бүртгэлтэй нэг ширхэг хувьцааг 100 ширхэг хувьцаанд хөврүүлэх замаар хувааж, компани нийт 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоож, компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 10 төгрөгөөр, хувь нийлүүлсэн хөрөнгө зөрүүтэй байсныг зөвтгөж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 113,286,000 төгрөг болгон өөрчилж, улмаар үнэт цаасны бүртгэл өөрчлөлт оруулах хүсэлтийг МХБ, СЗХ хүргүүлж, СЗХ-ны 2018 оны 5-р сарын 4-ны өдрийн 170 тоот тогтоолоор үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 113,286,000 төгрөг байна.

“Хөвсгал алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны бүртгэлтэй холбоотой тогтоол шийдвэрийн хуулбарууд:


- Хөвсгөл аймгийн ардын хурлын гүйцэтгэх захиргааны өмч хувьчлалын комиссын Тариалан сумын “Тариалан” сангийн аж ахуйг хувьчлах тухай 1994 оны 03 сарын 02 –ны 06 тоот тогтоолын хуулбар.
- 1994 оны 3 сарын 16-ны МХБ-д үнэт цаас бүртгүүлэхийг хүссэн өргөдлийн хуулбар
- Компаниудыг нэгтгэн зохион байгуулах тухай 1995 оны 04 сарын 8-ны өдрийн Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 5 тоот тогтоолын хуулбар



"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК





- Зарим аж ахуйг нэгтгэх тухай 1995 оны 05 сарын 1-ний өдрийн Тариалан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 6 тоот тогтоолын хуулбар
- Хөвсгөл алтан дуулга ХК –ийн 1996 оны 6 сарын 10-ны өдөр Монгол Улсын үнэт цаасны хороонд гаргасан өргөдлийн хуулбар
- 1998 оны 4 сарын 22-ны өдрийн Төрийн өмчийн хорооны өмчлөгчийн эрх олгох тухай 240 тоот тогтоолын хуулбар
- 1998 оны 4 сарын 22-ны өдрийн Төрийн өмчийн хорооны төрийн өмчийн хувьцааг худалдан авагчид шилжүүлэх тухай мэдэгдэл №14-ын хуулбар
- Монгол Улсын Үнэт цаасны хорооны 2000 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хасах, өөрчлөлт оруулах тухай 29 тоот тогтоолын хуулбар
- Монголын Хөрөнгийн биржийн 2000 оны 7-р сарын 21-ний өдрийн Төлбөр тооцоо, хадгаламжийн албанд үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл № 402-т өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн хуулбар
- Монголын Хөрөнгийн биржийн 2000 оны 8-р сарын 21-ний өдрийн Төлбөр тооцоо, хадгаламжийн албанд үнэт цаас хадгалуулах зөвшөөрөл № 402-т өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн хуулбар
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 5 дугаар 4-ны өдрийн 170 тоот тогтоолын хуулбар,
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрмийн хуулбарыг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзэж танилцана уу.





1.5 Компанийн бүтэц зохион байгуулалт

График 2. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн бүтэц, зохион байгуулалт.





Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн бүтэц зохион байгуулалтын хувьд дээрх схемийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн дүрмээр ТУЗ-ийн 9 гишүүдийг 2 жилийн хугацаатайгаар сонгодог байна.

2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байна.

Хүснэгт 3. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл


Овог, нэр	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд:
1 Д.Ганхуяг	ТУЗ-ийн ердийн гишүүн
2 Д.Дуламсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
3 Н.Ерөөгэрэл	ТУЗ-ийн ердийн гишүүн
4 М.Зулзаяа	ТУЗ-ийн ердийн гишүүн
5 Т.Мөнхгэрэл	ТУЗ-ийн ердийн гишүүн
6 О.Тунгалаг	ТУЗ-ийн ердийн гишүүн
7 Л.Даваа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8 З.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9 Д.Энхтогтох	ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

2011 оноос хэрэгжиж эхэлсэн "Компанийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгаар хувьцаат компанийн хувьд ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулахаар заасан. 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн ТУЗ-ийн хурлын то-18-07 тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын, бодлого төлөвлөлтийн зэрэг хороодыг байгуулсан байна. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн



Аудитын хороо	1. Д.Энхтогтох /Хорооны дарга/ 2. Т.Мөнхгэрэл 3. З.Батсүх
Цалин, урамшууллын хороо	2. Д.Ганхуяг- /Хорооны дарга/ 3. Д.Энхтогтох 4. З.Батсүх
Нэр дэвшүүлэх хороо	2. О.Тунгалаг- /Хорооны дарга/ 3. Л.Даваа 4. Д.Энхтогтох
Бодлого, төлөвлөлтийн хороо	1. Н.Ерөөгэрэл- /Хорооны дарга/ 2. Д.Дуламсүрэн 3. М.Зулзаяа





Хүснэгт 5. ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Ердийн гишүүд:		
Доржпүрэв овогтой ГАНХУЯГ	1985-1995 онд БГД-ийн 18-р сургууль, 2001-2005 онд Бизнесийн дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. 2016-2018 онд ШУТИС уул уурхайн менежментийн факультетыг уул уурхайн магистр зэрэгтэй төгссөн.	“Тэс трейд” ХХК-ийн захирлаар 2005 оноос хойш ажиллаж байна. Мөн МКМ, Хотол шим ХХК-уудын захирлаар 2012 он, 2015 онуудаас тус тус ажиллаж байна. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн даргаар 2012 оноос 2018 оны 2 сар хүртэл ажиллаж байсан.
Доржпүрэв овогтой Д.ДУЛАМСҮРЭН	1989 -1994 онуудад гадаад хэлний дээд сургууль багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. ХБНГУ-д зах зээлийн эдийн засгийн менежментийн 1 жилийн сургалтад 2003-2004 онд хамрагдсан, СЭЗДС-ийн мастерийн хөтөлбөрийг 2003 онд дүүргэсэн.	1998 оноос хойш “Хөвсгөл алтан дуулга” ХК-д нярав, боловсон хүчин ажиллаж байсан. 2012 оноос тус компанийн гүйцэтгэхээр захирлаар ажиллаж байна.
Ноов овогтой ЕРӨӨГЭРЭЛ	1982-1992 онд Нийслэлийн 62-р сургуульд суралцан төгссөн. 1992-1998 онуудад МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжилтэй магистр зэрэгтэй төгссөн. 2010-2011 онуудад Австрали улс Маккуари их сургуулийг актуарч магистр зэрэгтэй төгссөн.	1998-2001 оны хооронд Үндэсний статистикийн газар мэргэжилтэн, 2001-2003 онуудад Кредит Монгол ХХК –д төслийн зохицуулагч, 2003-2009 оны хооронд Ачид финанс ХХК-д гүйцэтгэх захирлаар, 2011-2017 онд М Си Эс холдинг ХХК-д эрсдлийн ахлах шинжээчээр, 2017 оны 10 сараас “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байна.
Очирхүрээ овогтой ТУНГАЛАГ	1966-1976 онд Нийслэлийн 10 жилийн 6-р сургууль, 1976-1977 онд ОХУ-ын Эрхүү хотын их сургуулийн хэлний бэлтгэл, 1977-1982 онд ОХУ-ын Воронеж хотын их сургуулийг хуульч мэргэжлээр тус тус төгссөн. Хууль зүйн ухааны магистр.	1982-1988 онд Баянзүрх дүүргийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд зохион байгуулагч, 1988-1992 онд УБ хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд референт, 1992-2005 онд Нийслэлийн ИТХ-ын ажлын албаны дарга, 2005-2014 онд УИХ-ын Тамгын газарт төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх, 2014 оноос Тунгаамал ТББ-ын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
Мандшир овогтой ЗУЛЗАЯА	1999-2002 онуудад Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургууль, 2002-2006 онуудад Их засаг их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.	Монголын өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн нарийн бичгийн дарга 2006 оноос хойш 5 жил Өмгөөллийн Сувдпартнеро ХХИ гишүүн хуульчаар





ажилласан, Өмгөөллийн "И Эл Си" ХХН-д хуульчаар 2016 оноос хойш ажиллаж байна.

Төмөр овогтой МӨНХГЭРЭЛ

1974-1984 онд Хөвсгөл аймаг Мөрөн сум 10 жилийн 1-р сургууль, 1984-1989 онд ОХУ-ын Москва хот Ахуйн үйлчилгээний технологийн дээд сургуулийг бүртгэлийн эдийн засагч мэргэжлээр төгссөн. Эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

2000-2005 оны хооронд Сангийн яаманд мэргэжилтэн, 2006-2012 онд БСШУЯ-нд мэргэжилтэн, 2012-2013 онуудад Хөвсгөл аймгийн татварын хэлтэст даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, 2013-2017 онд Сангийн яамны ахлах мэргэжилтнээр, 2018 оноос хувиараа ажиллаж байгаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

Лхам овогтой ДАВАА

1972-1982 онд 10 жилийн 1-р сургууль, 1982-1987 ХААДС-ыг агрономич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 1998 онд ХААИС-ыг ХААУхааны магистр зэрэгтэй, 2000-2004 онд ХААИС МДС-ийг ХААУхааны докторын зэрэгтэй төгссөн.

Дорнод талын бүсийн ХААЭШХ-д эрдэм шинжилгээний ажилтнаар 8 жил, ХААИС, Агроэкологийн сургуульд дэд профессороор 19 жил ажиллаж байна.

Заяат овогтой БАТСҮХ

1977-1987 онд Хөвсгөл аймгийн 10 жилийн 1-р сургууль, 1987-1992 онд ХААИС-ыг малын эмч мэргэжилтээр төгссөн. 1993-1996 онд ХААИС-ыг боловсролын доктор (Phd), 2009 онд шинжлэх ухааны доктор(ScD)-ын зэрэг хамгаалсан.

1992-2001 онд Мал эмнэлгийн хүрээлэнд ЭША, 2001-2006 онд Мал эмнэлгийн хүрээлэнгийн ЭНБДарга, 2006-2008 онд Мал эмнэлэгийн хүрээлэнгийн захирал, 2010-2013 онд ЗГХЭ, МЭҮ-ийн газрын дэд даргаар, 2013 оноос хойш Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн эхрлэгчээр ажиллаж байна.

Даваажав овогтой ЭНХТОГТОХ

1975-1985 онд Сэлэнгэ аймаг Зүүн хараагийн 10 жил, 1980-1982 онд СЭЗДС банкны нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр, 1985-1989 онд МУИС ЭЗФ –ыг статистикч, эдийн засагч мэргэжлээр төгссөн.


Хөрөө Хөвч Хангай ХХК-д санхүүгийн ерөнхий зөвлөхөөр 4 жил, Хас банк ББГ-т бүтээгдэхүүн хариуцсан менежер, Төв салбарын захирал, УБ бүсийн менежерээр 7 жил, ХХБ –д СУГ-ын захирал, салбарын захирал, ахлах ня бо-г 11 жил, ҮСХ-нд макро эдийн засгийн газарт эдийн засагч 1 жил, Нэг болон хоёр шатлалт банкны системд эдийн засагч, ерөнхий нягтлан бодогчоор 5 жил тус тус ажилласан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Сэрээтэр овогтой ОЮУНГЭРЭЛ

1966-1976 онуудад Хөвсгөл аймаг Мөрөн сумын 10 жилийн сургуульд суралцан төгссөн. 1976-1977 онуудад ОХУ-ын Эрхүүгийн сургуулийн хэлний бэлтгэл,

1982 оноос 1988 он хүртэл Хөвсгөл аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд дотоод ажил хариуцсан зохион байгуулагч, 1988-1992 онд УБ хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хуулийн хэлтэст болон





1977-1982 онуудад ОХУ-ын төрийн байгуулалтын хэлтэст Краснодар хот, Кубаний их мэргэжилтэн, 1992-2013 онд сургуулийг хуульч Нийслэлийн иргэдийн мэргэжлээр төгссөн. төлөөлөгчдийн хурлын ажлын албанд зохион байгуулагч, ахлах зохион байгуулагчаар, 2013 оноос тэтгэвэрт гаргасан бөгөөд 2017 оноос "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал:


Хүснэгт 6. Гүйцэтгэх захирлын боловсрол, ажлын туршлага

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Доржпүрэв овогтой Д.ДУЛАМСҮРЭН	1989 -1994 онуудад гадаад хэлний дээд сургууль багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. ХБНГУ-д зах зээлийн эдийн засгийн менежментийн 1 жилийн сургалтад 2003-2004 онд хамрагдсан, СЭЗДС-ийн мастерийн хөтөлбөрийг 2003 онд дүүргэсэн.	1998 оноос хойш "Хөвсгөл алтан дуулга" ХК-д ажиллаж байгаа бөгөөд нярав, боловсон хүчин, гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Ажиллах хугацаандаа газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлсэн, гурилын үйлдвэрийг ашиглалтанд оруулсан байна.

ТУЗ-ийн гишүүдийн анкет, гүйцэтгэх захирлын анкет, туз-ийн нарийн бичгийн даргын анкет, компанийн засаглалын гэрчилгээний хуулбарыг хавсралтаас үзнэ үү.

"Хөвсгөл алтан дуулга" ХК дээр хүний нөөцийн талаар баримталж буй бодлого, хийгдэж буй ажлуудаас дурьдвал:

Тус компани нь нийтдээ 60 орчим мэргэшсэн ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулдаг. Компанийн бүтэц зохион байгуулалтыг 2017 оноос өөрчлөн, борлуулалт маркетингийн албыг бий болгосон. Нэмэлт хувьцаа гарган санхүүжилт татснаар чанар, ХАБЭА хариуцсан албыг бий болгохоор, мөн гурил тэжээлийн үйлдвэрт цөөн тооны ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөөд байна. Компани ажиллагсадынхаа нийгмийн хамгаалал, цалин хөлсний бодлого, цалин урамшууллын системийг шинэчилж, 2018 оноос ажиллагсдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, ажиллагсдын нийгэм соёлын асуудал, сургалт хөгжилд зориулж компанийн цэвэр ашгаас сан байгуулсан бөгөөд энэхүү санг нэмэгдүүлэх, зарцуулах асуудлыг холбогдох бодлого, журмуудаар зохицуулдаг болсон.





1.6 Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл.


Компанийн тухай хуулийн 84.1-д компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно гэж заасан.


Хүснэгт 7. Эрх бүхий албан тушаалтан, эрхэлж буй албан тушаал, тэдгээрийн "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн хувьцаа эзэмшдэг эсэх, компанийн засаглалын гэрчилгээтэй эсэх тухай мэдээлэл

№	Овог нэр	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны тоо, хувь	Компанийн засаглалын гэрчилгээ (№)
ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга:				
1.1	Д.Ганхуяг	ТУЗ-ийн ердийн гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан. №0930167
1.2	Д.Дуламсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн, гүйцэтгэх захирал	5,238 ширхэг 4.62%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан №0230074
1.3	Н.Ерөөгэрэл	ТУЗ-ийн дарга	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан №0130901
1.4	М.Зулзаяа	ТУЗ-ийн ердийн гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан №0130902
1.5	Т.Мөнхгэрэл	ТУЗ-ийн ердийн гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан. №0130896
1.6	О.Тунгалаг	ТУЗ-ийн ердийн гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан. №0130895
1.7	Л.Даваа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан №0130903
1.8	З.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан. №0130897
1.9	Д.Энхтогтох	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан. №0230064
1.10	С.Оюунгэрэл	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	0%	КТХ-ын 75.8 заасны дагуу гэрчилгээ авсан №0230085

Компанийн эрх бүхий албан тушаалтан

1.11	Н.Одончимэг	Ерөнхий нягтлан бодогч	0%
1.12	Б.Лхагва-Очир	Ерөнхий агрономич	0%





1.7 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл

ҮЦЗЗТХ-ийн 4.1.29-д **нөлөө бүхий хувьцаа эзэмшигч** гэж тухай компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ гэж заасан байдаг. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь дараах этгээд байна. Үүнд:


Хүснэгт 8. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл


Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистр	Хувьцааны тоо, хувь эзэмшил	Үйл ажиллагааны чиглэл	Оршин байгаа хаяг
М.Золзаяа	РЭ90012503	886,100 ширхэг 7.82%		УБ, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 6 хэсэг, хатан туул в байр 3 тоот
“Тэс трейд” ХХК	2034948	7,997,200 ширхэг 70.59%	Гадаад худалдаа, хүнсний бөөний худалдаа, талх нарийн боовны үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх, гурилын үйлдвэрлэл,	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж 24-33
Д.Дуламсүрэн	РП71012506	523,800 ширхэг 4.62%		УБ, Баянзүрх, 26-р хороо, кристал таун, 802 байр 309 тоот

1.8 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаар мэдээлэл

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 1996 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 1997 оны 2 сарын 20-ны өдрийн төрийн өмчийн тооллогын материал болон 1998 оноос хойш санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийг 102,225,173 төгрөгөөр тусгаж иржээ. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хувьцааг хуваах, нэрлэсэн үнийг тогтоох болон хувь нийлүүлсэн хөрөнгийг зөвтгөх, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэн 01 тоот тогтоолыг баталж, хувьцаа хуваах болон нэрлэсэн үнэ хувь нийлүүлсэн хөрөнгийг зөвтгөх хүсэлтийг МХБ болон СЗХ-нд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах өргөдөл гаргасан.





C3X –ны 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 170 тоот тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 113,286 ширхэг энгийн хувьцааг нэгж хувьцааг 100 хувааж, 11,328,600 төгрөг болгон зөвтгөх зөвшөөрсөн билээ. “Хөвсгөл алтан дуулга” ХК нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай, 113,286,000 төгрөг хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болж, компанийн дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлтийг оруулаад байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө, нэрлэсэн үнэтэй холбоотой баримт материалын хуулбарууд:

- C3X-ны 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 170 тоот тогтоолын хавсралт,
- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар баталсан компанийн дүрмийн хуулбар.

Компанийн өөрийн хөрөнгө, биет бус хөрөнгийн мэдээлэл:

Өөрийн хөрөнгө (12/31/2017):	10,448,530 мянган төгрөг
Биет бус хөрөнгө(12/31/2017):	2,315,792 мянган төгрөг
Үүнд:	
Газар эзэмших эрх:	2,128,731,000 мянган төгрөг
Барааны тэмдэг:	184,339,000 мянган төгрөг


Хувьцааны мэдээлэл:

Хүснэгт 9. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны мэдээлэл

Үнэт цаасны нэр:	Хөвсгөл алтан дуулга
Үнэт цаасны төрөл:	Энгийн
Үнэт цаасны үсгэн болон тоон код:	ADU/402
Нийт гаргасан хувьцааны тоо:	11,328,600
Хувьцааны нэрлэсэн үнэ:	10 төгрөг
52 долоо хоногийн доод, дээд ханш:	1005-9305 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
6 сарын жигнэсэн дундаж ханш (5/09/2018):	5017 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
Хувьцааны ханш (5/09/2018):	9305 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
Зах зээлийн үнэлгээ (5/09/2018):	1,054,126,230 төгрөг

График 3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны арилжаа

Хувьцааны арилжаа /1999-2018/



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж www.mse.mn



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК



“Хөвсгөл алтан дуулга” ХК нь хувьцаагаа эргүүлэн худалдаж аваагүй болно.

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 11,328,600 бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэх өдөр болох 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 171 хувьцаа эзэмшигчтэй байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

Хүснэгт 10. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид

№	Нэр	Регистр	Хаяг	Хувьцааны тоо, хувь ЭЗЭМШИЛ
1	“Тэс трейд” ХХК	2034948	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж 24-33	70.59% 7,997,200 ширхэг
2	М.Золзаяа	РЭ90012503	УБ, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 6 хэсэг, хатан туул в байр 3 ТООТ	7.82% 886,100 ширхэг





1.9 Компанийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагын гаргасан дүгнэлт

“БДО Аудит” ХХК нь “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2015, 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийсэн.

2015 оны санхүүгийн тайланд аудит хийснээр “БДО Аудит” ХХК нь “Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, “Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн 2015 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу үнэн зөв бөгөөд шударгаар илэрхийлсэн байна” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

2016 оны санхүүгийн тайланд аудит хийснээр “БДО Аудит” ХХК нь “Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

“Од бүртгэл- аудит” ХХК нь “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийсэн.

“Од бүртгэл-аудит” ХХК 2017 оны санхүүгийн тайланд “Бидний дүгнэлтээр, Компанийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна” гэсэн дүгнэлтийг гаргасан.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хүснэгт 11. Сүүлийн 3 жилийн санхүүгийн байдлын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр

(Мянган төгрөгөөр)

	2015	2016	2017
Хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж	4,440,796	4,022,173	9,155,265
Биет бус хөрөнгө	463,000	362,996	2,315,792
Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,333	3,333	1000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,907,129	4,388,502	11,472,057

Хөрөнгө


Эргэлтийн бус хөрөнгө

Өмч, барилга, тоног төхөөрөмж


Биет бус хөрөнгө

Урт хугацаат хөрөнгө оруулалт

Эргэлтийн бус хөрөнгийн дүн



"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК



Эргэлтийн хөрөнгө

Бараа материал	929,390	1,600,106	1,266,220
Худалдааны болон бусад авлага	593,767	440,934	1,448,215
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,950	50,180	506,452
Эргэлтийн хөрөнгө	1,527,107	2,091,220	3,220,887
Нийт хөрөнгө	6,434,236	6,479,722	14,692,944

Өмч ба өр төлбөр

Өмч

Хувьцаат капитал	102,225	102,225	102,225
Дахин үнэлгээний нөөц			7,383,026
Хуримтлагдсан ашиг /алдагдал	3,115,424	2,926,436	2,963,279
Нийт өмч	3,217,649	3,028,661	10,448,530

Өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат зээл	191,313	541,119	-
Хойшлогдсон татварын өглөг			
Бусад урт хугацаат өглөг	201,811	201,811	201,811
Урт хугацаат өр төлбөр	393,123	742,930	201,811

Богино хугацаат өр төлбөр

Худалдааны болон бусад өглөг	934,740	674,304	810,615
Татварын өглөг	25,474	39,683	27,291
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	1,863,249	1,994,144	3,204,697
Богино хугацаат өр төлбөр	2,823,463	2,708,131	4,042,603
Нийт өр төлбөр	3,216,586	3,451,061	4,244,414
Нийт өмч ба өр төлбөр	6,434,236	6,479,722	14,692,944

АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Хүснэгт 12.Сүүлийн 3 жилийн орлогын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр

(Мянган төгрөгөөр)

	2015	2016	2017
Борлуулалтын орлого	3,473,700	3,036,492	2,461,115
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(3,112,585)	(2,347,149)	-1,996,755
Нийт ашиг	361,115	689,343	464,360
Ерөнхий удирдлагын зардал	(576,970)	(521,752)	(430,960)
Үйл ажиллагааны ашиг	(215,855)	167,592	33,400
Санхүүгийн орлого, зардал	(326,755)	(480,451)	409,940



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК





Бусад орлого, зардал	103,304	228,470	413,019
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(439,306)	(84,389)	36,885
Орлогын албан татварын зардал	(3,638)	(513)	(42)
Нийт татварын зардал	(3,638)	(513)	(42)
Цэвэр ашиг	(442,944)	(84,902)	36,843
Бусад дэлгэрэнгүй орлого			
Дахин үнэлгээний нэмэгдэл			7,383,026
Нийт дэлгэрэнгүй орлого			7,419,869

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт 13. Сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайлан зэрэгцүүлсэн дүнгээр

	2015	2016	2017
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:			
Мөнгөн орлогын дүн	2,742,885	3,175,337	3,148,740
Бараа борлуулсан, үйлчилгээний үзүүлсний орлого	2,742,885	3,175,337	2,453,433
Татаас, санхүүжилтын орлого			13,591
Бусад мөнгө орлого			681,716
Мөнгөн зарлагын дүн	1,118,686	3,741,905	3,144,062
Ажилчдад олгосон мөнгө	212,549	210,726	237,067
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	63,761	56,830	62,172
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	120,415	2,542,361	2,250,627
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	71,624	60,535	22,237
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	249,341	273,610	11,972
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	326,801	-	409,534
Татварын байгууллагад төлсөн мөнгө	68,292		25,254
Бусад мөнгөн зарлага	5,903		723,042
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,624,199	31,275	(593,166)
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:			
Мөнгөн орлогын дүн	11,228	-	445
Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдсан орлого	11,228		
Хүлээн авсан хүүний орлого			445
Мөнгөн зарлагын дүн	2,652,742	9,802	4,827
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	2,652,742		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		9,802	4,827
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(2,641,514)	(9,802)	(4,827)





3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:



Мөнгөн орлогын дүн	2,371,327	2,182,401	2,663,690
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,371,327	2,182,401	2,663,690
Хандив	192,491		
Мөнгөн зарлагын дүн	1,569,735	2,157,644	1,609,871
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,564,677	1,701,699	1,609,871
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		455,945	
Олгосон ногдол ашиг	5,058		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	994,083	24,757	1,053,819
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(23,233)	46,230	456,272
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,183	3,950	50,180
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,950	50,180	506,452


ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 14. Сүүлийн 3 жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан зэрэгцүүлсэн дүнгээр

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2015 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	102,225		3,359,429	3,461,654
НББүртгэлийн алдааны залруулга			198,940	198,940
2015 оны цэвэр алдагдал			(442,944)	(442,944)
Зарласан ногдол ашиг				
2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	102,225		3,115,424	3,217,649
Тайлант жилийн ашиг/ алдагдал			(84,902)	(84,902)
НББ-ийн бодлогын ба алдааны залруулга			(104,086)	(104,086)
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	102,225		2,926,436	3,028,661
Тайлант жилийн ашиг, алдагдал			36,843	36,843
Бусад дэлгэрэнгүй орлого		7,383,026		7,383,026
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		7,383,026	2,963,279	10,448,530

"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.





1.10 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай

"Хөвсгөл алтан дуулга" ХК –ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 113,286,000 төгрөг бөгөөд тус компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий дараах гэрээ хэлцлийг байгуулсан байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хэмжээтэй гэрээ хэлцлийн мэдээллийг 2017 оны жилийн эцсийн байдлаар гарган танилцуулж байна.: Үүнд

Зээлийн гэрээ

1. "Хөвсгөл алтан дуулга" ХК нь "Хаан банк"-тай 2016 оны 5 сарын 20-ны өдөр байгуулсан "газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах төслийн зээл. (Хөгжлийн банкны санхүүжилттэй)"

Зээлийн хэмжээ:	1,225,000 мянган төгрөг
Зээлийн хүү:	12.5%
Зээлийн хугацаа:	2 жил
Зээлийн төлөгдөх сүүлийн хугацаа:	2018 оны 6 сарын 5-ны өдөр
Зээлийн хэрэгжилт:	хэвийн
Зээлийн үлдэгдэл:	465,000 мянган төгрөг.
2. "Хөвсгөл алтан дуулга" ХК нь "Хаан банк"-тай байгуулсан "Бизнесийн зээл"

Зээлийн хэмжээ:	413,690 мянган төгрөг
Зээлийн хүү:	20.4%
Зээлийн хугацаа:	1 жил
Зээлийн төлөгдөх сүүлийн хугацаа:	2018 оны 9 сарын 5-ны өдөр
Зээлийн хэрэгжилт:	хэвийн
Зээлийн үлдэгдэл:	413,690 мянган төгрөг
3. "Хөвсгөл алтан дуулга" ХК нь "Хаан банк"-тай байгуулсан "Комбайны урьдчилгаа төлбөр төлөх зээл"

Зээлийн хэмжээ:	263,584.7 мянган төгрөг
Зээлийн хүү:	20.4%
Зээлийн хугацаа:	3 жил
Зээлийн төлөгдөх сүүлийн хугацаа:	2018 оны 7 сарын 22-ны өдөр
Зээлийн хэрэгжилт:	хэвийн
Зээлийн үлдэгдэл:	76,007.3 мянган төгрөг.
4. "Хөвсгөл алтан дуулга" ХК нь "Мал хамгаалах сан"-тай байгуулсан "ОХУ-аас малын өвс тэжээл импортлон оруулж ирэх ААН-тэй байгуулах зээл"

Зээлийн хэмжээ:	5,000,000 мянган төгрөг
Зээлийн хүү:	0.0%
Зээлийн хугацаа:	8 са р
Зээлийн төлөгдөх сүүлийн хугацаа:	2018 оны 8 сарын 31-ний өдөр
Зээлийн хэрэгжилт:	хэвийн
Зээлийн үлдэгдэл:	2,250,000 мянган төгрөг





Худалдан авалтын гэрээнүүд

Гэрээний утга	Гэрээ байгуулсан байгууллагын нэрс	Хэрэгжилт
1 Хүнсний улаанбуудай худалдах, худалдан авах	11 хувь хүн	хэвийн
2 Хүнсний улаанбуудай худалдах, худалдан авах	Шижирговь ХХК	хэвийн
3 Хүнсний улаанбуудай худалдах, худалдан авах	Шим ХХК	хэвийн
4 Ургамал хамгааллын бодис нийлүүлэх	Гацуурт ХХК	хэвийн
5 Үрийн будаа худалдах, худалдан авах	Дархан Үр сорт	хэвийн
6 Шатахуун, хор, улаанбуудай худалдах, худалдан авах	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	хэвийн
7 Газар тариалангийн тоног төхөөрөмж зээлээр худалдан авах	ХХААХҮЯам	хэвийн

Нэмж хувьцаа гаргахтай холбоотой байгуулагдсан гэрээ

Гэрээний утга	Гэрээ байгуулсан байгууллагын нэрс	Хэрэгжилт
1 Андеррайтерийн гэрээ	Бумбат-Алтай ҮЦК	хэвийн
2 Хуул зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Эм Ди Эс энд Хаанлекс ХХН	хэвийн
3 Санхүүгийн тайланд аудит хийх ажлын гэрээ	Од бүртгэл Аудит ХХК	хэвийн
4 Хөрөнгийн болон бизнесийн үнэлээ хийх гэрээ	БДО Аудит ХХК	хэвийн





1.11 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн мэдээлэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д “Холбогдох этгээд”-ийг тодорхойлсон байдаг. Үнэт цаас гаргагч “Хөвсгөл алтан дуулга” ХК нь охин болон хараат компани байхгүй болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааны 70,59%-ийн эзэмшигч, толгой компани “Тэс трейд” ХХК.

“Тэс трейд” ХХК-ийн товч танилцуулга

“Тэс трейд” ХХК нь гадаад худалдаа, хүнсний бөөний худалдаа, талх нарийн боовны үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх, гурилын үйлдвэрлэл, худалдаа, малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагааг эрхлэн явуулахаар 1996 оны 8 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан байна. Тус компанийн хувьцааг Монгол Улсын иргэн Доржпүрэв овогтой Ганхуяг 100 хувь эзэмшдэг байна.


“Тэс трейд” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрмийн хуулбарыг хавсралтаас үзнэ үү.

Үнэт цаас гаргагч “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд:

Хүснэгт 15. Эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдийн мэдээлэл.

№	Эрх бүхий албан тушаалтан	Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд нэрс	Регистр	Хувьцаа эзэмшлийн байдал
1	Д.Ганхуяг	Тэс трейд ХХК	2034948	100%
		МКМ ХХК	5033217	100%
		Хотол шим ХХК	5717698	100%

Компанийн эрх бүхий албан тушаалтанууд болох ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой хувь хүмүүсийн мэдээллийг тус бүрийн анкетнаас үзэж танилцана үү.






1.12 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл

Хөвсгөл аймгийн гурилын зах зээл

Хөвсгөл аймгийн жишсэн хүн амын гурилын хэрэгцээгээр тооцоход аймгийн гурилын жилийн нийт хэрэгцээ 14.9 мянган тонн байхаар байна. Харин нийт нийлүүлэлтээр тооцоход гурилын зах зээлийн багтаамж 13.7 мянган тонн бөгөөд үүний 81%-ийг өрхийн хэрэглээ, 19%-г үйлдвэр цехийн хэрэглээ эзэлж байна.

Хөвсгөл аймагт Алтан тариа, Улаанбаатар, Өег, Милл Хаус зэрэг компанийн гурилууд нийлүүлэгдэж байна.

График 4. Хөвсгөл аймгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ



Хөвсгөл алтан дуулга компанийн үйлдвэрлэл буурсантай холбоотойгоор зах зээлд эзлэх хувь хэмжээ нь сүүлийн 2 жилд буурсан байна. Иймд аймгийн зах зээл дэх байр сууриа өсгөхийн тулд гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тогтвортой нийлүүлэлт хийх шаардлагатай тулгарч байна. Хөвсгөл алтан дуулга компани нь одоогоор аймгийн гурил үйлдвэрлэлийн 80%-ийг дангаар эзэлдэг бөгөөд гурилын үйлдвэрлэл түүхий эдийн хангамжаас хамаарч хязгаарлагдмал байгааг өөрчлөх нь бизнес төлөвлөгөөний нэг гол зорилт юм.







График 5. Хөвсгөл аймгийн гурил үйлдвэрлэл, тонноор

Хөвсгөл аймгийн мөрөн сум нийлүүлэгдэж буй 1-р гурилын үнийн бүтцийг доор харуулав. Хөвсгөл алтан дуулга компанийн гурил 2017 оны эцсийн байдлаар хамгийн өндөр үнэтэй байгаа нь гурилын нөөц бага болсонтой холбоотой.

График 6. Хөвсгөл аймгийн гурил нийлүүлэлт

МӨРӨН ДЭХ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮНЭ /25 КГ САВЛАГААТАЙ 1 ДҮГЭЭР ГУРИЛ

Гурилын үйлдвэр	Үйлдвэрийн үнэ	Бөөний үнэ /төг/	Ашиг /төг/	Урамшуулал		Тээвэр /төг/	Зарагдаж байгаа үнэ
				Таган авалт /тн/	Хөнгөлөлт /төг/		
Өгөөж	820	800	30	2	10	60	890
				5	20		
				10	30		
Өег	820	800	30	10	10	60	890
Алтан тариа	830	810	30				900
Улаанбаатар	890	850	30				940
Милл Хаус	870	820	30	10	10		910
Алтан дуулга	920	920	30	0	0	30	970



- Өнөөдрийн байдлаар Мөрөнгийн зах дээр Алтандуулга 1 дүгээр гурилын үнэ бусад гурилын зарагдаж буй үнээс 30-80 төгрөгөөр өндөр үнэтэйгээр борлуулагдаж байна.



Улаанбаатар хотын зах зээл

Улаанбаатар хотын гурилын нийт зах зээлийн багтаамжийг статистик мэдээнд үндэслэн тооцвол жилд 115.5 мян тн байна. Үүний 50.4 мян тн нь өрхийн хэрэглээ, бусад нь гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийтийн хоолны салбарын хэрэглээ болно.





Улаанбаатар хотын гурилын хэрэглээ

Хүснэгт 16. Улаанбаатар хотын гурилын хэрэглээ.

№	Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2017 он	Хувь	Эх сурвалж
1	Гурил /тн/	115,540	100.0%	ҮСГ
2	Гоймон /тн/	7,073	6.1%	ҮСГ
3	Талх /тн/	23,510	20.3%	ҮСГ
4	Нарийн боов /тн/	17,505	15.2%	ҮСГ
5	Жигнэмэг /тн/	351	0.3%	ҮСГ
6	Нийтийн хоол	2,300	2.0%	Түүвэр судалгаа
7	Бууз баншны цех	8,000	6.9%	Үйлдвэрийн дундаж хэрэглээ
8	Хэрчсэн гурил	6,400	5.5%	Үйлдвэрийн дундаж хэрэглээ
9	Өрхийн хэрэглээ	50,400	43.6%	ҮСГ
НИЙТ		115,540	100.0%	

Улаанбаатар хотын гурилын зах зээлд Алтан тариа (40%), Улаанбаатар (30%), Милл Хаус, Нүүдэлчин групп, Од групп, Дорнод гурил, Хангай Миллс, Гацуурт компаниуд гол нийлүүлэлтийг хийж, импортын Алейка, Цесна гурилууд мөн зах зээлд багагүй жинтэй байна.

Нийт нийлүүлэлтийн 72%-ийг 1-р гурил, бусад хувийг дээд гурил, 2-р гурил болон бусад гурилын нэр төрөл бүрдүүлж байна.

Улаанбаатар хотын зах зээл дэх дотоодын гурилын үйлдвэрүүдийн үнийн судалгааг доор харуулав. Өег гурилын үнэ хамгийн доод жишгийг тогтоож байна.

Хөвсгөл алтан дуулга компанийн хувьд энэ зах зээлд 2017 оноос тандалт туршилтын маягаар шууд хүргэлтээр борлуулалт хийж байгаад 2018 оны 3-р сараас хүнсний бөөний төвүүд болон сүлжээ дэлгүүрүүдээр борлуулалт хийж эхэллээ. Энэ зах зээлд нэвтрэх бэлтгэл болгон 1-2 кг-ийн савлагааны шугамыг шинээр суурилуулсан.

Мөн Улаанбаатар хотод хийсэн хэрэглэгчийн судалгааны үр дүнгээс харахад хэрэглэгчид гурилын сонголтын гол хүчин зүйлд чанар, найдвартай байдал, амтыг үнээс илүү дурьдсан байна. Мөн хэрэгдэгчид өөрийн хэрэглэж дадсан гурилаа сонгох хандлагатай. Савлагааны хувьд 30% орчим нь 3 кг хүртэлх бага савлагааг, 30% гаруй нь дундаж буюу 5-10 кг, үлдсэн хувь нь 25-50 кг-ийн савлагааг тохиромжтой гэж үзжээ.

Гурилын нэр төрлийн хувьд хангалттай биш гэж 50-иас дээш хувь нь үзсэн байна.





Гурилын үйлдвэрийн үнэ

Хүснэгт 17. Гурилын үйлдвэрийн үнэ

Бүтээгдэхүүн нэр төрөл	кг	Үйлдвэрийн үнэ /төгрөг/										
		Алтан тариа		Милл хаус		Өөг		Ургац		Хурх		Дундаж үнэ
		нэгж	нийт	нэгж	нийт	нэгж	нийт	нэгж	нийт	нэгж	нийт	
Дээд гурил	50	1,100	55,000	1,080	54,000	1,040	52,000					1,073
	25	1,110	27,750	1,090	27,250	1,050	26,250	1,100	27,500	1,100	27,500	1,090
	10	1,160	11,600	1,120	11,200	1,090	10,900	1,110	11,100	1,150	11,500	1,126
	5	1,170	5,850	1,130	5,650	1,100	5,500	1,120	5,600			1,130
	1	1,180	1,180	1,150	1,150	1,110	1,110	855	855	1,250	1,250	1,109
1-р гурил	50	820	41,000	850	42,500	810	40,500	860	43,000	880	44,000	844
	25	830	20,750	870	21,750	820	20,500	870	21,750	900	22,500	858
	10	870	8,700	910	9,100	860	8,600	880	8,800	930	9,300	890
	5	880	4,400	920	4,600	870	4,350	890	4,450			890
	1	890	890	940	940	880	880	765	765	950	950	885
2-р гурил	50			650	32,500							650
	25	640	16,000	670	16,750			600	15,000	680	17,000	648
	10	350	3,500	680	6,800			610	6,100	700	7,000	585
	5			690	3,450			620	3,100			655
	1	710	710	700	700			540	540	780	780	683
Бүхэл үр	50			1,150	57,500							1,150
	5	1,250	6,250	1,200	6,000							1,225
	1	1,250	1,250	1,220	1,220							1,235
Хүүхдийн будаа	1	1,480	1,480	1,330	1,330			1,100	1,100			1,303
Хивэг	25	440	11,000	420	10,500	420	10,500	450	11,250	450	11,250	436


Хангайн бүсийн Булган, Завхан, Архангай, Өвөрхангай, Орхон аймгуудын зах зээл

Компани байршлын давуу талаа ашиглан хангайн болон Баруун бүсийн аймгуудын зах зээлд гурил нийлүүлэхээр төлөвлөж байгаа ба тэргүүн ээлжинд Булган, Завхан, Архангай, Өвөрхангай, Орхон аймгуудад гэрээт агентуудыг байгуулахаар сонгоод байна. Эдгээр аймгуудын жилийн нийт хэрэглээ нь 41.6 мян тн байгаа ба 4 жилийн хугацаанд энэ зах зээлийн 8-10%-ийг хангасан байна гэж төлөвлөсөн.

Хүснэгт 18. Хангай бүсийн зах зээл

Аймаг	Хүн ам	Жилийн хэрэглээ /кг/
Завхан	70,231	6,690,556
Архангай	92,597	8,821,253
Булган	60,308	5,745,242
Орхон	101,260	9,646,534
Өвөрхангай	112,755	10,741,605
Нийт		41,645,190





1.13 Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь компанийн засаглалын кодексын хүрээнд дараах журмуудыг эрх бүхий этгээдээр батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2012 оны 4 сарын 27-ны өдрийн ТУ/12 03 тоот тогтоолын хавсралт 1-ээр “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” –ыг баталсан байна.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 1-р хавсралтаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн сангийн хуримтлал ногдол ашиг хуваарилах журам;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 02 дугаар хавсралтаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 03 дугаар хавсралтаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагааны журам;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 4-р хавсралтаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 5-р хавсралтаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам;
- Мөн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот тогтоолын 1-р хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам”, 2-р хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам”, 3-р хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам”.
- 2018 оны 5 сарын 4-ны өдрийн гүйцэтгэх захирлын ту/18-08 тоот тушаалаар 2012 оны 7 сарын 16-ны өдрийн ту/12-10 тоот тушаалаар батлагдсан “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам.


Компанийн сангийн хуримтлал ногдол ашиг хуваарилах журам

Тус журмаар “Хөвсгөл алтан дуулга” ХК нь цэвэр ашгийг дараах сангийн хуримтлал ба ногдол ашигт хуваарилна. Үүнд:

- Гүйцэтгэх удирдлагын урамшууллын сан
- Ажилтнуудын нийгмийн хөгжлийн сан
- Хөрөнгө оруулалт нөөцийн сан
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашиг

Компанийн жилийн санхүүгийн тайланд үндэслэн цэвэр ашгийн хуваарилалтыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) тогтоохоор заажээ.





Сангийн хуримтлал, ногдол ашиг хуваарилах нөхцөл

Ашиг алдагдлын хувь хэмжээ, тухайн жилийн Компанийн төлөвлөгөөнөөс шалтгаалан сангуудад хуваарилах хувийг ТУЗ тогтооно. Сангийн хуваарилалт хийсний дараа цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргахдаа Компанийн тухай хуулийн 47 болон 48 дугаар зүйлийг баримтлана. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, эсхүл Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай ТУЗ-ийн шийдвэрт тусгана. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ шийдвэрлэсэн бол нөхцөл, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана гэж заасан байна.

Ногдол ашиг хуваарилах шийдвэр

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ-ийн шийдвэрт дараах мэдээллийг тусгана гэж заажээ. Үүнд:

- Хувьцаа бүрт ногдол ашгийн хэмжээ
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
- Ногдол ашиг төлөх өдөр


Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн өөрийн хөрөнгө нь ногдол ашиг хуваарилахын өмнөх хэмжээнээс 25- аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

Ногдол ашиг хуваарилалт, тайлагналт

Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгмийн шинжтэй сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг ТУЗ-өөр батлуулж мөрдөнө. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсны дагуу төлбөл зохих ногдол ашгийн дүнгээр өглөгийн данс үүсгэж, нягтлан бодох бүртгэлд тусгана. Ногдол ашгийн ҮЦТХТ-өөр дамжуулан олгож болно. Ногдол ашгийг эд хөрөнгөөр, эсхүл үнэт цаас хэлбэрээр хуваарилах шийдвэрт тус бүрийн үнэлгээг ТУЗ хэлэлцэн баталгаажуулж хавсаргасан байна. Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Биржид хүргүүлэнэ. Мөн дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана гэж заасан байна.

"Хөвсгөл алтан дуулга" ХК нь 2007 онд нэгж хувьцаанд 50 төгрөг, 2015 онд нэгж хувьцаанд 199.70 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

"Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн ногдол ашиг тараасан тухай албан бичгийг үнэт цаасны танилцуулгын хавсралтаар үзэж танилцана. уу





1.14 Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө

Үндсэн зорилго

“Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн газар тариалан ба түүнд түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмж, үр ашгийг сайжруулах, зорилтот зах зээл дэх байр суурийг нэмэгдүүлэх

Үндсэн үйл ажиллагаа

“Хөвсгөл Алтан Дуулга” ХК нь Хөвсгөл аймгийн Тариалан суманд газар тариалан, гурил тэжээлийн үйлдвэрлэл эрхэлдэг.

Хүлээгдэж буй үр дүн

Газар тариалан - Үр тарианы га-аас авах ургац нэмэгдэж, ургац алдах магадлал бууран, таримлын төрөл олширч, хөрсний үржил шим сайжрах
 Гурил тэжээлийн үйлдвэр - Гурил тэжээлийн үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаар ажиллан, түүхий эдийн тогтвортой нөөцтэй болж, зорилтот зах зээлийн хэрэгцээг найдвартай хангах, бүтээгдэхүүний нэр төрөл олшрох
 Бусад боловсруулах үйлдвэр – Шинэ таримлуудад түшиглэсэн боловсруулах үйлдвэр бий болох

Санхүү – Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг 26%-д хүргэх

Хүснэгт 19. Бизнес төлөвлөгөөний хүлээгдэж буй үр дүн

	Сүүлийн 5 жилийн дундаж	2022 онд
Га-ийн ургац	10 цн	16 цн
Таримлын төрөл	4	8-10
Гурилын үйлдвэрийн хүчин чадал ашиглалт	20-30%	90%
Тээрэмдэх улаанбуудай, тн	4152.3	18050.0
Үр тарианы агуулахын багтаамж	4.0 тн	14.0 тн
Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл	13	18-20
Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөж	3.8%	25.9%

Одоогийн хүчин чадал

- Хөвсгөл аймгийн Тариалан суманд 7045 га тариалангийн талбай
- John Deere, New Holland, Flexi Coli, Borgault зэрэг дэлхийн нэртэй үйлдвэрлэгч нарын трактор комбайн, үрлэгч зэрэг газар тариалангийн тоног төхөөрөмжүүд
- Хоногт 100 тн үр тариа тээрэмдэх хүчин чадалтай гурил, тэжээлийн үйлдвэр
- 4000 тн багтаамжтай үр тарианы босоо агуулах, 2500 тн багтаамжтай хэвтээ агуулах, хатаалга, цэвэрлэгээний механикжсан байгууламж
- 600 тн багтаамжтай бэлэн бүтээгдэхүүний агуулах





Төлөвлөгөөний үе шат

1-р үе	<ul style="list-style-type: none"> • 2018-2022 онд одоогийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, өргөжүүлэх
2-р үе	<ul style="list-style-type: none"> • 2022-2024 онд шинэ таримлуудад түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэл байгуулах

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ

Зориулалт	Хэрэгцээ, сая төг
Газар тариалангийн тоног төхөөрөмж авах	538.0
Гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг авах	40.0
Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх	3,166.8
Нийт	3744.8



Санхүүгийн үр ашиг

Хөрөнгө оруулалтын өгөөж 6-26%

Хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа 3 жил





САЛБАРЫН ХӨГЖИЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ



Улаан буудай тариалалт

Монгол улс сүүлийн 5 жилийн дундажаар 350 орчим мянган га талбайд үр тариа тариалсан бөгөөд үүний 330 мянган га орчим талбайд улаан буудай тариалж, га-гаас дунджаар 10.8 орчим центнер буудай хураан авсан байна. Ургац сайн байсан 2008-2014 онд буудайн га-ийн ургац дунджаар 14.8 байсан ба 2015, 2017 онуудад улсын хэмжээнд ургац алдсан нь сүүлийн 5 жилийн га-ийн ургацын үзүүлэлт буурахад нөлөөлжээ. ХХААЯ-ны статистик мэдээгээр 2017 онд 238.1 мянган тонн үр тариа, үүнээс 231.4 мянган тонн буудай хураан авсан нь 2016 оныхтой харьцуулахад 50.5 % бага байна. Буудай боловсрох үед газар тариалангийн бүс нутгуудаар хур тунадас бага орж, ган болсон нь ургац алдахад хүргэсэн байна. Ийнхүү ургац алдсаны улмаас 2018 оны дотоодын буудайн хэрэгцээний 50 орчим хувийг импортоор хангахад хүрч байна.

Хүснэгт 20. Улаан буудайн тариалалт ба ургац хураалт, импортын хэмжээ

	Үр тариа тариалалт	2013	2014	2015	2016	2017*	Дундаж
1	Нийт тариалсан талбай, мян.га	293.3	315.0	390.7	377.8	390.9	353.5
	Нийт хураасан ургац, мян.тн	387.0	518.8	216.3	483.5	238.1	368.7
3	Үүнд: Улаанбуудай тариалсан талбай, мян.га	275.6	291.2	361.2	355.1	365.7	329.8
6	Улаанбуудайн нийт ургац, мян.тн	368.5	488.3	203.9	467.1	231.4	351.8
5	Нийт импортлосон улаанбуудай, мян.тн	0.1	34.2	21.1	158.5	13.6	

График 7. Улаан буудайн үйлдвэрлэл, зорилтод түвшин





Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

2018 оны тариалалтад зориулан аж ахуйн нэгж, иргэд 30 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих сан 24.6 мянган тонн, нийт 54.6 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн бөгөөд хаврын тариалалтад дутагдаж байгаа 10 мянган тонн буудайг 2018 онд импортлохоор ХХААХҮЯ-аас сонгон шалгаруулалт зарласан байна.

Улаан буудай тариалалтыг стратегийн гол бүтээгдэхүүн гэж үзэж сүүлийн 10 гаруй жилд Засгийн газраас Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан үрийн буудайгаар хангах, тоног төхөөрөмж, шатахууныг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, улаан буудайны урамшуулал олгох зэргээр дэмжиж ирсэн. 2016 онд төрөөс үр тарианы үйлдвэрлэлд үзүүлсэн эдгээр дэмжлэгт 33.2 тэрбум зарцуулагдсан байна.

Тариалангийн тухай хуулийг анх 2002 онд баталсан бөгөөд 2006 онд нэмэлт өөрчлөлт орж, 2016 онд шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан хуулиар тариалан эрхлэх, тариалангийн бүс нутгийг тогтоох, тариалангийн газрыг зүй зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, газар тариалан болон мал аж ахуйн харилцан хамааралтай холбогдсон харилцааг зохицуулахаар томъёолсон.

Гурил үйлдвэрлэл

Монгол улсын гурилын жилийн нийт хэрэглээ 270.9 мянган тонн (2016 оны жишсэн хүн амын тоонд үндэслэв) бөгөөд үүний 43 хувийг Улаанбаатар хотын зах зээл, 57 хувийг орон нутгийн зах зээл эзэлдэг. Улсын хэмжээнд жилийн нийт хэрэгцээт гурилын 60%-80%-ийг дотоодын үйлдвэрлэлээс, 20%-40%-ийг импортоор хангадаг. Импортын нийт гурилын 90% орчмыг Оросын холбооны улсаас авдаг.

Улсын хэмжээнд нийт үйлдвэрлэж буй гурилын 60-70%-ийг нэгдүгээр гурил, 20-30 хувийг дээд гурил, 10 орчим хувийг хоёрдугаар гурил эзэлдэг. Нийт 70 орчим компани гурил үйлдвэрлэж буй гэдэг мэдээлэл байгаа бөгөөд суурилагдсан хүчин чадал болон үйлдвэрлэлээр Алтантариа, Улаанбаатар, Од, Милл Хаус, Өег, Өгөөж, Дорнод гурил, Нүүдэлчин групп, Хөвсгөл Алтан Дуулга, Гацуурт зэрэг компанийн үйлдвэрүүд (хоногт 100-300 тн) тэргүүлдэг. Гурилын үйлдвэрүүд нь нийтдээ жилд 1700 орчим мянган тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд хангайн бүсийн гурилын үйлдвэрүүдийн жилийн нийт хүчин чадал 80 мянган тонн юм.

Хөвсгөл аймагт 2017 оны байдлаар 3-4 гурилын үйлдвэр байгаагаас Хөвсгөл Алтан Дуулгын үйлдвэр хамгийн өндөр хүчин чадалтай бөгөөд тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 21. Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Хүн амын хэрэгцээ	253.8	258.7	263.3	267.4	270.9
Дотоодын үйлдвэрлэл	246.5	228.3	206.5	209.7	208.5
Гурилын импорт	23.90	17.50	20.51	30.00	

Эх сурвалж : Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо



"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК




2017 онд гурилын үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 1% буурсан бол борлуулалтын орлого өмнөх оноос 21% өссөн байна.

Хүн амын гурилын хэрэгцээ нь хүн амын өсөлттэй уялдан жил тутам 1.6% орчим өсч байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримлах бодлого

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримлах бодлого"-ыг 2015 онд УИХ-аар баталсан бөгөөд энэхүү бодлогод 2015-2025 онд Хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйг байгалийн аливаа эрсдлээс хамгаалах үйл ажиллагаанд баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан байна. УИХ-ын энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2016 онд Хүнс хөдөө аж ахуйн сайдын тушаалаар "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөө" батлагдсан. Энэ төлөвлөгөөнд суугдсан бөгөөд манай бизнес төслийг хэрэгжүүлэхэд таатай нөлөөлөх зарим бодлогын зорилтуудыг дурьдвал:

- Үр тариа, тэжээл, буурцагт ургамлын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах, экспортын чиг баримжаатай хөгжүүлэх
- Хөрс боловсруулах тэг элдэншүүлгийн технологийг үйлдвэрлэлд үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх болон тариалангийн газрын хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх
- Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримлын үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр хангах, үр, сортын тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх
- Хөрсний бүтэц, үржил шимд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан машин, тракторыг сонгож парк бүрдүүлэх, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, техникийн засвар үйлчилгээний тогтвортой сүлжээ байгуулах
- Эрчимжсэн мал аж ахуйг бүх төрлийн тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх





- Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих
- Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд түрших, нэвтрүүлэх
- Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн инкубатор, загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг тэргүүлэгч аж ахуйн нэгжээр дамжуулан хөгжүүлэх
- Эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх

Бидний боловсруулсан бизнес төлөвлөгөө нь бүхэлдээ төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод нийцсэн, дээрх бодлогын зорилтуудын хэрэгжилтийг дэмжсэн байдлаар боловсруулагдсан.

Үндсэндээ Монгол улсын хүнс ХАА-н салбарын хөгжил, түүний талаар төрөөс баримталж буй бодлого нь энэхүү бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд таатай нөлөө үзүүлэхээр байна.


2018-2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Компани ирэх 4 жилд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, гурил тэжээлийн үйлдвэрлэлийг 3-4 дахин нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, бүс нутгийн хүн амыг эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр тогтвортой хангаж, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн зорилго дэвшүүлсэн. Энэхүү зорилгыг доор задалж харууллаа.

Компанийн 2018-2022 оны үндсэн зорилтууд

Газар тариалангийн үйлдвэрлэл – Байгалийн хүчин зүйлийн үр дагаврыг бууруулах, тариалах талбай болон га-ийн ургацыг нэмэгдүүлэх, таримлын төрлийг нэмэх, хөрсний үржил шимийг сайжруулж, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ

Гурил үйлдвэрлэл – Гурилын үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулж, түүхий эдийн тогтвортой, найдвартай хангалт, хадгалалтыг баталгаажуулж, бүтээгдэхүүний





чанарыг тогтмол өндөр байлган, органик бүтээгдэхүүний стандартыг хангасан шинэ багц бүтээгдэхүүнтэй болох

Тэжээл үйлдвэрлэл – Сэлгээний болон малын тэжээлийн таримлуудыг тариалж, уургийн агууламж өндөртэй малын тэжээл үйлдвэрлэх замаар дайвар бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлэх

Бусад үйлдвэрлэл – Өөрийн болон бүс нутагт тариалагдаж буй таримлуудыг боловсруулж нэмүү өртөг шингээх шинэ бүтээгдэхүүний судалгааг хийж, зах зээлд нэвтрүүлэхэд бэлтгэх

Борлуулалт – Гурилын зах зээлийн хувьд Хөвсгөл аймагтаа тэргүүлэх, ойролцоох бүс нутагт болон УБ хотын зах зээлд 10%-ийг хангах, үүний тулд борлуулалт маркетингийн шинэ бодлого, системийг нэвтрүүлж, тогтвортой мөрдөх

Үр ашиг – Өөрийн хөрөнгийн өгөөжийг 26%–д хүргэх

Хүснэгт 22. Компанийн үр тарианы гүйцэтгэл болон төсөөлөл

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
	гүйцэтгэл				төсөөлөл			
Га-ийн ургац	4.9	13.8	4.4	12.0	13.0	14.0	15.0	16.0
Таримлын төрөл	4	4	4	5	6	7	8	8
Гурилын үйлдвэрийн хүчин чадал ашиглалт	21%	20%	11%	40%	54%	69%	87%	90%
Тээрэмдэх улаанбуудай, тн	4,653	4,066	2,293	8,000	10,800	13,800	17,300	18,050
Үр тарианы агуулахын багтаамж, тн	6,500	6,500	6,500	6,500	6,500	16,500	16,500	16,500
Бүтээгдэхүүний нэр төрөл	10	10	13	13	17	18	19	20
Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөж	- 12.1 %	- 2.7 %	0.4 %	6.1 %	11.5 %	19.2 %	24.9 %	25.9 %

Үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх стратеги

Компанийн газар тариалангийн талаар авах цогц арга хэмжээ:

- Уриншийг багасгаж сэлгээний таримлуудыг тариалах замаар тариалангийн талбайн ашиглалтыг 2 дахин нэмэгдүүлж, хөрсний үржил шимийг сайжруулна.
- Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримлын үр, сортын тариалан, үрийн аж ахуйг хөгжүүлэн бүс нутгийн хэрэгцээг хангана
- Тариалалтын технологийг тэг эдэншүүлэгт шилжүүлж, хөрс хамгаалал, үрийн чанарыг сайжруулах замаар өөрийн талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК



- Хүний нөөцийн чадавх, тариалалтын технологи, таримлын төрлийг сайжруулах, нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл явуулах чиглэлээр олон улсын болон дотоодын мэргэшсэн зөвлөх багуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлнэ
- Таримлын төрөл, технологийн шаардлага, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагаас үүдэн шаардлагатай техникээр хангана

Гурилын үйлдвэрлэлийн үндсэн зорилгуудыг хангах талаар авах цогц арга хэмжээ

- Хөвсгөл аймагт үр тарианы үрийн кластер хөгжүүлэх замаар гурилын түүхий эдийг тогтвортой, чанартай хангалтыг баталгаажуулна /1300 га-д өөрийн үрийн талбайтай/
- Агуулахын хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлнэ.
- Гурилын үйлдвэрт олон улсын ISO 9001, ISO 22000 стандартуудыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарын хяналт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулна
- Алтандуулга брэндийн органик бүтээгдэхүүний тэмдэг авах бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийнэ
- Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, Зэгсэн нэрийн шинэ бүтээгдэхүүний багцыг зах зээлд нэвтрүүлнэ

Тэжээлийн үйлдвэрийн зорилгыг хангах арга хэмжээнүүд

- Малын тэжээлийн чанарыг сайжруулах зорилгоор царгас, вандуй, шош зэрэг уургийн агууламж өндөр ашигт таримлуудыг тариална
- Тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах нэмэлт тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийнэ
- Малчид, фермерүүдийн хэрэгцээнд нийцсэн тэжээл үйлдвэрлэх үүднээс хэрэглэгчийн судалгаа хийж, шинэ хүчит тэжээл үйлдвэрлэнэ.

Гурилын борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх бодлого, стратегийг Маркетинг борлуулалтын төлөвлөгөө бүлэгт тусгайлан оруулав.


Судалгаа, шинжилгээг сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:


- Туршилтын талбайд шинэ таримлуудыг турших, үр үйлдвэрлэх, шинэ тарималд суурилан нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг дотоодын болон ОУ-ын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ

Гурилын үйлдвэрийн SWOT анализ

Хөвсгөл алтан дуулга компанийн гурилын үйлдвэрийг өрсөлдөгчидтэй харьцуулсан шинжилгээг доор харуулав.



ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> Түүхий эд бэлтгэхээс эхлэн эцсийн бүтээгдэхүүний борлуулалт хүртэлх бүхий л шат дамжлагыг хянаж байгаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> Түүхий эдийн чанар, нийлүүлэлтэд хяналт тавьж, 	<ul style="list-style-type: none"> Эргэлтийн хөрөнгө дутагдалтай Хөвсгөл аймгаас бусад зах зээлд бага танигдсан Үйлдвэрлэлийн хэмжээ түүхий эдийн






<p>өртгийг бууруулах боломжтой</p> <ul style="list-style-type: none"> ○ Бүс нутгийн тариаланчидтай олон жил хамтран ажиллаж байгаа нь түүхий эдийн хангалт, чанарыг хянах боломж олгож байгаа ○ Үр тарианы агуулах, үтрэм болон бэлэн бүтээгдэхүүний агуулахтай ○ Гурил, тэжээлийн иж бүрэн, хүчин чадал сайтай тоног төхөөрөмж бүхий үйлдвэртэй ○ Хамгийн том зах зээл болох Хөвсгөл аймаг, УБ хотод борлуулалтын сүлжээгээ шууд хариуцаж байна <ul style="list-style-type: none"> - Баруун ба хангайн бүс нутагт хамгийн өндөр хүчин чадалтай, тогтвортой үйл ажиллагаатай - Мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлсэн - Бүс нутагтаа өөрийн нэрийн бүтээгдэхүүнээр танигдсан - Хувьцаа нь нийтэд нээлттэй арилжигддаг 	<p>нөөцөөс хамаарч жигд бус, хүчин чадлын ашиглалт хангалтгүй байдаг</p> <ul style="list-style-type: none"> - Түүхий эд их хэмжээгээр нөөцлөхөд агуулахын багтаамж хүрэлцэхгүй - УБ хотын зах зээлээс алслагдсан
<p>БОЛОМЖ</p>	<p>АЮУЛ</p>
<ul style="list-style-type: none"> - Газар тариалангийн үйлдвэрлэлтэй хорших замаар гурилаас бусад таримал буюу овъёос, арвай, хөх тариа, буурцагт ургамал зэргийг боловсруулж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах боломжтой - Газар тариалангийн үйлдвэрлэлтэй хамтран үйлдвэрлэлийн тодорхой хэсгийг органик бүтээгдэхүүний чиглэлээр хөгжүүлэх боломжтой - Хангайн бүсэд болон УБ хотод зах зээлээ тэлэх боломжтой - Газар тариалангийн үйлдвэрлэлтэй хамтран уургийн болон шим тэжээлийн агууламж өндөр малын тэжээл үйлдвэрлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> - Байгаль цаг уурын тааламжгүй нөхцлөөс үүдэн ургац алдахад түүхий эдийн нийлүүлэлт хангалтгүй болох - Хамгийн том зах зээлд шинэ өрсөлдөгч бий болох эсвэл одоогийн өрсөлдөгчид халз өрсөлдөх бодлого барих - Үйлдвэрийн хэвийн ажиллагаа доголдоход бүтээгдэхүүний чанар, нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлөх - Галын болон бусад гэнэтийн эрсдэл гарах

Бид гурилын үйлдвэрийн үндсэн түүхий эд улаанбуудайн зөөлөн ба хатуу 7-8 төрлийн сортыг тариалж ингэснээр гурилын цавуулаг, эслэг, уургийн агууламж болон бусад үзүүлэлтүүдийг хэрэглэгчдийн онцлог шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэх, чанар стандартаа тогтвортой байлгах боломжтой байдаг. Үндсэн түүхий эдийн чанарыг өөрийн тариалалтаар дамжуулан хянахаас гадна бүс нутгийн тариаланчидтай хамтран





ажиллах замаар хянах боломжтой. Бид бүс нутагтаа үр тариа, хүнсний үйлдвэрлэлийг кластер байдлаар хөгжихөд манлайлах үүрэгтэй байхаар зорьж байна.

Гурилын үйлдвэрийн SWOT анализад үндэслэн авах арга хэмжээ

Боломжийг ашиглах талаар


- Буудайнаас бусад таримлууд болох хүнсний овъёос, хөх тариа, буурцагт ургамал, царгас зэргийг туршилтын байдлаар тариалах, шинэ таримлуудыг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлэх зорилгоор туршилт судалгааны ажлууд төлөвлөн ажиллаж байна.
- Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан тариалангийн талбайн тодорхой хэсгийг бэлдэж эхлэхээр төлөвлөсөн. Үүнд хөрсний үржил шим сайжруулалт, ургамал хамгаалал, үр бордооны сонголт, тариалах технологи зэрэгт тусгайлан анхаарах юм.
- Хангайн бүсэд болон УБ хотод зах зээлээ аажмаар тэлэх зорилгоор эдгээр зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. Цаашид Зэгсэн нэрийн багц бүтээгдэхүүн гаргахаар бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг судалгааны ажлуудыг эхлүүлсэн. Үүнд төрөл бүрийн баяжуулсан болон хольцтой гурил, бүхэл үрийн гурил, овъёосны гурил, нэвс, арвайн гурил, хөц будаа зэрэг бүтээгдэхүүнүүд хамаарч байна.
- Газар тариалангийн туршилтад вандуй, царгас зэрэг уургийн болон шим тэжээлийн агууламж өндөр ашигт таримлууд багтсан ба туршилтын үр дүнг малын тэжээл үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн


Сул талыг багасгах талаар

- Хувьцаа нэмж гаргаснаар эргэлтийн хөрөнгө нэмэгдэж, түүхий эдээ хангалттай хэмжээгээр нөөцлөн, үйлдвэрлэлийг жигд бүрэн хүчин чадлаар ажиллуулах боломжтой болно
- Компани ашигтай ажилласнаар түүхий эдийн агуулах нэмж барихад шаардагдах санхүүжилт шийдэгдэнэ
- Хөвсгөл аймгаас бусад зах зээлд нэрийн бүтээгдэхүүнийг таниулах цогц төлөвлөгөө гарган ажиллаж байна
- УБ хотын зах зээлд ажиллах багийг бүрдүүлж, өөрийн офисстой болж, борлуулалт, түгээлтийн асуудлыг шийдвэрлэсэн.
- ISO стандартуудыг 2019 онд авахаар төлөвлөн бэлтгэл ажилдаа орсон

Аюулыг зайлуулах талаар

- Байгаль цаг уурын нөлөөллөөс үүдэн ургац алдах эрсдлийг бууруулах зорилгоор газар тариалангийн багц ажлууд төлөвлөгдөж, холбогдох төсөв санхүүжилт нь энэхүү төлөвлөгөөнд суугдсан
- Өрсөлдөх давуу талыг сайжруулахаар борлуулалт, маркетингийн багц ажлууд төлөвлөгдсөн (Гурилын борлуулалт маркетингийн бодлогыг 20-р хуудаснаас үзнэ үү)
- Үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангах үүднээс Дотоод хяналтын албыг байгуулж ХАБЭА, чанарын хяналтын ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Мөн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцсан инженер ажиллаж, сэлбэг хэрэгслийг нөөцийг байнга бэлэн байлгах бодлогыг барьж байна





- Галын болон бусад гэнэтийн эрсдэлийг бууруулах зорилгоор Тариалан суманд байрлах Онцгой байдлын албатай хамтран эрсдлийн үнэлгээ хийлгэж, холбогдох арга хэмжээний талаар төлөвлөгөө гаргаж ажиллана. Дохиолол, хяналтын камерийн асуудлыг иж бүрэн шийдэхээр төсөвт тусгасан болно.

Маркетинг, борлуулалтын төлөвлөлт

Борлуулалтын өсөлтийн төлөвлөгөөг 2018-2022 оноор харуулвал

График 8. 2018-2022 оны үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ



2018 онд гурил ба дайвар бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээг 8.0 мянган тн, борлуулалтын орлогыг 8 тэрбум төгрөгт хүргэх замаар борлуулалтыг өмнөх оноос 249%-иар, 2013 оны борлуулалттай харьцуулвал 72%-иар өсгөх юм. Ийнхүү борлуулалтыг огцом өсгөх боломж Хөвсгөл аймгийн зах зээлийн багтаамж болон манай бүтээгдэхүүний танигдсан байдлаас үндэслэн бүрэн боломжтой ба үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч энэ боломжийг ашиглаж байгаагүй юм.



Одоогийн үйлдвэрлэл борлуулалтын байдалд үндэслэн 2018 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дараахь байдлаар борлуулна гэж тооцсон

- Хөвсгөл аймгийн зах зээлд 6.4 мян.тн
- УБ хотын зах зээлд 1.4 мян.тн
- Бусад аймагт 0.2 мян тн

Түүхий эдийн хангамжийг сайжруулж, борлуулалтын суваг бүрд тохирсон борлуулалт маркетингийн цогц бодлого хэрэгжүүлснээр компанийн Хөвсгөл аймаг дахь зах зээлд эзлэх хувийг 2018 онд 43%-д хүргэж, цаашид өсгөн 2022 он гэхэд 80%-д хүргэх боломжтой гэж төлөвлөлөө.

Компани 2018 онд УБ хотын зах зээлийн 1%-д борлуулалт хийж аажмаар 4 жилийн дотор 5-10%-д хүргэх зорилготой.

Хөвсгөл аймагтай хил залгаа ойр байрлалтай Булган, Завхан, Архангай, Өвөрхангай, Орхон аймгуудад шууд болон худалдааны төлөөлөгчөөр дамжуулан хийх гурил ба дайвар бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ 200 тн-оос 4000 тн хүртэл өсөхөөр төлөвлөгдсөн ба энэ нь тухайн аймгуудын зах зээлийн 8-10%-ийг эзлэх юм.





Алт чанарын дээд Алтан дуулга Алтандуулга гурил

ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

- Хөвсгөл нутгийн шимт сайн хөрсөнд ургасан
- Чанар стандартын шаардлага хангасан орчинд үйлдвэрлэсэн
- 11 сортын буудай хольж боловсруулсан
- Дэвшилтэт техник технологи ашиглан үйлдвэрлэсэн
- Цайруулагч болон нэмэлт чанаржуулагчгүй

НҮҮРС УСНЫ БАЯЛАГ ЭХ ҮҮСВЭР БОЛООД ЗОГСОХҮЙ НАЙРЛАГАДАА

- Уурагт бодис
- В бүлгийн амин дэмүүд
- Кальци, фосфор, төмөр, магнийн эрдэс давсууд
- Фолийн хүчил агуулдаг

ТА ЗАХИАЛ, БИД ХҮРГЭЭ **Хүргэлтийн утас: 7777-4433**
ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

АЛТАНДУУЛГА ГУРИЛААР БҮХ ТӨРЛИЙН ХООЛ ХИЙХЭД ТОХИРОМЖТОЙ

ЦУЙВАН НЬ СЭГСГЭР ТАЛХ НЬ ХӨВСГӨР БУУЗ НЬ ӨРӨОЛТОЙ

БАНШ НЬ БҮХЛЭЭРЭЭ АМИН ДЭМТЭЙ АМТ ЧАНАРТАЙ

ГУРИЛЫГ ГЭРИЙН НӨХЦӨЛД ХАДГАЛАХ ГОРИМ

БУУДАЙН ГУРИЛЫГ

- Агаарын солилцоо сайтай
- +15 градусаас ихгүй температурт
- 60-аас дээшгүй хувийн агаарын харьцангуй чийгшилд
- Нарны шууд тусгалаас хол
- Гадна орчны өвөрмөц үнэр, шороо, чийг, хортон шавжаас хамгаалагдсан саванд хадгална.

БИД БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ

Томоохон рестораноуд, ААН, хувийн сургууль, жижиг цайны газруудын хэрэгцээнд олон жилийн турш нийлүүлж байна.

Бүтээгдэхүүний хольц:

Үйлдвэрлэлийн технологид үндэслэн дээд гурил нийт бүтээгдэхүүний 25%, 1-р гурил 50%, хивэг 20% 3-р гурил ба бүхэл үрийн гурил 5% байхаар тус тус тооцсон

Түүхий эдийн хангалт: 2018 онд өөрийн тариалалтаас 3.3 мян.тн, гаднаас 4.7 мян.тонн буюу нийт 8.0 мян тонн байна. Гаднаас худалдан авах нийт буудайны дийлэнх хувийг 9-10-р сард худалдан авах шаардлагатай. Аажмаар ойролцоох бүсийн тариалан эрхлэгчдээс худалдан авах буудайн хэмжээг өсгөснөөр нийт хэрэгцээний 80%-ийг гаднаас хангахаар төлөвлөж байна. Зөвхөн Хөвсгөл аймаг жил бүр 20 мян.тн-оос доошгүй буудай хураан авч байна. Хөвсгөл ба Булган аймгуудын хэмжээгээр 2016-2017 онд 53.6-

58.9 мян га-д үр тариа тариалж 33.4-76.3 мян тн ургац авч байсан байна.

Савлагааны төлөвлөлт: Дээд, 1-р гурил, бүхэл үрийн гурилын 1-40 кг савлагааг өрхийн хэрэглээнд, 25-40 кг савлагааг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулна гэж үзэж борлуулалтын хандлагад тулгуурлан хуваарилалтыг хийсэн.

4P бодлого

Үйлдвэрлэлийн 4P	Зорилго
Бүтээгдэхүүний бодлого	Үндсэн бүтээгдэхүүний чанарыг тогтвортой сайн байлгах, нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ багц бүтээгдэхүүн гаргах
Үнийн бодлого	Өрсөлдөхүйц байна
Борлуулалтын сувгийн бодлого	Мөрөн хот болон УБ хотод төлөөлөгчийн газартай, бусад аймгуудад гэрээт борлуулагчтай болно.

Урамшуулал, идэвхжүүлэлтийн бодлого

Гэрээт борлуулагчдад чиглэсэн урамшуулал, идэвхжүүлэлтийг хүчтэй болгож том харилцагчид болон сүлжээ дэлгүүрүүдэд шууд тогтвортой нийлүүлэлт хийх



ГУРИЛЫН БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН БОДЛОГО

Гурилын төрөл	Зорилтот зах зээл	Идэвхжүүлэлт	Үнэ	Байршуулалт	Борлуулалтын мөчлөг	Сав баглаа	Ялгарал
Дээд гурил 1-10 кг савлагаатай	Дунд болон дундаас дээш орлоготой өрх	Бөөний борлуулагчдад тэгш боломж олгох Гэрээт борлуулагчдад урамшуулал олгох	Хамгийн өндөр борлуулалттай 3 үйлдвэрийн гурилын (Улаанбаатар, Алтан тариа ба Ургац) үнээс ихгүй байх	Бөөний худалдаачид болон супермаркетуудад байршуулах Зорилтот зах зээлд шууд маркетинг хийх	Өөрчлөлт бага 4-8, 10-12 сар ба Цагаан сарын өмнө хамгийн өндөр, 2 сард хамгийн бага	Цаасан ба нийлэг уутанд Одоогийн нийлэг савлагаагаар	1. “Зэгсэн” нэрийн багц бүтээгдэхүүн гаргах 2. Үнэ гол өрсөлдөгчидтэй өрсөлдөхүйц байх 3. ААН: тогтмол найдвартай нийлүүлэх
1-р гурил 1-40 кг савлагаатай	Өрхийн хэрэглээнд	Бөөний борлуулагчдад тэгш боломж олгох Гэрээт борлуулагчдад урамшуулал олгох	Хамгийн өндөр борлуулалттай 3 үйлдвэрийн гурилын (Улаанбаатар, Алтан тариа ба Ургац) үнээс ихгүй байх	Бөөний худалдаачид болон супермаркетуудад байршуулах	Мөчлөгийн ялгаа багатай	Цаасан ба нийлэг уутанд	1. “Зэгсэн” нэрийн багц бүтээгдэхүүн гаргах 2. Үнэ гол өрсөлдөгчидтэй өрсөлдөхүйц байх

СЭХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
2018.06.29 өдөр
01

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК
29871
ПРОН

ХӨВСГӨЛ АИМАГ
ХӨВСГӨЛ АИМАГ ДУУЛГА ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТББ3216 № 2034565

<p>25-40 кг савлагаатай 40 кг</p> <p>2087</p>	<p>Талх нарийн боов, гоймон, хэрчсэн гурилын үйлдвэр Нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч</p>	<p>олгох</p> <p>Бөөний борлуулалтад интервалууд тогтоож, интервалд хамаарсан татан авалтын урамшуулал олгох</p>	<p>Зах зээлийн үнээс бага зэрэг хямд байх</p>	<p>Зорилтот зах зээлд шууд маркетинг хийх</p>	<p>Цагаан сарын дараагийн сард хамгийн бага, бусад үед ялгаа бага</p>	<p>Одоогийн нийлэг савлагаагаар</p>	<p>ААН-д нийлүүлэхэд дээд гурил аваагүй 1-р гурилыг нийлүүлнэ</p>
<p>3-р гурил</p>	<p>Малчид ба спиртын үйлдвэр</p>		<p>Зорилтот зах зээлд шууд маркетинг хийх</p>	<p>Спирт:</p>	<p>Үнэ өрсөлдөхүйц байна</p>	<p>Одоогийн нийлэг савлагаагаар</p>	<p>Үнэ өрсөлдөхүйц байна</p>
<p>Хивэг</p>	<p>Малчид ба өөрийн тэжээлийн үйлдвэр</p>	<p>Шим тэжээл өндөртэй таримлуудтай хольж тэжээл үйлдвэрлэн малчдад сурталчлан таниулна</p>	<p>Бөөний худалдаачдад байршуулна</p>	<p>Малын тэжээл: Өвөл хавар борлуулалт өндөр</p>	<p>Малын тэжээлийн чанараар ялгарах</p>		
<p>Хүүхдийн будаа</p>	<p>Сургууль цэцэрлэг</p>	<p>Одоогийн хэрэглэгчдэд захиалгаар нийлүүлнэ</p>	<p>Захиалагчдад</p>	<p>8сарын сүүлийн хагас, 9-р сард хамгийн өндөр</p>	<p>Одоогийн савлагаагаар</p>	<p>Одоогийн савлагаагаар</p>	
<p>Бүхэл үрийн ба бусад бүтээгдэхүүн</p>	<p>Өндөр орлоготой өрхийн эзэгтэй Нарийн боовны үйлдвэр</p>	<p>Контент маркетинг хийх туршилтаар хэрэглүүлж, гурилын чанарыг мэдрүүлэх</p>	<p>Гол өрсөлдөгчидтэй өрсөлдөхүйц</p>	<p>Улаанбаатар, Мөрөн</p>	<p>Цаасан уут</p>	<p>1. “Зэгсэн нэрийн бүтээгдэхүүн гаргах</p> <p>2. Үнэ өрсөлдөхүйц байна</p>	

СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
2018.06.29 өдөр
01

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК
2087
2018.06.29 өдөр

ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТБ3216 2034565



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Энэхүү төслийг 2 үндсэн үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөв.

- 1-р үе** •2018-2022 онд одоогийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, өргөжүүлэх
- 2-р үе** •2022-2024 онд шинэ таримлуудад түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэл байгуулах

2018-2022 онд хэрэгжих эхний үе шатанд хэрэгжүүлэх ажлуудыг доор харуулав.

Үе шат	Үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа
Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар		
1	Газар тариалангийн талбайн 1 га тутмаас авах ургацын хэмжээ, ашиг шимийг нэмэгдүүлэх хүчин зүйлийн шинжилгээ судалгааг олон улсын болон дотоодын зөвлөхүүдийн тусламжтай хийж дуусгах	Хэрэгжсэн
2	Газар тариалангийн зөвлөхүүдийн зөвлөмжийн дагуу 2018-2022 оны тариалалтын төлөвлөгөөг эцэслэн баталж, тариалалтын бэлтгэл ажлыг хангах	Хэрэгжсэн
3	Газар тариалангийн нэмэлт тоног төхөөрөмжүүдийг захиалж, хэвийн ажиллагаанд оруулах	Хэрэгжсэн
4	2018 оны хаврын тариалалт, ургамал хамгаалал, уринш боловсруулалт, хашаажуулалт, ургац хураалт	2018 оны 5-10-р сар
5	2018 оны үндсэн, туршилт, үрийн талбайн ургац, үр дүнгийн судалгаа, шинжилгээ хийх, 2019-2022 оны тариалалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, ажилтнуудыг сургалтад хамруулах	2018 оны 11-12-р сар
6	2019-2022 оны тариалалтын бэлтгэл, тариалалт, ургамал хамгаалал, уринш боловсруулалт, хашаажуулалт, ургац хураалт ба бусад ажлууд	2019-2022 он
7	2019-2022 оны үндсэн, туршилтын, үрийн талбайн ургац, үр дүнгийн судалгаа, шинжилгээ хийх, дараа жилийн тариалалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, ажилтнуудыг сургалтад хамруулах	2019-2022 он






“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

8	Газар тариалангийн туршилт судалгааны хүрээлэн байгуулах судалгаа, төлөвлөгөө, бэлтгэл ажил	2020-2021 он
Боловсруулах үйлдвэрлэлийн талаар		
1	2018 оны түүхий эдийн хангалтын төлөвлөгөөний дагуу гэрээ хэлцлүүдийг хийж, татан авалтын хуваарийг гаргах	Хэрэгжсэн
2	Шинэ норм, норматив, цалин урамшууллын систем нэвтрүүлэх, үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хэрэгжиж буй
3	Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршилтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хэрэгжиж буй
6	Олон улсын ISO 9001, ISO 22000 стандарт хангах бэлтгэл ажлууд (ХАБЭА, чанарын хяналтын албыг бэхжүүлэх гэх мэт) хэрэгжүүлэх	Хэрэгжиж буй
7	Үйлдвэрийн нэмэлт тоног төхөөрөмжүүдийг захиалж, хэвийн ажиллагаанд оруулах	2018 оны 5-8-р сар
8	2018 оны шинэ ургацыг хүлээн авах	2018 оны 9-10-р сар
10	Малын тэжээлийн үйлдвэрийг сэргээж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	2018 оны 11-р сараас 2019 оны 8-р сар
11	Үр тарианы босоо агуулах шинээр захиалах, угсрах	2020 оны 5-р сараас 2021 оны 8-р сар
15	2019, 2020, 2021, 2022 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2020-2022 он
Ерөнхий удирдлага, борлуулалтын талаар		
1	НББ-ийн шинэ бодлого, хүний нөөцийн, эрсдлийн удирдлагын болон бусад дотоод журмуудыг шинэчлэн боловсруулж, танилцуулах сургалт зохион байгуулах	Хэрэгжиж буй
2	Борлуулалт, маркетингийн албыг байгуулж, бэхжүүлэх	Хэрэгжсэн
3	Борлуулалт, маркетингийн шинэ системийг баталж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх, Мөрөнд төлөөлөгчийн газар нээх	Хэрэгжсэн
5	Шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэх	2018 оны 10-11-р сар
10	Малын тэжээлийн хэрэглэгчийн судалгаа хийх, шинэ	2018 оны 11-р сараас





	бүтээгдэхүүн хөгжүүлэх	2019 оны 8-р сар
9	2018 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж 2019 оны төлөвлөгөөг эцэслэн батлах	2019 оны 1-р сар
12	Шинэ бүтээгдэхүүний судалгаа, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэл ажлууд	2020-2022 он
13	Органик бүтээгдэхүүний тэмдэг авах бэлтгэл ажлыг хангах	2020-2022 он
14	2019, 2020, 2021, 2022 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, дараа жилийн төлөвлөгөөг эцэслэн батлах	2020-2022 он

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


Компани хувьцаа нэмж гаргаснаар эргэлтийн хөрөнгийн тогтвортой эх үүсвэртэй болох, газар тариалан болон гурилын үйлдвэрийн зарим шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Нэмэлт хувьцаа гаргаж санхүүжүүлэх хөрөнгө оруулалт

Хүснэгт 23. Хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт

Зориулалт	Хэрэгцээ, сая төг	Тайлбар
Газар тариалангийн тоног төхөөрөмж авах	538.0	Өөрөө явагч бодис цацагчийн үлдэгдэл төлбөр 70% - 420.4 сая Чулуу түүгчийн үлдэгдэл төлбөр 70% - 117.6 сая
Гурил тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг	40.0	Гурил савлах төхөөрөмж болон дагалдах бусад сэлбэг – 40 сая
Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх	3,167	Зээл төлөх – 950 сая Буудай худалдан авах – 2,217 сая
Нийт	3,745	

Чулуу түүгч нь АНУ-д үйлдвэрлэгдсэн ба тариалангийн талбайн чулууг түүх зориулалттай. Ингэснээр трактор, үрлэгч, комбайны элэгдэл, эвдрэлийг бууруулж, сэлбэгийн зардлыг багасгах, талбайн тэгшрилтийг сайжруулж га-ийн ургац нэмэгдүүлэх боломж олгодог.



СЭХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018 оны 06 сар 18 өдөр

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Зураг 9. Чулуу түүгч

Чулуу түүгч: Kongskilde Stonebear 520: Авцын өргөн 5.2 м, багтаамж 1.8 м³, тракторын хүч 60 м.х+

Өөрөө явагч бодис цацагч нь Дани улсад үйлдвэрлэгдсэн, ургамал хамгааллын бодис болон шингэн бордоо цацах зориулалттай, 3 дахин богино хугацаанд үр дүнтэйгээр технологийн ажлыг гүйцэтгэх, га-ийн зардлыг бууруулах (шатахуун зарцуулалт 30%, бодисын зарцуулалт 25% хэмнэнэ) боломж олгоно.



Зураг 10. Бодис цацагч

Бодис цацагч: Case IH Patriot 3230: Авцын өргөн 27.3 м, танкны багтаамж 3028 л

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА
2087103
П/ОН-330

ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216 2034565



Эргэлтийн хөрөнгийн хөрөнгө оруулалт

Компани эргэлтийн хөрөнгөө үндсэндээ богино хугацаат зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байна. Энэ нь компанийн санхүүгийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна түүхий эдийн нөөц бүрдүүлэхэд хүрэлцдэггүй. Иймд компани 3,167 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хувьцаа нэмж гаргах замаар санхүүжүүлэхээр төлөвлөв. Ингэснээр 2018 оны зээлийн хүүгийн зардлыг 90 сая төгрөг (жилд 180 сая)-өөр бууруулж, 4300 тн буудай нэмж нөөцлөх боломж бүрдэнэ.

САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Түүхий эд материал

Гурилын үйлдвэрийн үндсэн түүхий эд болох улаанбуудайг 2 эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн.

- Өөрийн газар тариалангийн үйлдвэрлэл
- Бүс нутгийн тариалан эрхлэгчдээс худалдан авах

Компани жил бүр 2900-3000 га-д улаанбуудай тариалах ба га-аас 12-16 центр ургац авахаар төлөвлөсөн. Энэ нь гурилын үйлдвэрийн түүхий эдийн 2018 оны хэрэгцээний 40%-ийг хангах бол 2022 оны хэрэгцээний 20.5%-ийг хангах юм.

Улаанбуудайн үнэ, өртөг нь гурилын үйлдвэрлэлийн ашигт өндөр нөлөөтэй ба гурилын өртгийн 71.9-74.6%-ийг бүрдүүлдэг. Иймд компани өөрийн газар тариалангийн үйлдвэрлэлээс авах буудайн өртгийг бага байлгаснаар түүхий эдийн өртгийг бууруулах боломжтой болно. Энэ нь буудайн ургац ямар байхаас хамаарах тул ургацыг нэмэгдүүлэх, ургац алдах магадлалыг бууруулах чиглэлд газар тариалангийн хөрөнгө оруулалтыг чиглүүлсэн. Бидний тооцоолсноор компанийн тариалсан буудайн өртөг тонн нь 152-300 мян.төг байна.

Нөгөө талаар өөрийн тариалалтаас авах буудай нь гурилын үйлдвэрийн хэрэгцээг бүрэн хангахгүй тул ойролцоох бүс нутгийн тариалан эрхлэгчдээс буудай худалдан авахаар төлөвлөсөн ба 1 тонн буудайн үнийг олон жилийн дунджын орчим буюу 500.0 мян төг байхаар тооцлоо. Худалдан авах буудайн үнийг тогтмол байлгахын тулд компани хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байх хэрэгтэй ба ингэснээр намар ургац хураалт эхлэхээс өмнө тариаланчидтай гэрээ байгуулж урьдчилгаа төлөх, дараах төлөлтүүдийг хуваарийн дагуу 5 сарын дотор барагдуулах боломжтой болно. Мөн өөрийн үрийн аж ахуйгаас хаврын тариалалтад зориулж үр нийлүүлэн намрын ургацаар тооцоо хийх замаар буудайн нийлүүлэлтийг баталгаажуулах бодлого барьж байна.

Үйлдвэрлэл

Компанийн газар тариалан болон гурилын үйлдвэрлэл нь олон жил тогтвортой үйл ажиллагаатай, хүний нөөц хангалттай, техник технологи нь шинэчлэгдсэн тул





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

хөдөлмөрийн болон зардлын норм норматив нь тогтсон, төсөв төлөвлөгөө нь харьцангуй бодитой хийгдэх боломжтой байдаг.

Ажиллагсдын цалин, урамшууллыг 2018 онд ажлын байрны ялгавартайгаар 20-80 хувь нэмэхээр төсөвлөсөн тул дараагийн жилүүдэд цалинг тогтмол байхаар, ажилласан жилийн нэмэгдэл жил тутам 1%-иар өсөхөөр тооцов. Төсөвлөгдсөн хөдөлмөрийн зардал нь гурилын нийт өртгийн 8.1%, улаанбуудайн нийт өртгийн 11.6%-иас хэтрэхгүй байна.

Гурилын өртөгт үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал 15.1-15.8%-ийг эзэлдэг ба үүний дийлэнх нь сав баглаа боодлын зардал байдаг. Сав баглаа боодлын зардал нэмэгдвэл бүтээгдэхүүний үнэнд шингээхээр тооцов.

Гурилын үйлдвэрлэл жил тутам нэмэгдэх тул үйлдвэрийг 2 ээлжтэйгээр зохион байгуулж, 1 ээлжийн хоногт тээрэмдэх буудайн нормыг 30 тн гэж тооцлоо.

Хүснэгт 24. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гүйцэтгэл болон төсөөлөл

Бүтээгдэхүүн, тонн	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Тээрэмдэх буудай, тн	4,653	4,066	2,293	8,000	10,800	13,800	17,300	18,050
1-р ба дээд гурил, тн	3,525	3,040	1,742	5,400	7,290	9,314	11,677	12,183
3-р гурил, 25 кг, тн	232	176	100	360	486	621	779	812
Хивэг, 25 кг, тн	866	849	449	1,440	1,944	2,484	3,114	3,249
Бүхэл үрийн гурил, тн				800	1,080	1,380	1,730	1,805

Борлуулалт

Өнөөг хүртэл компанийн үйлдвэрлэлийн хэмжээ хязгаарлагдмал байсан тул борлуулалтын үйл ажиллагаанд харьцангуй бага анхаарч ирсэн. Харин 2018 оноос үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ огцом нэмэгдэхээр төлөвлөсөнтэй уялдуулан борлуулалт, маркетингийн системийг шинэчилж, иж бүрэн хөтөлбөр хэрэгжүүлэхээр шинэ албыг байгуулсан. Мөн гол зах зээл болох Мөрөн хот, Улаанбаатар хотод өөрийн төлөөлөгчийн газрыг байгуулсан. Ингэснээр борлуулалтын сувгийг өрөгжүүлэх боломжтой болсон.

Борлуулалт, маркетингийн зардал нь нийт борлуулалтын орлогын 3 хувиас хэтрэхгүй байхаар төсөвлөв.

Бүтээгдэхүүний үйлдвэрийн үнийг 2018 онд 12% бууруулж өрсөлдөх түвшинд хүргэх ба түүнээс хойш тогтмол байхаар тооцсон.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Төсөвлөгдсөн орлого үр дүн

	2018	2019	2020	2021	2022	ДҮН
сая төгрөг						
САНХҮҮГИЙН ОРЛОГО, сая төг						
Үр тариа, тэжээлийн борлуулалт	1,581	1,817	1,994	2,171	2,349	9,912
Гурилын борлуулалт	6,388	8,406	10,741	13,465	14,049	53,050
НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО	7,969	10,223	12,735	15,637	16,398	62,962
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,487	7,635	9,060	10,931	11,290	45,403
НИЙТ АШИГ	1,482	2,588	3,676	4,706	5,108	17,559
Боловсон хүчний холбогдолтой зардал	232	235	237	240	242	1,186
Ерөнхий удирдлагын бусад зардал	443	501	525	602	621	2,692
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	675	735	763	842	863	3,878
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ	806	1,853	2,913	3,864	4,245	13,681
Зээлийн хүүгийн зардал	214	126	36	36	36	448
Ердийн бус орлого зардал	115	120	125	135	145	640
ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО	707	1,847	3,002	3,964	4,353	13,872
Татварын зардал	71	185	300	396	435	1,387
ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	636	1,662	2,702	3,567	3,918	12,485

Хүснэгт 25. Төсөвлөгдсөн орлого үр дүн

Борлуулалт, маркетингийн алба байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор холбогдох зардал (2018 онд 224 сая төг) нь ерөнхий удирдлагын зардалын төсөвт орж ирсэн. Мөн ажиллагсдын цалин нэмэгдсэн (2018 оны цалингийн сан өмнөх оноос 40% өссөн) зэргээс үүдэн ерөнхий удирдлагын зардлын төсөв 2017 оны түвшингээс 86% өсөж төсөвлөгдсөн болно. Цаашид ерөнхий удирдлагын зардлыг нийт борлуулалтын орлогын 5%-иас хэтрүүлэхгүй байх зорилготой.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Төсөвлөгдсөн мөнгөн гүйлгээ

Мөнгөн гүйлгээ, сая төг	2018	2019	2020	2021	2022	ДҮН
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ						
Мөнгөн орлогын дүн (+)	8,084	10,343	12,860	15,772	16,542	63,602
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,969	10,223	12,735	15,637	16,398	62,962
Буудайн урамшуулал	104	113	122	131	139	609
Бусад мөнгөн орлого	10	7	3	5	5	31
Мөнгөн зарлагын дүн (-)	9,122	8,537	10,996	12,070	12,810	53,535
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	7,543	7,576	9,984	10,883	11,614	47,600
Ерөнхий удирдлагын зардалд төлсөн	327	348	358	368	373	1,774
Маркетинг, борлуулалтын үйл ажилалгаанд төлсөн	224	252	269	337	351	1,432
Хүүний төлбөрт төлсөн	214	126	36	36	36	448
Татварын байгууллагад төлсөн	71	185	300	396	435	1,387
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө						-
Бусад мөнгөн зарлага	743	50	50	50	-	893
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,038)	1,807	1,864	3,702	3,732	10,067
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ						
Мөнгөн орлогын дүн (+)	-	-	-	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	861	50	655	930	-	2,496
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	861	50	655	930	-	2,496
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(861)	(50)	(655)	(930)	-	(2,496)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ						
Мөнгөн орлогын дүн (+)	5,245	-	-	-	-	5,245
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,500	-	-	-	-	1,500
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,745	-	-	-	-	3,745





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Мөнгөн зарлагын дүн (-)	3,505	1,940	1,123	2,750	3,725	13,042
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,505	1,000	-	-	-	4,505
Төлсөн ногдол ашиг	-	940	1,123	2,750	3,725	8,538
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,740	(1,940)	(1,123)	(2,750)	(3,725)	(7,798)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(160)	(183)	86	22	7	(228)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	506	347	164	250	271	506
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	347	164	250	271	279	279


Хүснэгт 26. Төсөвлөгдсөн мөнгөн гүйлгээ

Мөнгөн урсгалын төсөөллөөр 2018-2019 онд зээлийн өрийг үндсэнд нь барагдуулж, 2019-2022 онуудад нийт 8.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Үүнд гол хувьцаа эзэмшигч Тэс трейд 2019-2020 онд авах ногдол ашгийн авлагаа 2022 он хүртэл хойшлуулж, бусад хувьцаа эзэмшигчиддээ жил бүр ногдол ашиг авах боломжийг олгож байгаа юм.

Тайлан тэнцлийн төсөөлөл

Хүснэгт 27. Тайлан тэнцлийн төсөөлөл

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бэлэн Мөнгө	4	50	506	347	164	250	271	279
Авлага	594	441	1448	298	298	298	298	298
Бараа Материал	794	1426	1145	2486	3407	4921	5486	6420
Бусад эргэлтийн хөрөнгө	135	174	122	415	5	5	5	5
Нийт эргэлтийн хөрөнгө	1527	2091	3221	3546	3874	5474	6060	7002
Газар	463	463	3387	3387	3387	3387	3387	3387
Барилга	1181	1181	5236	6386	6436	6936	7866	7866
Тоног төхөөрөмж, машин	5225	5209	13054	13905	13905	14060	14060	14060
Тавилга, эд хогшил	41	46	41	51	51	51	51	51
Нийт үндсэн хөрөнгө ба газар	6910	6899	21717	23729	23779	24434	25364	25364
Элэгдэл	2006	2514	10431	11135	11840	12566	13315	14064
Цэвэр үндсэн хөрөнгө	4904	4385	11287	12594	11938	11868	12049	11300
Барааны тэмдэг ба хөрөнгө оруулалт	3	4	185	185	185	185	185	185
НИЙТ ХӨРӨНГӨ	6434	6480	14693	16326	15998	17527	18294	18487
Богино хугацаат зээл	1,863	1,994	3,205	0	0	0	0	0
Дансны өглөг	935	598	631	276	226	176	126	126
Бусад богино хугацаат өглөг	25	116	206	206	206	206	206	206
Нийт богино хугацаат өглөг	2823	2708	4043	483	433	383	333	333
Урт хугацаат зээл	191	541	0	1200	200	200	200	200





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Бусад урт хугацаат өглөг	202	202	202	202	1312	2639	2639	1664
Нийт урт хугацаат өглөг	393	743	202	1402	1512	2839	2839	1864
Нийт өр төлбөр	3217	3451	4244	1885	1945	3222	3172	2197
Хувьцаа	102	102	102	157	157	157	157	157
Нэмж төлөгдсөн капитал	0	0	0	3301	3301	3301	3301	3301
Хөрөнгийн дахин үнэлгээ	0	0	7383	7383	7383	7383	7383	7383
Хуримтлагдсан Ашиг	3115	2926	2963	3599	3211	3463	4281	5448
Нийт өөрийн хөрөнгө	3218	3029	10449	14441	14053	14305	15122	16290
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	6434	6480	14693	16326	15998	17527	18294	18487

Бидний төлөвлөгөөгөөр нийт өр төлбөр активын харьцаа 2017 онд 29% байсныг 12% хүртэл бууруулж компанийн хөшүүргийг сайжруулах юм. Мөн ажлын капитал хасах дүнтэй байгааг 2022 он гэхэд 6.7 тэрбум төг хүртэл нэмэгдүүлнэ.

Хүлээгдэж буй санхүүгийн үр дүнгүүд

Хүснэгт 28. Хүлээгдэж буй санхүүгийн үр дүнгүүд

	2018	2019	2020	2021	2022
Хувьцааны дансны үнэ, төг	918	893	909	961	1,035
Хувьцааны гаргах үнэ, төг	850	850	850	850	850
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	40	106	172	227	249
Ашгийн үнэлгээ (P/E)	21	8	5	4	3
Цэвэр ахиуц ашиг	8%	16%	21%	23%	24%
Нийт хөрөнгийн эргэц	54%	63%	80%	89%	90%
ROA	4.3%	10.2%	16.9%	20.4%	21.4%
ROE	6.1%	11.5%	19.2%	24.9%	25.9%
Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг, төг		130	156	175	175
Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг, %		15.3%	18.3%	20.6%	20.6%
Дансны үний өсөлт		-2.7%	1.8%	5.7%	7.7%
Хувьцааны нийт өгөөж		12.6%	20.1%	26.3%	28.3%

Компанийн эргэлтийн хөрөнгө нэмэгдэж, борлуулалт өссөнөөр хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөж тогтвортой өсөх боломж бүрдэнэ. Компани 2018-2019 онуудад тухайн жилийн цэвэр ашгаас давсан хэмжээний ногдол ашиг хуваарилахаар төлөвлөсөн ба энэ нь компанийн өнгөрсөн хугацааны хуримтлагдсан ашгаас шинэ хувьцаа эзэмшигчид хүртэх боломжийг олгож буй явдал юм.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Мэдрэмжийн шинжилгээ

Ургацын нөлөөлөл

Гурилын үйлдвэрийн үндсэн түүхий эд болох улаанбуудайн тодорхой хэсгийг компани өөрийн ургацаар хангадаг. Төлөвлөгөөнд 5 жилийн дундаж га-ийн ургацыг 12-13 цн байхаар тусгасан. Хэрэв энэ төлөвлөсөн ургац 9-10 цн болж буурвал компанийн төсөвлөгдсөн орлого үр дүн ба мөнгөн гүйлгээнд хэрхэн нөлөөлөхийг мэдрэмжийн шинжилгээгээр судлахад доорх үр дүн гарч байна.

2018-2022 оны	Га-ийн ургац 12-16 цн	Га-ийн ургац 9-13 цн	Бууралт, %
Төсөвлөгдөн ашиг, сая төг	12,485	10,384	16.8%
Төсөвлөгдөн мөнгөн хөрөнгө, сая төг	279	-1,886	100%

Ургац буурахад төсөвлөгдсөн ашигт харьцангуй бага нөлөөлөлтэй боловч мөнгөн хөрөнгийг ихээхэн бууруулж, дутагдалд хүргэж байна.

Гурилын үнийн нөлөөлөл

Гурилын зах зээл дээр өрсөлдөөн ширүүсч үйлдвэрийн үнэ буурвал компанийн төлөвлөсөн ашиг болон бэлэн мөнгөнд ямар нөлөөтэй болохыг харуулах үүднээс үйлдвэрийн гурилын үнийг 5% бууруулж үзлээ.

2018-2022 оны	1-р гурилын үнэ кг нь 810 төг	1-р гурилын үнэ кг нь 779 төг	Бууралт, %
Төсөвлөгдөн ашиг, сая төг	12,485	11,011	11.8%
Төсөвлөгдөн мөнгөн хөрөнгө, сая төг	279	-1,146	100%

Гурилын үнэ буурахад төсөвлөгдсөн ашигт харьцангуй бага нөлөөлөлтэй боловч мөнгөн хөрөнгийг ихээхэн бууруулж, дутагдалд хүргэж байна.

Мэдрэмжийн шинжилгээнд үндэслэн дүгнэхэд ургац болон гурилын зах зээлийн үнэ төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл гарахад компани ногдол ашгийг төлөвлөсөн хэмжээнээс бууруулж олгох шаардлагатай болно.





1.15 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдлийн удирдлагын төлөвлөгөө

“Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанид учирч болох эрсдэл ба боломжууд, тэдгээрийн тохиох магадлал, үр дагавар, эрсдэл ба боломжийг хянах, удирдах арга замуудыг дараахь байдлаар томъёолж байна.

Эрсдэл/Боломж	Магадлал	Үр дагавар	Удирдах арга зам
<i>Үндсэн үйлдвэрлэлтэй холбоотой</i>			
Байгаль цаг уурын нөхцлөөс үүдэн га-ийн ургац буурах/өсөх	дунд	бага-дунд	Тариалалтын технологийг сайжруулах Хашаажуулах Үрийн чанарыг сайжруулах Ургацын даатгалд хамрагдах боломжийг судлах
Бүс нутгийг хамарсан ургац алдалт	бага	дунд-их	Буудайг өөр бүс нутгаас эсвэл импортоор татан авах
Үйлдвэрийн хэвийн ажиллагаа доголдох, ХАБЭА-н асуудал гарах (тоног төхөөрөмж эвдрэх, ЦЭХ-ний хангамж доголдох, гадны биет бүтээгдэхүүнд орох, аюулгүй ажиллагаа зөрчигдөх г.м)	дунд	бага-дунд	ХАБЭА, чанарын хяналт, лаборатор хариуцсан дотоод хяналтын албыг бэхжүүлэх Сэлбэг хэрэгслийн нөөцийг сайжруулах Инженер техникийн багийг бэхжүүлэх
Галын болон бусад гэнэтийн аюул гарах	дунд	дунд- маш их	Сумын онцгой байдлын албатай хамтран эрсдлийн үнэлгээ хийлгэж, авах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах Дохиолол, хяналтын камерийн асуудлыг иж бүрнээр шийдэх Хөрөнгийн даатгалд хамрагдах
Худалдааны төлөөлөгч эсвэл гэрээт борлуулагчид бэлэн	дунд	бага	Санхүүгийн хяналт, шалгалтыг сайжруулах





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

мөнгө шамшигдуулах	Бэлэн бус төлбөр тооцоог дэмжих Цалин, урамшуулал, хариуцлагын системийг сайжруулах
--------------------	--


Макро эдийн засаг, зах зээлтэй холбоотой эрсдэл

Гурилын зах зээлд үнийн өрсөлдөөн ширүүсэх, зарим гурилын үйлдвэрүүд хаагдах	дунд	дунд-их	Борлуулалтын шинэ систем, 4P бодлогыг тогтвортой мөрдөх Түүхий эдийн хангалтыг найдвартай байлгах Хаагдсан, зогссон үйлдвэрүүдийг нэгтгэх
Хувьцаа гаргалт амжилтгүй/амжилттай болох	бага	дунд-их	Амжилтгүй бол санхүүгийн өөр эх үүсвэрийг ашиглах
Шатахуун, ЦЭХ, бусад түүхий эдийн үнэ огцом нэмэгдэх	дунд	бага-дунд	Бүтээгдэхүүний үнэнд шингээх /өрсөлдөгчдийн байр суурийг харгалзана/ Дериватив хэрэгслийг судлах Шатахууныг урьдчилж нөөцлөх
УБ-ын зах зээлд нэвтрэлт амжилтгүй/амжилттай болох	дунд	бага-дунд	Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг дахин шүүж, шинэчлэх
Газар тариалан, гурилын үйлдвэрлэлд төрийн зохицуулалт нэмэгдэх/буурах	дунд	дунд-их	Зохицуулалтад нийцэж ажиллах Бусад боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Эрсдлийн үнэлгээний матриц

		Үр дагавар			
		Бага	Дунд	Их	Маш их
Магадлал	Бага				
	Дунд				
	Их				
	Маш их				





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

1.16 Хөрөнгийн үнэлгээ

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2017 оны 12-р сарын 22-нд “БДО Аудит” ХХК-тай үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, биет болон биет бус хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн. “БДО Аудит” ХХК нь биет болон биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо зах зээлийн хандлага, орлогын хандлага, өртгийн хандлагын аргаар авч үзсэн байна.

Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл

Хүснэгт 29. Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл

Хөрөнгийн бүлэг	Индексжүүлсэн нормативт өртгийн арга	Орлого капиталжуулах арга		Зах зээлийн харьцуулалтаар	Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ
		Цэвэр түрээсийн өгөөж	Бохир түрээсийн өгөөж		
Газар эзэмших эрх	1,751,497,000	1,754,294,000	2,674,330,000	2,334,802,000	2,128,731,000
Барааны тэмдэг	-	-	-	-	184,339,000
Барилга, байгууламж	5,521,529,000	3,518,284,000	3,451,314,000	2,972,374,000	4,452,633,000
Тоног төхөөрөмж	4,509,631,000	4,603,442,000	4,600,498,000	4,272,841,000	4,301,549,000
Нийт үнэлгээ	11,782,657,00	9,876,020,000	10,726,142,000	9,580,017,000	11,157,252,000

Үнэ цэнийн дүгнэлт

“БДО Аудит” ХХК-ийн гүйцэтгэсэн үнэлгээний шинжилгээгээр “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний байдлаарх Газар эзэмших эрх нь 2,128,731,000 (хоёр тэрбум нэг зуун хорин найман сая долоон зуун гучин нэгэн мянган) төгрөг, Барааны тэмдэг нь 184,339,000 (Нэг зуун наян дөрвөн сая гурван зуун гучин есөн мянган) төгрөг, Барилга байгууламж нь 4,542,633,000 (дөрвөн тэрбум таван зуун дөчин хоёр сая зургаан зуун гучин гурван мянган) төгрөг, Машин тоног төхөөрөмж нь 4,301,549,000 (Дөрвөн тэрбум гурван зуун нэг сая таван зуун дөчин есөн мянган) төгрөгийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнэтэй байх үндэслэлтэй байна.” гэсэн байна.

Хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралтаас үзэж танилцана уу.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

1.17 Бизнесийн үнэлгээ

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2017 оны 12-р сарын 22-нд “БДО Аудит” ХХК-тай үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, бизнесийн үнэлгээг хийлгэсэн байна. “БДО Аудит” ХХК нь бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо зах зээлийн хандлага болон орлогын хандлагыг авч үзсэн байна. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд жишиг компанийн арга зүйл болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаарх үнэлгээнд хорогдуулсан мөнгөн гүйлгээний загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцсон байна.

“БДО -Аудит” ХХК бизнесийн үнэ цэнэд дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

Бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнийн дүгнэлт

- Бид мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгаасны үндсэнд дээр дурдсан арга хандлагуудаас Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүн нь үнэлгээний өдрөөр байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн.
- Тохируулсан цэвэр активын арга (ТЦАА)-аар тооцсон бизнесийн үнэ цэнэ буюу үнэлгээний өдөр компанийн хөрөнгийг зарж борлуулснаас олох эдийн засгийн өгөөжийг зах зээлийн харьцуулалтын арга тайлбарлаж чадахгүй байсан тул тасралтгүй байх төсөөлөл бүхий бизнесийн үнэ цэнийг төлөөлөх чадваргүй гэж үнэлгээний баг дүгнэсэн.
- “Хөвсгөл алтан дуулга” ХК нь үнэлгээний өдрийн байдлаар 3,406,508 мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөртэй, 506,452 мянган төгрөгийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөтэй тул бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнэ **18,228,596-21,244,239** мянган төгрөгийн хооронд байх үндэслэлтэй байна.

Бизнесийн 100%-ийн өмчийн хувь оролцооны үнэ цэнэ

Хүснэгт 30. Бизнесийн үнэлгээний дүн

		мянган төгрөг	
Орлогын хандлага	ХМУ загвар	Дээд	21,244,239
		Доод	18,228,596
Зах зээлийн хандлага	ЖКАЗ	Дээд	18,799,991
		Доод	14,111,492
	ЖКАЗ	Дээд	22,439,056
		Доод	20,067,972
Хөрөнгийн хандлага	ТЦАА		10,448,530

Бизнесийн үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралтаас үзэж танилцана уу.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

1.18 Хууль зүйн дүгнэлт

Үнэт цаас гаргагч “Хөвсгөл алтан дуулга” ХК нь нэмж хувьцаа гаргах, түүнтэй холбогдуулан үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-тэй 2018 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна.

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-өөс дараах асуудлыг хамруулан дүгнэлт гаргасан байна

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх,
2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар,
3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх,
4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх,
5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх
6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх
7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх,
8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх,
9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох,
10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа
11. Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ
12. Гол дүгнэлт.

Хууль зүйн дүгнэлтийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК




ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Хоёр. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2.1 Үнэт цаасны тухай


Үнэт цаас гаргагч	“Хөвсгөл Алтандуулга” ХК
Үнэт цаас гаргагчийн үсгэн болон тоон код	ADU/402
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	11,328,600 ширхэг
Нэрлэсэн үнэ	10 төгрөг
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	4,405,600 ширхэг
Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	15,734,200 ширхэг
Нэмж гаргаж буй хувь	28.0%
Нэгж хувьцааны санал болгох доод үнэ	850 төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны тоо	3,228,600 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо	1,177,000 ширхэг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ	3,744,760,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Газар тариалан болон гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, зээлийн эх үүсвэрийг бууруулах, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтанд зарцуулагдана.
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох арга	Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер хүлээн авч хуваарлана.
Олон нийтэд санал болгох арга хэлбэр	Захиалгын бүртгэлийн аргаар санал болгон худалдана
Андеррайтер	“Бумбат Алтай ҮЦК” ХХК
Төлбөр, тооцоо	“Арилжааны Төлбөр Тооцоо” ХХК
Үнэт цаасны хадгаламж	“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК
Арилжаалах зах зээл	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК





2.2 Нэмж гаргаж буй хувьцааны тухай

Компанийн тухай хуулийн 62.1.3 заасны дагуу “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж хувьцаа гаргах тухай асуудлыг хэлэлцэн, “Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, Төлөөлөн удирдах зөвлөлд зарим бүрэн эрх олгох тухай” 2 тоот тогтоолыг баталсан болно. Уг тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.



Нэмж хувьцаа гаргаснаар хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах өөрчлөлт орно. Үүнд:

Хүснэгт 31. Хувьцаа эзэмшигчдийн бүтэцийн өөрчлөлт

Хувьцаа эзэмшигчдийн нэрс:	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Нэмж хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо	Эзэмших хувь
“Тэс трейд” ХХК	7,997,200	70.59%	7,997,200	50.83%
М.Золзаяа	886,100	7.82%	886,100	5.63%
Д.Дуламсүрэн	523,800	4.62%	523,800	3.33%
Бусад хувьцаа эзэмшигч	1,921,500	16.96%	1,921,500	12.21%
Шинэ хувьцаа эзэмшигч			4,405,600	28%
Нийт	11,328,600		15,734,200	





2.3 Эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэр

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, 39-2 Финтек оффисын хурлын зааланд болж, хурлаар

- Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах,
- Нэмж хувьцаа гаргах тухай, хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай
- Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай,
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай,
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцсэн.

Компанийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигчдийн 86.93% оролцсноор хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 100% хурлаар хэлэлцэж буй асуудлуудыг зөвшөөрсөн шийдвэрийг гаргасан.

Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас “Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, төлөөлөн удирдах зөвлөлд зарим эрх олгох тухай” №2 тоот тогтоолыг баталсан байна. Уг тогтоолоор дараах шийдвэрүүд гаргасан. Үүнд:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргахыг,
2. Хувьцаа нэмж гаргах төслийг хавсралтаар батлаж,
3. Нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдож буй тул хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг батлах, хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, нэмж гаргах хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох,
4. “Хөвсгөл алтан дуулга” ХК -ийн нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг СЗХ болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай харилцах ажлыг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосон,
5. Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай болсон тохиолдолд дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 2019 онд зохион байгуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр тус тус шийдвэрийг гаргасан.

Мөн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай асуудлаар хэлэлцэн, тус компанийн нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, тогтоол шийдвэр, холбогдох баримт материалын дэлгэрэнгүйг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.

2.4 Нэмж гаргаж буй хувьцааны үнэ тогтоосон үндэслэл, тооцоолол

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны үнэ тогтоосон үндэслэл

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 4,405,600 ш хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэсэн билээ.

Мөн компани хувьцаа нэмж гаргахын өмнө нэгж хувьцааг 100 хуваах хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргаж холбогдох зөвшөөрлийг авснаар компани нэг бүр нь 1000 төг-ийн нэрлэсэн үнэтэй 113,286 ш хувьцаатай байсан бол нэг бүр нь 10 төг-ийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай болсон. Ийнхүү хувьцааг хуваах замаар хувьцааны ширхгийг нэмэгдүүлснээр хувьцааны хөрвөх чадвар сайжирч МХБ дээрх хувьцааны арилжаа идэвхжих боломж бүрдсэн.

Компани нэмж гаргах хувьцааны үнийг тогтоохдоо дараах үндэслэлүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

1. Компанийн бизнесийн үнэлгээ
2. Компанийн хөрөнгийн үнэлгээ
3. Хувьцааны зах зээлийн үнэ
4. Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ
5. Шинээр гаргах хувьцааны нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувь харьцаа
6. Хувьцааг арилжих хэлбэр

Компанийн бизнесийн үнэлгээ

Компани 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон бизнесийн үнэлгээг “БДО Аудит” ХХК-иар хийлгэсэн. Бизнесийн үнэлгээ нь орлогын хандлага, зах зээлийн хандлага, хөрөнгийн хандлага гэсэн 3 аргачлалыг авч үздэг. “БДО Аудит” ХХК орлогын хандлагаарх үнэлгээ буюу хорогдуулсан мөнгөн гүйлгээний загварын үр дүнг манай бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж үзсэн байна. Энэ үнэлгээгээр компанийн бизнесийн өмчид хамаарах үнэ цэнэ нь 18.2-21.2 тэрбум төгрөгт үнэлэгдэж байна. Бизнесийн үнэлгээгээр нэгж хувьцаа 1159-1350 төгрөгийн үнэ цэнээр үнэлэгдэж байна.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Компанийн хөрөнгийн үнэлгээ

Компани 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон биет ба биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг “БДО Аудит” ХХК-иар хийлгэсэн. Энэ нь компани хувьчлагдсанаас хойш анх удаа хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж байгаа онцлог үйл ажиллагаа юм.

Хөрөнгийн үнэлгээ нь компанийн үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, газар эзэмших эрх болон барааны тэмдгүүдийг хамарсан.

Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо зах зээлийн хандлага, орлогын хандлага, өртгийн хандлагыг авч үзсэн байна. Компанийн биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнэ 11,157,252 мянган төгрөгт үнэлэгдсэн. Энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаснаар компанийн хувьцаа эзэмшигчдийн өмчид хамаарах хөрөнгө буюу өөрийн хөрөнгө нь 10,448,530 мянган төгрөг болж байна. Ингэснээр компанийн нэгж хувьцааны дансны бүртгэлийн үнэ 922 төгрөгтэй байна.

Хувьцааны зах зээлийн үнэ

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь МХБ-ийн 3-р самбарт бүртгэлтэй, хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг билээ. 2018 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн байдлаар компанийн хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш 5017 төгрөг байна. Хувьцаа хуваагдахаас өмнө хамгийн сүүлийн арилжаа хийгдсэн өдөр буюу 2018 оны 5-р сарын 4-ний өдрийн хувьцааны ханш нь 9305 төгрөг байна. Компанийн хувьцаа хуваагдсан байдлаар тооцож үзэхэд хувьцааны зах зээлийн ханш нь 93.05 төгрөг болж байгаа нь хувьцааны бүртгэлийн үнээс 10 дахин доогуур байгаа ба энэ нь дараах шалтгаануудтай холбоотой гэж үзэж байна.

- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн энгийн хувьцаа МХБ-д анх бүртгэгдсэн үнэ 100 төгрөг байсан нь компанийн хувьцаат капиталын дүнг зөв илэрхийлээгүй байсныг хөндлөнгийн аудитын байгууллагууд тодорхойлсон. Энэ үнэ нь 1996 оны Төрийн өмчийн хорооны тооллогоор тогтоосон хувьцаат капиталын дүнг 9 дахин бууруулсан үнэ байсан ба энэхүү зөрүүг залруулах хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргаж 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдөр шийдвэрлүүлээд байна. Ингэснээр манай хувьцааны нэрлэсэн үнэ хувьцаа хуваагдахаас өмнөх 1000 төгрөг байсан ба хувьцааг 100 хувааснаар хувьцааны нэрлэсэн үнэ 10 төгрөг болсон.
- Компанийн хувьцааны 70.59%-ийг “Тэс трейд” ХХК-д 1998 онд төрийн өмчийн дуудлага худалдаагаар худалдан авч хувьцааны 70,59% төвлөрсөн бөгөөд бусад хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь хөдөө алслагдмал амьдардгаас хувьцааны арилжаанд идэвхтэй оролцдоггүй. Энэ нь МХБ-д анх бүртгэгдсэнээс хойших 24 жилийн хугацаанд дөнгөж 38 удаагийн арилжаа хийгдсэнээс харагдаж байгаа юм. Ийнхүү хувьцааны нийлүүлэлт бага, арилжаа идэвхгүй байгаагаас үүдэн хувьцааны зах





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

зээлийн үнэ 2017 оныг хүртэл удаан өсөлттэй явж компанийн бизнесийн бодит өсөлтийг тусгаж чадахгүй байсан.

- Компани хувьчлагдсанаас хойш техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинэ гурилын үйлдвэр барих зэргээр үйл ажиллагаагаа тогтмол өргөжүүлж, хуримтлагдсан ашгаасаа өөртөө хөрөнгө оруулалт хийж ирсэн. Ингэснээр ногдол ашиг хуваарилах боломж бага байсан, түүнчлэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгээгүй олон жил болсон нь компанийн бизнесийн өсөлтийн талаарх зөв төсөөллийг олон нийтэд хүргэж чадаагүй байж болзошгүй. Энэ нь хувьцааны эрэлт талд сөргөөр нөлөөлсөн байх талтай.

Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ

Зориулалт	Хэрэгцээ сая төг	Зарцуулалт
Газар тариалангийн тоног төхөөрөмж авах	538.0	Өөрөө явагч хор цацагчийн үлдэгдэл төлбөр 70% - 420.4 сая Чулуу түүгчийн үлдэгдэл төлбөр 70% - 117.6 сая
Гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг авах	40.0	Гурил савлах төхөөрөмж болон дагалдах бусад сэлбэг
Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх	3,166.8	Зээл төлөх – 950 сая Буудай худалдан авах – 2,216.8 сая
Нийт дүн	3744.8	


Компани эргэлтийн хөрөнгө үндсэндээ богино хугацаат зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байна. Энэ нь компанийн санхүүгийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна түүхий эдийн нөөц бүрдүүлэхэд хүрэлцдэггүй. Иймд компани 3,166.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хувьцаа нэмж гаргах замаар санхүүжүүлэхээр төлөвлөв. Ингэснээр 2018 оны зээлийн хүүгийн зардлыг 90 сая төгрөг (жилд 180 сая)-өөр бууруулж, 4300 тн буудай худалдан авч, нэмж нөөцлөх боломж бүрдэнэ.

Нэмж гаргах хувьцаа нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувь, харьцаа

Компани ойролцоогоор 4 тэрбум төгрөгийн хэрэгцээнд үндэслэн нэмж гаргах хувьцааны нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувийг 28% байхаар тооцсон ба нэмж хувьцаа гаргаснаар одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувь 72% байна. Ингэж тооцсоноор компанийн нэмж гаргах хувьцааны тоо 4,405,600 ширхэг, нэмж гаргах нэгж хувьцааны үнэ ойролцоогоор 908 төгрөг болж байна.

График 9. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны хувь, хэмжээ





Хувьцааны үнэ

Үнэ тогтоох үндэслэл	Нэгж хувьцааны үнэ	Бүртгэлийн үнэтэй харьцуулсан харьцаа
Компанийн бизнесийн үнэлгээ	1159-1350	125.7%-146.4%
Компанийн хөрөнгийн үнэлгээ	922	100%
Хувьцааны зах зээлийн үнэ /увьц	93.05	10.1%
Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ ба нэмж гаргах хувьцааны нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувь	908	98.5%
Санал болгох доод үнэ	850	92.2%


Нэмж гаргаж буй хувьцааны санал болгох доод үнэ нь хувьцааны бүртгэлийн үнээс 7.8% доогуур байна. Нэмж гаргах хувьцааны үнийн санал нь хувьцааны бүртгэлийн үнээс хэт доогуур байх нь компанийн сүүлийн 20 жилд бүтээж бий болгосон хөрөнгийн үнэ цэнэ, одоогийн хувьцаа эзэмшигчдийн 24 жил хүлээсэн өгөөжийн үнэ цэнийг бууруулж үнэлэх сөрөг талтай. Иймд Компанийн нэмж гаргах нэгж хувьцааны худалдах доод үнийг 850 төгрөгөөр тогтоож, хөрөнгө оруулагчдад санал болгохоор ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн №то-18-18 тоот тогтоолоор шийдвэрлэсэн болно.

Нэмж гаргаж буй хувьцааг арилжих хэлбэр

Компани хувьцааг дараах хэлбэрээр арилжихаар төлөвлөв.

Хөрөнгө оруулагч	Санал болгох хувьцааны тоо, ширхэг	Санал болгох арга, нэгж хувьцааны худалдах үнэ
Стратеги хөрөнгө оруулагч	3,228,600	Тогтоосон үнэ, 850 төгрөгөөр
Олон нийт	1,177,000	Захиалгын бүртгэл, 850 төгрөгөөс

Стратеги хөрөнгө оруулагчид нэгж хувьцааг 850 төгрөгөөр шууд санал болгож, захиалгыг урьдчилан авч бүрэн биелүүлэх амлалт өгнө. Харин олон нийтээс захиалга авахдаа хувьцааны үнийг 850 төгрөг ба түүнээс дээш санал өгөх боломжийг олгож, захиалгын бүртгэлийн зарчмаар арилжааг зохион байгуулна.






2.5 Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигчдийн эрх

Компанийн энгийн хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуульд заасны дагуу дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ. /КТХ 4.1/
- Нийлүүлэх, нэгтгэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй. /КТХ 24.1/
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх /КТХ 34.1.1/
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах /КТХ 34.1.2/
- Компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх /КТХ 34.1.3/
- Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй /КТХ 34.2/
- Компанийн тухай хуулийн 53.1.1, 53.1.2, 53.1.3 дурьдсан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй. /КТХ 53.1/
КТХ-ийн 53.1.1 нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах,
53.1.2 компани КТХ-ийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн
53.1.3 компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан.
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй. /КТХ 53.2/





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК


ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй. /КТХ 63.3/
- Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй. /КТХ 88.3/
- Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 90.1 д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. /КТХ 90.2/
- Энэ хуулийн 89.1-т заасан этгээд нь энэ хуулийн 91, 92 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөн, эсхүл компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. /КТХ 93.4 /
- Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй. /КТХ 98.3/

Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах /ҮЦЗЗТХ 20.1.1/
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх. /ҮЦЗЗТХ 20.1.3/
- тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох /ҮЦЗЗТХ 20.1.4/
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх /ҮЦЗЗТХ 20.1.5/
- Хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх /ҮЦЗЗТХ 20.1.6/
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх /ҮЦЗЗТХ 20.1.7/
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх /ҮЦЗЗТХ 20.1.8/






- Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх /ҮЦЗЗТХ 20.1.9/
- Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх /ҮЦЗЗТХ 20.1.10/
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, компанийн хэлбэрийг өөрчлөх, өрийн хэрэгсэл гаргагч нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулан үнэт цаасаа бүртгэлээс хасуулах тохиолдолд энэ тухай хүсэлтээ арилжаа эрхлэх байгууллагад тэргүүн ээлжинд гаргана./СЗХ ҮЦБЖ 3.1.6/
- Компани энэ хуулийн 60.1 заасан шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй. /КТХ 60.4/
- Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчийг энэ хуулийн 65.6 заасан баримт бичигтэй танилцах боломжоор хангах, хуралдах байранд орох бололцоогоор хангах үүрэгтэй. /КТХ 65.7,65.8/
- Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй. /КТХ 88.4/
- Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй. /КТХ 89.5/
- Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой Хорооноос шаардсан тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй. /СЗХ ҮЦБЖ 3.1.7/
- Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрх, ашгийг хамгаалах чиглэлээр компанийн ногдол ашгийн бодлогыг боловсруулан баталж, мөрдөх үүрэгтэй. /СЗХ ҮЦБЖ 3.1.9/
- Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох бүх баримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой материалыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш арван жилийн хугацаанд компани дээрээ хадгалах үүрэгтэй. /СЗХ ҮЦБЖ 3.1.11/
- Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааварт туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана. /МХБ ҮЦБЖ 21.1/
- Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа энэхүү журамд заасан өрийн хэрэгслийн болон хувьцааны зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллана. /МХБ ҮЦБЖ 21.2 /





- Санхүүгийн тайлан тэнцлийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж, зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар тогтмол баталгаажуулна. /МХБ ҮЦБЖ 21.3/
- Үнэт цаастай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хувьцаа эзэмшигч, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий үнэт цаас хариуцсан ажилтантай байна. /МХБ ҮЦБЖ 21.5/
- Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх ба мөрдөх боломжгүй тохиолдолд хувьцаа эзэмшигч болон олон нийтэд тайлбар гаргана. Хувьцааны I ангилалд үнэт цаасаа бүртгүүлсэн үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын үндсэн зарчмуудыг бүрэн дагаж мөрдөнө. /МХБ ҮЦБЖ 21.6 /
- Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа холбогдох журам болон гэрээнд заасны дагуу жилийн үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй. /МХБ ҮЦБЖ 21.7/
- Үнэт цаас гаргагч нь Биржтэй байгуулсан бүртгэлийн гэрээнд заасан үүргээ бүртгэлтэй байх хугацаандаа бүрэн биелүүлж ажиллана. /МХБ ҮЦБЖ 21.8/
- Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаар, мөн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээллийг хууль болон Хорооны холбогдох журмын дагуу нийтэд болон Биржид мэдээлэх ба гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд энэ журмын 7.1 дэх заалтыг баримтлан мэдээлнэ. /МХБ ҮЦБЖ 21.9/





2.6 Нэмж гаргаж буй хувьцаатай холбоотой үүсэх хувьцаа эзэмшигчийн эрх, үг эрхийг хэрэгжүүлсэн байдал

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь Компанийн тухай хуулийн 62.1.3, 62.1.8 заасны дагуу 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “Компани нэмж хувьцаа гаргах, нэмж хувьцаа гаргах төслийг батлах”, “Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай” асуудлуудыг хэлэлцэн компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжин худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх шийдвэрийг гаргасан учраас нэмж гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжинд санал болгохгүй бөгөөд нэмж гаргаж буй хувьцааг бүхэлд нь олон нийтэд санал болгоно. Хувьцаа эзэмшигчид нэмж гаргаж буй хувьцаанаас худалдан авах хүсэлтэй бол олон нийтэд санал болгож буй хувьцаанаас худалдан авах боломжтой.

Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх

“Хөвсгөл алтан дуулга” ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 87.1.2-т заасны дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдох учир компанийн тухай хуулийн 53, 54 зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн.

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ хуралдаж, хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээний тухай то-18-17 тоот тогтоолыг баталсан. Тус тогтоолоор компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнийг 8095 төгрөгөөр тогтоож, хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацааг 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн ажлын 30 өдрөөр буюу 2018 оны 5 сарын 17-ны өдөр дуусгавар болгохоор тогтоосон болно. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн худалдаж авах, шаардах эрх хэрэгжүүлэх ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 8 дугаартай тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь компанийн тухай хуулийн 54.1 заасны дагуу СЗХ –ны 2016 оны 7 сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчдэд “Хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагааны журам” болон шаардах эрх үүссэн тухай мэдэгдэл зарыг хүргэсэн байна. 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс 2018 оны 5



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



дугаар сарын 17-ны өдрийн хооронд хувьцаа эзэмшигчдээс шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт ирүүлээгүй болно.

2.7 Нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгох, анхдагч зах зээлд байршуулах

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 02 тоот тогтоолоор компани 4,405,600 ширхэг хувьцааг нэмж гарган нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн билээ. 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №то-18-18 тоот тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны худалдах доод үнийг 850 төгрөгөөр тогтоосон.



“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох, анхдагч зах зээлд байршуулах ажиллагаа дараах дарааллаар зохион байгуулна.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Олон нийтэд мэдээлэл, танилцуулга сурталчилгаа

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгож, үнэт цаасны танилцуулгыг бүртгэснээр үнэт цаасыг олон нийтэд сурталчлах ажиллагаа эхлэнэ. Үнэт цаасыг олон нийтэд сурталчлах буюу үнэт цаасны танилцуулах арга хэмжээ нь биечлсэн болон олон нийтийг хамарсан уулзалтууд, компанийн цахим хуудас, хэвлэмэл материалыг тараах, цахим орчин болон радио телевиз, сонин сэтгүүлээр дамжуулан олон нийтэд үнэт цаасны мэдээллийг хүргэнэ. Энэхүү үйл ажиллагааг үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компани маркетингийн төлөвлөгөөний дагуу тодорхой хугацаанд зохион байгуулна.

Үнэт цаасны байршуулах төлөвлөгөө

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер хүлээн авч, хуваарилалтыг гүйцэтгэх ба олон нийтэд санал болгож буй хувьцааны захиалгыг үнэт цаасын компани(ҮЦК)- удаар дамжуулан авна.

Арилжаа

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах аянг зохион байгуулж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг авна. Нэмж гаргаж буй хувьцааны стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер хүлээн авч, хуваарилалтыг андеррайтер зохион байгуулна. МХБ-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журамд заасны дагуу анхдагч зах зээлийн арилжааны программаар дамжуулан захиалгын бүртгэлийн аргаар хувьцаа худалдан авах үнийг тогтоохдоо доод үнэ 850 төгрөгөөс эхлүүлэн тухайн үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнийг харгалзан үзнэ. Биелэх боломжтой захиалга тус бүрээр үнэт цаасны хуваарилалтыг хийнэ.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар

Хөрөнгө оруулагч үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцох буюу “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг худалдан авахдаа дараах зааврын дагуу оролцоно.





Хувьцаа худалдан авах ДАНС НЭЭЛГЭХ	Монголын Хөрөнгийн Бирж гишүүн ҮЦК-д данс нээлгэх
ЗАХИАЛГА ӨГӨХ	Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-д нэмж гаргаж буй хувьцаанаас худалдан авах захиалга өгнө.
Хувьцаа худалдан авах МӨНГӨ БАЙРШУУЛАХ	Хүлээн авагч банк: Арилжаа төлбөр тооцооны төв Хүлээн авагчийн дансны дугаар: 0021 Хүлээн авагчийн нэр: (Овог, нэр), (регистер) Гүйлгээний утга: “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны үнэ.
ЗАХИАЛГА БАТАЛГААЖУУЛАХ	Мөнгө тушаасан баримтыг захиалгын гэрээтэй тулган захиалгаа баталгаажуулах

Санамж:

1. Хөрөнгө оруулагч та хувьцаа худалдан авах захиалгын дагуу хувьцааны үнэ болон арилжааны шимтгэлийг хамт тушааж, дансаа зузаатгах.
2. Анхдагч зах зээлийн арилжаанд оролцоходоо арилжаа эхлэхээс нэг хоногийн өмнө захиалга өгч, хувьцаа худалдан авах дансаа зузаатган, захиалга баталгаажуулсан байх.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгоход мөрдөх дүрэм, журам:

- “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”,

Арилжааны шимтгэл

Хувьцаа худалдан авч буй этгээд нь захиалгын үнийн дүнгээс тодорхой хувиар тоохон үйлчилгээний хөлс болох арилжааны шимтгэлийг өөрийн үйлчлүүлж буй болон захиалга өгсөн ҮЦК-д төлөх ба уг шимтгэлд МХБ, ҮЦТХТ, ҮЦК-ийн шимтгэлүүд багтсан байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Монголын хөрөнгийн биржийн журмын дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж, хувьцааны арилжаалсан тайлан болон арилжааны мэдээний хамт Санхүүгийн зохицуулах хороонд хянуулж, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг хүргүүлэн, Санхүүгийн зохицуулах Хорооны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Ингэснээр хувьцааг анхдагч зах зээл дээрээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдах эрх нээлттэй болно.

Албан татвар

Хөрөнгө оруулагч хувь хүн нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн 13.1.3-т заасан ногдол ашгийн орлогоос 19.1.3-т заасны дагуу ногдол ашгийн орлогын





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

үнийн дүнгээр нь, мөн хуулийн 14.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос 20.1.2-т заасны дагуу хувьцаа борлуулсны орлогын тухайд түүнийг борлуулсан үнээс уг хувьцааг худалдаж авсан үнийг хассан зөрүүгээр нь, 20.1.4-т заасан хувьцаа бусад үнэт цаас борлуулсан тохиолдолд нийт хувьцаа, бусад үнэт цаас худалдсан үнээс тэдгээрийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн нийт дүнг хассан зөрүүгээр нь тус хуулийн 23.2.4-т заасны дагуу 10%-аар тооцон татвар төлнө. Оршин суугч бус албан татвар төлөгч нь тус хуулийн 23.2.5-д заасны дагуу орлогын дүнд 20 хувиар албан татвар төлнө.

Гурав. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДҮҮДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1 Үнэлгээний компанийн мэдээлэл

Үнэлгээг хийж гүйцэтгэсэн: “БДО-АУДИТ” ХХК

Үнэлгээний компанийн нэр: “БДО-Аудит” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9018001010

Регистрийн дугаар: 2546442

Үйл ажиллагааны чиглэл: Аудитын үйл ажиллагаа, хөрөнгийн үнэлгээ хийх

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж, Нарны зам 62, Юнион Блюдинг, В блок, 15 давхар 1502 тоот

Утас: 70404040, 77454026

Хороонд бүртгэлтэй эсэх: СЗХ-ны 2014 оны 01 сарын 29-ны өдрийн 22 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээл дээр хөрөнгийн үнэлгээний хийх хуулийн этгээдээр бүртгэгдсэн.

“БДО АУДИТ” ХХК-ийн танилцуулга

БДО нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1328 салбар оффисоороо дамжуулан харилцагчтай хамтран ажилладаг.

БДО сүлжээ нь 1963 онд мэдлэг туршлага солилцон, өргөжүүлж харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд Их Британий Нэгдсэн Вант Улс болон Канадын байгууллагууд нэгдсэнээр анх үүсгэн байгуулагдсан юм. БДО нь Бейндер Дикер Отте & Ко гэж нэрээ солихоос өмнө 1973 он хүртэл бид Бейндер Сайдман Интернэйшл гэдэг нэрээр дэлхийд танигдсан.

БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо БДО Монгол нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай “Итгэлт Аудит” ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. “БДО Аудит” ХХК нь чиглэл чиглэлээр мэргэшсэн зэрэг, цолтой 2 партнер, 40 орчим





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

мэргэжилтнүүд бүхий чадварлаг багийн туршлага, мэдлэгээр дамжуулан үйлчлүүлэгчдийн бизнесийг дэмжин ажилладаг байна.

“БДО Аудит” ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагыг хангаж, дараах салбарт ажиллах жагсаалтад бүртгэгдсэн. Үүнд:

- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад аудитын үйлчилгээ үзүүлэх
- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх
- Даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх

СЗХ-ны 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 22 тоот “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай” тогтоолоор “БДО Аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн байна.

3.2 Үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл:

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь “БДО Аудит” ХХК-тай компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийлгэхээр 2017 оны 12 сарын 21-ны өдөр 2017-Ү9/ХӨ дугаартай гэрээг байгуулсан байна.

Гэрээгээр үнэлгээний байгууллага, үйлчлүүлэгч дараах эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ гэж заасан байна. Үүнд:

Үнэлгээний байгууллагын эдлэх эрх:

- Үйлчлүүлэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, хууль болон энэхүү Гэрээгээр тогтоосон нөхцлийг зөрчсөн Үйлчлүүлэгчийн аливаа шаардлагыг биелүүлэхээс татгалзах;
- Үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж Гэрээг цуцлах болон Үйлчлүүлэгч тодорхой хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээг дангаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэсэн ажлын зардлыг нэхэмжлэх/ энэ зардлын нэг өдөрт ногдох хамгийн бага хэмжээ 2,000,000 төгрөг байна;
- Гэрээт ажлын үр дүнгийн талаар Үйлчлүүлэгчид ямарваа байдлаар нэмэлт, баталгаа өгөхгүй байх / үнэлгээний үр дүнд гарах мөнгөн дүнг урьдчилан тодорхойлж, түүндээ хөтлөгдсөн үнэлгээ хийхгүй байх;
- Гэрээнд заасан бусад эрхийг хэрэгжүүлнэ;

Үнэлгээний байгууллагын хүлээх үүрэг:

- Үйлчлүүлэгчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, холбогдох ажиллагаа хийх бүрт тэмдэглэл хөтлөх, ажлын явц үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх;
- Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон даруйд Үйлчлүүлэгчид мэдэгдэх;





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээний нөхцлийг чанд мөрдөх;
- Гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ.

Үйлчлүүлэгчийн эдлэх эрх:


- Үнэлгээний байгууллагаас Гэрээгээр хүлээн үүргээ зохих ёсоор биелүүлэх, энэхүү Гэрээгээр харилцан тохиролцсон нөхцөл, шаардлага болон холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн үнэлгээ хийх, тайлан гаргахыг шаардах;
- Гэрээнд заасны дагуу гаргаж өгсөн баримт материалыг буцаан өгөх, тэдгээрт холбогдох мэдээллийн нууцыг хадгалахыг шаардах;
- Үнэлгээний байгууллага Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Үйлчлүүлэгчийн итгэлийг эвдсэн аливаа үйлдэл хийсэн тохиолдолд Гэрээг дангаар цуцлах;
- Гэрээнд заасан бусад эрхийг хэрэгжүүлнэ;
- Үнэлгээний байгууллага үйлчлүүлэгчээс хамаарахгүй шалтгаанаар энэхүү гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гэрээг хэтрүүлсэн хоног тутамд гэрээний үнийн 2,000,000 төгрөгтэй тэнцэх алданги нэхэмжлэх эрхтэй;

Үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг:

- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайландаа үнэлэгдсэн хөрөнгүүдийг тусгасан байх бөгөөд Гэрээний Хавсралт №1-д заасан баримт бичгийг Үнэлгээний байгууллагад Ажил эхлүүлэх нэгдсэн уулзалт зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор бэлтгэж, актаар хүлээлгэн өгөх;
- Гэрээт ажилтай холбоотой Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхийл мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан тухай бүрт нь бүрэн гүйцэт, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Үнэлгээний байгууллагыг өөрийн байранд нэвтрэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлыг зохион байгуулах;
- Үйлчлүүлэгч нь Үнэлгээний байгууллагад нэр төр, ажил хэргийн нэр хүндэд нь харш үйлдэл хийх, Үнэлгээний байгууллагыг ашиг сонирхлын зөрчил, хараат байдалд оруулахуйц харилцаа холбоо үүсгэх болон хууль бус шаардлагыг биелүүлэх талаар хүсэлт, шаардлага гаргахгүй байх;
- Гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ.

Талуудын хариуцлага:





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Үнэлгээний байгууллага нь Үйлчлүүлэгчээс өгөх аливаа мэдээлэл болон Гэрээт ажил гүйцэтгэх явцад олж мэдсэн бүх мэдээллийг зөвхөн энэхүү Гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ашиглах ба Үйлчлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөл, шүүхийн шийдвэрээр шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй;
- Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үйлчлүүлэгчээс авч ашиглагдсан эх мэдээлэл, баримт материал, баримтууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэх бөгөөд Үнэлгээний байгууллага нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэн дотоод мэдээлэлтэй холбогдох дараах ажиллагаа хийхийг хориглоно. Үүнд:
 - Дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах,
 - Дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх,
 - Дотоод мэдээллийг олон нийтэд мэдээлэх,
 - Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу дотоод мэдээлэл эзэмшигчийн хийхийг хориглосон бусад ажиллагаа;

Үнэлгээний байгууллага нь үйлчилгээ үзүүлэх явцдаа олж авсан аливаа мэдээллийг задруулснаас Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, бизнесийн нэр хүндэд хохирол учирсан нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээж, хохирлыг барагдуулна.

3.3 Аудитын компанийн мэдээлэл

Аудитын дүгнэлт гаргасан: “Од бүртгэл аудит” ХХК

Компанийн нэр: “Од бүртгэл аудит” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9018001014

Регистрийн дугаар: 5189748

Үйл ажиллагааны чиглэл: аудитын үйл ажиллагаа

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 7/3, Цэлмэг тауэр, 7 давхар, Утас: 70150003

Хороонд бүртгэлтэй эсэх: СЗХ-ны 2016 оны 04 сарын 06-ны өдрийн 121 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд оролцогчидод аудитын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн.

“ОД БҮРТГЭЛ АУДИТ” ХХК-ийн товч танилцуулга

“Од Бүртгэл Аудит” ХХК нь 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр үүсгэн байгуулагдсан, Мүүр Степенс Интернэйшнл олон улсын сүлжээнд 2016 оны 1 сард элссэн бөгөөд Монгол Улс дахь корреспондент фирм юм. “Од Бүртгэл Аудит” ХХК нь Мүүр Степенс Интернэйшнлийн Олон Улсын бодлогын хорооноос гаргасан шийдвэрийн дагуу Мүүр Степенс Интернэйшнлийн аудитын технологи, гарын авлагыг үйл ажиллагаандаа баримталж, үйлчилгээг үзүүлдэг байна. Мөн тус сүлжээнээс явуулж буй бизнесийн хөгжил, стратеги төлөвлөлт, сургалт, хүний нөөцийн бодлогод нийцүүлэн өөрсдийн үйл ажиллагааг явуулдаг байна.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

“Од Бүртгэл Аудит” ХХК нь дараах үйлчилгээг үйлчлүүлэгч санал болгодог байна.

Баталгаажуулах үйлчилгээ:

- Санхүүгийн тайлангийн аудит
- Санхүүгийн тайланг нягтлах ажил
- Бусад баталгаажуулах ажил
- Санхүүгийн холбогдох үйлчилгээ

Зөвлөх үйлчилгээ:

- НББ-ийн зөвлөх үйлчилгээ
- НББ-ийн аутсорсингийн үйлчилгээ
- СТОУС, үндэсний стандартын зөвлөгөө
- НБББББ боловсруулалт болон зөвлөгөө
- Сургалт

Санхүүгийн зөвлөх үйлчилгээ:

- Гүйцэтгэлийн зөвлөх үйлчилгээ
- Нийцлийн зөвлөх үйлчилгээ
- Бизнесийн өөрчлөн байгуулалт, татан буулгалт, дампуурлын хэрэгт зөвлөгөө өгөх, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх
- Дотоод аудитын аутсорингийн үйлчилгээ.

3.4 Аудитын байгууллагатай байгуулсан гэрээний эрх, үүрэг, хариуцлагын тухай мээдэлэл:

Үнэт цаас гаргагч “Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр “Од Бүртгэл Аудит” ХХК-тай ОВА-2017-СТА-45 дугаартай санхүүгийн тайланд аудит хийх ажлын гэрээг байгуулсан байна. Гэрээнд захиалагч тал: “Хөвсгөл алтан дуулга” ХК, гүйцэтгэгч тал: “Од Бүртгэл Аудит” ХХК болно.

Гэрээгээр захиалагч дараах эрх, үүргийг хүлээнэ гэж заасан байна. Үүнд:

Захиалагчийн эдлэх эрх:

- Гүйцэтгэгчээс гэрээний дагуу үзүүлэх ажлын даалгаварыг (Хавсралт1) баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Гүйцэтгэгчээс гэрээнд заасан ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг шаардах;
- Гэрээт ажлын гүйцэтгэлийн явц, ажлын чанарт хяналт тавих;
- Гэрээт ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнтэй танилцаж, Аудитын тухай хуульд заасан үндэслэл байвал томилогдсон баг, багийн бүрэлдэхүүнээс татгалзах саналыг аудитын хуулийн этгээдэд гаргах;
- Аудитын тайлан, дүгнэлтийн талаар гүйцэтгэгчээс тайлбар өгөхийг шаардах, тайлбар, тодруулга авах;





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Гүйцэтгэгч тал гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээний заалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд захиалагч талын санаачлагаар цуцлах, гэрээ цуцлагдсантай холбоотойгоор өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй гэж заажээ.

Захиалагчийн хүлээх үүрэг:

- Гэрээт ажлын даалгавар (Хавсралт1), түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар гүйцэтгэгч талтай зөвшилцөж, баталгаажуулах;
- Гүйцэтгэгч талын гаргасан ажлын график (Хавсралт2)-ийн дагуу аудитад бэлтгэх;
- Захиалагч, хариуцагч байгууллагын удирдлагын зүгээс аудитын үйл ажиллагаанд саад учруулахгүй, ямар нэг хэлбэрээр дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Гэрээт ажлыг явуулах нөхцөл бололцоогоор хангах, гүйцэтгэгчийн хүссэн, шаардлагатай тайлан мэдээ, холбогдох нотлох баримтыг хариуцагч болон гуравдагч этгээдээс гаргуулж өгөх;
- Гүйцэтгэгчээс шаардсан баримт, мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн хугацаанд багтаан жагсаалтаар хүлээлгэн өгөх;
- Гүйцэтгэгчид гаргаж танилцуулсан санхүүгийн тайланг холбогдох олон улсын стандарт болон эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм, журамд нийцүүлэн гаргасан эсэхийг болон бусад баримт, мэдээллийн үнэн зөв, бодитой байх хариуцлагыг үйлчлүүлэгч байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодох бүртгэлийн удирдах ажилтан хүлээнэ.
- Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг холбогдох олон улсын стандарт болон эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм журамд нийцүүлэн гаргасан санхүүгийн болон бусад үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусгасан тухай, мөн эдгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулсан, энэ талаар үүсч болох хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг гүйцэтгэгчид гаргаж өгөх;
- Аудитын шалгалт, баталгаажуулах ажлын явцад нэмэлт мэдээ, баримт, тодруулга шаардагдах бол түүнийг тухай бүрт гүйцэтгэгчдэд гаргаж өгөх;
- Санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагааны талаар судалгаа шинжилгээ, тайлбар, тодруулга, илтгэх хуудас зэрэг баримт бичгийг гүйцэтгэгчийн хүсэлт, шаардлага, зөвлөмжийн дагуу үзүүлж, тайлбарлан танилцуулах;
- Гүйцэтгэгчээс гаргасан тайлан, дүгнэлттэй санал зөрсөн тохиолдолд энэ тухай тайлбарыг бичгээр гаргах өгөх;
- Гэрээт ажлын явцад болон төгсгөлд менежментийн захидлаар гүйцэтгэгчийн санал болгосон санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн бичилт, залруулгын саналыг хүлээн авах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх эсэхийг бие даан шийдвэрлэх бөгөөд хэрэв залруулах бичилт, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах, залруулгын санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй бол энэ тухайгаа албан бичгээр хариу мэдэгдэх;
- Менежментийн захидлаар гүйцэтгэгчийн санал болгосон санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн бичилт, залруулга, зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс үүсэх үр дагаварыг хариуцах;





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний хөлсийг энэ гэрээний 4.2-д заасан хугацаанд нь саадгүй төлөх;
- Захиалагч талын санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажилд ногдох хөлсийг гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу төлөх;

Гэрээгээр гүйцэтгэгч тал дараах эрх, үүргийг хүлээнэ гэж заасан байна. Үүнд:

Гүйцэтгэгчийн эдлэх эрх:

- Гэрээт ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнийг томилох, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах;
- Захиалагч, хариуцагч байгууллага, тэдгээрийн гүйцэтгэх удирдлага, нягтлан бодох бүртгэлийн удирдах ажилтан, аудитын хорооны дарга, дотоод аудитын нэгжийн ажилтан, санхүү, бүртгэлийн болон бусад ажилтнаас аудитын үйл ажиллагааны гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон баримт, мэдээллийг гаргуулж авах, ажиглалт, асуулга, ярилцлага, тулган баталгаажуулалт хийх;
- Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээг батлагдсан маягт, зааврын дагуу үнэн зөв гаргаж, гэрээнд заасан хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгөхийг захиалагч, хариуцагчаас шаардах;
- Шаардлагатай нэмэлт баримт материалыг шаардаж авах, дотоод хяналтын бүтэц болон санхүүгийн тайланд агуулагдаж байгаа мэдээллийн талаар удирдлага болон бусад хүмүүст асуулга тавьж, судалгаа хийх, биечлэн үзэх, тайлбар нотолгоог холбогдох хүмүүсээс бичгээр гаргуулан авах;
- Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангахыг захиалагч, үйлчлүүлэгч талуудаас шаардах;
- Үйлчлүүлэгч байгууллагад өмнө нь хийгдсэн аудитын ажлын баримт, мэдээлэлтэй танилцах;
- Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой баримт мэдээллийг харилцагч банк, санхүүгийн байгууллага болон бусад холбогдох аж ахуй нэгж байгууллагаас авч танилцах;
- Аудитын горим, стандарт, мэргэшсэн нягтлан бодогчийн болон мэргэжлийн ажилтаны ёс зүйтэй холбоотой асуудлаар захиалагч, хариуцагч байгууллага болон гүйцэтгэх багийн хооронд үл ойлголцол гаргасан тохиолдолд ММНБИ-ийн Стандартын хорооноос зөвлөгөө авах;
- Гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг энэ гэрээний 4.2-д заасны дагуу захиалагчаас нэхэмжлэн авах;

Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг:

- Гэрээт ажлын даалгавар (Хавсралт1), аудитын хамрах хүрээ, гүйцэтгэх хугацааны талаар захиалагчтай зөвшилцөн, шаардлагатай тохиолдолд ажлын даалгаварт өөрчлөлт оруулах;
- Гэрээт ажлыг гүйцэтгэх ажлын график (Хавсралт2)-ийг боловсруулж баталгаажуулан захиалагчид танилцуулах





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 2 хоногт багтаан гэрээт ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнийг томилж, захиалагчид танилцуулах;
- Гэрээт ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, холбогдох олон улсын стандартын дагуу гүйцэтгэх;
- Гэрээт ажлыг хийж болохооргүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээт ажлаас татгалзах, эсхүл бусад мэргэжилтнийг татан оролцуулах, шаардлага гарвал энэ тухай захиалагч, хариуцагч байгууллага мэдэгдэх;
- Гэрээт ажлын төгсгөлд “Хараат бус аудиторын дүгнэлт, аудитын тайлан”-г бичгээр гаргана;
- Гэрээт ажлын тайлан, дүгнэлтийн талаар талуудын хооронд санал зөрүүтэй асуудал үүсвэл дүгнэлтийнхээ үндэслэлийг бичгээр болон амаар тайлбарлах. Тайлбар тодруулгыг тухай бүрт нь гаргаж өгөх, авах;
- Гэрээт ажлын явцад захиалагч, хариуцагч талуудын хооронд байгуулсан гэрээ, гэрээний үүргийн биелэлт, хариуцагч байгууллагын удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон гол чухал тооцоолол, шийдлүүдийг үнэлж, илэрсэн дотоод хяналтын сул тал, материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдлуудын талаар менежментийн захидал бичиж хариуцагчийн гүйцэтгэх удирдлага, захиалагч талд хүргүүлж, залруулгын санал, зөвлөмж өгнө;
- Гэрээт ажлын явц, үр дүнд тавих чанарын хяналтыг байгууллагын дотоодод мөрдөх чанарын хяналтын аргачлал, удирдамжийн дагуу гүйцэтгэх;
- Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны технологийн болон бизнесийн нууцыг бусдад задруулахгүй байх;
- Гэрээнд заасан үүргээ бусад гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;
- Гэрээт ажилтай холбогдсон хариуцлагыг хүлээнэ гэж гэрээнд заасан байна.

3.5 Хуулийн компанийн мэдээлэл

Хууль зүйн дүгнэлт гаргасан: Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН

Компанийн нэр: “Өмгөөлөлийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН

Улсын бүртгэлийн дугаар: 9022001010

Регистрийн дугаар: 5495997

Үйл ажиллагааны чиглэл: Хууль зүйн зөвлөгөө өгөх /6910 кодтой/

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатарын талбай, Централ тауэр, 13 давхар, 1301 тоот.

Утас: 976-11-330048, 99119181

Хороонд бүртгэлтэй эсэх: СЗХ-ны 2016 оны 02 сарын 24-ны өдрийн 42 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн байна.

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийн товч танилцуулга

“Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл) нь өөрийн эрхэлж байгаа онцлог үйл ажиллагааныхаа хувьд Монгол Улс дахь хамгийн том, олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл байна. “Эм Ди Эс Ассошэйтс” болон “ХаанЛекс Адвокэйтс”





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ЗБН (зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл)-үүд нь тус бүр 2011 онд байгуулагдаж, хоёр нөхөрлөлийн нэгдлийн үр дүнд “Эм ДиЭс энд ХаанЛекс” ХХН нь 2014 онд байгуулагдсан байна. Тэд өөрсдийн ажлын арвин их туршлага, олон улсын эрх зүйн мэдлэгтээ түшиглэн үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байна. Тус нөхөрлөлийн үйлчлүүлэгчид нь Төрийн Өмчит Компани, төрийн байгууллагуудаас эхлэн, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн томоохон компаниуд байдаг байна. “Эм Ди Эс ХаанЛекс” ХХН-ийг хууль эрх зүйн салбарын тэргүүлэх Legal500 болон AsiaLaw хэвлэлүүд хүлээн зөвшөөрч, зөвлөмж болгож буй хуулийн фирмүүдийн түвшинд үнэлдэг байна. “Эм ДиЭс энд ХаанЛекс” ХХН нь зургаан партнер, зургаан хуульчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Нөхөрлөлийн үйл ажиллагааны чиглэл нь компанийн эрх зүй, компанийн нэгдэл ба худалдан авалт, банк, санхүү, уул уурхай, дэд бүтэц, хөрөнгийн зах зээл, үл хөдлөх хөрөнгө, барилга, маргаан шийдвэрлэх, эрчим хүч, газрын тос, ТХХТ/Төслийн санхүүжилт, оюуны өмч байна.

3.6 Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН –тэй 2018 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр д-18/001 дугаартай “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна. Гэрээнд үйлчлүүлэгч тал нь “Хөвсгөл алтан дуулга” ХК, зөвлөх тал “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН байна.

Гэрээгээр үйлчлүүлэгч болон зөвлөх тал дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээхээр тусгасан байна. Үүнд:

Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг:

- Гэрээнд заасан хугацаанд үйлчилгээг бүрэн авах;
- Үйлчилгээний талаар шаардлага, санал гаргах;
- Үйлчилгээтэй холбоотой үнэн бодитой мэдээлэл, холбогдох баримт бичгүүд (Үнэт цаас гаргагчаас гаргуулан авах баримт бичгийн жагсаалтыг Зөвлөх гаргаж өгнө)- ээр түргэн шуурхай хангах, Зөвлөхөөс ирүүлсэн асуулт, хүсэлтэд түргэн шуурхай хариу өгөх;
- Зөвлөхийн зүгээс орон нутгийн төрийн болон бусад байгууллагатай харилцах, мэдээлэл лавлагаа гаргуулах зэрэгт дэмжлэг үзүүлэх;
- Гэрээний дагуу хууль зүйн зөвлөх үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

Зөвлөхийн эрх, үүрэг:

- Шаардлагатай баримт бичигтэй танилцах;
- Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн оновчтой менежментээр гүйцэтгэж, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үйлчлүүлэгчийн зөвлөхийн хувиар ажиллах бөгөөд Үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

- Гэрээгээр хүлээсэн үйлчилгээг заасан хугацаанд бүрэн үзүүлэх;
- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцүүлэн хууль зүйн үйлчилгээг үзүүлнэ;
- Үйлчилгээг үзүүлэхдээ үнэт бодит мэдээллээр хангах;
- Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;

Хариуцлага:

- Хэрвээ аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан хэрэг биш бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй;
- Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй;

3.7 Андеррайтерийн компанийн мэдээлэл

Андеррайтер: “Бумбат Алтай ҮЦК” ХХК

Компанийн нэр: “Бумбат Алтай ҮЦК” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 1611002020

Регистрийн дугаар: 2087103

Үйл ажиллагааны чиглэл: Брокер, дилер, андеррайтер

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Хот айл 4 давхар, 41 тоот.

Утас: 99022166

Тусгай зөвшөөрөл: СЗХ-ны 2016 оны 04 сарын 06-ны өдрийн 120 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон.

“Бумбат Алтай ҮЦК” ХХК-ийн танилцуулга

Андеррайтер, брокер, дилерийн “Бумбат Алтай” ҮЦК ХХК нь 1991 онд үүсгэн байгуулагдаж, хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 27 жилийн турш үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Манай компани нь нийт 80,000 гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй Монголын Хөрөнгийн биржийн анхны гишүүн компани юм. 1991 оноос хойш брокер, дилерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, 2016 онд андеррайтерийн тусгай зөвшөөрлийг авсан.

2017 онд Монголын Үнэт Цаасны Бирж буюу анхны хувийн хөрөнгийн биржийн хамгийн эхний IPO болох “Анд Энерги” ХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон, 1.6 тэрбум төгрөгийг, МХБ- дээр бүртгэгдсэн “Монгол базальт” ХК-ийн 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2017 оны Монголын Хөрөнгийн Биржийн хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцсон идэвхи, арилжааны үнийн дүнгээр эхний аравт жагсаж байсан бол 2018 оны эхний 2 сарын байдлаар арилжааны оролцсон байдал буюу нийт хийсэн арилжааны үнийн дүнгээр эхний 3-рт жагсан улам бүр амжилтгаа ахиулан ажиллаж байна.

3.8 Андеррайтерийн гэрээний эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл:

Үнэт цаас гаргагч “Хөвсгөл алтан дуулга” ХК нь “Бумбат –Алтай ҮЦК” ХХК-тай 01 дугаартай андеррайтерийн гэрээг 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр байгуулсан. Гэрээгээр үнэт цаас гаргагч болон андеррайтер дараах эрх, үүргийг хүлээнэ гэж заасан байна. Үүнд:

Компанийн хүлээх эрх, үүрэг:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржээс батлан гаргасан дүрэм журмыг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө;
- Андеррайтерийн магадлан шинжилгээ бүрэн хийх бүх бололцоог хангах;
- Бүртгэлийн баримт бичиг, үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг Андеррайтерт хугацаанд нь бүрэн гарган өгч, тэдгээрийн үнэн зөв байдлыг хариуцна;
- Үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагатай хөрөнгийн үнэлгээний тайлан, аудитын болон хуулийн дүгнэлтийг Хорооны зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, шинжээчээр гаргуулна;
- Дүгнэлт гаргах хуулийн этгээд, шинжээчтэй харилцах, тэднээс шаардлагатай мэдээлэл авах, тэдний гаргасан дүгнэлт, баримт бичигтэй бүрэн танилцах боломжоор Андеррайтерийг хангана;
- Энэхүү Гэрээний 3.4, 3.5-д заасан мэдээллийг Андеррайтерт гаргаж өгөх тухай заалтыг холбогдох хуулийн этгээд, шинжээчтэй байгуулах гэрээнд тусгана;
- Андеррайтерт гарган өгсөн аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай Андеррайтерт ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ;
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Хороо хүчин төгөлдөрт тооцсон тохиолдолд андеррайтерийн үйлчилгээний шимтгэлийг нэхэмжлэхийн дагуу Компанид ажлын 5 (тав) хоногийн дотор шилжүүлнэ;

Андеррайтерийн хүлээх эрх, үүрэг:

- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллана;
- Андеррайтер үүргээ бусдын нөлөөнд авталгүй чин шударгаар гүйцэтгэнэ;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн холбогдох журмын шаардлага, стандартыг бүрэн хангасан үнэт цаасны танилцуулга бэлтгэнэ;
- Компанийн үйл ажиллагаа, татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүний зарцуулалт, төсөвлөсөн ашгийн таамаглал, эрсдлийн хүчин зүйлийн талаар бодит үнэн зөв, үндэслэл бүхий мэдээллийг үнэт цаасны танилцуулгад тусгана;
- Үнэт цаасыг нийтэд санал болгох арга, нэгж үнэт цаасны үнийг тодорхойлон Компанид танилцуулна;





“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Үнэт цаасны бүртгэлийн баримт бичиг, өргөдлийг бэлтгэн Хороо болон Биржид хүргүүлнэ;
- Нийцүүлэгч сонгоход нь Компанид туслалцаа үзүүлнэ;
- Хороо болон Биржид бүртгүүлсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах (Road show), Биржийн гишүүн үнэт цаасны компаниутай хамтран үнэт цаасны захиалга авах, захиалгыг хуваарилах ажлыг өөрийн хөрөнгөөр зохион байгуулна;
- Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг сонирхогч этгээдүүдэд худалдах чиглэлээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд арилжаалагдаагүй үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авна;
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг бэлтгэн Хороонд хүргүүлэх, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг Хорооноос авна;
- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, бүртгэлийн баримт бичиг боловсруулахад шаардагдах бүх төрлийн мэдээллийг Компаниас гаргуулан авна;
- Компаниас гаргуулан авсан бүх төрлийн мэдээллийн нууцлалыг бүрэн хангаж, Компанийн зөвшөөрөлгүй эдгээр мэдээллийг аливаа хэлбэрээр бусдад дамжуулах, хувилан олшруулах, бусад зорилгоор ашиглах зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй;
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Хороо хүчин төгөлдөрт тооцсон тохиолдолд андеррайтерийн үйлчилгээний шимтгэлийг Компаниас нэхэмжлэнэ;





**ХӨВСГӨЛ
АЛТАНДУУЛГА**
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХАВСРАЛТ





ОД БҮРТГЭЛ-АУДИТ

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан


Дүгнэлт

Бид, “ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” Хувьцаат Компанийн (цаашид Компани гэх) 2017 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.





Аудитын Гол Асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах зүйлсийг гол асуудал гэж тодорхойлсон.

- Тайлант онд хараат бус үнэлгээний "БДО Аудит" ХХК-аар 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компанийн өмчлөлд байгаа барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, биет бус хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэсэн. Дахин үнэлгээгээр барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн дансны үнэ 5,363,294 мянган төгрөгөөр, биет бус хөрөнгийн дансны үнэ 2,019,732 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэхүү бизнесийн зорилгоор хийгдсэн хөрөнгийн үнэлгээний дүнг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэсэн эсэхийг бид хянаж үзсэн.
- 2017 оны 12 дугаар сард ХХААХҮЯ-ны Мал хамгаалах сангаас 2,250,000 мянган төгрөгийн хүүгүй зээл авсан. Зээлийг ОХУ-аас малын тэжээл импортлон гэрээнд заагдсан аймгуудад тогтоосон үнээс илүү гаргахгүйгээр борлуулах, малын тэжээлийн хангамжийг сайжруулахаас өөр бусад зориулалтаар ашиглахыг хориглосон.

Удирдлага болон Засаглах удирдлагын Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага


Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.


Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж







авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба дангаараа юмуу нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.





- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан.


Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдалын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцсан.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Handwritten signature

У.ОЮУНАА

Огноо: 2018.03.30.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150013, **И-мэйл:** info@odburtgel.mn



СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018 он 06 сар 18 өдөр

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тодруулга	АУДИТЛАГДСАН		
	2017.12.31	2016.12.31	
	/мян.төг/	/мян.төг/	
Борлуулалтын орлого (цэвэр)	5	2,461,115	3,036,492
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6	(1,996,755)	(2,347,149)
Нийт ашиг (алдагдал)		464,360	689,343
Үйл ажиллагааны зардал	7	(430,960)	(521,752)
Санхүүгийн зардал	8	(409,534)	(480,464)
Бусад орлого	9	429,508	228,484
Бусад зардал	10	(16,489)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		36,885	(84,389)
Орлогын татварын зардал	11	42	513
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		36,843	(84,902)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Дахин үнэлгээний нэмэгдэл	14	7,383,026	-
Нийт дэлгэрэнгүй орлого		7,419,869	(84,902)


ОД БҮРТГЭЛ
АУДИТ

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салцгүй хэсэг болно.

2018.06.29
2987103
П/ОН-230

ОД БҮРТГЭЛ
АУДИТ
108



ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216 2034565



“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ	Тодруулга	АУДИТЛАГДСАН	АУДИТЛАГДСАН
		2017.12.31 /мян.төг/	2016.12.31 /мян.төг/
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19	506,452	50,180
Дансны авлага	18	1,440,172	440,934
Татвар, НДШ–ийн авлага	17	2,280	-
Бараа материал	16	1,266,220	1,600,106
Урьдчилж төлсөн зардал	17	4,944	-
Бусад авлага	17	819	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		3,220,887	2,091,220
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	12	9,155,265	4,022,173
Урт хугацаат хөрөнгө оруулалт	15	1,000	3,333
Биет бус хөрөнгө	13	2,315,792	362,996
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		11,472,057	4,388,502
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		14,692,944	6,479,722
			6,479,722 ол
			АУДИТ
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	21	631,479	597,885
Татварын өр	22	27,291	19,302
НДШ-ийн өглөг	22	-	20,381
Зээлийн хүүгийн өглөг	22	4,540	-
Ногдол ашгийн өглөг	22	606	606
Урьдчилж орсон орлого	22	108,332	-
Бусад богино хугацаат өглөг	22	65,658	75,813
Богино хугацаат зээл	23	3,204,697	1,994,144
Богино хугацаат өр төлбөрийн дүн		4,042,603	2,708,131
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	23	-	541,119
Бусад урт хугацаат өр төлбөр	24	201,811	201,811
Урт хугацаат өр төлбөрийн дүн		201,811	742,930
Өр төлбөрийн нийт дүн		4,244,414	3,451,061
Эздийн өмч			
Өмч:			
- Хувийн	20	102,225	102,225
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14	7,383,026	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		2,963,279	2,926,436
Эздийн өмчийн дүн		10,448,530	3,028,661
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		14,692,944	6,479,722



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал /мян.төг/	Дахин үнэлгээний нэмэгдэл /мян.төг/	Хуримтлагдсан ашиг /мян.төг/	Дүн /мян.төг/
2016.01.01-ний үлдэгдэл	102,225	-	3,115,424	3,217,649
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(84,902)	(84,902)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын ба алдааны залруулга	-	-	(104,086)	(104,086)
2016.12.31-ний үлдэгдэл	102,225	-	2,926,436	3,028,661
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	36,843	36,843
Бусад дэлгэрэнгүй орлого	-	7,383,026	-	7,383,026
2017.12.31-ний үлдэгдэл	102,225	7,383,026	2,963,279	10,448,530



СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
2018.06.29 өдөр 01

О.Д. ЭНН
ИТ -10-

ХӨВСГӨЛ АМГАГ
ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТБ3216 2034565

Санхүүгийн тайлангийн тодруулууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	АУДИТЛАГДСАН 2017.12.31 /мян.төг/	АУДИТЛАГДСАН 2016.12.31 /мян.төг/
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	<u>3,148,740</u>	<u>3,175,337</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,453,433	3,175,337
Татаас, санхүүжилтын орлого	13,591	-
Бусад мөнгөн орлого	681,716	-
Мөнгөн зарлагын дүн	<u>3,741,905</u>	<u>3,144,062</u>
Ажилчдад олгосон мөнгө	237,067	210,726
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	62,172	56,830
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	2,250,627	2,542,361
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	22,237	60,535
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	11,972	273,610
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	409,534	-
Татварын байгууллагад төлсөн мөнгө	25,254	-
Бусад мөнгөн зарлага	723,042	-
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(593,166)</u>	<u>31,275</u>

2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн	<u>445</u>	-
Хүлээн авсан хүүний орлого	445	-
Мөнгөн зарлагын дүн	<u>4,827</u>	<u>9,802</u>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,827	9,802
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(4,382)</u>	<u>(9,802)</u>



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018.06.29 өдөр

3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн	<u>2,663,690</u>	<u>2,182,401</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,663,690	2,182,401
Мөнгөн зарлагын дүн	<u>1,609,871</u>	<u>2,157,644</u>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,609,871	1,701,699
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	455,945
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>1,053,819</u>	<u>24,757</u>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>456,272</u>	<u>46,230</u>
Мөнгөний эхний үлдэгдэл	50,180	3,950
Мөнгөний эцсийн үлдэгдэл	506,452	50,180

ОД БҮРТГЭЛ
АУДИТ
3,950
50,180

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Хөвсгөл Аймаг
Хөвсгөл Аймаг
2987103
П.ОМ-330

ОД БҮРТГЭЛ
АУДИТ
-12-
112

ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЙМАГ ДУУЛИА
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216 № 2034565



Нууцлалын гэрээгээр хатуу хязгаарлагдсан

ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА ХК

Бизнесийн үнэлгээний тайлан

2017 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон

БДО Аудит Хязгаардлагдмал Хариуцлагатай Компани

Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гшшүүн мөн.

Энэхүү тайлан нь Хавсралт А-д заасан Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл болон Удирдлагад хаягласан захидалд тусгасан үнэлгээний зорилгын дагуу бэлтгэгдсэн болно. Таны хэрэгцээнд зориулж энэ тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж байна. Зөвхөн гарын үсэг зурж, тамга дарсан хувилбар нь хүчин төгөлдөр болно.





Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж
Нарны зам-62, Юнион Бюлдинг
В блок, 15-р давхар, 1502 тоот

Хатагтай Д. Дуламсүрэн (цаашид "Та" гэх) танаа:

Огноо: 2018 оны 4-р сарын 9-ны өдөр

Хүндэт хатагтай,

Бидний хооронд 2017 оны 12-р сарын 22-нд байгуулсан Үнэлгээний үйлчилгээний гэрээт ажлын захидал (цаашид "Гэрээ" гэх)-д заасан дагуу бид Хөвсгөл Алтандуулга ХК (цаашид "Компани эсвэл үйлчлүүлэгч" гэх)-ийн захиалгаар тус компанийн газар тариалан, гурилын үйлдвэрийг хамарсан бизнес (цаашид "Бизнес" гэх)-ийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэлээ.

Компани нь хөрөнгийн зах зээлд шинээр нэмж хувьцаа гаргах замаар өмчийн санхүүжилт босгох зорилгоор бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэлгээ (цаашид "Үнэлгээ" гэх) хийхийг биднээс хүссэн.

Энэхүү тайлан нь 2017 оны 12-р сарын 31 ("Үнэлгээний өдөр")-ны байдлаар бизнесийн үнэлгээний үр дүнг нэгтгэсэн болно. Үнэлгээний зорилго нь хараат бус экспертийн журмаар компанийн эрхэлж буй бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцоход оршино.

Үнэлгээний хураангуй дүгнэлт нь энэ тайланд толилуулагдсанаас гадна бидний ашигласан горим, арга зүйн тайлбар, үнэлгээний шинжилгээ хийхэд авч үзсэн хүчин зүйлс багтсан. Бид мөн ашигласан мэдээллийн эх сурвалжийг аливаа хязгаарлалтын хамт энэхүү тайлангийн Хавсралт А-И-д жагсаасан. Хавсралт А-И-д дурдсан мэдээлэл, тооцоолол, үнэлгээний хязгаарлалтын нөхцөл нь уг тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



Энэхүү тайланд тусгагдсан бизнестэй холбогдох шинжилгээ нь танай өгсөн мэдээлэлд үндэслэсэн. Бизнесийн үнэ цэнийг мэргэжлийн шүүмж (шийдэл) ашиглан тооцсон тул бусад үнэлгээчид үүнтэй ижил үр дүнг гаргахгүй байж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Бидэнд өгсөн мэдээлэл ба ашигласан төсөөллүүдэд суурилан бид энэхүү тайланд тооцоолсон үнэ цэнэ нь үл үндэслэлтэй гэж үзэж байна.

Энэ үнэлгээнд материаллаг үр нөлөөтэй аливаа мэдээллийг бид олж мэдсэн нөхцөлд холбогдох нэмэлт мэдээллийг тусгах үүднээс өөрсдийн үнэлгээний дүгнэлтээ шинэчлэн найруулах эрхтэй боловч ийм үүрэг хүлээхгүй.

Хэрэв танд аливаа тайлбар эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай бол Г.Баянмөнх-тай +976 9111 4040, bayalmunkh@bdo.mn гэсэн хаягаар, эсвэл Д.-Алтансүх +976 9999 1614, altansukh@bdo.mn хаягаар холбоо барина уу.

Таныг хүндэтгэсэн,

(Signature)

Гомбын БАЯНМӨНХ
Удирдах партнер
Тэргүүлэх үнэлгээчин
БДО Аудит ХХК

Даланбаярын АЛТАНСҮХ
Гүйцэтгэх захирал
МНБ
БДО Аудит ХХК



Тодорхойлолт, товчилсон үгийн тайлар



Товчилсон үг	Утга
БДО Монгол/Бид	БДО Аудит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 2546442 регистрийн дугаартай, аудит, үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж
Гэрээт ажлын захидал	2017 оны 12-р сарын 22-ны өдөр БДО Монгол болон Хөвсгөл Алтандуулга ХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө ба бизнесийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ
Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө	Газар тариалан ба боловсруулах үйлдвэрийн төсөлд багтсан бизнесийн үйл ажиллагааны ирээдүйн төлөвлөгөө
ЖААЗ	Жишиг арилжааны арга зүй
Жишиг арилжаа	Тайлангийн Хавсралт Е-д тодорхойлсон зах зээлийн арилжаанууд
Жишиг компани	Тайлангийн Хавсралт Г-д тодорхойлсон нээлттэй компаниуд
ЖКАЗ	Жишиг компанийн арга зүй
Зах зээлийн хандлага	Зах зээлийн өгөгдлөөс үүссэн үнэлгээний үржүүлэгч, өмнөх арилжааны харьцуулалтад үндэслэдэг үнэлгээний хандлага
КЖДӨ	Капиталын жигнэсэн дундаж өртөг
КХҮЗ	Капитал хөрөнгө үнэлгээний загвар
Орлогын хандлага	Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэд үндэслэдэг үнэлгээний арга
Оруулсан капиталын үнэ цэнэ	Эх үүсвэрээс үл хамааран бизнест одоогоор оруулсан байгаа мөнгөний нийт дүн бөгөөд нийт хөрөнгөөс өр төлбөр болон мөнгийг хассан үнэ цэнэ байдлаар ихэвчлэн тодорхойлогддог.
Өмчийн үнэ цэнэ	Бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм.



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Товчилсон үг	Утга
ТЖХХБ	Түүхэн ХХ-р тайлант жил
ТЖХХТ	Ирээдүйн ХХ-р тайлант жил
ТЦАА	Тохируулсан цэвэр активын арга
Удирдлага	Хөвсгөл Алтандуулга ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэн
Үйлчлүүлэгч/Компани	Хөвсгөл Алтандуулга Хувьцаат Компани; Улсын бүртгэлийн 2034565 регистрийн дугаар бүхий 1710001001 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй газар тариалан, гурилын үйлдвэрлэлийн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж
Үнэлгээний баг	БДО Монголын арилжааны үйлчилгээний баг
Үнэлгээний өдөр	2017 оны 12-р сарын 31
ҮОУС	Үнэлгээний олон улсын стандартын консулаас бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт
ХМУ-ийн арга	Хорогдуулсан мөнгөн урсгалын арга
Хөрөнгийн хандлага	Бизнесийн нэгжийн тохируулсан цэвэр үнэ цэнэд суурилсан үнэлгээний хандлага
ХТӨА	ХҮҮ, татварын өмнөх ашиг
ХТЭХӨА/ХТЭӨА	ХҮҮ, татвар, элэгдэл, хорогдолын өмнөх ашиг
ХТЭХТТА	ХҮҮ, татвар, элэгдэл, хорогдол, түрээсийн төлбөрийн өмнөх ашиг



Тайлангийн агуулга

1. Хураангуй үр дүн	4	6.2 Санхүүгийн таамаглал	23
2. Үндсэн мэдээлэл	5	6.3 Зах зээлийн шинжилгээ	25
2.1 Захиалагчийн мэдээлэл	6	7. Үнэлгээний үр дүн	28
2.2 Гүйцэтгэчийн мэдээлэл	6	Орлогын хандлага: ХМУ загвар	29
2.3 Үнэлгээний зорилго	6	Зах зээлийн хандлага: ЖКАЗ	30
2.4 Үнэ цэнийн суурь	6	Зах зээлийн хандлага: ЖААЗ	31
2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд	8	Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр активын арга	32
2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал	9	Хавсралт	33
3. Салбарын тойм	10	Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл	34
3.1 Макро эдийн засаг	11	Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд	35
3.2 Хөрш орнуудын гурил үйлдвэрлэлийн салбар	12	Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг	36
3.3 Монгол улсын гурил үйлдвэрлэлийн салбар	13	Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл	39
4. Бизнесийн үндсэн мэдээлэл	14	Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл	41
4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл	15	Хавсралт Е. Жишиг арилжааны мэдээлэл	47
4.2 Орлого бий болгогч нэгж	16	Хавсралт Ё. Мэдээллийн эх сурвалж	48
5. Санхүүгийн мэдээлэл	17	Хавсралт Ж. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл	49
5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан	18	Хавсралт З. Үнэлгээний баг	50
5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан	19	Хавсралт И. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл	51
6. Үнэлгээний шинжилгээ	20		
6.1 Үнэлгээний арга хандлага	21		



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

1. Хураангуй үр дүн

Бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд бид жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаарх үнэлгээнд хорогдуулсан мөнгөн гүйлгээний загварыг удирдлагын төсөөлдөнд үндэслэн тооцсон. Ашигласан аргачлал тус бүрийн үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав.


Бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнийн дүгнэлт

- Бид мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгаасны үндсэнд дээр дурдсан арга хандлагуудаас Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүн нь үнэлгээний өдрөөр байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн.
- Тохируулсан цэвэр активын арга (ТЦАА)-аар тооцсон бизнесийн үнэ цэнэ буюу үнэлгээний өдөр компанийн хөрөнгийг зарж борлуулснаас олох эдийн засгийн өгөөжийг зах зээлийн харьцуулалтын арга тайлбарлаж чадахгүй байсан тул тасралтгүй байх төсөөлөл бүхий бизнесийн үнэ цэнийг төлөөлөх чадваргүй гэж үнэлгээний баг дүгнэсэн.
- Хөвсгөл Алтандуулга ХК нь үнэлгээний өдрийн байдлаар 3,406,508 мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөртэй, 506,452 мянган төгрөгийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөтэй тул бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнэ **18,228,596 - 21,244,239** мянган төгрөгийн хооронд байх үндэслэлтэй байна.

Бизнесийн 100%-ийн өмчийн хувь оролцооны үнэ цэнэ мянган төгрөг

Орлогын хандлага	ХМУ загвар	Дээд	21,244,239
		Доод	18,228,596
Зах зээлийн хандлага	ЖКАЗ	Дээд	18,799,991
		Доод	14,111,492
Хөрөнгийн хандлага	ТЦАА	Дээд	22,439,056
		Доод	20,067,972

Үнэ цэнийн дээд, доод хязгаар



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.



2. Үндсэн мэдээлэл



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

2.1 Захиалагчийн мэдээлэл

Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал багийн газар нутагт байрлах Хөвсгөл Алтандуулга ХК нь энэ үнэлгээний ажлын захиалагч тал бөгөөд бизнесийн үнэлгээний объект мөн.

2.2 Гүйцэтгэгчийн мэдээлэл

- Үнэлгээчин нь компанийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар, хөрөнгийн зах зээлд нэмэлт хувьцаа гаргах зориулалтаар тодорхойлж, үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүргүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.
- БДО Аудит ХХК нь захиалагчийн хүсэлтээр Компанийн газар тариалан, гурилын үйлдвэрлэл хамарсан бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч хараат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бус үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.

- Үнэлгээний багийг БДО Аудит ХХК-ийн үнэлгээ хариуцсан партнер ноён Г.Баянмөнх удирдан гүйцэтгэсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт 3-аас харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн түвэгтэй нөхцөл байдал үүсэх магадлал бага гэж таамагласан учраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн туслалцаа аваагүй.
- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Аудит ХХК нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан болно. Даатгалын гэрчилгээний хуулбарыг Хавсралт И-ээс харна уу.

БДО Аудит ХХК болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь компанид энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ

үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх ашиг сонирхлын зөрчилгүй болно.

2.3 Үнэлгээний зорилго

- БДО Монгол болон Хөвсгөл Алтандуулга компанийн хооронд 2017 оны 12-р сарын 22-нд байгуулсан үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээт ажлын захидалд заасан дагуу бид уг компанийн газар тариалан, гурилын үйлдвэрлэлийг хамарсан бизнесийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэхээр сонгогдсон.
- Үйлчлүүлэгч нь энэ үнэлгээний тайланг зөвхөн хөрөнгийн зах зээлд нэмж хувьцаа гаргах дотоод зорилгоор ашиглана. Бидний шинжилгээний үр дүн нь хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргах үндэслэл болохгүй.

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн бүртгэлийн дүрмийн дагуу бид өөрсдийн бэлтгэсэн үнэлгээний тайланд тусгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.

2.4 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын консул (УОУК)-ын бэлтгэн томилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (УОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.
- Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь УОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу нь "зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжавал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн"-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:



“Тооцоолсон дүн” - харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс үл үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.

“Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино” - гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.

“Үнэлгээний өдрөөр” - гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дурын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.

“Бэлэн байгаа худалдан авагч” - гэдэг нь худалдан авах сэдэл санаачлагатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь “тухайн зах зээл”-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.

“Бэлэн байгаа борлуулагч” - нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг үл үндэслэлтэйгээр харгалаан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачлагатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.

“Хамааралгүй талуудын ажил гүйлгээ” нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.

“Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа” - гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой. Зах зээлд гарган таниулах хугацаа нь үнэлгээний өдрөөс өмнө байна.

“Талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй” - гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар үл үндэслэлтэйгээр мэдээлсэн байна гэсэн урьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Суурин хувьд хамгийн тааламжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгөөр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөгөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

“Албан шахалт шаардлагагүй” - гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачлагатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

■ Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн туршид монгол төгрөгөөр, мянган оронгийн нарийвчлалтайгаар ашигласан. Иймд үнэлгээний валют нь монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг болно.

2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд

- Бид дараах таамаглал ба төсөөллийг дэвшүүлснээр 100 хувийн өмчийн тооцолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон. Үүнд:
- Компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд өөрийн газар тариалан, гурилын үйлдвэрлэлийн бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэх үйл ажиллагааны төсөөлөл баримтална.
- Компанийн тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэл урьдчилан харах боломжтой ирээдүйд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй гэж таамагласан.
- Мөн урсгалын төсөөлөл нь Хөвсгөл Алтандуулгаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд суурилсан бөгөөд уг төлөвлөгөөнд тасралт агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой гэж таамагласан.

- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд багтсан аливаа тооцоолол нь бизнесийн үйл ажиллагааны хамгийн сайн ашиглалтад үндэслэсэн.

- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд үйлдвэрийн ирээдүйн хүчин чадал ашиглалтыг тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж таамагласан.

- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тодорхойлсноор компани нь 2021 он гэхэд 3950 га талбайд тариалалт хийж, 5.4 мянган тонн ургац хураахаар таамагласан. Гурилын үйлдвэрлэл мөн онд 17.3 мянган тонн буудай тээрэмдэж, 12.7 мянган тонн дээд ба нэгдүгээр гурил борлуулахаар төсөөлсөн. Гурилын борлуулалтын хэмжээ ТЖ19-ТЖ21 оны хооронд жилд дунджаар 27%-иар өснө. Гурилын борлуулалтын үнэ бизнесийн төлөвлөгөөний туршид өөрчлөгдөхгүй бөгөөд ТЖ17 оны жишиг үнэ тогтмол хадгалагдана.

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэх аливаа техникийн эвдрэл, гэмтэл, энгийн болон энгийн бус элэгдэл, хоргодол, ажиллах хүчний зардлын өсөлт үүсэхгүй. Мөн түүнчлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг бууруулах өргөжилтийн тогтмол үр өгөөж, тогтмол зардлын бууралт үүсэхгүй.

- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт компанийн бизнесийн үйл ажиллагаа болон газар эзэмших эрхийн хүчин төгөлдөр байдалд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй.

- Компанийн бизнес нь Монгол улсын татварын хуулиар зохицуулагдах бөгөөд урьдчилан харах боломжтой ирээдүйд мэдэгдэхүйц өөрчлөгдөхгүй гэж таамагласан.

- Компанийн санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, үнэлгээний өдрөөрх шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Газар тариалангийн бизнест мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг уурын таагүй нөхцөл урьдчилан харах боломжтой ирээдүйд үүсэхгүй.

2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үнэлгээний тайлан нь Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Монгол хэлнээс өөр хэлээр энэ тайланг орчуулах эрх зөвхөн БДО Аудит ХХК-д байна. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Гарын үсэг зурж, тамга дарсан хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.
- Үнэлгээний тайлангийн 2.3-т дурдсанчлан, үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хөрөнгийн зах зээл дээр нэмэлт хувьцаа гаргахаас өөр зорилгоор хувилж, эсвэл иш татаж ашиглахыг хориглоно. Энэхүү тайланг зөвхөн Хөвсгөл Алтандуулга ХК-ийн дотоод албан хэрэгцээнд ашиглана.



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.



3. Салбарын тойм




Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

3.1 Макро эдийн засаг

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 826.0 (5.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 573.9 (8.5%) тэрбум төгрөг, бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 191.8 (9.7%) тэрбум төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 259.1 (18.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Бодит ДНБ, улсын инфляцийн өөрчлөлт, %



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны эцсийн байдлаар 1.1% байсан инфляцийн түвшин 2017 оны жилийн эцэст 6.4% болж даруй 5.3%-иар өссөн. 2018 онд төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үзэл баримтлалд инфляцийн зорилтот түвшинг 8%-д барихаар баталсан.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 оны эцэст 15.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 76.6 (6.6%) тэрбум төгрөг, өмнөх оноос 3.6 (29.9%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд төгрөгийн хадгаламж 657.1 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны эцэст 823.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 70.4 (7.9%) тэрбум төгрөг, өмнөх оноос 81.0 (9.0%) тэрбум төгрөгөөр буураа. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.0 хувийг эзэлж, өмнөх сараас 0.6 пункт, өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, улсрулын эцсийн байдлаар

Тэрбум төгрөгөөр	2015Q4	2016Q4	2017Q4
Мөнгөний нийлүүлэлт, M2	10,049	12,159	15,798
Жилийн өөрчлөлт, %	-5.5%	21.0%	29.9%
Нийт хадгаламж	7,382	8,580	11,093
Жилийн өөрчлөлт, %	0.0%	16.2%	29.3%
Төгрөгийн хадгаламж	5,434	5,790	8,562
Жилийн өөрчлөлт, %	0.4%	6.5%	47.9%
Валютын хадгаламж	1,948	2,790	2,532
Жилийн өөрчлөлт, %	-1.1%	43.2%	-9.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төгрөгийн америк доллартой харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 12 дугаар сард 2433.49 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.08 (2.0%) төгрөг, өмнөх сараас 0.6 хувиар чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 12 дугаар сард 369.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.26 (2.9%) төгрөгөөр суларч, өмнөх сараас 0.2 хувиар чангарсан байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханш

Төгрөгөөр	2015Q4	2016Q4	2017Q4
Америк доллар	1,995.84	2,482.57	2,433.49
Жилийн өөрчлөлт, %	6.0%	24.4%	-2.0%
Евро	2,171.72	2,619.89	2,879.43
Жилийн өөрчлөлт, %	-6.5%	20.6%	9.9%
Юань	309.34	358.73	369.00
Жилийн өөрчлөлт, %	1.6%	16.0%	2.9%
Рубль	28.57	40.00	41.52
Жилийн өөрчлөлт, %	-15.6%	40.0%	3.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 8.9 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оноос 1.9 их наяд төгрөгөөр буурахад татварын орлого 1.4 (27.3%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.

- Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (27.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.3 (26.1%) тэрбум америк доллароор, импорт 977.3 (29.1%) сая америк доллароор тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2016 онд 1.6 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2017 онд өмнөх оноос 307 (19.7%) сая америк доллароор нэмэгдэж, 1.9 тэрбум америк долларт хүрсэн. Экспорт 2017 онд өмнөх оноос 1.3 тэрбум америк доллароор өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум америк доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Гадаад худалдааны төлөв байдал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.6 хувийг эзэлж байгаа бол импортын 67.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин, механик төхөөрөмж,

National Bureau of Statistics of China, China Insight Consultancy Limited.
http://www.hkexnews.hk/APPI/SEHK/2017/2017110602/at13220/ETPHL-20171106-14.PDF


Хуудас 12 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

3.2 Хөрш орнуудын гурил үйлдвэрлэлийн салбар

- БНХАУ дахь гурил үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2012 оны 70.2 сая тонноос тогтвортой өсөж 2016 онд 76.9 сая тоннд хүрсэн. Энэ хугацааны туршид хуримтлагдсан өсөлтийн хувь 2.3% байсан. Үр тариа тээрэмдэх технологи сайжирснаар салбарын бүтээмж нэмэгдсэн нь гурил үйлдвэрлэл өсөх гол шалтгаан болсон. БНХАУ-ын статистикийн хороо²-ны таамагласнаар 2021 он гэхэд БНХАУ дахь нийт гурил үйлдвэрлэл 85.4 сая тоннд хүрч, хуримтлагдсан өсөлт 2.1% байхаар хүрэхээр хүлээгдэж байна.

Гурилын нийт үйлдвэрлэлийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: National Bureau of Statistics of China

- ОХУ болон хар тэнгисийн орнууд нь дэлхийн нийт үр тариа экспортын 30 орчим хувийг хангадаг. Европын гурил үйлдвэрлэгчдийн холбоо²-ны тэмдэглэснээр 2015 оны эцсийн байдлаар ОХУ-д 295 гурилын аж үйлдвэр, 3000 орчим жижиг тээрэм бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр үйлдвэрүүд жилд дунджаар 13.7 сая тонн гурил үйлдвэрлэдэг.

² http://www.world-grain.com/Departments/Country-Focus/Country-Focus-Home/Focus-on-Russia.aspx?cck=1




Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

3.3 Монгол улсын гурил үйлдвэрлэлийн салбар

Монгол улсын гурилын зах зээлийн нийт багтаамж 2017 оны эцсийн байдлаар 208.5 мянган тонн буюу 225.7 тэрбум төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс даруй 21 хувиар өссөн байна.

Монгол улс дахь гурил үйлдвэрлэл, борлуулалт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Гурилын борлуулалт ирэх жилүүдэд харьцангуй тогтвортой өсөхөөр хүлээгдэж байна. Энэ нь нэг талаас эдийн засгийн орчин өнгөрсөн жилээс сайжирсан, өрхийн хэрэглээний зардал дахь хүнсний хэрэглээ өсөх хандлагатай байгаатай холбоотой. Тухайлбал, 2016 онд эдийн засгийн өсөлт 1%-тай байхад гурилын нийт борлуулалт 4 хувиар буурсан бол 2017 онд өсөлт 6%-д хүрэхэд даруй 21 хувиар өссөн.

Энэ салбарын голлох тоглогчдод Алтан тариа, Улаанбаатар, Милл Хаус, Нүүдэлчин групп, Од групп, Дорнод гурил, Хангайн гурил, Гацуурт зэрэг багтана. 2017 оны байдлаар гурилын зах зээлд Улаанбаатар гурил ХХК эргүүлдэг. Алтан тариа ХХК удаалж байна. Мөн Милл Хаус, Од групп компаниуд тус тусад нь нийт зах зээлийн 10 хувийг эзэлж байна.

Салбарын өрсөлдөөн 2009 оноос хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн нь өрхийн хэрэглээгээс гадна нарийн боовны цех, нийтийн хоолны салбарын өсөлт уг зах зээлд нөлөөлж байна.

зээлд нэмэлт эрэлт үүсгэснээс болсон. Эцсийн хэрэглэгчдийн хэрэглээний зан төлөв богино хугацаанд өөрчлөгдөх хандлага байгаа тул цаашид гурил, гурилан бүтээгдэхүүний эрэлт тогтвортой хадгалагдана гэж таамаглаж байна.


Салбарын гол тоглогчдын зах зээлд эзлэх байр суурь (ойролцоолсон дүн)



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Богино хугацаанд гурилын нийт үйлдвэрийн хэмжээ 5-9 хувиар, салбарын нийт борлуулалтын орлого 10-15 хувиар өсөх төлөвтэй байна. Салбарын түүхэнд өгөгдөлд үндэслэн тооцвол 2021 онд гурилын нийт үйлдвэрлэл 280 мянган тонн, нийт борлуулалтын орлого 300 тэрбум төгрөг байхаар хүлээгдэж байна.

Гурилын үйлдвэрлэлийн цаашдын төлөв



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

4. Бизнесийн үндсэн мэдээлэл



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан


Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл

Хөвсгөл Алтандуулга ХК нь 1996 оны 04 сарын 25-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан.

- 2005 оны 10 сарын 28-ны өдөр Монгол улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, Улсын бүртгэлийн 2034565 регистрийн дугаар бүхий 1710001001 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.
- Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 6-р сарын 11-ний өдрийн А/226 тоот тушаалаар улаан буудайн нутагшуулсан элит болон сортын үр үйлдвэрлэх, үржүүлэх үйл ажиллагааны 20147053 тоот тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан.
- Компанийн үндсэн үйл ажиллагаа нь газар тариалан, гурилын үйлдвэрлэл бөгөөд тайлант жил үйл ажиллагаанд аливаа өөрчлөлт ороогүй болно. 2017 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 58 ажиллагсадтай байна.

Хувьцаа эзэмшигчдийн өмчийн бүтэц



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан




Монгол улсын БОД Аудит АХХ нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

4.2 Орлого бий болгогч нэгж

Компани нь газар тариалан, гурилын үйлдвэрлэл гэсэн үйл ажиллагааны үндсэн хоёр сегменттэй. Газар тариалангийн сегмент нь 7000 га эргэлтийн талбайд улаан буудай, овёёс тариалж, хураасан ургацынхаа дийлэнх хэсгийг гурилын үйлдвэр рүү шилжүүлдэг. Гурилын үйлдвэр нь хоногт 100 тн, жилд 26 мянган тонн буудай тээрэмдэх хүчин чадалтай. Одоогоор гурилын үйлдвэрийн хүчин чадал ашиглалт 25 орчим хувьтай байна.

- Гурилын сегментийн орлого нь тус компанийн бизнесийн гол мөнгө бий болгогч нэгж бөгөөд гурилын борлуулалт ТЖ15 онд 2.9 тэрбум төгрөг байсан бол ТЖ16 онд 2 тэрбум төгрөг болж 30 гаруй хувиар буурсан.
- Харин буудай, хивэг, бусад борлуулалтын орлого ТЖ16 онд мэдэгдэхүйц нэмэгдэж, орлогын багцын диверсификаци сайжирсан. ТЖ16 онд гурилын борлуулалтын орлого нийт борлуулалт 66 хувийг эзэлсэн нь ТЖ14 онтой харьцуулахад даруй 8 хувиар буурсан үзүүлэлт юм. Эсрэгээр буудайн борлуулалтын орлого нийт борлуулалтын 20 хувь болж ТЖ14 онтой харьцуулахад 4 хувиар, хивэг борлуулалтын орлого 10 хувь болж ТЖ14 оноос 1 хувиар тус тус нэмэгдсэн.


Борлуулалтын орлогын бүрэлдэхүүн (сая төгрөг)




Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Борлуулалтын орлогын бүрэлдэхүүн, %



ТЖ14



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.



5. Санхүүгийн мэдээлэл



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан

Сүүлийн гурван жилийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөг	ТЖ15	ТЖ16	ТЖ17
Өмч, барилга, тоног төхөөрөмж	4,440,795	4,022,173	9,155,265
Биет бус хөрөнгө	463,000	467,082	2,315,792
Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,333	3,333	1,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,907,128	4,492,588	11,472,057
Бараа материал	929,390	1,600,106	1,266,220
Худалдааны болон бусад авлага	513,902	440,934	1,448,215
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,950	50,180	506,452
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,447,242	2,091,220	3,220,887
Нийт хөрөнгө	6,354,370	6,583,808	14,692,944
Хувьцаат капитал	102,225	102,225	102,225
Хуримтлагдсан ашиг, алдагдал	3,035,559	3,030,522	10,346,305
Нийт өмч	3,137,784	3,132,747	10,448,530
Урт хугацаат зээл	1,790,976	541,119	-
Бусад урт хугацаат өр төлбөр	201,811	201,811	201,811
Урт хугацаат өр төлбөр	1,992,787	742,930	201,811
Худалдааны болон бусад өглөг	934,740	674,304	810,615
Татварын өглөг	25,474	39,683	27,291
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	263,585	1,994,144	3,204,697
Богино хугацаат өр төлбөр	1,223,799	2,708,131	4,042,603
Нийт өр төлбөр	3,216,586	3,451,061	4,244,414
Нийт өмч ба өр төлбөр	6,354,370	6,583,808	14,692,944

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- Хөвсгөл Алтандуула ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэггүй бөгөөд удирдлагын баг санхүүгийн тайланд бэлтгэнэ толилуулах үүрэгтэй.
- Өмч, барилга, тоног төхөөрөмжийн ТЖ17-ийн үзүүлэлт нь энэ тайлангаас тусдаа гаргасан Хөвсгөл Алтандуула ХК-ийн 2017 оны 12 сарын 31-нээрх биет болон биет бус хөрөнгийн үнэлгээний тайлан дахь хөдлөх хөрөнгийн үнэлэгдсэн дүнг илэрхийлнэ.
- Биет бус хөрөнгө нь анх олж бэлтгэх өртгөөр хэмжигдэж, 2017 оны 12 сарын 31-нээр өдрийн байдлаар дахин үнэлгээний сууриар хэмжигдсэн газар эзэмших, ашиглах эрх болон бараан тэмдгийн өнөөгийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ.
- Бараа материал нь өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжигдсэн.
- Авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээр хэмжигдсэн.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Сүүлийн гурван жилийн аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

Мягган төгрөг	ТЖ15	ТЖ16	ТЖ17
Борлуулалтын орлого	3,473,700	3,036,492	2,461,115
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(3,112,585)	(2,347,149)	(1,996,755)
Нийт ашиг	361,115	689,343	464,360
Ерөнхий Удирдлагын зардал	(576,970)	(521,752)	(430,960)
Үйл ажиллагааны ашиг	(215,855)	167,592	33,400
Санхүүгийн орлого, зардал	(326,755)	(480,451)	(409,534)
Бусад орлого, зардал	222,379	228,470	413,019
Бусад олз, гарз	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	(320,231)	(84,389)	36,885
Орлогын татварын зардал	(3,638)	(513)	(42)
Нийт татварын зардал	(3,638)	(513)	(42)
Цэвэр ашиг	(323,869)	(84,902)	36,843

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

■ Компанийн борлуулалт нь өөрийн эзэмшлийн хөдөө аж ахуйн эдлэлбэр газарт тариалсан үр тариаг өөрийн үйлдвэрт боловсруулан гурил үйлдвэрлэж, борлуулсан орлого болон малын тэжээл, үр тарианы борлуулалтаас олсон орлогоос бүрдэнэ.

■ Компани нь ТЖ15 болон ТЖ17 оны тайлант жилүүдэд тариалсан ургацын нэлээд хэсгийг байгал, цаг уурын хүчин зүйлээс улбаалан алдсан нь компанийн борлуулалтыг бууруулах нөлөө үзүүлсэн.

■ Нөгөө талаас компани хонотт 100 тонн буудай тээрэмдэж гурил үйлдвэрлэх хүчин чадалтай гурилын үйлдвэрийн 25 орчим хувийг ашигладаг тул тайлант жилийн борлуулалт нь боломжит борлуулалтын ердөө 25%-тай тэнцүү байна.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

6. Үнэлгээний шинжилгээ



6.1 Үнэлгээний арга хандлага

Бизнесийн өмчийн үнэ цэнийг үнэлэхдээ бид дараах зүйлсийг нэгтгэн авч үзсэн. Үүнд:

Газар тариалан, гурилын үйлдвэрийг хамарсан бизнесийн зах зээлийн үнэ цэнэ;

Компанийн эзэмшиж буй биет ба биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ;

Компанийн үндсэн бизнесийн шугам нь газар тариалан, гурилын үйлдвэрлэл бөгөөд энэ бизнесийн шугамаас өөр аливаа үйл ажиллагаа, түүнээс бий болсон орлого түүхэн тайлант хугацаанд үүсээгүй болно.

Компанийн бизнесийг үнэлэхдээ бид дараах төсөөлдөлд үндэслэн орлогын хандлагаас ХМУ-ний загвар, зах зээлийн хандлагаас жишиг компани ба жишиг арилжааны арга зүйг сонгон ашигласан бөгөөд хөрөнгийн хандлагаарх үнэлгээнд ач холбогдол өгөөгүй ч үнэ цэнийн баталгаажуулалт хийх зорилгоор авч үзсэн. Бизнес ба бизнесийн хувь оролцооны үнэлгээнд ашигладаг нийтлэг хандлагуудын хураангуй тайлбаруудыг Хавсралт Б-ээс дэлгэрүүлнэ үү.

Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлагыг тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх төсөөлөл баримталдаг. Иймээс тасралтгүй хугацаанд уг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн ХМУ-ний загвар боловсруулах боломжтой.

Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн хандлагыг ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдчтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг. Хөдөө аж ахуйн салбарын уламжлалт эрх зүйлээс (нийт нийлүүлэлт тогтвортой бус, гурилын үнэд нөлөөлөх чадвар сул, салбарын өрсөлдөөн хүчтэй, уур амьсгал, цаг уурын эрсдэлд мэдрэмтгий) шалтгаалан дан ганц ХМУ загвар ашиглан үнэ цэнэ тооцох нь

хангалтгүй бөгөөд хүрэлцээгүй гэж бид үзсэн. Иймээс сүүлийн жилүүдэд гурил үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн бодит арилжаа, нээлттэй жишиг компаниудын зах зээлийн үнэ цэнийг шинжлэх замаар үнэлгээний өдрөөр байдлаар зах зээлийн арилжааны ханшийг тогтоосон. Хавсралт Г-д зах зээлийн хандлагаарх үнэлгээнд ашиглагдсан жишиг компаниудын хураангуй танилцуулгыг тусгасан.

Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын догол мөр 70.2 юм уу 70.3-ын шалгуурыг маш цөөн тохиолдолд хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагыг ихэвчлэн хэрэглэдэггүй. Гэсэн ч хөрөнгөд суурилсан бизнесийн хувьд орлого болон зах зээлийн хандлагын үр дүнг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн аргаар үнэлгээ бэлтгэж болно.

Орлогын ба зах зээлийн хандлагаарх үнэлгээний үр дүн хоорондоо нийцгүй байж болно. Энэ нь үнэлгээний хандлагуудын дотоод шинж чанараас ихээхэн хамаарна. Тухайлбал, ХМУ-ний хандлага нь ирээдүйд бүтээн босгох үйлдвэрийн ажилд шаардагдах капитал, хугацааны мэдээллийг тусгахад хамгийн зохистой хандлага юм. Харин зах зээлийн хандлага нь салбарын өнөөгийн төлөв байдал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, хөрөнгө оруулагчдын хандлагыг тусгахад илүү тохиромжтой байдаг.

Зах зээлийн хандлага: Жишиг компанийн арга зүй (ЖКАЗ) ба жишиг арилжааны арга зүй (ЖААЗ)

Бизнес дэх өмчийн сонирхлыг үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийг нээлттэй компаниуд болон (1) ижил буюу төстэй бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг (2) эдийн засгийн, байгаль орчны, улсын төрлийн эрсдэлд адилхан өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон эдгээр компанийн бодит арилжаатай харьцуулдаг.

Дээрх хоёр арга зүйг дараах байдлаар тодорхойлдог:

ЖКАЗ: Энэ арга зүй нь нээлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил шугаманд үйл ажиллагаа явуулдаг компаниудын



Хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэнэ тодорхой болдог.

- ЖААЗ: Энэ арга зүйг мөн “арилжааны арга” эсвэл “нэгдэл ба худалдан авалтын арга” гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг. Ингэснээр арилжаалагдахуйц хяналтын эрхтэй сонирхлоор зах зээлийн үнэ цэнэ тодорхой болдог.

■ Бид өөрсдийн дотоод мэдээллийн сан болон албан ёсны төлбөртэй мэдээллийн эх сурвалжид үндэслэн үнэлгээний шинжилгээнд ЖКАЗ болон ЖААЗ-н аль алиныг авч үзсэн.

■ Жишиг компани болон жишиг арилжааны арга зүйд үндэслэн зах зээлийн үржүүлэгчдийг бид дараах байдлаар тооцсон:

- ЖКАЗ: Бид үнэлгээний өдрөөрх жишиг компаниудын зах зээлийн үнэ ба эдгээр компаниудын санхүүгийн гүйцэтгэлийг харгалзан цашид ашиглах үнийн үржүүлэгчийг тодорхойлно. Ингэхдээ жишиг компани тус бүрийн хувьд үнэлгээний өдрөөрх үржүүлэгчдийг албан ёсны мэдээллийн эх сурвалж болон өөрсдийн дотоод шинжилгээнд үндэслэн тооцсон.

- ЖААЗ: Жишиг арилжааны хэлцлийн үнэ, тэдгээртэй холбогдох санхүү ба үйлдвэрлэлийн хэмжүүр үзүүлэлтүүдийн харилцан хамаарлыг олж тогтооно. Арилжааны эрх зүйн байдал, компанийн өөрчлөн байгуулалт, шинэчлэгдсэн бүтцийг шинжилж арилжааны ханшаар илэрхийлэгдэх үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлно.

Орлогын хандлага: ХМУ-ын загвар

Ирээдүйн мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнийн шинжилгээ буюу ХМУ-ий загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь бизнесийн үнэ

Хөрөнгийн зах зээл дээр өмчийн үнэт цаас сарагах зорилгоор хийгдэж буй үнэлгээний ажил үйлдвэрлэлээр илэрхийлэгдсэн үр дүн илүү тохиромжтой байдаг.

Хуудас 22 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

цэнийг илтгэнэ гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг капиталын жигнэсэн дундаж өртгөөр хорогдуулдаг. Хэрэв мөнгөн урсгалын төсөөлөл нь шууд өмч рүү чиглэсэн бол өмчийн өртгийг хорогдуулах хүү болгон ашигладаг. КЖДӨ-ийн бүрэлдэхүүн болох өмчийн капиталын өртгийг Капитал хөрөнгө үнэлгээний загвар (КХХЗ) ашиглан тооцно.

■ Мөнгөн урсгалын прогноз эсвэл хорогдуулах хүүний аль нэгэнд тусгагдаагүй хүчин зүйлийг тодорхойлох нь орлогын хандлагаарх үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, үнэлж буй хувь оролцооны зах зээлд арилжаалагдах чадвар, эсвэл бизнесийн хяналтын юм уу хяналтын бус хувь оролцоо гэдгээс шалтгаалан холбогдох тохируулга хийгдэнэ. Хэрэв дээрх хүчин зүйлс аль хэдийн мөнгөн урсгалын төсөөлөлд багтсан бол хорогдуулах хүүнд тохируулга хийх шаардлагагүй байдаг. Үйлчлүүлэгчийн бизнесийн загвар, үнэлгээний зорилгод нийцгүй гэж үзэж, мөнгөн урсгалын загварт хяналттай нэмэгдэл, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулаг тооцоогүй.

■ Хорогдуулсан мөнгөн урсгалын тооцоололтой холбогдон эдийн засгийн болон салбарын ирээдүйн төлөв байдлыг зайлшгүй харгалзан үздэг. Бид үйлчлүүлэгчийн газар тариалангийн бизнест учирч болзошгүй аливаа эрсдэл, боломжийг шинжлэхийн тулд гадаад болон дотоод орчны эрсдэлийг онилсон салбарын судалгаа бэлтгэсэн. Дотоод орчны эрсдэлд салбарын өрсөлдөөн, нийлүүлэлтийн болон эрэлтийн шок, салбарт шинээр нэвтрэх болон гарах зардал, орлуулах бүтээгдэхүүний нөлөө зэргийг харгалзан үзсэн бол гадаад орчны эрсдэлд макро эдийн засгийн орчин, технологийн өөрчлөлт, хүн ам зүйн нөлөө, эрх зүйн орчин, нийгмийн нөлөөг багтаан судалсан.

■ Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь тодорхой бус шинжтэй тул холбогдох эрсдэлийг бууруулах зорилгоор бид олон хувилбар бүхий БДО Корпорацийн санхүүгийн загвар боловсруулж, үнэлгээний үр дүнг олон талаас шинжилдэг. БДО Корпорацийн санхүүгийн загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын хамгийн багадаа гурван хувилбарыг үнэлж, бизнесийн үнэ цэнийг харуулдаг. Ингэснээр үнэлгээний үр дүнг тодорхой интервалаар илэрхийлэх боломжтой болдог.³



6.2 Санхүүгийн таамаглал

Компанийн дунд хугацааны санхүүгийн таамаглал нь удирдлагын бэлтгэсэн Газар тариалан ба боловсруулах үйлдвэрийн төсөлд үндэслэсэн бөгөөд ҮОУС 105-Үнэлгээний хандлагууд ба аргууд, 10.7-р догол мөрний дагуу үнэлгээний орц мэдээлэл үнэлгээний зорилгод тохиромжтой эсэхийг нягталсан.

Үйлдвэрлэл ба борлуулалтын хэмжээ

- Газар тариалан ба боловсруулах үйлдвэрийн төсөлд тодорхойлсны дагуу компани нь 2022 он гэхэд 3950 га талбайд үр тариа тариалж, 1 га талбайгаас 12-13 центнер ургац хураах боломжтой. Гурилын үйлдвэр 2018 онд 8.2 мянган тонн гурил тээрэмдэж, цаашлаад хүчин чадал ашиглалтыг дээд хязгаарт хүргэхээр төлөвлөсөн.

Гурил үйлдвэрлэл ба борлуулалтын төсөөлөл, тонн



Эх сурвалж: Хөвсгөл Алтандуулга ХК-ийн газар тариалан ба боловсруулах үйлдвэрийн төсөл



Борлуулалтын үнэ

- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд гурилын борлуулалтын үнэ 2017 оны түвшинд тогтвортой хадгалагдан гэж таамагласан. Инфляцийн өсөлтийг борлуулалтын үнээр дамжуулан хязгаарласан тул хорогдуулах хүүний тооцоололд уг нөлөөллийг тусгах зорилгоор бодит хүү ашигласан (инфляцийн төсөөлөл хэсгийг харна уу).

Өнгөрсөн арван жилийн гурилын дундаж үнэ, нэг кг

Огноо	төгрөг
ТЖ08 оны жилийн эцэс	860.95
ТЖ09 оны жилийн эцэс	759.85
ТЖ10 оны жилийн эцэс	677.52
ТЖ11 оны жилийн эцэс	759.62
ТЖ12 оны жилийн эцэс	800.52
ТЖ13 оны жилийн эцэс	834.29
ТЖ14 оны жилийн эцэс	986.67
ТЖ15 оны жилийн эцэс	1114.57
ТЖ16 оны жилийн эцэс	1159.14
ТЖ17 оны жилийн эцэс	1422.00

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

- Бид дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан хөдөлмөрийн орцын мэдээлэлд үндэслэн шууд хөдөлмөрийн зардлыг тооцсон. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг хууль, тогтоомжийн дагуу тооцож, мөнгөн урсгалын тооцоололд багтаасан.


- Гурил үйлдвэрлэх өртөг нь шууд хөдөлмөр, шууд материал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг хувьсах ба тогтмол зардал гэж ангилна. ҮНЗ-ын тогтмол хэсэгт капиталын өртгийг системтэйгээр зардалд шингээнэ. Шууд хөдөлмөрт үйлдвэрлэлд шууд оролцох нэгж хэсгүүдийн ажилчдын цалин хөлс, түүнтэй адилтгах бусад зардал хамаарна.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Доорх дүрслэлд тод саарал цэнхэр өнгөөр борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өөрчлөлт, ногоон өнгөөр борлуулалтын орлого, бүдэг саарал өнгөөр нийт ашгийн түвшинг илэрхийлсэн.

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн динамик



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Таамагласан хугацааны туршид үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж үйл ажиллагааны хөшүүргийн нөлөөгөөр бүтээгдэхүүний өртөг буурна гэж таамагласан.

Удирдлага борлуулалтын зардал

Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд үндэслэн бид удирдлага борлуулалтын зардлыг хувьсах ба тогтмол хэсгээр ангилсан. Хувьсах зардалд цалин хөлс, маркетингийн зардлууд багтах бөгөөд таамагласан ирэх 5 жилийн хугацаанд маркетинг борлуулалтын зардал дунджаар 4%-иар өснө гэж таамагласан. Харин цалингийн зардлын ТЖ18-ТЖ20 он хүртэл бага хэмжээгээр өсөж үлдүүлийн хоёр жилд өргөжилтийн нөлөөгөөр 12%-иар өснө гэж таамагласан. Бусад зардлуудын нь таамагласан хугацаанд тогтмол байхаар хүлээгдэж байна. Түүхэн санхүүгийн мэдээллээс харахад үйлчлүүлэгчийн үйл

ажиллагааны зардал ТЖ17 онд 363,136 мянган төгрөг байсан нь зардлын таамагласан утгаас хэт зөрүүгүй тул үндэслэлтэй гэж үзсэн.

Капиталын зардал

Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тодорхойлсны дагуу үйлчлүүлэгч нь газар тариалангийн нэмэлт тоног төхөөрөмж болон 1441 га талбайн хашаажуулалтад 900,000 мянган төгрөг, гурил тэжээлийн үйлдвэрийн нэмэлт тоног төхөөрөмжид 300,000 мянган төгрөг, 10 мянган тоннын багтаамжтай үр тарианы босоо агуулахад 1,000,000 мянган төгрөг, ажлын капиталд 3,200,000 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Капиталын зардлын төсөөлөл

мян төгрөг	
Босоо агуулах (10,000 тн)	1,000,000
Газар тариалангийн тоног төхөөрөмж	900,000
Гурил, тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	300,000
Ажлын капитал	3,200,000
Төлөвлөсөн анхны хөрөнгө оруулалт	5,400,000
Төлөвлөсөн анхны хөрөнгө оруулалт (ажлын капитал ороогүй)	2,200,000

Эх сурвалж: Хөвсгөл Алтандуулга ХК-ийн газар тариалан ба боловсруулах үйлдвэрийн төсөл

Элэгдэл, хорогдлын зардал

Хөрөнгийн ашиглалтын хугацааг Монгол улсын татварын хууль тогтоомжийг дагуу тооцсон. Элэгдэл, хорогдлын зардлын дийлэнх хэсэг эцсийн бүтээгдэхүүний өртөгт шингэн мөнгөн урсгалын тооцоололд багтсан. Удирдлага, борлуулалттай холбоотой элэгдлийн зардал ТЖ18 онд 38,693 мянган төгрөг, цаашид 40,290 мянган төгрөгөөр тогтмол хадгалагдахаар хүлээгдэж байна.

Татвар ба төлбөр, хураамж

Мөнгөн урсгалын төсөөлөлд багтсан татвар ба төлбөр, хураамжийн тооцоолол нь Монгол улсын татварын хууль, тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн. Үндсэн татвар ба төлбөр, хураамжид орлогын албан татвар, газрын төлбөр багтана.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан дагуу 3,000,000 мянган төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10%-ийн татвар, 3,000,000 мянган төгрөгөөс дээш давсан дүнд 25%-ийн орлогын албан татвар ногдуулна.

Мөнгөн урсгал таамагласан хугацаа

- Бизнесийн үнэлгээний практикт мөнгөн урсгалыг ихэвчлэн хугацааны хоёр мөчлөгтэй тооцдог. Бид мөн уг практикийг баримтална (1) ТЖ18-ТЖ22 он хүртэлх таван жил, (2) ТЖ22 оноос цаашид хязгааргүй хугацаа⁴ -гаар мөнгөн урсгалыг таамагласан.

Инфляцийн түвшин

- Мөнгөн урсгалын төсөөлөлд үнэлгээний валютын үнэ цэнийн өөрчлөлтийг тусгахын тулд инфляцийн нөлөөг тусгах шаардлагатай болдог. Жишээлбэл, орлогын багцын дийлэнх хэсэг нь гадаад валютаар хэрэгждэг тохиолдолд тухайн гадаад валютын инфляцийг мөнгөн урсгалд, эсвэл хорогдуулах хүүний аль нэгэнд тусгах шаардлагатай. Хэрэв борлуулалтын үнийн өсөлтийг тооцох замаар инфляцийн нөлөөг мөнгөн урсгалд тусгасан бол хорогдуулах хүүг нэрлэсэн хүүгээр тооцох нь зохистой. Харин үнийн өсөлтийг шууд мөнгөн урсгалд тусгаагүй тохиолдолд хорогдуулах хүүд уг нөлөөг тохируулсан байх шаардлагатай.
- Бид өөрсдийн мөнгөн урсгалын төсөөлөлд төгрөгөөр илэрхийлэгдсэн үзүүлэлт ашигласан тул Монгол улсын инфляцийн түвшинг шинжилсэн. Мөнгөн урсгалын төсөөлөлд борлуулалтын үнийг тогтмол байдлаар тусгасан тул хорогдуулах хүүг бодит хүүгээр тооцсон.

Инфляцийн төсөөллийн хураангуй


Монгол улс	2015	2016	2017	2018	Урт хугацаанд
Эх сурвалж: Bloomberg, IMF	1.13%	0.48%	6.13%	6.07%	6.44%

Мөнгөн урсгалын төсөөлөлд практикт 50 жилээс дээш хугацааг хязгааргүй хугацаа гэж тайлбарладаг. Энэ нь тасралтгүй буюу дискрет мөнгөн урсгалын тооцоолол 50-иас дээш үеэр тооцоход тасралтгүй

Хуудас 28 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

- Олон улсын валютын санхүүгийн төсөөллөөр Монгол улсын инфляцийн түвшин 2018 онд 6.07%, урт хугацаанд 6.44% байхаар хүлээгдэж байна.

Инфляцийн урт хугацааны төсөөлөл



Эх сурвалж: Bloomberg, IMF

- Нэрлэсэн хүүг бодит хүүний рүү хөрвүүлэхдээ бид Фишерийн тэгшитгэл ашигласан бөгөөд тооцооллыг Хавсралт Д-гээс дэлгэрүүлнэ үү.

6.3 Зах зээлийн шинжилгээ

- Үнэлж буй бизнестэй ижил үйл ажиллагаа эрхэлдэг нээлттэй компаниудын зах зээлийн үнэлгээг бид шинжилсэн. Ингэхдээ гадаад зах зээл дэх ижил төстэй компаниудын зах зээлийн үнэлгээ, үнэлгээний үржүүлэгчдийг өөрсдийн өгөгдлийн санд тулгуурлан судалсан.
- Доорх хүснэгтэд үйлчлүүлэгчтэй ижил төстэй бизнес бүхий нээлттэй компаниудын зах зээлийн үнэлгээний гол үржүүлэгчид болон зарим харьцаануудыг хураангуйлав.

Буюу хязгааргүй хугацаанд тооцсон мөнгөн урсгалын үр дүнтэй материаллаг зөрүүгүй болбоотой холбоотой.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Зах зээлийн үнийн үржүүлэгчид

	Хувьцааны үнэ/Ашиг	Норматив-хувьцааны үнэ/Ашиг	Форвард үнэ/Ашиг	Хувьцааны үнэ/ХТЭХӨА	Норматив-хувьцааны үнэ/ХТЭХӨА	Хувьцааны үнэ/ХТЭХӨА	Норматив-хувьцааны үнэ/ХТЭХӨА	Хувьцааны үнэ/ХТЭХӨА	Хувьцааны үнэ/Чөлөөт үнэ/Мөнгөн урсгал	Хувьцааны үнэ/Мөнгөн урсгал	Хувьцааны үнэ/Дансны үнэ	Хувьцааны үнэ/Биет хөрөнгийн дансны үнэ
ADM	14.4x	14.5x	14.2x	8.3x	8.4x	8.3x	8.4x	0.4x	27.1x	12.1x	28.5x	1.2x
ABF	22.3x	27.7x	23.0x	12.2x	14.1x	10.8x	12.3x	1.7x	41.0x	17.6x	16.9x	3.2x
INGR	17.3x	16.7x	14.5x	8.6x	8.4x	8.6x	8.4x	1.4x	17.5x	10.9x	17.6x	3.1x
BG	21.6x	13.0x	17.4x	7.1x	5.9x	7.1x	5.9x	0.2x	13.2x	6.5x	10.6x	1.4x
524226	21.0x	21.0x	12.2x	8.7x	8.7x	8.7x	8.7x	0.7x				
01006	7.1x	6.8x	4.8x	4.8x	4.6x	4.8x	4.6x	0.6x	6.8x	5.2x	1.8x	0.8x
2009	18.0x	18.0x	12.0x	12.0x	12.0x	12.0x	12.0x	0.9x			1.9x	0.6x
1229	10.2x	10.5x	9.3x	9.3x	9.5x	9.3x	9.5x	5.9x	9.8x	9.1x	37.4x	1.2x
Медлан	17.6x	15.6x	14.5x	8.7x	8.5x	8.7x	8.5x	0.8x	15.4x	10.0x	16.9x	1.2x
Дундаж	16.5x	16.0x	16.3x	8.9x	8.9x	8.7x	8.7x	1.5x	19.2x	10.2x	16.4x	1.6x
Хамгийн их	22.3x	27.7x	23.0x	12.2x	14.1x	12.0x	12.3x	5.9x	41.0x	17.6x	37.4x	3.2x
Хамгийн бага	7.1x	6.8x	12.2x	4.8x	4.6x	4.8x	4.6x	0.2x	6.8x	5.2x	1.8x	0.6x

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Үнэлгээний зарим гол харьцаанууд

Үнэлгээний үржүүлэгчид	Медлан	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	25%	75%	Стандарт хаазилт	Вариацийн коэффициент
Байгууллагын үнэ цэнэ/ Орлого	0.6x	1.5x	0.3x	6.5x	0.4x	1.7x	2.1x	1.4x
Байгууллагын үнэ цэнэ/ ХТӨА	11.7x	12.1x	3.5x	19.3x	10.0x	16.0x	5.1x	0.4x
Нормативчилсан байгууллагын үнэ цэнэ/ ХТӨА	11.5x	11.8x	3.3x	19.7x	10.2x	14.6x	5.0x	0.4x
Байгууллагын үнэ цэнэ/ ХТЭХӨА	10.0x	9.0x	2.7x	11.9x	8.0x	10.7x	2.9x	0.3x
Нормативчилсан байгууллагын үнэ цэнэ/ ХТЭХӨА	9.3x	8.9x	2.6x	13.8x	8.0x	10.5x	3.2x	0.4x
Байгууллагын үнэ цэнэ/ Татварын өмнөх ашиг	12.9x	13.4x	3.4x	25.3x	10.0x	17.0x	6.7x	0.5x
Байгууллагын үнэ цэнэ/ Хөрөнгө	0.8x	1.0x	0.3x	2.0x	0.5x	1.4x	0.6x	0.7x
Байгууллагын үнэ цэнэ/ Чөлөөт мөнгөн урсгал	20.3x	21.6x	3.9x	40.2x	13.0x	31.0x	13.8x	0.6x
Байгууллагын үнэ цэнэ/ Форвард ХТЭХӨА	9.7x	9.6x	6.5x	12.3x	8.7x	10.8x	2.2x	0.2x
Байгууллагын үнэ цэнэ/ Форвард орлого	0.6x	0.9x	0.3x	1.7x	0.5x	1.5x	0.6x	0.7x
Зах зээлийн үнэлгээ/ Орлого	0.8x	1.5x	0.2x	5.9x	0.5x	1.5x	1.9x	1.3x
Зах зээлийн үнэлгээ/ ХТӨА	11.6x	11.3x	6.2x	16.5x	10.4x	12.1x	2.8x	0.3x
Зах зээлийн үнэлгээ/ ХТЭХӨА	8.3x	8.7x	4.8x	12.2x	7.8x	10.0x	2.5x	0.3x

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
2018.06.29 өдөр
01



2987103
ПРОЦЕСС

ХӨВСГӨЛ АИМ
Хуудас 36
ХӨВСГӨЛ АИМ
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ГБ3216 ш. 2034565



Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хүнсний чиглэлийн нээлттэй компаниудын зах зээлийн үнэлгээний зарим үзүүлэлтүүд

Мах Имтекс

СҮҮ		Талх чихэр		Атар өргөө			
Нийт хувьцааны тоо	3,800,721	Нийт хувьцааны тоо	344,000,000	Эргэлтэд байгаа хувьцааны тоо	1,023,703	Эргэлтэд байгаа хувьцааны тоо	174,136
Нэг хувьцааны зах зээлийн үнэ	2,900	Нэгж хувьцааны зах зээлийн үнэ	261	Нэгж хувьцааны зах зээлийн үнэ	28,800	Нэгж хувьцааны зах зээлийн үнэ	61,850
Зах зээлийн үнэлгээ	11,022,090,900	Зах зээлийн үнэлгээ	89,880,320,000	Зах зээлийн үнэлгээ	29,482,646,400	Зах зээлийн үнэлгээ	10,770,311,600
Зах зээлийн үнэлгээ	11,022,091	Зах зээлийн үнэлгээ	89,880,320	Зах зээлийн үнэлгээ	29,482,646	Зах зээлийн үнэлгээ	10,770,312
Санхүүгийн өр төлбөр	7,590	Санхүүгийн өр төлбөр	22,036,976	Санхүүгийн өр төлбөр	4,044,644	Санхүүгийн өр төлбөр	-
Мөнгөний үлдэгдэл	(104,269)	Мөнгөний үлдэгдэл	(437,867)	Мөнгөний үлдэгдэл	(303,618)	Мөнгөний үлдэгдэл	-
ААН-ийн үнэ цэнэ	10,925,412	ААН-ийн үнэ цэнэ	111,479,429	ААН-ийн үнэ цэнэ	33,223,673	ААН-ийн үнэ цэнэ	10,770,312
Борлуулалт	10,325,984	Борлуулалт	48,183,566	Борлуулалт	36,427,389	Борлуулалт	13,963,536
ХТӨӨА		ХТӨӨА		ХТӨӨА		ХТӨӨА	
Цэвэр ашиг	354,752	Цэвэр ашиг	2,430,128	Цэвэр ашиг	1,128,017	Цэвэр ашиг	313,253
Татвар	41,059	Татвар	225,238	Татвар	171,444	Татвар	82,612
ХҮҮ	42,805	ХҮҮ	2,447,712	ХҮҮ		ХҮҮ	
ХТӨА	438,616	ХТӨА	5,103,078	ХТӨА	1,299,461	ХТӨА	395,865
Элэгдэл		Элэгдэл	2,241,900	Элэгдэл		Элэгдэл	829,652
ХТӨӨА	438,616	ХТӨӨА	7,344,979	ХТӨӨА	1,299,461	ХТӨӨА	1,225,517
ААН-ийн үнэ цэнэ	10,925,412	ААН-ийн үнэ цэнэ	111,479,429	ААН-ийн үнэ цэнэ	33,223,673	ААН-ийн үнэ цэнэ	10,770,312
Биет бус хөрөнгө	(4,810)	Биет бус хөрөнгө	(1,546,062)	Биет бус хөрөнгө		Биет бус хөрөнгө	(2,372)
ААН-ийн биет хөрөнгө	10,920,602	ААН-ийн биет хөрөнгө	109,933,367	ААН-ийн биет хөрөнгө	33,223,673	ААН-ийн биет хөрөнгө	10,767,940
БҮЦ/ Борлуулалт	1.1x	БҮЦ/ Борлуулалт	2.3x	БҮЦ/ Борлуулалт	0.9x	БҮЦ/ Борлуулалт	0.8x
БҮЦ/ ХТЭЖӨА	24.9x	БҮЦ/ ХТЭЖӨА	15.2x	БҮЦ/ ХТЭЖӨА	25.6x	БҮЦ/ ХТЭЖӨА	8.8x
БҮЦ/ ХТӨА	24.9x	БҮЦ/ ХТӨА	21.8x	БҮЦ/ ХТӨА	25.6x	БҮЦ/ ХТӨА	27.2x
БҮЦ/ Биет хөрөнгө	1.0x	БҮЦ/ Биет хөрөнгө	1.0x	БҮЦ/ Биет хөрөнгө	1.0x	БҮЦ/ Биет хөрөнгө	1.0x

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.



7. Үнэлгээний үр дүн



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Орлогын хандлага: ХМУ загвар

Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийн доод, дээд хязгаарыг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Д-ээс дэлгэрүүлнэ үү.)

■ Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дүнд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн бөгөөд хорогдуулах хүүний тооцооллыг БДО Монгол-ын шинжилгээгээр 15.5%-иас 14.1% байхаар тооцсон. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметруудийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

- Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
- Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам-ны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.61%-ийг 3% болгон тохируулсан.
- Урт хугацааны хүлээгдэж буй инфляци 6.44% байна.
- Капиталын зардлыг санхүүжилтийн эхний жилд зарцуулна гэж таамагласан.
- Бид хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.
- Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн байгууллагад ногдох зах зээлийн үнэ цэнэ **21,128,652 - 24,144,295** мянган төгрөг байна.
- Үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгч нь 3,406,508 мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөр, 506,452 мянган төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй байсан. Иймээс бизнесийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнэ **18,228,596 - 21,244,239** мянган төгрөг байна.

Орлогын хандлагаар тооцсон үнэлгээний үр дүн

мянган төгрөг	Доод хязгаар	Дээд хязгаар
Бизнесийн чөлөөт мөнгөн урсгал	9,331,044	9,331,044
Бизнесийн үлдэх үнэ цэнэ	30,142,292	33,671,829
Бизнесийн үнэ цэнэ (мянган төгрөг)	21,128,652	24,144,295
Хасах: Санхүүгийн өр төлбөр	3,406,508	3,406,508
Нэмэх: Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	506,452	506,452
100%-ийн өмчийн үнэ цэнэ	18,228,596	21,244,239

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Зах зээлийн хандлага: ЖКАЗ

Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн зээлийн үнэлгээг тооцож, бизнесийн үнэ цэнийн доод, дээд хязгаарыг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Г-ээс дэлгэрүүлнэ үү.)

- Жишиг компанийн арга зүйгээр тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн байгууллагад ногдох зах зээлийн үнэ цэнэ **17,011,548 - 21,700,047** мянган төгрөг байна.
- Үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгч нь **3,406,508** мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөр, **506,452** мянган төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй байсан. Иймээс бизнесийн **100%**-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнэ **14,111,492 - 18,799,991** мянган төгрөг байна.

Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн

мянган төгрөг	LTM
Үйл ажиллагааны ашиг	106,657
Нэмэх: Бусад орлого	319,995
Нэмэх: Мөнгөн бус зардал	422,092
Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг	848,743

мянган төгрөг	БҮЦ/ХТЭХӨА	
	Дээд	Доод
Санхүүгийн хэмжүүр	848,743	848,743
Сонгосон үржүүлэгч	25.6x	20.0x
Бизнесийн байгууллагад ногдох үнэ цэнэ	21,700,047	17,011,548
Хасах: Санхүүгийн өр төлбөр	3,406,508	3,406,508
Нэмэх: Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	506,452	506,452

100%-ийн хувь оролцоонд ногдох үнэ цэнэ	18,799,991	14,111,492
---	------------	------------

Эх сурвалж: БДО Монгол Шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Зах зээлийн хандлага: ЖААЗ

Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын нэгдэл ба худалдан авалтын зах зээл дахь арилжаануудыг судлах замаар бизнесийн үнэ цэнийн доод, дээд хязгаарыг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Г-ээс дэлгэрүүлнэ үү.)

- Жишиг арилжааны аргаар тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн байгууллагад ногдох зах зээлийн үнэ цэнэ **22,968,028 - 25,339,112** мянган төгрөг байна.
- Үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгч нь **3,406,508** мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөр, **506,452** мянган төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй байсан. Иймээс бизнесийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнэ **20,067,972 - 22,439,056** мянган төгрөг байна.

Жишиг арилжааны аргаар тооцсон үнэлгээний үр дүн

мянган төгрөг	LTM
Үйл ажиллагааны ашиг	106,657
Нэмэх: Бусад орлого	319,995
Нэмэх: Мөнгөн бус зардал	422,092
Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг	848,743

мянган төгрөг	БҮЦ ХТЭХӨА	
	Дээд	Доод
Санхүүгийн хэмжүүр	848,743	848,743
Согдсон үржүүлэгч	29.9x	27.1x
Бизнесийн байгууллагад ногдох үнэ цэнэ	25,339,112	22,968,028
Нэмэх: Санхүүгийн өр төлбөр	3,406,508	3,406,508
Хасах: Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	506,452	506,452

100%-ийн хувь оролцоонд ногдох үнэ цэнэ 22,439,056 20,067,972

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр активын арга

Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлж, цэвэр активт тохируула хийх замаар бизнесийн үнэ цэнийн доод хязгаарыг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав.

- Хөвсгөл Алтандуула ХК-ийн биет ба биет бус хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгасны дараа үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ **10,448,530** мянган төгрөг байна.

Бизнесийн 100%-ийн өмчийн хувь оролцооны үнэ цэнэ-Цэвэр хөрөнгөөр

мянган төгрөг	ТЖ17
Өмч, барилга, тоног төхөөрөмж	9,155,265
Биет бус хөрөнгө	2,315,792
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,472,057
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,220,887
Нийт хөрөнгө	14,692,944
Хасах нь: Санхүүгийн бус өр төлбөр	(837,906)
Оруулсан капитал	13,855,038
Хасах нь: Санхүүгийн өр	(3,406,508)
100%-ийн хувь оролцоонд ногдох дүн	10,448,530

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт

- Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл
- Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд
- Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг
- Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл
- Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл
- Хавсралт Е. Жишиг арилжааны мэдээлэл
- Хавсралт Ё. Мэдээллийн эх сурвалж
- Хавсралт Ж. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл
- Хавсралт З. Үнэлгээний баг
- Хавсралт И. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл

Энэхүү тайланд багтсан үнэ цэнийн дүгнэлттэй холбогдох хязгаарлах нөхцөлийг доор хураангуйлан орууллаа.

- Энэхүү үнэлгээний тайлан нь бусад үнэлгээ эсвэл судалгаатай хамт хэрэглэгдэхгүй. Үнэлгээний дүгнэлт, тайланд багтсан судалгаа, гүйцэтгэсэн горимууд нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд эдгээрийг тусад нь салгаж хэрэглэхгүй.
- Үнэлгээг зөвхөн тайланд заасан зорилго, зориулалт, этгээдүүдэд л зориулж бэлтгэсэн. БДО Аудит ХХК-аас бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хувилах, энд дурдсан мэдээлэл, тоо, дүнг ямар нэгэн өөр зорилгоор гуравдагч этгээд ашиглахыг хориглоно.
- БДО Аудит ХХК-аас өөр байгууллага, хувь хүн тайлангийн ямар нэг хэсэгт зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно. Ийм төрлийн өөрчлөлт орсон тохиолдолд БДО Аудит ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- Гэрээт ажилтай холбоотой ажлын баримтыг бид хадгалж үлддэг бөгөөд үнэлгээний дүгнэлтэд тайлбар авах шаардлага гарсан тохиолдолд ажлын баримттай танилцаж болно. Гэхдээ энэ үйлчилгээ үнэлгээний гэрээт ажлын захидалд тусгайлан заагаагүй тохиолдолд нэмэлт төлбөртэй байна.
- Энэхүү тайланг БДО Аудит ХХК-аас бичгээр зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зар сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулж олон нийтэд түгээх, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо эсвэл Засгийн Газарын бусад байгууллагад санал өгөхөөс өөрөөр хувийн болон олон нийтэд мэдээлэл өгөхөө иш татах зэргээр нийтэд дэлгэх, түгээхийг хориглоно.

Үнэлгээний дүгнэлтэд нөлөөлж болох үнэлгээний өдрөөс хойш гарсан аливаа үйл явдал, нөхцөл байдал бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.

Энэхүү үнэлгээнд ашигласан зарим таамаглал эсвэл төсөөлөл нь хэрэгжихгүй байж болох ба урьдчилан таамаглаагүй үйл явдал үүсч болзошгүй. Үүнд: эдийн засгийн өөрчлөлт, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн томоохон томоохон өөрчлөлт; үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн томоохон

өөрчлөлт; татвар ба бусад хууль зүйн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд багтана. Тиймээс төлөвлөсөн хугацааны бодит үр дүн нь хөрөнгө оруулагчийн шаардлагаас өөр байх магадлалтай. Энэ хэлбэлзэл нь материаллаг байж болох ба үнэлгээний тайланд багтсан үнийн дүнд нөлөөлж болзошгүй.

- Ирээдүйн үйл явдалтай холбоотой төсөв/урьдчилсан таамаглал/прогноз зэрэг нь төлөвлөсөн хугацаанд хүчинтэй хэвээр байна гэсэн таамаглалд суурилсан боловч энэ нь биелэхгүй байж болно. Ийм учраас төсөвлөсөн/урьдчилсан таамаглал нь бодит дүнтэй хэр ойрхон буух тал дээр бид ямар нэгэн дүгнэлт гаргаагүй болно.
- Удирдлагаас болон түүнээс эрх олгогдсон төлөөллөөс бидэнд өгсөн мэдээллийн үнэн зөв байдал эсвэл иж бүрэн байдал бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү ажлыг хийхтэй холбоотой гэрээгээр урьдчилан тохируулгүй эсвэл үйлчлүүлэгчийн зүгээс хүсэлт тавьж, нэмэлт төлбөр санал болгож, урьдчилсан тохиролцоо хийгээгүй л бол бид үнэлсэн хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хуралд оролцох, захиргааны үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.
- Энэхүү тайланг зөвхөн тайланд дурдсан зориулалтаар хэрэглэх бөгөөд тайлан нь иж бүрнээрээ байхдаа хүчинтэй байна. Тайланд эцсийн байдлаар оруулсан тооцоолсон зах зээлийн үнэ цэн нь зөвхөн үнэлгээний өдрөөр хүчинтэй байна.
- Үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн бидэнд өгсөн нягтлан бодох бүртгэлийн болон хууль эрхзүйн мэдээллийн үнэн зөв байдалтай холбоотой санал дүгнэлтийг БДО Аудит ХХК гаргаагүй бөгөөд бид хөрөнгийн эзэмшлийн эрхэд ямар нэгэн Дню дилижинсийн үйлчилгээ үзүүлээгүй болно.
- Зөвхөн тайланд багтсан төсөөлөл ба хязгаарлах нөхцөлүүдээр л БДО Аудит ХХК-ийн гүйцэтгэсэн шинжилгээ болон дүгнэлт хязгаарлагдана.
- Бид үйлчлүүлэгчийн өгсөн мэдээллийн иж бүрэн байдал ба үнэн зөв байдалтай холбоотой ямар нэгэн өр төлбөр эсвэл үүрэг хариуцлага хүлээхгүй.



Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд

Аливаа хөрөнгө ба бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг уламжлалт гурван үнэлгээний хандлага байдаг. Үүнд: (i) Орлогын хандлага; (ii) Зах зээлийн хандлага; ба (iii) Хөрөнгөд суурилсан хандлага багтана. Эдгээр үндсэн гурван хандлага дотор үнэ цэнэ тооцоолох хэд хэдэн арга хамаарна.

- Гурван хандлага тус бүрийг доор хураангуйлан тайлбарлав.

Орлогын хандлага

Орлогын хандлага нь хөрөнгө ба бизнесийн ирээдүйд бий болгохоор хүлээгдэж буй эдийн засгийн орлогын үнэ цэнэд суурилан зах зээлийн үнэ цэнэ тооцдог. Чөлөөт мөнгөн урсгал нь (i) тодорхой таамагласан хугацааны чөлөөт мөнгөн урсгал (ii) үлдэх эцсийн үнэ цэнэ гэсэн хоёр бүрэлдэхүүний өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байна. Хүлээгдэж буй чөлөөт мөнгөн урсгал (жишээ нь: таван жил)-ыг тооцохдоо түүхэн өгөгдөл ба удирдлагаас хүргүүлсэн таамаглалыг авч үздэг. Эцсийн үнэ цэнэ нь таамагласан хугацаанаас цааших үнэлж буй хөрөнгө ба бизнесийн ирээдүйн мөнгөн урсгалыг илтгэнэ. Тасралтгүй үйл ажиллагааны арга эсвэл урт хугацаанд салбараас гарах аргыг ашиглан эцсийн үнэ цэнийг тооцдог. Урт хугацаанд салбараас гарах арга нь таамагласан хугацааны сүүлийн жилийн чөлөөт мөнгөн урсгалыг капиталжуулдаг арга юм. Үүний дараа таамагласан чөлөөт мөнгөн урсгал ба эцсийн үнэ цэнийг нийт хөрөнгө оруулсан капиталд шаардлагатай өгөөжөөр өнөөгийн үнэ цэнэ хүртэл дискантулгана. Орлогын хандлага дотор хамгийн өргөн ашиглагддаг арга зүй нь хорогдуулсан мөнгөн урсгалын загвар юм.

Хорогдуулсан мөнгөн урсгалын загвар

Хорогдуулсан мөнгөн урсгалын загвар нь хөрөнгө ба бизнесийн үнэ цэнэд нөлөөлөх түлхүүр хүчин зүйлсийг системтэйгээр нэг загварт нэгтгэдэг. Үнэ цэнэд олон хүчин зүйлс нөлөөлдөг ч академик хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудаас дүгнэхэд хөрөнгө оруулагчид дараах долоон хүчин зүйлс зах зээлийн үнэ цэнийг илүү тайлбарладаг гэж үздэг.

Хүлээгдэж буй татварын дараах үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал хүлээгдэж буй капиталын зардал

- Хүлээгдэж буй ажлын капиталын хэрэгцээ
- Удирдлага капиталын өртгөөс давсан өгөөж олно гэсэн зах зээлийн хүлээлтийн хугацаа
- Хүлээгдэж буй капиталын өгөөж
- Бизнесийн эрсдэл
- Санхүүгийн хөшүүрэг

Эхний дөрвөн хүчин зүйлс нь урьдчилан таамагласан мөнгөн урсгалыг илтгэх бол үлдсэн гурван хувьсагч нь мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоход ашиглагдах хорогдуулах хүүг тодорхойлно.

Хөрөнгө ба бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохын тулд зохих капиталжуулах хувь/жигнэсэн дундаж капиталын өртөг (КЖДӨ)-өөр хөрөнгө оруулагчдад ногдох ирээдүйн татварын дараах чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулах хэрэгтэй. Бидний шинжилгээний зорилгоор чөлөөт мөнгөн урсгал нь хүүний зардлын дараах татвараар тохируулсан ашиг, нэмэх нь элэгдэл ба бусад мөнгөн бус зардал, хасах нь одоогийн бүтээмжийн чадварыг хадгалах эсвэл хөрөнгө ба бизнесийн ирээдүйн өсөлтийг бий болгоход шаардагдах капиталын зардал байдлаар тодорхойлогдоно.

Зах зээлийн хандлага

Зах зээлийн хандлага нь орлуулалтын зарчимд үндэслэдэг үнэлгээний арга юм. Зах зээлийн хандлагын үндсэн зарчим нь ижил төсөөтэй хөрөнгө/ижил салбар дахь жишиг компаниуд үнэлж буй хөрөнгө ба компанийн үнэ цэнийг илтгэж чадна гэж үздэг. Зах зээлийн үнэ ханш нь нээлтэй байдаг/хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг жишиг хөрөнгө/компани болон үнэлж буй хөрөнгө/бизнесийн хооронд харьцуулалт хийх замаар зах зээлийн үнэ цэнэ тооцох үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлж, шинжилнэ. Үүнээс гадна, харьцуулахуйц жишиг нэгдэл ба худалдан авалтын арилжаагаар тодорхойлогдсон үнэлгээний үржүүлэгчдийг ашигладаг.

Хөрөнгийн хандлага

Хөрөнгийн хандлага нь үлдэж буй компанийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг зах зээлийн үнэ рүү тохируулах замаар зах зээлийн үнэ цэнэ тооцдог арга. Өөрөөр хэлбэл энэ арга нь үнэлж буй бизнесийн биет ба биет бус хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ, нийлбэрт үндэслэдэг. Хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн өнөөдөр дахин бүтээн босгоход шаардагдах зах зээлийн зардлыг тодорхойлдог.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг

Бизнесийн эрсдэлийн төлөө зохих мэдлэгтэй хөрөнгө оруулагчид шаардагдах өгөөжийн түвшинг тооцохын тулд тухайн бизнесийг санхүүжүүлэхэд бэлэн байгаа өр ба өмчийн капиталын урт хугацааны хольцод ногдох капиталын жигнэсэн дундаж өртгийг ашигладаг.

- Энэ шинжилгээнд хөгжүүлсэн мөнгөн урсгалын тооцоо нь өр ба өмчийн хөрөнгө оруулагчдад аль алинд нь чиглэсэн мөнгөн урсгалыг төлөөлөх өр төлбөрийн дараах сууриар толилуулагдсан. Мөнгөн урсгалд ашигласан хорогдуулах хүү нь өр ба өмчийн хөрөнгө оруулагчдын шаардлагатай өгөөжийг хоёуланг нь тусгасан зах зээлийн суурь бүхий КЖДӨ-т үндэслэсэн. КЖДӨ-ийн тэгшитгэл дараах байдалтай байна:

$$WACC = \left(\frac{D}{D+E} \right) (K_d) + \left(\frac{E}{D+E} \right) (K_e)$$

Энд:

- D = Өрийн капиталын үнэ цэнэ;
- K_d = Өрийн капиталын өртөг;
- E = Өмчийн капиталын үнэ цэнэ; ба
- K_e = Өмчийн капиталын өртөг

Капиталын бүтэц

- КЖДӨ тооцоо эхний алхам нь үйлчлүүлэгчийн зохистой капиталын бүтцийг тооцоолох явдал юм. Шинжилгээнд баримталсан капиталын бүтэц нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой салбарын дундаж капиталын бүтцийг төлөөлөх жишиг компаниудын өр/өмчийн харьцааны медианаар тооцоологдсон.

Өрийн өртөг (K_d)

Өрийн капиталын өгөөж нь үйлчлүүлэгч дээрх капиталын бүтцээ санхүүжүүлэхэд шаардлагатай хүүний өнөөгийн түвшин байна. Өрийн өртгийг тооцоолоход бид (1) тухайн бизнесийн орчны дундаж зээлийн хүү (2) 2017 оны

12-р сарын 31-ний байдлаар үйлчлүүлэгчийн капиталын бүтэц дэхь санхүүгийн өрийн өртгийг шинжилсэн. Бизнесийн хүүний зардал татвараас хасагдах зардал тул өрийн бодит өртөг нэрлэсэн хүүнээс бага байна.

- Үнэлгээний практикт өрийн өртгийг дараах байдлаар тооцдог.

$$K_d = R_f + Credit\ spread_i$$

Энд:

- R_f = Эрсдэлгүй өгөөж;
- $Credit\ spread_i$ = Зээлийн хүүний зөрүү;

Өмчийн өртөг (K_e)

- Өмчийн өртгийг капитал хөрөнгийн үнэлгээний загвар (КХҮЗ) ашиглан тооцсон. КХҮЗ-ийн тэгшитгэл дараах байдалтай байна:

$$K_e = R_f + \beta_1 (R_m - R_f) + R_{size} + CRP$$

Энд:

- K_e = Өмчийн шаардлагатай өгөөж;
- R_f = Эрсдэлгүй өгөөж;
- β_1 = Хөрөнгийн бэга;
- $(R_m - R_f)$ = Өмчийн эрсдэлийн шагнал;
- R_{size} = Хэмжээний нэмэгдэл; ба
- CRP = Улсын эрсдэлийн шагнал.

- Энэхүү загварыг Монгол улсын хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбарт тохируулахын тулд компанийн тусгайлан эрсдэлийн хүчин зүйл болон салбарын эрсдэлийн нэмэгдлээр засварлаж, үйлчлүүлэгчийн өмчийн өртгийг тодорхойлсон. Өмчийн өртгийн өргөтгөсөн загвар дараах байдалтай байна:

$$K_e = R_f + \beta_1 (R_m - R_f) + R_{size} + CRP + R_{climate} + CSR$$



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Энд:

$R_{climate}$ = Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл;

CSR = Компанийн тусгай эрсдэл;

Хөдөө аж ахуйн салбарын уламжлалт эрсдэл нь уур амьсгалын нөлөөгөөр ихэвчлэн тайлбарлагддаг. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой. Дээрх онцлогийг харгалзан байгаль, цаг уурын эрсдэлийн нэмэгдлийг 2%-иар тооцсон.

Эрсдэлгүй өгөөж (R_f)

Хөрөнгө оруулалтын эрсдэлгүй өгөөжийг ихэвчлэн Америкийн Нэгдсэн Улс-ын засгийн газрын урт хугацаат бондын өгөөжөөр төлөөлүүлдэг. Бид мөнгөн урсгалын загварт мөн энэ зарчмыг баримтлан АНУ-ын 10 жилийн хугацаатай бондын өгөөжөөр эрсдэлгүй өгөөжийн түвшинг төлөөлүүлж тооцсон.

Энэ нь Монгол улсын засгийн газрын бонд нээлттэй зах зээл дээр бага арилжаалагддаг тул эрсдэлгүй өгөөжийг илэрхийлэх боломжгүй гэж үзсэнтэй холбоотой. АНУ-ын засгийн газрын бондын өгөөжийн загварт ашиглахдаа Монгол улсын эзэлжих зэрэглэлд суурилан тооцсон улсын эрсдэлийн нэмэгдлээр өсгөж, эрсдэлийн ялгааг тохируулсан.

Бэта (β)

Бэта нь системийн шинжтэй эрсдэлийн хэмжүүр бөгөөд тухайн хувьцааны өгөөж болон нэгдсэн индексээр хэмжсэн зах зээлийн өгөөжийн хамаарлыг илтгэх функц байдлаар илэрхийлэгддэг.

Олон нийтэд нээлттэй нийтлэгдсэн бета нь тухайн компанийн капиталын бүтэц дэх өрсөлдөгчүүдийн хөшүүргийг тусгадаг тул хөрөнгийн бета юм. БДО Монгол-ын шинжлэх үнэлгээний явцад үйлчлүүлэгчийн капиталын бүтцийг тусгахын тулд жишиг компанийн бетаг тохируулах шаардлагатай болсон. Бид жишиг компанийн

өмчийн бетаг тооцох замаар уг тохируулгыг хийж гүйцэтгэсэн. Сонгон авсан жишиг компанийн талаарх мэдээллийг Хавсралт Г-ээс дэлгэрүүлнэ үү.

■ Өмчийн бетаг тооцоох томъёо:

$$\beta_u = \frac{\beta_1}{\left[1 + (1 - T_c) \left(\frac{D}{E}\right)\right]}$$

Энд:

β_u = Өмчийн бетаг; ба

T_c = Татварын түвшин.

■ Өмчийн бетаг нь хөрөнгө оруулалт бүхэлдээ өмчөөр санхүүжиж байгаа нөхцөлд шаардлагатай өгөөжийн хэмжээг тусгах зорилгоор капиталын бүтцээс өрийн нөлөөг хязгаарладаг. Үүний дараа бид сонгон авсан капиталын бүтцээр бетаг дахин өргөтгөж тооцно. Дээрх тооцооллын үр дүнд үүссэн бетаг нь үйлчлүүлэгчийн санхүүгийн хөшүүргийн зэргийг тусгайлан тохируулсан зах зээлийн суурь бүхий бета болно. Бетаг дахин өргөтгөх томъёо дараах байдалтай байна:

$$\beta_1 = \beta_u \left[1 + \left(\frac{D}{E}\right) (1 - T_c)\right]$$

■ Жишиг компанийн хөрөнгийн бетаг Филпук өгөгдлийн сан (Pitchbook Data Base)-гаас түүвэрлэн ашигласан. Жишиг компани сонгох шалгуурыг доор тайлбарлав.

Жишиг буюу харьцуулах компани сонгох шалгуур

■ Бид үнэлгээний ажилд үйлчлүүлэгчтэй харьцуулагдах найман жишиг компанийг дараах шалгуураар сонгон авсан. Үүнд:

- сонгон авсан жишиг компаниуд нь үйлчлүүлэгчтэй ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг;
- сонгон авсан жишиг компаниуд нь хангалттай борлуулалтын хэмжээ



Хуудас 37 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

бүхий хамгийн багадаа хоёр жилийн арилжааны түүхтэй; ба

сонгон авсан жишиг компаниуд нь Монгол улстай хөрш зэргэлдээ, ижил бүс нутаг дахь нээлттэй зах зээл дээр бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүд байна.

Өмчийн зах зээлийн эрсдэлийн нэмэгдэл ($R_m - R_f$)

- Өмчийн зах зээлийн эрсдэлийн шагнал нь засгийн газрын урт хугацаат бондын өгөөж дээр энгийн хувьцаа эзэмшигчдийн тогтоосон шагналын түвшинг илтгэдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч эрсдэлгүй үнэт цааснаас эрсдэлтэй үнэт цаас руу хөрөнгө оруулалтаа шилжүүлэх үед шаардаж буй нөхөн олговор юм.
- Монгол улсын нөхцөлд өмчийн зах зээлийн эрсдэлийн нэмэгдэл тооцоход бэрхшээлтэй тул үнэлгээний мэргэжлийн практикийн дагуу тогтвортой эдийн засаг (АНУ)-ийн эрсдэлийн нэмэгдлээр төлөөлүүлэн тооцсон.

Хэмжээний нэмэгдэл (R_{Size})


- Иботсон Ассешт (Ibbotson Associates, Inc.) байгууллагын хэмжээний нөлөөг судалсан эмпирик судалгааны ажлуудаас харахад жижиг хэмжээтэй компаниудын тогтоосон нийт өгөөж КХУЗ-ын анхны тавилаас илүүтэй урт хугацаанд өндөр байдаг байна. Энэ нь КХУЗ урт хугацаанд жижиг компаниудад тулгардаг эрсдэлд ногдох шаардлагатай өгөөжийг тооцож чаддаггүй болохыг илтэнэ.
- Жижиг компанийн хэмжээнд ногдох нэмэгдэл өгөөжийг ихэвчлэн хэмжээний нэмэгдэл гэж нэрлэдэг бөгөөд өнөөгийн байдлаар хорогдуулах хүүний тооцоололд нийтлэг ашиглаж байна. Үнэлгээний загварт баримталсан хэмжээний нэмэгдлийг Даф энд Пеллс Корпораци (Duff & Phelps Corporation)-ийн “Үнэлгээний гарын авлага 2017 - Капиталын өртгийн заавар” -т тодорхойлсон микро-капиталуулалтад хамаарах хэмжээний шагналаар төлөөлүүлсэн.

Улсын эрсдэлийн нэмэгдэл (CRP)

- Улсын эрсдэлийн шагнал нь тухайн улсад бизнес эрхэлснээр хүлээх үйл ажиллагааны эрсдэлийг тусгахад чиглэдэг. Үнэлж буй бизнес тухайн улсын орчинд хэт өртөмтгий байгаагаас шалтгаалж энэ төрлийн эрсдэлийг тохируулах бөгөөд улсын эрсдэлд өртөмтгий бизнесийн орлогыг тараан байршуулах замаар бодит эрсдэлийг тооцоход анхаардаг.
- Энэ үнэлгээний зорилгын дагуу бид корпорацийн санхүүгийн судалгаагаараа алдартай Нью Йоркийн Стейн Бизнесийн сургуулийн профессор Асват Дамодараны нийтэлсэн улсын эрсдэлийн судалгаанаас Монгол улсын эрсдэлийг 7.5%-иар сонгон авсан.

Компанийн тусгайлан эрсдэлийн нэмэгдэл (CSR)

- Компанийн тусгайлан эрсдэлийг тооцохын тулд бид газар тариалангийн бизнесийн гадаад болон дотоод эрсдэлийг багтаасан асуулга удирдлагын багийн гишүүдэд хүргүүлсэн. Асуулгын үр дүнг БДО Монгол дотоод эрсдэлийн шинжилгээтэй харьцуулж эцсийн үнэлгээ өгсөн.



Хуудас 38 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл

Жишиг компани

Арчер-Даниэлс-Мидланд
Archer Daniels Midland Co

Тодорхойлолт

Тослогт ургамлын үр, эрдэнэ шиш, улаан буудай, какао, хөдөө аж ахуйн бусад бүтээгдэхүүний боловсруулагч Арчер-Даниэлс-Мидланд Компани нь 1923 оны 5-р сарын 2-нд байгуулагдсан. Энэ компани нь уураг, ургамлын тос, эрдэнэ шишийн чихэр, гурил, биодеизель, этанол, бусад хоол, тэжээлийн найрлагыг үйлдвэрлэдэг. Энэ компанийн сегментүүд нь Хөдөө аж ахуйн үйлчилгээ, Эрдэнэ шишийн боловсруулалт, Тослогт ургамлын үр боловсруулах үйлдвэр, Зэрлэг амт болон Өвөрмөц найрлагууд, бусад аж ахуйн нэгжүүд багтана. Түүний газарзүйн сегментүүд нь АНУ, Швейцар, Кейман Арлууд болон Герман зэрэг улсууд юм. Компани нь тослогт ургамалын үр, эрдэнэ шиш, улаан буудай, мило, овъёос, арвай, болон боловсруулсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг худалдан авах, хадгалах, цэвэрлэх, тээвэрлэх тээврийн сүлжээ болон дэлхийн үр тарианы өндөрлөг юм. Компани нь хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Мөн хоол хүнс, малын тэжээл, химийн болон эрчим хүчний хэрэглээний бүтээгдэхүүнүүдэд эрдэнэ шиш, тослогт ургамлын үр, улаан буудайн бүтээгдэхүүнийг боловсруулдаг.

Ассөүшт Бритиш Фүүдс
Associated British Foods PLC

Ассөүшт Бритиш Фүүдс нь олон улсын хоол хүнс, орц найрлагууд, жижиглэн худалдааны компани юм. Энэ компанийн сегмент нь хүнсний бүтээгдэхүүн, элсэн чихэр, хөдөө аж ахуй, орц найрлагууд, жижиглэн худалдаа орно. Компанийн газарзүйн сегментүүд нь Их Британи, Европ, Африк, Америк, Ази Номхон далай юм. Хүнсний сегмент нь хүнсний бүтээгдэхүүн болох халуун уух зүйлс, чихэр, чихэр орлуулагч, ургамлын тос, талх, нарийн боов, үр тариа, угсаатны хүнс, ургамал, халуун ногоо, махан бүтээгдэхүүн зэргийг жижиглэн худалдаа, бөөний худалдаа, хоолны үйлчилгээний бизнесүүдэд нийлүүлдэг. Элсэн чихрийн сегмент нь чихрийн нишингэ, чихрийн нишингийн боловсруулалтыг аж үйлдвэрийн хэрэглэгчдэд борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Хөдөө аж ахуйн сегмент нь малын тэжээл, хөдөө аж ахуйн салбарт зориулсан бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлдэг. Орц найрлага нь талх нарийн боовны хөөлгөгч, талх нарийн боовны орц болон ферментийг үйлдвэрлэдэг. Жижиглэн худалдааны сегмент нь худалдан авалт болон бараа бүтээгдэхүүнийг Примкарк, Пенигийн жижиглэн худалдааны сүлжээгээр дамжуулан хувцас, туслах хэрэгслийг худалдан авах, борлуулдаг.

Ингрэдин
Ingredion Inc

Ингрэдин нь 1997 оны 3-р сарын 27-нд байгуулагдсан ба орц найрлагуудын шийдэгч нийлүүлэгч юм. Тус компани дотоод, гадаадын олон төрлийн үйлдвэрүүдэд чихэр орлуулагч, цардуул, хүнсний орцууд болон бусад цардуулын материал болон эрдэнэ шишийг чийгшүүлэх, боловсруулалтаар гаргаж авсан биоматериалын шийдлүүдийг борлуулдаг. Энэ компани нь Хойд Америк, Өмнөд Америк, Ази, Номхон далайн болон Европ, Ойрхи Дорнод болон Африк зэрэг 4 хэсэгт үйл ажиллагаа явуулдаг. Эрдэнэ шиш, цардуулаар хийсэн үрэл, төмс, бусад хүнсний ногоо, жимс жимсгэнүүдийг хүнс, ундаа, цаас, шар айраг болон бусад үйлдвэрлэлийн зориулалтаар найрлага, био материалууд болгон хувирагадаг. Мөн компанийн бүтээгдэхүүний жагсаалд малын тэжээл, хүнсний эрдэнэ шишийн тос зэрэг багтдаг. Мөн чихрийн бүтээгдэхүүн нь глюкозын сироп, митозын өндөр сироп, өндөр фруктозын эрдэнэ шишийн сироп (HFCS), карамел өнгө, декстроз, полиолол, глюкоз болон сиропын хатуу бодис юм. Цардуулд суурилсан бүтээгдэхүүн нь хүнсний ангиллын болон үйлдвэрлэлийн цардуул, био материал зэрэг юм. Мөн тусгай найрлага орцууд санал болгодог. Энэхүү компани нь, хүнсний бүтээгдэхүүн, ундаа, цаас, давирхай, шар айраг, эмийн бүтээгдэхүүн, нэхмэл болон хувийн үйлдвэрлэлийн салбарууд, малын тэжээл, эрдэнэ шишийн тосны зах зээл зэрэг дэлхийн даяар олон төрлийн үйлчлүүлэгчдэд бараагаа нийлүүлдэг.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл ('үргэлжлэл)

Тодорхойлолт

Баянж нь 1995 оны 5-р сарын 18-нд үүсгэн байгуулагдсан хөдөө аж ахуйн салбараас өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнтэй нэгдсэн аж ахуйн нэгж бүхий агробизнес, хүнсний компани юм. Энэ компани нь тослог ургамлын үр боловсруулагч бөгөөд ургамлын гаралтай тос, уургийн хоол үйлдвэрлэгч; үр тарианы боловсруулагч; дэлхийн хэмжээний савласан ургамлын тос худалдагч; улаан буудайн гурил, нарийн боовны хольц, хуурай эрдэнэ шишийн бүтээгдэхүүн болон цагаан будааны бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, худалдагч; Бразил дахь элсэн чихэр, этанол үйлдвэрлэгч; мөн дэлхийн хэмжээний элсэн чихэр худалдагч, худалдан авагч болно.

Тус компани нь таван сегментээр үйл ажиллагаа эрхэлдэг: Агробизнес, Хүнсний зориулалттай тосны бүтээгдэхүүн, Тээрэмдсэн бүтээгдэхүүн, Элсэн чихэр болон Био эрчим хүч, Бордоо зэрэг орно.

Гужарат Амбужа Экспорт нь түүхий болон цэвэршүүлсэн шар буурцгийн тос, эрдэнэ шишийн цардуул, шар буурцагны тосгүйжүүлсэн цардуул, шингэн глюкоз зэргийг санал болгодог. Энэ компанийн сегментүүдэд Хөвөн утас, Эрдэнэ шиш Боловсруулалт, Агро Боловсруулалт, Эрчим хүч болон бусад зүйлс орно. Агро боловсруулах сегмент нь уусгагчаар олборлолт, гурилын үйлдвэр, малын тэжээл зэргийг багтаана. Эрчим хүчний сегмент нь өөрсдийн хэрэглээгээ хангах зорилгоор шууд буюу шууд бус эрчим хүч үүсгэдэг. Энэ компанийн бүтээгдэхүүнүүд нь хөвөн утас, боловсруулсан хүнсний тос, ванаэрати шар тос, талх нарийн боов, улаан буудайн гурил, шар буурцгийн лецитин, шар буурцгийн хальс, рап үрнээс гаргаж авсан тосгүйжүүлсэн рап үрийн хоол хүнс зэрэг багтана. Өдөрт 4,600 метр тонн үрийг суулгаж, өдөрт 1,200 метр тонн хүнсний тосыг боловсруулах хүчин чадалтай. Эрдэнэ шиш Боловсруулах үйлдвэрлэлийн хэлтэс нь өдөрт 2,000 тоннын үр суулгах хүчин чадалтай, Хөвөн утас үйлдвэрлэлийн хэлтэс нь өдөрт 65,520 ширхэг ээрүүл утас үйлдвэрлэх хүчин чадалтай. Эрчим хүчний хэлтэс нь 42.85 мегаватт хүчин чадалтай.

Чангшоухуй Фүүдс нь эрдэнэ шишийн тосны бизнес эрхэлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Энэхүү компани нь гурван бизнесийн сегментээр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг. Эрдэнэ шишийн тосны сегмент нь бренд нэргүй эрдэнэ шишийн тос, өөрсдийн Longevity Flower нэртэй бренд эрдэнэ шишийн тос үйлдвэрлэж, борлуулдаг.

Бусад тосны сегмент нь цэвэршүүлсэн хүнсний наранцэцгийн үрийн тос, чидун жимсний тос, газрын самрын тос болон цагаан будааны үр хөврөлийн тосыг үйлдвэрлэх, борлуулахад голчлон оролцдог. Эрдэнэ шишийн хоол сегмент нь эрдэнэ шишийн хоолны үйлдвэрлэл, борлуулалтад оролцдог.

Торигоз нь Япон дахь гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг үйл ажиллагаа эрхэлдэг. Улаан буудай, хөх тариа, улаан буудайн хивэг, нарийн боовны орц найрлагууд, нэмэлтүүд, дээшлүүлэгчүүд, хөлдөөсөн болон зохицуулах үйл ажиллагаатай хүнсний бүтээгдэхүүн, эрүүл мэндийн бүтээгдэхүүн, цагаан будааны гурил, арвай, тэжээлийг санал болгодог. Тус компани нь өмнө нь Торигоз Шотенс ХХК гэж нэрлэгдэж байсан бөгөөд 1951 оны 12-р сард Торигоз ХХК-д нэрээ сольсон. Торигоз ХХК нь 1935 онд байгуулагдсан бөгөөд Японы Фукуока хотод төвтэй.

Лин Хуя Индастрил Корп нь Тайван улсад байгуулагдсан бөгөөд улаан буудайн хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах, түгээх чиглэлээр ажилладаг. Энэ компанийн улаан буудайн хүнсний бүтээгдэхүүн нь гурил, улаан буудайн хивэг, улаан буудайн үр тариа, улаан буудайн үр хөврөл, гоймон зэргийг багтаадаг. Мөн компани нь үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхэлдэг бөгөөд үл хөдлөх хөрөнгө болон газар худалдах, түрээслэх, болон үл хөдлөх хөрөнгийн менежмент, хөгжилжүүлэлт зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг.

Гужарат Амбужа Экспорт
Gujarat Ambuja Exports Ltd

Чангшоухуй Фүүдс
Changshouhua Food Co Ltd

Торигоз
The Torigoe Co., Ltd

Лин Хуя Индастрил Корп
Lien Hwa Industrial Corp





Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.

Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл

Мөнгөн урсгалын төсөөлөл

	Түүхэн			Төсөөлөл			
	ТЖ14Б	ТЖ15Б	ТЖ16Б	ТЖ17Б	ТЖ18Т	ТЖ21Т	ТЖ22Т
Борлуулалтын орлого	3,110,161	3,473,700	3,036,492	2,461,115	10,943,490	8,776,819	11,126,986
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(2,561,635)	(3,112,585)	(2,347,149)	(1,996,755)	(9,558,875)	(6,493,121)	(8,267,908)
Нийт ашиг	548,526	361,115	689,343	464,360	1,384,615	2,283,698	2,859,078
Үйл ажиллагааны нийт зардал	(107,036)	(576,970)	(521,752)	(430,960)	(397,194)	(385,022)	(409,622)
Цалингийн зардал	(59,826)	(86,380)	(96,355)	(153,215)	(172,301)	(173,703)	(175,105)
ЭМНДШ-ийн зардал	(4,414)	(10,797)	(7,260)	(13,586)	(17,230)	(17,370)	(17,510)
Томилголт/ арга хэмжээний зардал	(4,173)	-	(5,347)	(21,038)	(15,000)	(6,000)	(6,000)
Элээдлийн зардал	(28,560)	(27,482)	(29,039)	(29,193)	(38,693)	(40,290)	(40,290)
Шуудан холбооны зардал	(2,422)	(2,157)	(2,836)	(15,725)	-	-	-
Шатахууны зардал	(7,561)	(12,228)	(14,220)	(2,339)	(12,000)	(12,000)	(12,000)
Цахилгаан ба ашиглалт	-	-	-	(30,923)	(6,000)	(6,000)	(6,000)
Зөвлөх үйлчлэгээний зардал	-	-	-	-	(20,000)	(20,000)	(20,000)
Маркетингийн зардал	-	-	-	-	(109,130)	(102,819)	(125,877)
Бусад зардал	(80)	(437,926)	(366,695)	(164,941)	(6,840)	(6,840)	(6,840)
Үйл ажиллагааны ашиг	441,490	(215,855)	167,591	33,400	987,421	1,898,676	2,449,456
Санхүүгийн орлого, зардал	(204,710)	(326,755)	(480,451)	(409,534)	(280,107)	(141,288)	(21,403)
Бусад орлого, зардал	416,110	222,379	228,470	413,019	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	652,890	(320,231)	(84,390)	36,885	707,314	1,757,388	2,428,053
Орлогын гатварын зардал	(26,461)	(3,638)	(513)	(42)	(70,731)	(175,739)	(242,805)
Цэвэр ашиг	626,429	(323,869)	(84,903)	36,843	636,583	1,581,649	2,185,248
ХТЭХӨА (EBITDA)	1,198,036	768,970	1,097,794	868,511	1,026,114	1,938,966	2,489,746
ХТӨА (EBIT)	1,186,876	329,619	791,365	839,318	987,421	1,898,676	2,449,456

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитеддэй гишүүн мөн.

Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ('үргэлжлэл)

Ашигт ажиллагааны үзүүлэлт

Ашигт ажиллагааны үзүүлэлт	ТЖ14Б	ТЖ15Б	ТЖ16Б	ТЖ17Б	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Ашигт ажиллагааны үзүүлэлт									
Нийт ашгийн түвшин	17.64%	10.40%	22.70%	18.87%	12.65%	26.02%	25.69%	23.99%	24.82%
ХТӨА түвшин	38.16%	9.49%	26.06%	34.10%	9.02%	21.63%	22.01%	20.65%	21.63%
ХТЭХБА түвшин	38.52%	22.14%	36.15%	35.29%	9.38%	22.09%	22.38%	20.95%	21.91%
Цэвэр ашгийн түвшин	20.14%	-9.32%	-2.80%	1.50%	5.82%	18.02%	19.64%	18.59%	19.23%

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Цэвэр ажлын капиталын өөрчлөлт

Ажлын капиталын хувиарь	ТЖ14Б	ТЖ15Б	ТЖ16Б	ТЖ17Б	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Эрээлтийн хөрөнгө									
Худалдааны авлага	640,411	513,902	440,934	1,448,215	278,972	278,972	278,972	278,972	278,972
Бараа, материал	1,879,510	929,390	1,600,106	1,266,220	2,767,220	3,602,922	4,706,943	4,208,212	4,025,701
Мөнгөнөөс бусад эргэлтийн хэрэгч	-	-	-	-	184,421	307,190	312,960	317,760	317,760
Богшино хувиараар өөрчлөлт									
Худалдааны өглөг	1,745,206	934,740	674,304	810,615	342,136	342,136	342,136	342,136	342,136
Бусад богино хугацаат өглөг	187,959	289,059	2,033,827	3,231,988	124,744	145,686	145,686	145,686	145,686
Цэвэр ажлын капитал (CA - CL - net cash)	586,756	219,493	(667,091)	(1,328,168)	2,763,733	3,701,262	4,811,053	4,317,122	4,134,611
Цэвэр ажлын капитал (AR + Inv - AP)	774,715	508,552	1,366,736	1,903,820	2,704,056	3,539,758	4,643,779	4,145,048	3,962,537
Цэвэр ажлын капиталын өөрчлөлт									
	774,715	(266,163)	858,184	537,084	800,236	835,702	1,104,021	(498,731)	(182,511)

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ('үргэлжлэл)

Хорьгодуулах хүүний тооцоолол - доод хязгаар

Компангийн нэр	Тэмдэг	Хөшүүртэй бэла	Нийт өр	Үнэлгээ	Өр/өмч харьцаа	Үр ашигт татвар	Хөшүүртэй бэла
ХХД ХК-ийн хөшүүртэй бэла-гийн тооцоолол							
Арчер Даниелс Мидланд Со	ADM.N	1.00	-	-	0.41	0.44%	0.71
Associated British Foods PLC	ABF.L	0.56	-	-	0.10	23.16%	0.52
Ingredion Inc	INGR.N	0.38	-	-	0.66	30.15%	0.26
Bunge Ltd	BG.N	1.29	-	-	0.76	16.86%	0.79
Gujarat Ambuja Exports Ltd	GAME.NS	1.55	-	-	0.00	26.08%	1.55
Changshouhua Food Co Ltd	1006.HK	1.33	-	-	0.10	16.72%	1.23
The Torigoe Co., Ltd	2009.FU	0.48	-	-	0.10	32.71%	0.45
Lien Hwa Industrial Corp	1229.TW	0.55	-	-	0.14	2.52%	0.48
Өмчийн өртөг							Хөшүүртэй бэла дундаж 0.61
Эрсдэлгүй өгөөж							Ашиглах өр/өмч харьцаа 32.3%
Зах зээлийн эрсдэлийн нэмэгдэл							Ашиглах татварын түвшин 10.0%
Хөшүүртэй бэла							Дахин хөшүүртэй бэла 0.79
КХҮЗ							
Хэмжээний нэмэгдэл							
Улсын эрсдэлийн нэмэгдэл							
Салбарын эрсдэл							
Компанийн эрсдэлийн нэмэгдэл							
Өмчийн өртөг							
КҮДӨ							
Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ							



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ('үргэлжлэл)

Хоргогдуулах хүүний тооцоолол - дээд хязгаар

Хоргогдуулагч хүүний тооцоолол	ХАД ХК-ийн хөшүүрэгтэй бэлтгэлийн тооцоолол	Тэмдэг	Хөшүүрэгтэй бэлтгэлийн тооцоолол	Нийт өр	Үнэлгээ	Өр/өмч харьцаа	Урашигт татвар	Хөшүүрэггүй бэлтгэлийн тооцоолол
Өр ба нийт үнэлгээний харьцаа	24.4%	ADM.N	1.00	-	-	0.41	0.44%	0.71
Өмч ба нийт үнэлгээний харьцаа	75.6%	ABF.L	0.56	-	-	0.10	23.16%	0.52
		INGR.N	0.38	-	-	0.66	30.15%	0.26
Өрийн өртөг		BG.N	1.29	-	-	0.76	16.86%	0.79
Өрийн өртөг	16.1%	GAME.NS	1.55	-	-	0.00	26.08%	1.55
ААН/ОАТ хувь хэмжээ	10.0%	1006.HK	1.33	-	-	0.10	16.72%	1.23
Татварын дараах өрийн өртөг	14.5%	2009.FU	0.48	-	-	0.10	32.71%	0.45
		1229.TW	0.55	-	-	0.14	2.52%	0.48
Өмчийн өртөг								
Эрсдэлгүй өгөөж	2.4%							0.61
Зах зээлийн эрсдэлийн нэмэгдэл	6.4%							32.3%
Хөшүүрэгдсэн бэлтгэлийн тооцоолол	0.79							10.0%
КХҮЗ	7.5%							0.79
Хэмжээний нэмэгдэл	3.7%							
Улсын эрсдэлийн нэмэгдэл	7.5%							
Салбарын эрсдэл	2.0%							
Компанийн эрсдэлийн нэмэгдэл	3.1%							
Өмчийн өртөг	23.7%							
КҮЖӨ	21.5%							

Хөшүүрэггүй бэлтгэлийн тооцоолол
 Ашиглах өр/өмч харьцаа 32.3%
 Ашиглах татварын түвшин 10.0%
 Дахин хөшүүрэгдсэн бэлтгэлийн тооцоолол 0.79

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедгийн гишүүн мөн.

Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ('үргэлжлэл)

Хоргодуулсан мөнгөн урсгалын загвар - доод хязгаар

Мөнгөн урсгалын хуваарь	ТЖ14Б	ТЖ15Б	ТЖ16Б	ТЖ17Б	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Татварын дараах цэвэр ашиг	626,429	(323,869)	(84,903)	36,843	636,583	1,581,649	2,185,248	2,543,725	2,789,445
Нэмж: Мөнгөн-бус зардал (элэгдэл, хорогдол)	452,903	451,825	453,382	451,285	680,785	682,382	682,382	682,382	682,382
Нэмж: Хүүний зардал	-	-	-	-	280,107	141,288	21,403	-	-
Хасах: Капиталын зардал	-	-	-	-	2,200,000	-	-	-	-
Хасах: Цэвэр ажлын капиталын өөрчлөлт	774,715	(266,163)	858,184	537,084	835,702	1,104,021	1,104,021	(498,731)	(182,511)
Бизнесийн чөлөөт мөнгөн урсгал	304,617	394,119	(489,705)	(48,956)	(1,402,761)	1,569,617	1,785,012	3,724,838	3,654,338
Бизнесийн үлдэх үнэ цэнэ	-	-	-	-	-	-	-	-	30,142,292
Хорог дуулах үе	-	-	-	-	0.50	1.50	2.50	3.50	4.50
Хорог дуулах хүчин зүйл	-	-	-	-	0.93	0.81	0.70	0.60	0.52
Хорог дуулсан дискрет мөнгөн урсгал	-	-	-	-	(1,305,061)	1,264,464	1,245,451	2,249,573	1,911,066
Хорог дуулсан эдийн мөнгөн урсгал	-	-	-	-	-	-	-	-	15,763,159
Бизнесийн үнэ цэнэ (мянган төгрөг)	-	-	-	-	21,128,652	-	-	-	-
Хасах: Санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	3,406,508	-	-	-	-
Нэмж: Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	506,452	-	-	-	-
100%-ийн өмчийн үнэ цэнэ	-	-	-	-	18,228,596	-	-	-	-

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Хоргодуулсан мөнгөн урсгалын загвар - доод хязгаар

Мөнгөн урсгалын хуваарь	ТЖ14Б	ТЖ15Б	ТЖ16Б	ТЖ17Б	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Татварын дараах цэвэр ашиг	626,429	(323,869)	(84,903)	36,843	636,583	1,581,649	2,185,248	2,543,725	2,789,445
Нэмж: Мөнгөн-бус зардал (элэгдэл, хорогдол)	452,903	451,825	453,382	451,285	680,785	682,382	682,382	682,382	682,382
Нэмж: Хүүний зардал	-	-	-	-	280,107	141,288	21,403	-	-
Хасах: Капиталын зардал	-	-	-	-	2,200,000	-	-	-	-
Хасах: Цэвэр ажлын капиталын өөрчлөлт	774,715	(266,163)	858,184	537,084	800,236	835,702	1,104,021	(498,731)	(182,511)
Бизнесийн чөлөөт мөнгөн урсгал	304,617	394,119	(489,705)	(48,956)	(1,402,761)	1,569,617	1,785,012	3,724,838	3,654,338
Бизнесийн үлдэх үнэ цэнэ	-	-	-	-	-	-	-	-	33,671,829
Хорог дуулах үе	-	-	-	-	0.50	1.50	2.50	3.50	4.50
Хорог дуулах хүчин зүйл	-	-	-	-	0.94	0.82	0.72	0.63	0.55
Хорог дуулсан дискрет мөнгөн урсгал	-	-	-	-	(1,312,541)	1,286,290	1,281,448	2,341,195	2,011,698
Хорог дуулсан эдийн мөнгөн урсгал	-	-	-	-	-	-	-	-	18,536,205
Бизнесийн үнэ цэнэ (мянган төгрөг)	-	-	-	-	24,144,295	-	-	-	-
Хасах: Санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	3,406,508	-	-	-	-
Нэмж: Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	506,452	-	-	-	-
100%-ийн өмчийн үнэ цэнэ	-	-	-	-	21,244,239	-	-	-	-

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Хөвсгөл Аймаг
Хуудас 45
ХӨВСГӨЛ АЖАЙН ДУУЛГА ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТЭ3216 2034565

СЭХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
2018 оны 06 сар 18 өдөр 01



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Е. Жишиг арилжааны мэдээлэл

Жишиг компани	Тодорхойлолт
Masuda Flour Milling Company	Энэхүү компанийг нь 2017 оны 12-р сарын 29-нд 3.04 тэрбум Японы иенээр Mitsubishi (TKS: 8058) охин компани болох Nitto Fuji Flour Milling Company (TKS: 2003) худалдан авах гэрээ байгуулсан.
Tofuku Flour Mill Company	Энэхүү компанийг Nippon Flour Mills (TKS: 2001) нь 2016 оны 8-р сарын 4-нд үл мэдэгдэх дүнгээр худалдан авсан.
Black Earth Farming	Энэхүү компанийг 2017 оны 5-р сарын 22-нд Кукурагийн гэр бүл 1.5 тэрбум Швед кронаар худалдаж авсан.
Agria	Энэхүү компанийг 2016 оны 1-р сарын 29-нд 226.6 сая юанаар Suanjin Lai худалдан авах талаар яригдаж байсан. Дараа нь уг гэрээ 2016 оны 4-р сарын 12-нд цуцлагдсан. Өмнө нь энэхүү компани нь 2007 оны 11-р сарын 7-ны өдөр "GRO" гэсэн биржийн тэмдэгтээр Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр 282.97 сая ам.долларын хувьцааг анхдагч зах зээл дээр гаргасан. Нийт 17,150,000 ADS (АНУ-ын хөрөнгийн бирж дээр худалдан авах боломжтой гадаад компанийн АНУ-ын доллароор нэрлэсэн үнэтэй өмчийн хувьцаа) хувьцааг нэг бүрийн 16.50 ам.долларын нэрлэсэн үнээр зарсан. Хувьцааг анхдагч зах зээл дээр гаргасны дараа, нэг бүрийн 16.50 ам.долларын үнэтэй нийт 126,400,000 ширхэг энгийн хувьцаа нь (хувьцааны хуваарилалтаас хэтэрснийг оруулахгүйгээр) энэхүү компанийг 1.04 тэрбум доллароор үнэлсэн. Ийнхүү хувьцаа борлуулсаны (зардал ороогүй) 198 сая ам.долларын орлого компанид орсон ба хувьцаагаа зарж буй хувьцаа эзэмшигчдэд 84.97 сая долларын орлого орсон байна. Энэхүү анхдагч зах зээл дээр 12,000,000 ширхэг ADS хувьцааг зарсан бөгөөд хувьцаагаа зарж буй хувьцаа эзэмшигчид нь 5,150,000 ширхэг хувьцаагаа зарсан байна. Хэрэв хувьцааны хуваарилалтын хэтэрснийг төлөхийн тулд тухайн андеррайтерууд нь энэхүү компаниас болон хувьцаагаа зарж буй хувьцаа эзэмшигчдээс нэмэлтээр 2,572,500 ширхэг хүртэл ADS хувьцааг худалдан авах боломжийг олгосон.
General Mills	Энэхүү компанийг (NYSE: GIS) 2016 оны 12-р сарын 13-нд 10 тэрбум ам.долларын зээлээр нээлттэй компаниас хаалттай хувийн өмчит болгон 3G Капитал худалдан авах талаар яригдаж байсан. Дараа нь гэрээ цуцлагдсан. Fidelity National Financial компани нь нээлттэй зах зээлийн хэлэлцээрээр дамжуулан 2017 оны 2-р сарын 3-ны өдөр 62.23 сая ам.долларын өөрийн хувьцааг энэхүү компанид (NYSE: GIS) зарсан.
Z Trim Holdings	Энэхүү компани (PINK: ZTHO) нь 2015 оны 1-р сарын 14-ний байдлаар хувийн хөрөнгө оруулалтаар дамжуулан нэр үл мэдэгдэх хөрөнгө оруулагчдаас 20 сая ам.долларын хөрөнгө оруулалтын 1.04 сая ам.долларыг хүлээн авсан байна.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Ө. Мэдээллийн эх сурвалж

Энэхүү тайланг бэлтгэхэд ашиглагдсан мэдээллийн үндсэн эх сурвалжид дараах зүйлс хамаарна:

- санхүүгийн гүйцэтгэл, санхүүгийн байдал, үйл ажиллагаатай холбоотой та бүхэнтэй хийсэн ярилцлага, хэлэлцүүлэг;
- 2014-2017 оны тайлан жилийн эцсээрх СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайлан;
- Барааны тэмдгийн үндэсний тохирлын гэрчилгээ цахим хувилбар;
- Та бүхнээс бидэнд ирүүлсэн бусад мэдээлэл ба баримт.

■ Бидний ашигласан бусад хөндлөнгийн мэдээллийн эх сурвалжид:

- БДО Аудит ХХК-ийн үнэлгээний багийн хийсэн “Монгол улсын 1991-2017 оныг хамарсан сүүлийн 27 жилийн нэг га-гаас хураасан үр тарианы статистик мэдээ”
- S&P Capital IQ, PitchBook-ээс цуглуулсан жишиг компаниудын үнэлгээний параметрууд;
- Moody’s “Сар бүрийн Үйл ажиллагааны түрээсийн зах зээлийн төлөв” 2017 оны 1-р сараас 2017 оны 12 сар хүртэл сар бүрийн мэдээ
- БДО Монгол Газар тариалангийн салбарын тойм;

■ Бидний судалсан бусад хууль эрхзүйн бичиг баримтууд:

- Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
- Тариалангийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль
- Таримал ургамлын үр сортын тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль

Хүндэтгэл нь үнэлгээний өдөр хүртэл өгөгдсөн мэдээлэлд үндэслэн бэлтгэгдсэн. Бид хөндлөнгийн мэдээллээс бусад энэ тайланд багтсан эсвэл бидэнд ирүүлсэн аливаа мэдээллийг баталгаажуулах оролдлого хийгээгүй болно.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт Ж. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл

Бид дараах зүйлсийг баталж байна:

- Энэхүү тайланд багтсан мэдэгдлүүд нь үнэн зөв бөгөөд алдаагүй;
- БДО Аудит ХХК-д үйлчлүүлэгчийн хөрөнгө эсвэл оролцогч этгээдүүдтэй холбоотой ямар нэгэн өнөөгийн эсвэл ирээдүйн хувь оролцоо, ялгаварлах үзэл байхгүй болно.
- Бидний шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа авч ашигласан суурь мэдээллүүд үнэн зөв ба алдаагүй болно. Энэхүү тайланд багтсан мэдээлэл, тооцоолол, дүгнэлт буюу үнэ цэнийн талаарх дүгнэлт нь үнэн зөв, алдаагүй бөгөөд найдвартай эх үүсвэрээс авсан мэдээлэлд суурилсан. Гэсэн хэдий ч эдгээр зүйлсийн үнэн зөв байдлын талаар өндөр түвшинд баталгаа гаргахгүй.
- Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодитой тооцоолсон гэж үзэж байна.
- Тайлагнасан шинжилгээ, дүгнэлт нь тайлагнасан таамаглал ба хязгаарлах нөхцөлөөр л хязгаарлагдсан бөгөөд эдгээр нь бидний хувийн бөгөөд тусгайлан ялгаварлан авч үзээгүйгээр гаргасан мэргэжлийн шинжилгээ, шийдэл, дүгнэлт болно;
- БДО Аудит ХХК болон бидний зүгээс үнэлэгдсэн өмчид ямар нэгэн алс хэтийн хувийн ашиг сонирхол, хувь оролцоо байхгүй бөгөөд оролцсон талуудтай ямар нэгэн хувийн ашиг сонирхол байхгүй болно;
- Үнэлгээний объект буюу үнэлэгдэж буй хөрөнгө нь энэ гэрээт ажилд оролцсон этгээдүүдтэй ямар нэгэн холбоогүй болно;

Үнэлгээчид болон БДО нь Хөвсгөл Алтандуула ХК, түүний охин болон хараат компаниудтай ашиг сонирхлын холбоогүй;

Энэ гэрээт ажилд оролцсон манай баг урьдчилан тодорхойлсон дүнг гаргах зорилгоор ажиллаагүй болохыг баталж байна;

Хуудас 49 | Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

- Энэ гэрээт ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой бидний ажлын хөлс нь урьдчилан тодорхойлсон дүнг боловсруулж тайлагнах эсвэл үйлчлүүлэгчийн хүслийг биелүүлэх, болзолт үр дүн гаргах зэргээс хамааралгүй болно;
- Бидний хийсэн шинжилгээ, мэргэжлийн шийдэл, дүгнэлт нь Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хууль, Үнэлгээний олон улсын стандарт, Үнэлгээчдийн ёс зүйн дүрмийн шаардлагад нийцэж байгаа болно;
- Энэхүү баталгааг энд гарын үсэг зурсан Тусгай зөвшөөрөл эзэмшигч үнэлгээчид болон БДО Аудит ХХК-ийн эрх бүхий удирдлагууд гаргаж байгаа бөгөөд энэхүү ажилд оролцсон бусад мэргэжилтнүүдэд хамаарахгүй.



Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

Хавсралт 3. Үнэлгээний баг

Г. Баянмөнх
Үнэлгээний партнер
БДО Аудит ХХК
Холбоо барих:
+976 9111 4040
+976 7740 4040
bayantunkh@bdo.mn



Г. Өсөхбаяр
Үнэлгээчний туслах
БДО Аудит ХХК
Холбоо барих:
+976 9917 1317
+976 7740 4040
usukhbayar@bdo.mn



Э. Буяннэмэх
Ахлах аудитор
БДО Аудит ХХК
Холбоо барих:
+976 9901 6488
+976 7740 4040
byuannemekh@bdo.mn



Б. Цэнгэл
IT мэргэжилтэн
БДО Аудит ХХК
Холбоо барих:
+976 9904 1200
+976 7740 4040
usukhbayar@bdo.mn



Г. Баянмөнх нь Монгол улсын хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд тэргүүлэх зэрэгтэй үнэлгээчин юм. Тэрээр үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үнэлгээ, Дню Дилижинсийг хамарсан мэргэжлийн тайлан гаргаж байсан 30 гаруй жилийн туршлагатай.

Г. Баянмөнх одоогоор БДО Аудит ХХК-д Ерөнхий захирал бөгөөд БДО олон улсын сүлжээний Монгол дах Удирдах захирлын албан тушаал хашихын хажуугаар Аудит ба Үнэлгээний ажлыг хариуцан ажилладаг.

Түүний салбарын туршлагад газар тариалан, уул уурхай, эм үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө, төмөр зам, банкны сектор, барилга угсралт, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрийн салбар багтана.

Г. Өсөхбаяр нь БДО сүлжээний Монгол дахь оффист 2017 онд нэгдсэн бөгөөд одоогоор хөрөнгө ба бизнесийн үнэлгээ, М&А зах зээлийн судалгаанд үнэлгээчний туслахын үүрэг гүйцэтгэж байна.

Тэрээр дараах үнэлгээний ажлуудад оролцож байсан туршлагатай. Үүнд:

- АПУ ХК-ийн бизнесийн үнэлгээ
- Астериск ХК-ийн бизнесийн үнэлгээ
- Эко Скуул Гарден ХХК-ийн тусгай зориулалтын бизнесийн үнэлгээ
- Мошеа-Эко Энержи ХХК-ийн бизнесийн үнэлгээ
- Цемент Шохой ХК-ийн хөрөнгийн үнэлгээ
- ХААН банкны тусгай активын үнэлгээ

Э. Буяннэмэх нь Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд БДО сүлжээний Монгол дахь оффист ахлах аудиторын үүрэг гүйцэтгэдэг. БДО-д нэгдэхээс өмнө тэрээр Итгэл Аудит ХХК-д аудиторын туслах, туслах аудитор, аудитор зэрэг албан тушаал хашиж байсан.

Түүний салбарын туршлагад хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхай, эм үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө, төмөр зам, банкны сектор, барилга угсралт, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрийн салбар багтана.

Б. Цэнгэл нь мэдээллийн технологийн мэргэжилтэн бөгөөд БДО сүлжээний Монгол дахь оффист мэдээллийн аудитын үйлчилгээ үзүүлдэг. Тэрээр БДО сүлжээнд нэгдэхээс өмнө програм хангамж суориуулалтын компанид ажилласан туршлагатай.

Түүний салбарын туршлагад өгөгдөл боловсруулалт, програм хангамж, хагас дамжуулагч, байгууллагын дотоод хяналтын систем, ERP систем зэрэг багтана.



СЗХ
 2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
 2018.06.29 өдөр

Хуудас 51 | Хөвсгөл Алгандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар .07120001..

Иргэний ургийн овог: Мундсар
 Иргэний овог нэр: Гомбо овогтой Баянмох
 Иргэний үнэмлэхний дугаар: УБ0620617
 Иргэний бүртгэлийн дугаар: РП167042814
 Үнэлгээний гэрчилгээний дугаар: _____
 Иргэний хаяг: УБ 1068695, Нийслэл, БЗД, 12-р хороо, Кристал таун 801-809 тоот
 Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2010/12/20-ны өдрийн 280 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД _____ С.БАЯРЦОГТ /
 УЛААНБААТАР ХОТ

Хавсралт И. Үнэлгээний тусгай зөвшөөрөл

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитетийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2013 оны 286 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2013 оны 12-р сарын 20-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Ч.УЛААН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.... оны дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.... оны-р сарын-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.... оны дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.... оны-р сарын-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

0000001

BDO
 2987103
 ПУОНСЗ30

ХӨВСГӨЛ АИМАГ
 ХӨВСГӨЛ
 АЛДАН ДУУЛГА
 ХК
 /ГЭРЭЭНИЙ/
 ГТБ3216 ш. 2034565

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018.08.29 өдөр

Хуудас 52 | Хэвсгөл Алгандуулга ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан



Peace Avenue 47/2, Bayanzurkh District
15th Khoroо, Ulaanbaatar, Mongolia
Tel: 976-7575888
Fax: 976-7000808
E-mail: info@khaandaatgal.mn

ДААТГАЛЫН ГЭРЧИЛГЭЭ № 1719

“ХААН ДААТГАЛ” ХХК (Даатгагч) болон “БДО АУДИТ” ХХК (Даатгуулагч) нар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу дор дурдсан нөхцлөөр Даатгалын гэрээг байгуулсан болохыг үүгээр гэрчилж байна.

ГЭРЭЭНИЙ ДУГААР: № Г17089873

ДААТГУУЛАГЧ: “БДО АУДИТ” ХХК
Хөрөнгийн үнэлгээчин-Г.Баянмөнх /РП67042814/
Хөрөнгийн үнэлгээчин - Ж.Энхчимэг /ТИ65050264/

ДААТГАГЧ: “ХААН ДААТГАЛ” ХХК
47/2, Энхтайваны өргөн чөлөө, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар-210644, Монгол Улс

ДАВХАР ДААТГАГЧ: HANNOVER RUCKVERSICHERUNG AG
Karl-Wiechert-Allee 50, 30625 Ханновер,
Герман Улс

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ: МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ: 1,000,000,000.00 ₮

ДААТГАЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ: МОНГОЛ УЛС

ДААТГАЛЫН ХУГАЦАА: Эхлэх хугацаа: 2017.08.16
Дуусах хугацаа: 2018.08.15

УЛААНБААТАР ХОТ
ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХААН ДААТГАЛ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж. БАЯРСАЙХАН

Хавсралт И. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл (“үргэлжлэл”)

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нээсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитетийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

BDO
2987103
ПОН-330

ХӨВСГӨЛ
АЛБАН ДУУЛИН
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТБ3216 № 2034565

Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.



Хөвсгөл Алтандуула ХК-ийн бизнесийн үнэлгээний тайлан

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

№ _____

Улаанбаатар хот

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИАС НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАН
НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД
ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН
ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР

Хэнд: Д.Дуламсүрэн
Гүйцэтгэх захирал
“Хөвсгөл Алтан дуулга” ХК
Монгол улс, Хөвсгөл аймаг,
Тариалан сум, Мандал баг

Хэнээс: Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Цэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
и-мэйл хаяг: info@mdsa.mn

Огноо: 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр






Агуулга

Нийтлэг үндэслэл..... 3

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх 4
2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар..... 5
3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх..... 9
4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх 13
5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх..... 16
6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх..... 18
7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх 19
8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх 22
9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох . 22
10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа 23
11. Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ..... 23
12. Гол дүгнэлт..... 26





Нийтлэг үндэслэл

Өмгөөллийн “Эм Ди Эс энд Хаан Лекс” ХХН (цаашид “**MDSK**” гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “**СЗХ**” гэх)-ны 2014.01.29-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд “Эм Ди Эс энд Ассошэйтс” ХХН болон “ХаанЛекс адвокатс” ХХН 2 хуулийн фирм нэгдэж, өөрчлөн байгуулагдсаны дараа СЗХ-ны 2016.02.24-ний өдрийн 42 дугаар тогтоолоор нэрээ шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (**Хавсралт 1.1**)-ийн хувьд энэхүү хууль зүйн Үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.


Монгол Улсын хуулийн этгээд болох “Хөвсгөл Алтан дуулга” ХК (цаашид “**Алтан дуулга**” гэх) нь нэмж хувьцаа гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсэж улмаар бид 2018.01.08-ны өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” (**Хавсралт 1.2**) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.


Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу нэмж хувьцаа гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид “**МХБ**” гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

Энэхүү хувьцааны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015.11.23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, МХБ-ийн ТУЗ-ийн 2018.01.25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012.02.10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан “МХБ ТӨХК-ийн Арилжааны журам”-ын дагуу явагдана.

Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор Алтан дуулга-аас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн





эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан хууль зүйн дүгнэлт гаргаж байна:

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх

“Хөвсгөл Алтан дуулга” ХК нь Хөвсгөл аймгийн Тариалан Сангийн аж ахуйн суурин дээр 1943 онд үүсгэн байгуулагдсан. Тус САА нь өмч хувьчлалд хамрагдаж, төрийн өмч давамгайлсан Алтандуулга ХК байгуулагдсан ба компанийн төрийн өмчид байсан 70.7 хувийг “Тэс Трейд” ХХК нь 1998.04.02-ны өдрийн Төрийн өмчийн хорооны “Төрийн өмчийн хувьцааг худалдан авагчид шилжүүлэх тухай” 14 дүгээр мэдэгдлийн дагуу (Хавсралт 1.3) 1998.03.27-ны өдөр зохион байгуулсан нийтийн дуудлага худалдаанд ялж хувьчилж авснаар компани 100% хувийн өмчит компани болсон байна (Хавсралт 1.4).

Хөвсгөл аймгийн ардын хурлын гүйцэтгэх захиргааны өмч хувьчлалын комиссын Тариалан сумын “Тариалан” сангийн аж ахуйг хувьчлах тухай 1994 оны 03 сарын 02 –ны 06 тоот тогтоолоор Тариалан сум “Тариалан” сангийн аж ахуйг “Алтандуулга”, “Дулаанхаан”, “Баян хошуу” хувьцаат компани, “Одос”, “Алтан эмээлт” бүрэн бус хариуцлагатай компани болгон хувьчлахаар төслийг баталжээ (Хавсралт 1.5). Уг тогтоолын 2-рт аж ахуй нэгжүүдэд үлдэх бүх хөрөнгийг 31,803.6 мянган төгрөг, гаргах бүх хувьцаа ногдол хувийг 318036 ширхгээр, үүнээс “Алтан дуулга” компанийн гаргах хувьцааг 128253 ширхэг, “Дулаанхаан” компанийн гаргах хувьцааг 65094 ширхэг, “Баянхошуу” компанийн гаргах хувьцааг 61419 ширхэг, “Одос” компанийн гаргах ногдол хувийг 50988 ширхэг, “Алтан эмээлт” компанийн гаргах ногдол хувийг 12282 ширхгээр, ажиллагсдын давуу эрхээр авах хувьцаа, ногдол хувийг “Алтандуулга” хувьцаат компанид 22050 ширхэг, “Дулаанхаан” хувьцаат компанид 13440 ширхэг, “Баянхошуу” хувьцаат компанид 18550, “Одос” бүрэн бус хариуцлагатай компанид 21000 ширхэг, “Алтан эмээлт” бүрэн бус хариуцлагатай компанид 1330 ширхэг тус тус тогтоож компаниудын хувьцаа, ногдол хувийг зохих журмын дагуу арилжаалахыг “Хөвсгөл” брокерын пүүс-т зөвшөөрсөн шийдвэрийг тус тус гаргасан байна.

Компаниудыг нэгтгэн зохион байгуулах тухай 1995.04.08-ны өдөр Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар 5 тоот тогтоолыг баталсан байна. Уг тогтоолд Алтандуулга ХК-д Баянхошуу хувьцаат компани, Алтан эмээлт ББХКомпанийг 1994-04-10-ны өдрөөс нэгтгэн зохион байгуулах арга хэмжээ авахыг сумын засаг дарга /О.Гунаажав/-д зөвшөөрөх шийдвэр (Хавсралт 1.6)-ийг гаргасан байна.

Алтан дуулга нь 2005.10.28-ны өдрийн улсын бүртгэлийн гэрчилгээ (Хавсралт 1.7), 2018.02.20-ны өдрийн компанийн дүрмийн (Хавсралт 1.8) дагуу үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, хүнсний ногоо тариалах, малын тэжээлийн үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, мал аж ахуй, хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхэлнэ хэмээн заасан байна.





Компанийн оноосон нэр 1998 оны дүрэмд “Алтан дуулга” ХК, 2012 оны дүрэмд “Хөвсгөл Алтан дуулга” ХК гэж бичигдсэн бөгөөд нэрийн өөрчлөлт хийгдсэн тухай архивын материалаас үзвэл 1996 онд “Дулаанхаан”, “Баян хошуу”, “Одос”, “Алтан эмээлт” компаниудыг нэгтгэх үеэс “Хөвсгөл Алтан дуулга” хэмээн өөрчилж, 1996.06.10-ны өдөр Үнэт цаасны хороонд өргөдөл (Хавсралт 1.9) өгч, 2007.11.12-ны өдөр Монголын хөрөнгийн биржид А/07-59 тоот “Нэр солих тухай” албан бичиг (Хавсралт 1.10)-ээр хүсэлт тавьж шийдвэрлүүлж байсан байна.

Олон нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргахаар бэлтгэх явцад тус компанийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах асуудлыг МХБ, СЗХ-д тавьж шийдвэрлүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2018.05.04-ний өдрийн 170 дугаар тогтоолоор Алтан дуулга-ын нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 113,286 ширхэг хувьцааг 100 хувааж, нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,328,600 ширхэг энгийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэлд зохих өөрчлөлтийг бүртгэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000075664,

Улсын бүртгэлийн дугаар: 1710001001,

Регистрийн дугаар: 2034565

Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр: “Хөвсгөл Алтан дуулга” Хувьцаат компани

Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэл, хүнсний ногоо тариалах, гадаад дотоод худалдаа, мал аж ахуй, хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.

Хугацаа: Хугацаагүй

Гишүүдийн тоо: 171 (2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалгаагаар)

Өөрийн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр): 113,328

Хуулийн этгээдийн албан ёсны хаяг: Хөвсгөл аймаг, Тариалан сум, 1-р баг, Мандал

Гэрчилгээ олгосон огноо: 2014.05.19

Гүйцэтгэх захирал: Д.Дуламсүрэн

Энэхүү хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар 2005.10.28-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн тухай 2014.05.19-ний өдөр олгогдсон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000075664, Улсын бүртгэлийн дугаар 1710001001, Регистрийн дугаар 2034565) бүхий “Хөвсгөл Алтан дуулга” ХК нь хууль зүйн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар

Тайлан гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Алтан дуулгын дүрмийн 8.1-д тус компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна”





гэж заасан шаардлагад нийцсэн байна. Компанийн дүрэмд үндэслэн тус компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Зөвлөх инженер, Ерөнхий агрономич, Ерөнхий нягтлан бодогч нарыг хамруулан авч үзлээ.

Алтан дуулгын 70.7 хувийг эзэмшигч “Тэс Трейд” ХХК нь “Компанийн тухай” хуулийн дагуу нэг гишүүн (Доржпүрэвийн Ганхуяг РД:РП78111012)-тэйгээр 1996 онд үүсгэн байгуулагдсан (Улсын бүртгэлийн дугаар: 9011688108; РД: 2034948) Монгол Улсын хуулийн этгээд юм (Хавсралт 2.1, 2.2).

2018.02.20-ны өдрийн Алтан дуулгын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоол (Хавсралт 2.3)-оор тус компанийн ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. ТУЗ-ийн дарга Ноовын Ерөөгэрэл, 1998 онд МУИС Эдийн Засгийн сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжлээр магистр зэрэгтэй, 2011 онд Австрали улсын Маккуари Их сургуулийг актуарч мэргэжлээр магистр зэрэгтэй тус тус суралцаж төгссөн. М Си Эс холдинг ХХК-д эрсдэлийн ахлах шинжээчээр ажиллаж байсан бөгөөд 2017 оноос Алтан дуулгын санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байна (Хавсралт 2.4).
2. ТУЗ-ийн гишүүн Дорждүрэвийн Дуламсүрэн, 1994 онд Гадаад хэлний дээд сургуулийг багш мэргэжлээр, 2004 онд ХБНГУ-ын ЭЗХАХЯ-ны дэргэдэх Зах зээлийн эдийн засгийн менежмент чиглэлээр, 2003 онд СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагыг магистр зэрэгтэйгээр тус тус суралцаж төгссөн. 2012 оноос хойш Алтан дуулгын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.5).
3. ТУЗ-ийн гишүүн Доржпүрэвийн Ганхуяг, 2005 онд Бизнесийн дээд сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. “Тэс трейд” ХХК-ийн Захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.6).
4. ТУЗ-ийн гишүүн Мандширийн Зулзаяа, 2006 онд Их засаг дууд сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. 2011 оноос 2016 оны хооронд Сувд партнерс хуулийн фирмд өмгөөлөгчөөр ажиллаж байсан бөгөөд, 2016 оноос өнөөдрийн хүртэл ELC хуулийн фирмд өмгөөлөгчөөр ажиллаж байна (Хавсралт 2.7).
5. ТУЗ-ийн гишүүн Очирхүрээгийн Тунгалаг, 1982 онд ОХУ-ын Воронеж хотын Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр магистр зэрэгтэйгээр суралцаж төгссөн. УИХ-ын Тамгын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөхөөр ажиллаж байгаад 2014 оны 12 сард өндөр насны тэтгэвэрт гарсан (Хавсралт 2.8).
6. ТУЗ-ийн гишүүн Төмөрийн Мөнхгэрэл, 1989 онд ОХУ-ын Москва хотын Ахуйн үйлчилгээний технологийн дээд сургуулийг бүртгэлийн эдийн засагч мэргэжлээр ЭЗШУ-ны магистр зэрэгтэйгээр суралцаж төгссөн. Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтнээр сүүлийн жилүүдэд ажиллаж байсан бөгөөд одоо хувиараа бизнэс эрхэлж байна (Хавсралт 2.9).
7. ТУЗ-ийн хараат бус гишүүн Даваажавын Энхтогтох, 1989 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. “Хараа хөвч хангай” ХХК-ийн зөвлөх үйлчилгээний төвийн ерөнхий зөвлөхөөр ажиллаж байна (Хавсралт 2.10).

¹ Компанийн дүрмийн 8.1: ТУЗ-ын дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно.





8. ТУЗ-ийн хараат бус гишүүн Лхамын Даваа, 1987 онд ХААДС-ийг агрономич мэргэжлээр, ХААУхааны доктор, МУ-ын зөвлөх агрономич цолтойгоор тус тус суралцаж төгссөн. 1999 оноос ХААИС, АЭС-д багшаар ажиллаж байсан бөгөөд 2007 оноос хойш өнөөдрийн хүртэл ХААИС-ийн ЭШСҮ-ийн “Нарт” төвийн захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.11).
9. ТУЗ-ийн хараат бус гишүүн Заяатын Батсүх, 1992 онд ХААДС-ийг малын их эмч мэргэжлээр, МАА-н шинжлэх ухааны доктор, профессор зэрэгтэйгээр суралцаж төгссөн. 1992 оноос Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн даргаар ажиллаж байна (Хавсралт 2.12).
10. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Сэрээтэрийн Оюунгэрэл, 1982 онд ОХУ-ын Кубанийн Их сургуулийн хуулийн тэнхимийг хуульч мэргэжлээр төгссөн. Нийслэлийн ИТХ-ын ажлын албаны зохион байгуулагчаар ажиллаж байсан бөгөөд одоо Алтан дуулгын ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна (Хавсралт 2.13).


Алтан дуулгын Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэн нь 2012.04.27-ны өдрийн ТУ/12-04 дугаартай ТУЗ-ийн хурлын тогтоол (Хавсралт 2.14)-оор, Зөвлөх инженер Ц.Жаргал нь 2015.08.31-ний өдрийн ТУ-15-11 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.15)-аар, Ерөнхий агрономич Б.Лхагва-Очир нь 2006.02.15-ны өдрийн 06 дугаартай Захирлын тушаалаар, Ерөнхий нягтлан бодогч Н.Одончимэг нь 2017.10.27-ны өдрийн ТУ/17-15 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.16)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

1. Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэн (дээрхээс танилцана уу).
2. Зөвлөх инженер Ц.Жаргал нь ОХУ-ын Одесс хотын Хүнсний технологийн дээд сургуулийг Үр тариа хадгалан боловсруулах үйлдвэрийн технологич мэргэжлээр төгссөн. 2014-2017 оны хооронд Жавхлант групп ХХК-д гурилын үйлдвэрийн технологичоор ажиллаж байсан. Одоо Алтан дуулгад зөвлөх инженерээр ажиллаж байна (Хавсралт 2.17).
3. Ерөнхий агрономич Б.Лхагва-Очир нь 2005 онд ХААИС-ийг агрономич мэргэжлээр төгссөн, Швейцар улсад газар тариалан, эмийн ургамлын чиглэлээр 6 сар дадлага хийсэн. 2006 оноос одоог хүртэл Алтан дуулгын ерөнхий агрономичоор ажиллаж байна (Хавсралт 2.18).
4. Ерөнхий нягтлан бодогч Н.Одончимэг нь 1998 онд СЭЗДС-ийг банкны санхүүч, эдийг засагч мэргэжлээр төгссөн. “Ачид орг” ХХК-д нягтлан бодогчоор ажиллаж байсан. 2017 оны 10 дугаар сараас хойш Алтан дуулгад ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна (Хавсралт 2.19).

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр авч үзвэл:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	Нэрс/Шаардлага	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокуратурын	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)	Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)







		байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх			
1	Н.Ерөөгэрэл (ТУЗ-ийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130901/	Тийм
2	Д.Дуламсүрэн (ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.01.25-ны өдөр, Дугаар 0230074/	Тийм
3	Д.Ганхуяг (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.01.25-ны өдөр, 0330085	Тийм
4	М.Зулзаяа (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130902/	Тийм
5	О.Тунгалаг (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130895/	Тийм
6	Т.Мөнхгэрэл (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130896/	Тийм
7	Д.Энхтогтох (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.01.25-ны өдөр, Дугаар 0230064/	Тийм
8	Л.Даваа (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130903/	Тийм
9	З.Батсүх (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.03.02-ны өдөр, Дугаар 0130897/	Тийм
10	С.Оюунгэрэл (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.04.29-ний өдөр, Дугаар 0230085/	Тийм

*Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013.01.31-ний өдрийн А/12 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу Ял шийтгэлэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан ял шийтгэлгүй эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараа хүснэгтээр авч үзвэл:

ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага				
№	Шаардлага	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс		
		Л.Даваа	Д.Энхтогтох	З.Батсүх
1.	Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1)	Тийм**	Тийм**	Тийм**
2.	Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2, КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
3.	Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**	Тийм**
4.	Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-	Тийм**	Тийм**	Тийм**





	ийн 79.1.4)			
5.	Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
6.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
7.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
8.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
9.	Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
10.	Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**

**Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4-т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв

Алтан дуулгын 70,7 хувийн хувьцаа эзэмшигч “Тэс трейд” ХХК-ийн болон Алтан дуулгын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Алтан дуулгын Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан бөгөөд компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх

Хөвсгөл Алтан дуулга ХК-ийн дүрэм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012.04.27-ны өдрийн тогтоолын Хавсралт 2-оор Компанийн одоогийн мөрдөгдөж буй дүрэм (цаашид “Дүрэм” гэх)- ийг (**Хавсралт 3.1**) баталсан байна. Дүрэм нь нийт 14 бүлэгтэй бөгөөд Компанийн эрх зүйн байдал, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчид, Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтныг тодорхойлж, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн засаглал, нягтлан бодох бүртгэл, хяналт, мэдээллийн үндсэн зарчим, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байна.

Дүрмийн 1.3-т Компанийн оноосон нэрийг тусгасан, 3.3-т Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 16.2.1, 16.2.6-д тус тус нийцсэн байна.

Компанийн засаглалын журмууд

ТУЗ-ын үйл ажиллагааны журам. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг Компанийн засаглалын кодекст нийцүүлэх зорилгоор нийт 8 бүлэгтэй “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг 2012.04.27-ны өдрийн ТУ/12-03 дугаар тогтоолын хавсралт 1-ээр (**Хавсралт 3.2**) баталсан байна. Тус журамд ТУЗ-ийн эрх зүйн байдал, ТУЗ-





ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийг тухайлан зааснаас гадна ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг сонгох журам, тэдэнд тавигдах шаардлага, тэдгээрийн ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой эдлэх эрх, хүлээх үүрэг, ТУЗ-ийн хурлын зар хүргэх журам, ТУЗ-ийн хороод, тэдгээрийн бүрэлдэхүүнтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1, 80.4, Компанийн засаглалын Кодексийн 5.1.4, 5.2.2, 5.4.2-т заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байна.

Алтан дуулгын сангийн хуримтлал, ногдол ашиг хуваарилах журам. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, санхүүгийн тогтвортой үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулах сонирхлыг хамгаалахаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын Кодекст нийцүүлэн Компанийн жилийн ашгийг зөв зохистой хуваарилах зорилгоор нийт 4 бүлэгтэй сангийн хуримтлал, ногдол ашиг хуваарилах журмыг 2017.12.26-ны өдрийн 08 дугаар тогтоолын Хавсралт 1-р батлан (**Хавсралт 3.3**) хувьцаа эзэмшигчдэд танилцуулан мөрдөж байна. Тус журамд Компанийн ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлсноос гадна ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг төлөх хэлбэр, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах хугацаа, түүнд тусгах мэдээлэл, ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг зохицуулсан байна.

Тус журам нь Компанийн тухай хуулийн 46,47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, журамд нийцсэн байхаас гадна тус хуулийн 76.1.12, Компанийн засаглалын кодексийн 2.2.2-т заасан компани ногдол ашгийн бодлоготой байр, ногдол ашиг тодорхойлох журамтай байх зэрэг шаардлагыг хангаж байна.

Хувьцааг эргүүлэн худалдан авах журам. Компанийн ТУЗ-аас компанийн хувьцааг Компани өөрөө болон хувьцаа эзэмшигчид өөрөө эргүүлэн худалдаж авах нөхцөл, журмыг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэгтэй Хувьцааг эргүүлэн худалдан авах журмыг 2017.12.26-ны өдрийн 08 дугаар тогтоолын Хавсралт 3-р батлан (**Хавсралт 3.4**) мөрдөж байна.

Тус журамд Компанийн өөрийн гаргасан энгийн хувьцаа, энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах нөхцөл, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, хувьцаа эзэмшигчдийн хурлаас тодорхой шийдвэр гарсан тохиолдолд уг асуудлаар эсрэг саналтай байсан эсхүл уг шийдвэрийг гаргахад оролцоогүй хувьцаа эзэмшигчид хүсвэл өөрийн хувьцааг худалдан авахыг компаниас шаардах тодорхой нөхцөлүүдийг тодорхойлж, тэдгээртэй холбоотойгоор Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авахад хориглох зүйлс, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага зэргийг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 49-р зүйл “Үнэт цаас эргүүлэн худалдаж авах”, 52-р зүйл “Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах”, 54-р зүйл “Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам” болон Компанийн засаглалын кодексийн 2.2.6-д заасан хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхэд нийцсэн байна.





ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны болон ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам. Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагаа, эрх үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэгтэй ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг 2018.02.28-ны өдрийн тогтоолын Хавсралт 3-р (**Хавсралт 3.5**), ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг 2018.02.28-ны өдрийн тогтоолын Хавсралт 2-р батлан (**Хавсралт 3.6**) тус тус мөрдүүлж байна. Эдгээр журмуудаар цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, тэднийг томилох ажиллагаа, тус хорооны хурал хуралдах журам, хурлаас гарах шийдвэр, тэмдэглэл, хорооны эрх, үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан байна.

Эдгээр журам нь Компанийн тухай хуулийн 81.1-р зүйлд ТУЗ шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын хороо болон түр хороо байгуулж болно, Компанийн засаглалын кодексийн 5.5.4-т цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга хараат бус гишүүн байх, 5.6.2-т Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх системийг боловсруулж, батлах зэрэг үүрэг гүйцэтгэдэг байхыг шаардсан шаардлагад нийцсэн байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам. Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагаа, эрх үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэгтэй ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журмыг 2018.02.28-ны өдрийн тогтоолын Хавсралт 1-р (**Хавсралт 3.7**) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар аудитын хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, тэднийг томилох ажиллагаа, хорооны эрх, үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулсан байна.


Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 81.1-р зүйлд ТУЗ шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын хороо болон түр хороо байгуулж болно, Компанийн засаглалын кодексийн 5.5.4-т аудитын хорооны дарга хараат бус гишүүн байх, 5.7.1, 5.7.2-т аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа зэрэгт хяналт тавьж, үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, хөндлөнгийн аудитыг нэр дэвшүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэдэг байхыг шаардсан шаардлагад нийцсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагад хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 3 бүлэгтэй Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг 2017.12.26-ны өдрийн тогтоолын Хавсралт 2-р (**Хавсралт 3.8**) батлан мөрдүүлж байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 38.2, 60.1-р зүйл болон 65-р зүйлд заасан шаардлагыг хангаж байна.

Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам. Компанийн ТУЗ нь эрх бүхий байгууллагад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг





хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлэгтэй Компанийн хурлын зар хүргэх журмыг 2017.12.26-ны өдрийн тогтоолын Хавсралт 4-р (Хавсралт 3.9) батлан мөрдүүлж байна.

Энэхүү журам нь нийтэд мэдээллийг тогтмол хүргэх хугацаа, тухай бүр нээлттэй байх мэдээлэл, компанийн үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан, арилжаа түр зогссон тохиолдолд авах арга хэмжээ, мэдээллийн архив бүрдүүлэх, хадгалах, мэдээллийг нээлттэй болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйлс зэргийг зохицуулж өгсөн байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 95.8, 98 зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 79.1, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын зохицуулалтад нийцсэнээс гадна Компанийн засаглалын кодексийн 7.3.1-7.3.5-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

Хөдөлмөрийн дотоод журам. Компанийн гүйцэтгэх захирал нь 2012.06.11-ны өдрийн ТУ/12-10 тоот тушаалын Хавсралт 1-ээр хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч ба ажилтны эрх, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журмыг (Хавсралт 3.10) мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журам, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, сахилгын зөрчил, хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, ажил амралтын цаг, цалин хөлс урамшууллын тогтолцоо, албан томилолт, сургалтын журам, дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.2, 130.1-т заасан шаардлагад нийцсэн байна.

Үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам. Компанийн гүйцэтгэх захирал нь 2012.07.16-ны өдрийн ТУ/12-10 тоот тушаалын Хавсралт 1-ээр байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн Үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг (Хавсралт 3.11) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтны эрх, үүрэг, дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны чиглэл, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд ногдуулах хариуцлага зэргийг зохицуулсан холбогдох хууль, Засгийн газрын тогтоолд нийцсэн байна.

Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам. (Хавсралт 3.12) ТУЗ-ийн 2017.12.26-ны өдрийн 08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан. Уг журмаар тус компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт гаргаж бүртгэх, түүнтэй компанийн хийх хэлцлийг тодорхойлох, компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.





4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх

Бид тус компаниас ирүүлсэн Алтандуулгын үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

Зээлийн гэрээнүүд

1. Хаан банк болон Алтан дуулга нарын хооронд 2015.07.09-ний өдөр байгуулагдсан ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ (Хавсралт 4.1).

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 263,584,700 төгрөг
- Зээлийн зориулалт: Комбайны урьдчилгаа төлбөр төлөх
- Зээлийн хүү: жилийн 20.4 хувь
- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 36 сар
- Хариуцлага: Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүний төлбөрийг зээлийн гэрээний хавсралтад заасан зээлийг эргэн төлөөгүй эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Энэхүү гэрээг талууд бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 451.2-т заасан “зээлийн гэрээг бичгээр байгуулах” шаардлагыг хангасан байна.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2015.07.09-ний өдөр байгуулагдсан БГҮ15/94 тоот Барьцааны гэрээг зээлдүүлэгч болон барьцаалуулагчдын хооронд байгуулсан.

Хаан банкны 2018.02.22-ны өдрийн дансны гүйлгээ, үлдэгдлийн баталгааны (Хавсралт 4.2) дагуу 2017.12.31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 76,007,270.75 төгрөг, зээлийн ангилал “хэвийн” хэрэгжиж байна.

2. Хаан банк болон Алтан дуулга нарын хооронд 2016.05.20-ны өдөр байгуулагдсан 16/15 тоот Зээлийн гэрээ (Хавсралт 4.3).

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 1,225,000,000 төгрөг
- Зээлийн зориулалт: Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах
- Зээлийн хүү: жилийн 12.5 хувь





- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 24 сар
- Хариуцлага: Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүний төлбөрийг зээлийн гэрээний хавсралтад заасан зээлийн эргэн төлөөгүй эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Энэхүү гэрээг талууд бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 451.2-т заасан “зээлийн гэрээг бичгээр байгуулах” шаардлагыг хангасан байна.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2015.05.20-ны өдөр байгуулагдсан БГҮ16/15 тоот Барьцааны гэрээг зээлдүүлэгч болон барьцаалуулагчдын хооронд байгуулсан.

Алтан дуулгын 2018.05.22-ны өдрийн А-18-181 тоот албан бичгийн (Хавсралт 4.3.1) дагуу уг зээлийн үлдэгдэл 2018.03.01-ний өдрийн байдлаар 461,698,044 төгрөг, хэвийн хэрэгжиж байна.

Хаан банк болон Алтан дуулга нарын хооронд 2017.12.28-ны өдөр байгуулагдсан ЗШГ17/86 тоот Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.4).

Гэрээний мэдээлэл:


- Зээлийн дүн: 1,500,000,000 төгрөг
- Зээлийн зориулалт: Эргэлтийн хөрөнгийн тогтворжуулах
- Зээлийн хүү: жилийн 18 хувь
- Коммитмент хүү: жилийн 4 хувь
- Зээлийн хугацаа: 24 сар

Хариуцлага: Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүний төлбөрийг зээлийн гэрээний хавсралтад заасан зээлийн эргэн төлөөгүй эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2015.05.20-ны өдөр байгуулагдсан БГҮ16/15 тоот Барьцааны гэрээг зээлдүүлэгч болон барьцаалуулагчдын хооронд байгуулсан.

Алтан дуулгын 2018.05.22-ны өдрийн А-18-181 тоот албан бичгийн (Хавсралт 4.3.1) дагуу уг зээлийн үлдэгдэл 2018.03.01-ний өдрийн байдлаар 1,140,600,000 төгрөг, хэвийн хэрэгжиж байна.





Зээлийн гэрээ: Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон Алтан дуулга нарын хооронд байгуулсан ОХУ-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах зээлийн 2017/Ү/23 тоот гэрээ (Хавсралт 4.6). Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Мал хамгаалах сан болон Алтан дуулга нарын хооронд 2017.11.29-ний өдөр байгуулсан 2017/Ү/23 тоот Оросын холбооны улс (цаашид “ОХУ” гэх)-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах зээлийн гэрээний дагуу Алтан дуулга нь Оросын Холбооны улсаас малын тэжээл импортлон Хөвсгөл, Дундговь, Өмнөговь аймгуудад малын тэжээлийг хүргэж борлуулан түүний орлогоос зээлээ графикийн дагуу эргэн төлөхөөр тохиролцсон байна.

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн хугацаа: 9 сар
- Зээлийн зориулалт: ОХУ-аас малын тэжээл импортлон борлуулах малын тэжээл хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх санхүүжилтэд зарцуулна.
- Зээлийн ерөнхий нөхцөл: 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн урьдчилгаа 25 хувь болох 1,250,000,000 төгрөгийг зээлдэгчийн Төрийн банкны 102200514972 тоот дансанд шилжүүлэх бөгөөд үлдэх 75 хувийг төрийн банкинд Алтан дуулга-ын нэр дээр нээсэн 102200519278 тоот нөхцөлт дансанд байршуулна.
- Хяналтын зардал: Олгосон санхүүжилтээс 0,1%-тай тэнцэх хэмжээтэй хяналтын зардал авч төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.

Хариуцлага: Зээлийг хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувийн алдангийг Зээлдэгч Зээлдүүлэгчид төлөх бөгөөд Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг зээлийн гэрээний хавсралтад заасан хугацаанд зээлийг эргэн төлөөгүй, эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2017.11.29-ний өдөр 2017/Ү/23 тоот Барьцааны гэрээг байгуулсан.

Алтан дуулгын 2018.05.22-ны өдрийн А-18-181 тоот албан бичгийн (Хавсралт 4.3.1) дагуу уг зээлийн үлдэгдэл 2018.03.01-ний өдрийн байдлаар 2,850,000,000 төгрөг, хэвийн хэрэгжиж байна.

Үйлчилгээний гэрээ. (Хавсралт 4.7) Алтан дуулга нь www.tesgroup.mn домэйн нэрийг ашиглах, түүнтэй холбоотой төлбөр тооцоо зэрэгтэй холбогдох харилцааг 2012.01.04-ний өдөр “Датаком” ХХК-тай байгуулсан “Үйлчилгээний гэрээ”-ээр зохицуулдаг байна. Дээрх гэрээний дагуу Алтан дуулга нь домэйн нэрийг нэг жил ашиглах эрх үүссэн бөгөөд гэрээний хугацаа дуусахад талуудын аль нэгээс цуцлах санал гаргаагүй бол гэрээнд дурдсан нөхцөлөөр дахин сунгагдсанд тооцохоор тохиролцсон байна.

Оффисын түрээсийн гэрээ. (Хавсралт 4.8) Модернкастл модифаер (МКМ) ХХК болон Алтан дуулга нарын хооронд 2017.12.01-ний өдөр байгуулсан Түрээсийн гэрээний дагуу Алтан дуулга нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Батмөнхийн гудамж





хаягт байрлах “Fintech office”-ийн барилгын 8-р давхрын 344.6 м2 талбай оффисын зориулалттай байрыг 1 жилийн хугацаатайгаар түрээслэхээр тохирч уг гэрээ хэрэгжиж байна. Тус гэрээнд: “Түрээслүүлэгч нь Түрээслэгчтэй өөрийн холбоотой этгээдүүдтэй авлага, өглөгийн тооцоо хийж дуусах хүртэл хугацаанд Ажлын байрыг түрээслэх түрээсийн төлбөр 0 (тэг)-тэй тэнцүү байна” гэж заасан. Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн, хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжих боломжтой байна.

Үрийн буудайг зээлээр олгох гэрээ. (Хавсралт 4.9) Хүнс хөдөө аж ахуйн яамны харьяа Тариалан эрхлэлтийн сан болон Алтан дуулга нарын хооронд байгуулдаг Хаврын тариалалтад шаардагдах үрийн буудайг зээлээр олгодог гэрээнүүдийг хянаж үзэхэд Иргэний хуульд нийцсэн байна.

Худалдах худалдан авах гэрээ. (Хавсралт 4.10) Худалдан авагч нартай байгуулдаг “Буудай худалдах-худалдан авах гэрээ”-үүдийг хянаж үзэхэд гэрээнд бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл, үүнтэй холбоотойгоор талуудын эдлэх эрх, хүлээх хариуцлага, гэрээ дуусгавар болох нөхцөлүүдийг тусгасан нь Иргэний хуульд нийцсэн байна.

Дизелийн түлш зээлээр олгох гэрээ. (Хавсралт 4.11) Хүнс хөдөө аж ахуйн яам, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Алтан дуулга нарын хооронд байгуулдаг гэрээг хянаж үзэхэд гэрээнд бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл, үүнтэй холбоотойгоор талуудын эдлэх эрх, хүлээх хариуцлага, гэрээ дуусгавар болох нөхцөлүүдийг тусгасан байгаа нь Иргэний хуульд нийцэж байна.

Бэлтгэн нийлүүлэх гэрээ. (Хавсралт 4.12) Худалдан авагч нартай байгуулдаг гурил бэлтгэн нийлүүлэх гэрээнүүдийг хянаж үзэхэд гэрээнд бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл, үүнтэй холбоотойгоор талуудын эдлэх эрх, хүлээх хариуцлага, гэрээ дуусгавар болох нөхцөлүүдийг тусгасан нь Иргэний хуульд нийцэж байна.

Хөдөлмөрийн болон Нууцлалын гэрээний загваруудыг (Хавсралт 4.13, 4.14) хянасан бөгөөд хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 21-р зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг, үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалаас үзвэл тус компани нь 2010 оноос хойш техник тоног төхөөрөмжөө шинэчлэх, гурилын үйлдвэр барих гэх мэт хөрөнгө оруулалтад нийт 5.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Эдгээр хөрөнгө оруулалтыг өөрийн үйл ажиллагааны ашиг, банкны зээлийн эх үүсвэр зэргээс санхүүжүүлснээс гадна тус компанийн том хувьцаа эзэмшигч “Тэс трейд” ХХК (“Тэс трейд” ХХК нь Алтан дуулгын ТУЗ-ийн дарга, иргэн Д.Ганхуягын 100%-ийн эзэмшлийн компани юм) -аас тодорхой хэмжээний богино хугацааны санхүүжилт авч байсан. Нөгөө талаар “Тэс трейд” ХХК нь





оруулсан санхүүжилтээ буцаан татах, богино хугацааны тооцоогоор мөнгө авах гэх мэтээр өглөг, авлагын тооцоо үүсгэж ирсэн байна. 2017 оны эцсийн байдлаар 2 компанийн хоорондын тооцоог хийхэд “Алтан дуулга” нь “Тэс трейд” ХХК-аас 941.4 сая төгрөгийн авлагатай болсон байна. Мөн Алтан дуулгад тодорхой тооны мал бүртгэгдсэн байдаг бөгөөд малчдын цалин хөлс, малын тэжээл гэх мэт зардлуудыг Алтан дуулга байнга санхүүжүүлж ирсэн байна. Гэвч тус компани мал аж ахуйгаас мөнгөн орлого олдоггүй тул малыг том хувьцаа эзэмшигч Тэс трейд ХХК-д балансын дүнгээр шилжүүлж, малтай холбоотой үүссэн 306,684,076 төгрөгийн зардлыг хуримтлуулан “Хотол шим” ХХК (Д.Ганхуягын 100 хувийн эзэмшлийн) –аас авах авлагад тооцож бүртгэснийг “Тэс трейд” ХХК-аас авах авлагын тооцоонд оруулж хаах асуудлыг тус компани зөвшөөрч, ХЭХ-аар сонирхлын зөрчилтэй хэлцэл батлуулахаар хэлэлцүүлсэн байна. Энэхүү хоёр томоохон хэмжээний авлагыг нэгтгээд 1,248,091,589 төгрөгийн дүнгээр мөн иргэн Д.Ганхуягын 100%-ийн эзэмшлийн “МКМ” ХХК-ийн өмчлөлийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Батмөнхийн гудамж хаягт байрлах “Fintech office”-ийн барилгын 8-р давхрын 344.6 м2 талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг авлагад тооцож авах сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх эрхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрөх асуудлыг ХЭХ хэлэлцэж баталсан байна. Офисын барилга болон авлагад тооцож авах талбайн үнэлгээг хараат бус үнэлгээчин БЭСТЭ ХХК хийж, үнэлгээний тайлан гаргасан байна. Ингэснээр “Тэс трейд” болон түүний холбоотой компаниудтай үүссэн авлагын тооцоо хаагдаж, “Хөвсгөл Алтан дуулга” ХК УБ хотод үл хөдлөх хөрөнгөтэй болж борлуулалтын үйл ажиллагаагаа явуулах ажлын байртай болно хэмээн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан байна.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар “Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах тухай” асуудлыг хэлэлцэн, уг асуудлаар хэлцэл хийх сонирхол бүхий “Тэс трейд” ХХК-ийн төлөөлөл болон хувьцаа эзэмшигч Д.Дуламсүрэн нар санал хураалтад оролцолгүйгээр бусад хуралд оролцогч 5 хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар уг хэлцлийг хийх эрхийг Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд олгосон байна.

Хөвсгөл Алтан дуулга ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 03 дугаартай “Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах тухай” шийдвэрт:

1. Хөвсгөл Алтандуулга ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигч Тэс трейд ХХК (100 хувь Д.Ганхуягийн эзэмшлийн) болон түүний холбоотой талуудаас авах 1,248,091,589 төгрөгийн авлагыг МКМ ХХК (100 хувь Д.Ганхуягийн эзэмшлийн)-ийн өмчлөлийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Батмөнхийн гудамж, “Fintech office” хаягт байрлах оффисын барилгын 8 давхарт байрлах үл хөдлөх хөрөнгөөр тооцож барагдуулахыг компанийн гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд зөвшөөрсүгэй.
2. Дээрх шийдвэртэй холбоотойгоор “Тэс трейд “ХХК-ийн холбоотой талуудаас авах авлагыг МКМ ХХК-ийн өмчлөлийн оффисын зориулалтын 344.6 м2 талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгөөр тооцож барагдуулах акт үйлдэх эрхийг гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд зөвшөөрсүгэй” гэжээ.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 03 дугаартай “Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах тухай” шийдвэр нь Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тодорхойлсон 62 дугаар зүйлийн 62.1.11-д: “энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын





зөрчилтэй хэлцлийг батлах”, мөн хуулийн 92 дугаар зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн байна. Түүнчлэн уг оффисын кв.м-ийн үнэлгээг Бэстэ үнэлгээний компани 4,062,831 төгрөгөөр тогтоосон бөгөөд Алтандуулга кв.м-ийг нь 3,621,856 төгрөгөөр тооцож авлагадаа авч байгаа нь тус ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцэж байна.

Их хэмжээний хэлцэл

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон Алтан дуулга нарын хооронд байгуулсан ОХУ-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах зээлийн 2017/Ү/23 тоот гэрээ нь Компанийн тухай хуулийн 87.1-д заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байх тул Компанийн тухай хуулийн 88.1-д заасны дагуу гэрээ байгуулах шийдвэрийг Алтан дуулгын ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр гаргасан байх шаардлагатай. Алтан дуулгын ТУЗ-ийн 2017.11.27-ны өдрийн хурлаар Мал хамгаалах сангаас 5 тэрбум төгрөгийг 9 сарын хугацаатай зээлэх асуудлыг хэлэлцэж санал нэгтгэйгээр дэмжиж, 2017.11.27-ны өдөр ТО/17-04 тоот “Их хэмжээний хэлцэл хийх тухай” тогтоол (Хавсралт 5.1) гаргасан байгаа нь Компанийн тухай хууль болон Иргэний хуульд нийцсэн байна.


Хаан банк болон Алтан дуулга нарын хооронд 2017.12.28-ны өдөр байгуулагдсан ЗШГ17/86 тоот Зээлийн шугамын гэрээ нь Компанийн тухай хуулийн 87.1-д заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байх тул Компанийн тухай хуулийн 88.1-д заасны дагуу гэрээ байгуулах шийдвэрийг Алтан дуулгын ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр гаргасан байх шаардлагатай. Алтан дуулгын ТУЗ-ийн 2017.12.20-ны өдрийн хурлаар Хаан банкнаас 1,500,000,000 төгрөгийг жилийн 18 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай зээлэх асуудлыг хэлэлцэж санал нэгтгэйгээр дэмжиж, 2017.12.20-ны өдөр ТО/17-05 тоот “Их хэмжээний хэлцэл хийх тухай” тогтоол (Хавсралт 5.2) гаргасан байгаа нь Компанийн тухай хууль болон Иргэний хуульд нийцсэн байна.

6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх

Алтандуулгын эрхэлж байгаа, түүний дүрэмд заасан үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэл, хүнсний ногоо тариалах, гадаад, дотоод худалдаа, мал аж ахуй эрхлэхэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл авах шаардлага тавигддаггүй болно. Харин “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч”-ийн хувьд Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Тариалангийн тухай хуулиар тодорхой хүлээсэн үүрэг хүлээдэг. Энэ талаар энэхүү тайлангийн төгсгөлд авч үзэх болно.

Алтан дуулга нь 2012.01.31-ний өдөр Монгол Улсын шадар сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар 10043 дугаар Барааны тэмдгийн гэрчилгээг (Хавсралт 6.1) 10 жилийн хугацаатайгаар, 2012.02.02-ны өдөр Монгол Улсын шадар сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар 10049 дугаар Барааны тэмдгийн гэрчилгээг (Хавсралт 6.2) 10 жилийн хугацаатайгаар, 2012.02.02-ны өдөр Монгол Улсын шадар сайдын 2012 оны 18 дугаар





тушаалаар 10047 дугаар Барааны тэмдгийн гэрчилгээг (Хавсралт 6.3) 10 жилийн хугацаатайгаар авсан байна.

Алтан дуулгын нэр дээр байх дээрх барааны тэмдгийн гэрчилгээ дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл илрээгүй болно.

7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх

Үнэт цаас. Алтан дуулга аливаа үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 7.0)

Газар эзэмших эрх. Алтан дуулгаас өгсөн мэдээллийн дагуу болон Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2018.01.19-ний өдрийн 4/24 тоот лавлагааны (Хавсралт 7.1) дагуу Алтан дуулга нь доорх газруудыг эзэмшдэг болно. Үүнд:

№	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Байршил	Газрын хэмжээ мкв, эсхүл га-аар	Газрын гэрчилгээний дугаар/Хавсралт №	Газрын төлбөрийн хэмжээ, жилээр	Барьцаалагдсан эсэх
1.	211100038	Үтрэмийн үйлчилгээ	Сумын төв Сант 5-р гудамжанд	3.73 га	176521/ Хавсралт 7.2	21,840	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
2.	211101375	Техникийн хашаа үйлчилгээ	Сумын төв Сант 5-р гудамжанд	1.57 га	307045/ Хавсралт 7.3	12,560	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
3.	211100038	Техникийн хашаа үйлчилгээ	Сумын төв урд хэсэг	1.57 га	176515/ Хавсралт 7.4	12,560	
4.	211100028	Худалдаа үйлчилгээний	Сантын 1-16 тоот	3127 мкв	176518/ Хавсралт 7.5	2,501	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
5.	211100037	Албан контор үйлчилгээ	Сант 5-р гудамж	1.61 га	176516/ Хавсралт 7.6	12,880	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон





							2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
6.	211100037	Гэр бүлийн хэрэгцээний		0.38 га	176520/ Хавсралт 7.7		
7.	211101374	Гэр бүлийн хэрэгцээний	Сантын 7-4 тоот	3850 мкв	307046/ Хавсралт 7.8		2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
8.	211100033	Худалдаа үйлчилгээний	Төв дэлгүүрийн гудамжинд	36 мкв	176517/ Хавсралт 7.9	288,000	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
9.	6701000032	Газар тариалангийн	Тариалан сумын Таван толгой багийн нутагт	6175 га	176530/ Хавсралт 7.10	3,705,000	2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээ болон 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
10.	6701000315	Үйлдвэрлэл үйлчилгээ	Сант хэсэгт	1.8 га	308110/ Хавсралт 7.11		
11.	210706021	Худалдаа үйлчилгээний зориулалттай	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8- р баг Тэмээн 28 тоот	3914.9 м/кв	0209162/ Хавсралт 7.12		2016.05.20-ны 16/15 тоот Зээлийн гэрээний дагуу 2015.07.09-ны ЗГ15/94 тоот Зээлийн гэрээний дагуу
12.	6701000053	Үр тариа	Тариалан сумын төв хэсэг	870 га	308075/ Хавсралт 7.13	522,000	

Газрын төлбөр. Алтан дуулгын бидэнд гаргаж өгсөн баримтуудаас үзвэл газрын төлбөрийг дараах байдлаар төлсөн байна. Үүнд:

- ✓ 2017.05.25-ны өдөр 1,500,000 төгрөг (Хавсралт 7.14)
- ✓ 2017.11.29-ний өдөр 1,066,400 төгрөг (Хавсралт 7.15)
- ✓ 2017.12.27-ны өдөр 1,727,000 төгрөг (Хавсралт 7.16)

Алтан дуулгын эзэмшдэг дээрх нийт 12 газраас хүснэгтийн 3, 6, 10-д дурдсан газруудаас бусад газрууд нь зээлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор бусдад барьцаалагдсан бөгөөд зээлийн гэрээнүүд хэвийн хэрэгжиж байна. БДО Аудит ХХК-ийн 2017.12.31-ний





өдөр хийж гүйцэтгэсэн “Биет ба биет бус хөрөнгийн үнэлгээний тайлан”-д дээрх хүснэгтийн 1, 3, 5, 6, 9, 12-д дурдсан газруудыг тусгаж үнэлгээ гаргасан байна.

Үл хөдлөх эд хөрөнгө. Алтан дуулгаас өгсөн мэдээллийн дагуу болон Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2018.02.12-ны өдрийн 1/206 тоот лавлагааны (Хавсралт 7.17) дагуу Алтан дуулга нь доорх үл хөдлөх эд хөрөнгүүдийг өмчилдөг болно. Үүнд:

№	Улсын бүртгэлийн дугаар	Үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт	Байршил	Үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ мкв-аар	Гэрчилгээний дугаар/Хавсралт №	Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх
1.	Ү-1720000295	Гурилын үйлдвэр, агуулах	Мандал баг	1907	000198301/ Хавсралт7.18	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
2.	Ү-172000054	Орон сууц	Тариалан сумын Мандал баг	144	000199894/ Хавсралт7.19	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
3.	Ү-172000055	Үйлчилгээний (Зоогийн газар, зочид буудал)	Тариалан сумын Мандал баг	216	000199898/ Хавсралт7.20	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
4.	Ү-172000052	Үйлдвэрлэл	Тариалан сумын Мандал баг	200	000199893/ Хавсралт7.21	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
5.	Ү-172000051	Контор, хүнсний агуулах	Тариалан сумын Мандал баг	782	000199893/ Хавсралт7.22	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
6.	Ү-172000056	Үйлчилгээ	Тариалан сумын Мандал баг	36	000199892/ Хавсралт7.23	
7.	Ү-172000016	Үйлдвэрлэл	Тариалан сумын Мандал баг	1292	000199896/ Хавсралт7.24	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ
8.	Ү-172000355	Үр тарианы агуулах	Тариалан сумын Мандал баг	1400	000059147/ Хавсралт7.25	2015.07.09-ний ЗГ15/94 тоот Зээлийн гэрээ, 2016.05.23-ны нэмэлт зээлийн гэрээ,2017.12.28-ны зээлийн гэрээ

Алтан дуулгын эзэмшдэг дээрх нийт 8 үл хөдлөх хөрөнгөөс хүснэгтийн 6-д дурдсан үл хөдлөх хөрөнгөөс бусад үл хөдлөх хөрөнгүүд нь зээлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор бусад барьцаалагдсан байна. Зээлийн чанар хэвийн байна. БДО Аудит ХХК-





ийн 2017.12.31-ний өдөр хийж гүйцэтгэсэн “Биет ба биет бус хөрөнгийн үнэлгээний тайлан”-д дээрх хүснэгтийн 8-д дурдсан үр тарианы агуулахыг тусгаж үнэлгээ гаргасан байна.

Алтан дуулга нь аливаа үнэт цаас өмчилдөггүй, дээр дурдсан 12 нэгж талбар бүхий газар эзэмших эрхтэй, 8 үл хөдлөх эд хөрөнгө буюу барилга объект өмчлөх эрхтэй, дүгнэлт гаргах өдрийн байдлаар газар эзэмших эрхүүд болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхүүд нь хүчин төгөлдөр байна. Тус компанийн эзэмшлийн 9 нэгж талбар бүхий газар эзэмших эрх, өмчлөлийн 6 үл хөдлөх эд хөрөнгө буюу барилга объект нь банкны зээлийн барьцаанд байна. (Банкны зээлийн эргэн төлөлт графикийн дагуу хийгдэж байгаа, хэвийн ангилалд байгаа талаар энэхүү дүгнэлтийн 4 дэх хэсгээс үзнэ үү).

8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх


Алтан дуулгын Хувьцаа эзэмшигчдийн 2018.04.02-ны өдрийн ээлжит хурлын 2 дугаартай “Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, ТУЗ-д зарим бүрэн эрхийг олгох тухай” тогтоол (Хавсралт 8.1)-оор дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Мөн Алтан дуулгын нэмж гаргаж буй хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгож буй үнэ, нэмж гаргах хувьцаатай холбоотой асуудлаар тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг ТУЗ-д олгосон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,3,8 дахь заалт, Алтан дуулгын тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан дүрмийн 7.7.1, 7.7.3, 7.8.2, 7.8.8 дахь заалтуудад тус нийцэж байна. Уг хурлаар “Хөвсгөл Алтандуулга” ХК-аас нэмж гаргаж буй хувьцааг тус компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (Хавсралт 8.2)-нь Компанийн тухай хуулийн 38.8, 62.1.8, тус компанийн дүрмийн 7.8.2-т заасантай нийцэж байна.

Энэхүү шийдвэрийг үндэслэн Алтан дуулгын ТУЗ нь 2018.05.16-ны өдөр хуралдаж “Компанийн нэмж гаргаж буй хувьцааны худалдах үнийг тогтоох тухай” ТО-18-18 дугаартай тогтоол (Хавсралт 8.3)-оор Алтан дуулгын нэмж гаргаж буй нэгж хувьцааны нийтэд санал болгох доод үнийг 850 төгрөгөөр тогтоосон нь Компанийн тухай хуулийн 55.2, 55.6, 55.9 заалт, 76.1.6, Алтан дуулгын хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрмийн 7.31.21 дахь заалтуудад нийцэж байна.

Нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, компани, түүний холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилсний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.

9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн төв архивын газраас 2018.01.15-ны өдөр 1/69 тоот албан бичгээр ирүүлсэн Алтан дуулгын хуулийн 51 тусгай





дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 9.1)-г тус өдрийн байдлаар гаргуулан судалсан. Бид энэхүү дүгнэлтийг гаргахдаа хувьцаа нэмж гаргах тухай шийдвэр гаргасан тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн байдлаарх хувьцааны тархалтын мэдээллийг үндэслэв. Дурдсан өдрийн байдлаар Алтан дуулгын саналын эрхтэй энгийн хувьцааны 70.59 хувийг Монгол Улсын хуулийн этгээд “Тэс Трэйд” ХХК, 7.82 хувийг Монгол Улсын иргэн Мөнх-Эрдэнэ овогтой Золзаяа бусад хувьцаа эзэмшигчид компанийн үлдсэн хувьцааг эзэмшиж байна. Энэхүү хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Алтан дуулгын саналын эрхтэй энгийн хувьцааны 70.59 хувийг эзэмшиж байгаа Монгол Улсын хуулийн этгээд “Тэс Трэйд” ХХК-ийн хувьцааг 100 хувь Доржпүрэв овогтой Ганхуяг эзэмшиж байна. Алтан дуулгын ТУЗ-ийн гишүүн Доржпүрэв овогтой Ганхуяг нь Тэс трейд ХХК болон “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч хэмээн тодорхойлох үндэслэлтэй байна.

10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа

Алтан дуулга нь 2018.01.10-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 10.1), 2018.01.19-ний өдрийн байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлийн өр, төлбөргүй (Хавсралт 10.2), 2018.02.09-ний өдрийн байдлаар Татварын байгууллагад 13,994,113 төгрөгийн дутуу төлөлттэй (Хавсралт 10.3) байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Алтан дуулгад татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги оногдуулаагүй байна.

Доорх лавлагаа болон мэдээллүүдийг (Хавсралт 10.4-10.11) төрийн эрх бүхий байгууллагуудаас цуглуулж энэхүү дүгнэлтэд ашигласан болно. Үүнд:

- Монголын олон улсын ба үндэсний арбитраас 2018.01.09-ний өдөр гаргасан Лавлагаа №4/24-д дурдсанаар 2018.01.09-ний өдрийн байдлаар Алтан дуулга нь сүүлийн гурваж жилийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2018.01.11-ний өдөр гаргасан Лавлагаа №01/153-д дурдсанаар Алтан дуулга нь тус компанитай 2010-2018 онуудад “Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ”, 2015 онд “ҮЦТТТХТ ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ”-г байгуулсан бөгөөд аливаа өр, авлагын тооцоогүй болохыг тодорхойлсон;
- Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газраас ирүүлсэн Лавлагаа №1/36-д дурдсанаар Алтан дуулга нь сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болохыг тодорхойлсон;
- Монголын хөрөнгийн биржээс 2018.01.16-ны өдөр гаргасан Лавлагаа №1/26-д дурдсанаар Алтан дуулгын 2012.04.27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн





хурлаар баталсан гэх тус компанийн дүрэмд компанийн гаргасан хувьцааны тоо ширхэг болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой заагаагүй нь Компанийн тухай хуулийн 16.2.2-т заасан шаардлагыг бүрэн хангаагүй, зарласан энгийн хувьцааны нэрлэсэн үнэ нь гаргасан энгийн хувьцааны нэрлэсэн үнээс зөрүүтэй байгаа нь Компанийн тухай хуулийн 32.4 дэх заалтыг зөрчсөн, капиталын дүн нь биржийн бүртгэлээс зөрүүтэй зэрэг засч залруулах шаардлагатай асуудлууд байгааг тодорхойлсон. Үүний дагуу СЗХ-ны 2018.05.04-ний өдрийн тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны тоо, нэрлэсэн үнийг өөрчлөн тогтоосон болно;


- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2018.01.17-ны өдөр гаргасан Лавлагаа №1/75-д дурдсанаар Алтан дуулга нь Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.6-д заасны дагуу давамгайл байдлаар аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй ба тус компанийн үйл ажиллагаатай холбогдох өргөдөл, гомдол баримт материал архивд бүртгэлгүй болохыг тодорхойлсон;
- Нийслэлийн газрын албанаас 2018.01.17-ны өдөр гаргасан Лавлагаа №03/170-д дурдсанаар нийслэлийн газрын мэдээллийн санд Алтан дуулгад газар эзэмшүүлж, ашиглуулсан бүртгэл байхгүй болохыг тодорхойлсон;
- Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2018.01.19-ний өдөр гаргасан Лавлагаа №4/24-д дурдсанаар Алтан дуулга нь нийт 10 нэгж талбар бүхий газар эзэмшиж байгаа тухай дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэн;
- Санхүүгийн Зохицуулах хорооноос 2018.01.22-ны өдөр гаргасан Лавлагаа № 9/192-д дурдсанаар 2018.01.22-ны өдрийн байдлаар Алтан дуулга болон түүний эрх бүхий албан тушаалтан нь зөрчил гаргаж захиргааны хариуцлага хүлээсэн талаарх мэдээлэл байхгүй болохыг тодорхойлсон. Түүнчлэн, ТУЗ-ийн дэд хороодыг Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасны дагуу гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдэнэ гэснийг хангаагүй болохыг тодорхойлсон бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг 2018.02.20-ны өдрийн ХЭХ-аар хуульд нийцүүлэн томилсон болно.

Дээрх судалгаа шинжилгээгээр тогтоосон фактуудад ямар нэгэн өөрчлөлт ороогүйг Алтан дуулгын Гүйцэтгэх захирлын 2018.05.22-ны өдрийн А-18-179 тоот албан бичгээр баталсан болно.

11. Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ

Алтан дуулгын эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотойгоор дараах мэдээллийг нэмэлтээр авч, хууль зүйн судалгаа шинжилгээ хийв:





Тариалангийн тухай хууль (2016). Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нь уг хуулийн 20.2.8-д зааснаар өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа тариалангийн газарт хуульд заасан хугацаанд агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэх үүрэгтэй гэж заасан бөгөөд уг хуулийн 26.7-д зааснаар агрохими, агрофизикийн шинжилгээг таван жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ гэж заасны дагуу 2016.04.30-ны өдрөөс 2016.10.29-ний өдрийн хооронд “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн судлаачид “Алтан дуулгын талбайн агрохимийн судалгааны ажлын тайлан”-г 2016.12.05-ны өдөр (Хавсралт 11.1) хийж гүйцэтгэжээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль (2012). Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч уг хуулийн 6.1-д зааснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг; хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журмын талаарх мэдээллийг батлагдсан маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллага /цаашид “хяналтын байгууллага” гэх /-д мэдээлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж болно гэж заасан. Хуулийн энэхүү шаардлагын дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 23-06-026/840 дугаартай дүгнэлт (Хавсралт 11.2)-ийг 2012.12.12-ны өдөр гаргасан байна. Уг дүгнэлтэд: ”Алтан дуулгын үйлдвэрийн байр нь цэвэр, бохир ус, халаалтын төвлөрсөн шугамд холбогдсон, агааржуулалтын нэгдсэн системтэй, байгалийн гэрэлтүүлэг хүрэлцээтэй, энгийн хаяг, ажиллах цагийн хуваарьтай, хальтиргаа гулгаанаас хамгаалсан довжоотой, галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан тухай мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэй, үйлдвэрийн болон ахуйн байруудад мэргэжлийн байгууллагаар урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьжийн устгалыг гэрээнд заасан хугацаанд хийлгэсэн байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг зохих журмын дагуу өгдөг, ажлын байранд шаардлагатай цэгүүдэд дохио санамжуудыг ил тод байрлуулсан байна. Алтан дуулгын гурилын үйлдвэр нь Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хуулийн 7.1 болон холбогдох стандартуудад заасан шаардлагыг тус тус хангасан байна” гэжээ.

Түүнчлэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг тодорхойлсон уг хуулийн 10.1-д заасан 10 шаардлагыг хэрхэн хангах талаар Дотоод хяналтын журамдаа тусгасан байхыг шаардсаны дагуу энэ талаар журамдаа тусгасан байна (Хавсралт 11.3).

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг хэдэн ажилтан байдаг, тэдгээр ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулсан, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулсан тухай тоо баримт, цаг хугацаа бүхий мэдээллийг Алтан дуулгын Гүйцэтгэх захирлын 2018.04.02-ны өдөр ирүүлсэн албан бичигт (Хавсралт 7.0) дурдсан байна.

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль (2003)-ийн 16.1-д “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эхэлснээс хойш гурван сарын дотор





тохирлын баталгаанд заавал хамруулна” гэж заасан. Алтан дуулга нь “Үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх” гэрчилгээ дугаар 217-(Хавсралт 11.4)-г Стандартчилал, хэмжил зүйн газраас 2015.07.10-ны өдөр гурван жилийн хугацаатайгаар авсан байна. Тус тохирлын гэрчилгээний дагуу Алтан дуулгын буудайн гурил (ангилал: БГ-055, БГ-085, БГ-140) нь MNS 0244:2009 стандартад нийцсэн байна. Стандартын шаардлага хангаж, Тохирлын гэрчилгээ авсан нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн шаардлагыг хангасныг мөн нотолж байна.

12. Гол дүгнэлт

“Хөвсгөл Алтан дуулга” компанийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Энэ тухай Хавсралт 12–оос үзнэ үү.

ХҮНДЭГЭЭСЭН,



Д.ДҮГЭРЖАВ
ПАРТНЕР
“ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН





Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

2018.06.27

№ 8-18/296



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАРТ

Хууль зүйн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 5.2.2.1 болон 5.2.2.4-т дурдсаны дагуу тус хуулийн фирмээс хүргүүлсэн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Д-18/211 дугаартай Хууль зүйн дүгнэлтэд түүний салшгүй хэсэг болох энэхүү нэмэлт дүгнэлтийг дараах асуудлаар гаргаж байна.

Нэг. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх талаар.

“Хөвсгөл Алтандуулга” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн ээлжит хурлаар **“Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, ТУЗ-д зарим бүрэн эрхийг олгох тухай”** 2 дугаартай тогтоолд:

1. “Хөвсгөл Алтандуулга” ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг босгох зорилгоор компанийн нийт хувьцааны 28%-тай тэнцэх 4,405,600 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргахыг зөвшөөрч, “Хөвсгөл Алтандуулга” ХК дараах төрөл, үнэ, тоо ширхэг бүхий хувьцааг нэмж гаргасугай. Үүнд:

а. Хувьцааны төрөл:	Энгийн
б. Нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг:	4,405,600 ширхэг
с. Хувьцааны нэрлэсэн үнэ:	850 төгрөг
2. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн хувьцаа нэмж гаргах төслийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. “Хөвсгөл Алтандуулга” ХК –ийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдож буй тул хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, нэмж гаргаж буй хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай” гэжээ.






“Компани нэмж хувьцаа гаргах тухай, нэмж гаргаж буй хувьцаатай холбогдох асуудлыг батлах тухай” Хувьцаа эзэмшигчдийн хурлын энэхүү шийдвэр нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 заалт, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дахь заалт, “Хөвсгөл Алтандуулга” Хувьцаат компанийн дүрмийн 7.7.1 заалт, 7.7.3 заалт, 7.8.2 заалт, 7.8.8 заалтад нийцсэн байна.

Түүнчлэн тус хурлын **“Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх тухай”** 3 дугаартай тогтоолоор бүртгэлийн өдрийн байдлаарх “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тус ХК-аас нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 38-р зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7.8.2 дахь заалтад нийцэж байна.

Хоёр. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх талаар.

Дээр дурдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын 6 дахь заалтаар эрх олгосны дагуу тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хуралдаж **“Хувьцаагаа эргүүлэх худалдан авахыг компаниас шаардах хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээний тухай”** ТО-18-17 дугаартай тогтоол гаргаж дараах шийдвэр гаргасан байна.

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компани 4,405,600 ширхэг буюу нийт хувьцааны 28%-тай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган, олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 87.1.2, 53.1.2-т зааснаар мөн хуульд заасан нөхцөл хангасан хувьцаа эзэмшигчийн хувьд өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх нь үүссэн болохыг дурдсугай.
2. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнийг 8095 төгрөгөөр тогтоосугай.
3. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрийг уг шаардах эрх үүссэн өдөр болох 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөр тогтоосугай.
4. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацааг уг эрх үүссэн өдөр болох 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн ажлын 30 өдрөөр буюу 2018 оны 5 сарын 17-ны өдөр дуусгавар болгохоор тогтоосугай.
5. Шаардах эрх үүссэн, уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (Д.Дуламсүрэн)-д үүрэг болгосугай. Үүнд:






- a. Шаардах эрх үүссэн, уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх зарыг 2018 оны 4 сарын 5-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлэх
 - b. Давтан зарыг 2018 оны 4 сарын 20-ны өдөр сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгнээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.
6. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн худалдаж авах, шаардах эрх хэрэгжүүлэх ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 8 дугаартай тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны журам"-ын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Д.Дуламсүрэн)-д даалгасугай гэжээ.

ТУЗ-ын энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалт, 53 дугаар зүйлийн 53.1.2 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйл, 53 дугаар зүйлийн 53.5 дахь хэсэг, "Хөвсгөл алтан дуулга" Хувьцаат компанийн дүрмийн 7.32.13 дахь заалт, тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 8 дугаартай тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны журам"-д тус тус нийцсэн бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн худалдаж авах, шаардах эрх хэрэгжүүлэх ажиллагааг зохих журмын дагуу тогтоосон хугацаанд, СЗХ-ны Хувьцаа эзэмшигчдийн зар мэдээ хүргэх журмаар тогтоосон арга хэрэгслээр нийтэд мэдээлсэн нь хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын 6 дахь заалтаар эрх олгосны дагуу тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж "Компанийн нэмж гаргаж буй хувьцааны худалдах үнийн тогтоох тухай" ТО-18-18 дугаартай тогтоолоор нэмж гаргаж буй нэгж хувьцааны худалдах доод үнийг 850 төгрөгөөр тогтоож МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3-т зааснаар захиалгын бүртгэлийн аргаар байршуулан арилжаалах, татан төвлөрүүлэх хөрөнгийг компанийн зээлийн эх үүсвэрийг бууруулах болон эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулахаар шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 55.2, 55.6, 55.9, 76.1.6 дахь заалт, Хөвсгөл Алтандуулга ХК-ийн дүрмийн 7.31.21 дэх заалт, ТУЗ-д эрх олгосон хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн ээлжит хурлын 2 тоот тогтоолд тус тус нийцсэн бөгөөд анхдагч зах зээлийн арилжаанд оролцогч хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашигт нийцсэн байна.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ  Д.ДҮГЭРЖАВ





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

2018 он 05 сар 23 өдөр

Дугаар № _____

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН НЭМЖ ГАРГАЖ БҮЙ ХУВЬЦААНД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

“Бумбат Алтай ҮЦК ХХК” (цаашид “**Андеррайтер**” гэх) нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 4 сарын 26-ны өдөр олгосон “Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд “ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК (цаашид “**Үнэт цаас гаргагч**” гэх)-тай 2017 оны 11 сарын 01-ний өдрийн 01 тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “**Андеррайтерийн гэрээ**” гэх)-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцааг нэг бүрийг 850 төгрөгөөс доошгүй үнээр нийтэд санал болгон нийтдээ 3,744,760,000 (гурван тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая долоон зуун жаран мянган) төгрөгөөс доошгүй хэмжээний санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр **андеррайтераар** ажиллаж байгаа билээ.



Үнэт цаас гаргагч нь энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгийг газар тариалан болон гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авах, эргэлтийн хөрөнгийн зориулалтаар буюу зээлийн эх үүсвэрийг бууруулах, улаан буудай худалдан авахад зарцуулна.


Андеррайтер нь энэхүү Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй хувьцааг арилжаалах үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дугаар сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэж байгаа болно.

Андеррайтерын үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа шинжилгээнүүдээс бид дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

Компанийн бизнес, үйл ажиллагааны талаар

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 1943 онд Хөвсгөл аймгийн Тариалангийн САА-н суурин дээр үүсгэн байгуулагдсан байна. Тус САА-г 1994 онд өмч хувьчлалын Комиссын шийдвэрээр төрийн өмч давамгайлсан Хөвсгөл алтан дуулга хувьцаат компаниар зохион байгуулагдсан байна. Тус компанийн төрийн өмчийн 70.7 хувийг төрийн өмчийн






хорооны дуудлага худалдаагаар 1998 онд “Тэс трейд” ХХК худалдан авч, улмаар Хөвсгөл аймагтаа газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх эхлэлийг тавьсан байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь үр тариа тариалалт, гурил үйлдвэрлэл, тэжээл үйлдвэрлэл, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2011-2015 онд нийт 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь техник тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагааг ханган үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. 2012 онд 4000 тн үр тариа хадгалах хатаалгатай иж бүрэн механикжсан байгууламж, хоногт 100тн буудай тээрэмдэх хүчин чадалтай гурилын үйлдвэрийн барьж ашиглалтанд оруулсан байна.


Газар тариалан хувьд: “Хөвсгөл алтан дуулга” ХК нь нийт 7045 га талбайтайгаас 3000-4000 га-д улаан буудай, 50-500 га-д овъёос, тосны ургамал, арвай тариалдаг ба улаан буудай нь голлох тариалалтыг эзэлдэг бөгөөд жилд га-гаас 12 центнэр ургац авдаг байна.

Гурил, тэжээлийн үйлдвэрийн хувьд: 2000 онд хоногт 26 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай гурилын үйлдвэр байгуулсан бөгөөд 2011-2012 онд 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж, гурилын үйлдвэрийг шинэчилж өдөртөө 100 тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай болсон байна. Компани 2013-2017 онд нийт 19.7 мянган тонн буудайг тээрэмдэж үйл ажиллагаандаа ашигласны 87.8%-ийг өөрийн тариалсан буудайнаас, үлдэх 12.2%-ийг бусад тариалан эрхлэгчдээс худалдан авч гурил үйлдвэрлэдэг бөгөөд үйлдвэр 100% хүчин чадлаараа ажиллахын тулд эргэлтийн хөрөнгийн нэмэгдүүлэх буюу улаан буудай нэмж худалдан авах шаардлагатай байдаг байна. Иймд компани нэмж хувьцаа гарган, татан төвлөрүүлсэн хөрөнгөөс гурилын үйлдвэрийн түүхий эд болох улаан буудай худалдан авахаар төлөвлөөд байна. Үйлдвэр нь одоогоор дээд гурил, 1-р гурил, 3-р гурил, хивэг, хүүхдийн будаа, арвайн гурил зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулж байна.

Бүтээгдэхүүний үйлдэвлэлийн хэмжээ болон борлуулалт.



Монгол улс даяар 2015 болон 2017 онд гантай байснаас компанийн өөрийн жураасан болон бүс нутгаас худалдан авсан улаан буудайн хэмжээ эрс багассан, үүнээс үлдэн үйлдвэрлэлийн хэмжээ буурсан байна.





Компани буудай хадгалах 6.5 мянган тонн-ын багтаамж бүхий агуулах, 700-800 тонн бэлэн бүтээгдэхүүн хадгалах агуулахтай байна. Мөн тус компани нь бүтээгдэхүүний чанарт анхаарч, үйлдвэрийн дэргэдэх лаборатороор түүхий эдийг хүлээн авахаас эхлэн үйлдвэрлэлийн шат бүрд бүтээгдэхүүнээс тогтмол дээж авч шинжилдэг байна.

Компанийн гол үйлдвэрлэл болох үр тариа, гурилын үйлдвэрээс гарах хагас боловсруулсан болон хаягдал бүтээгдэхүүнд түшиглэн байгальд хор нөлөөгүй, эдийн засгийн хэмнэлттэй орчин үеийн технологитой тэжээлийн үйлдвэрийг байгуулж, аймгийн болон хил залгаа аймгуудад малын тэжээл нийлүүлдэг байна.

Гурилын үйлдвэрийн үндсэн түүхий эд болох улаан буудайг 2 эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Өөрийн газар тариалангийн үйлдвэрлэл
- Бүс нутгийн тариалан эрхлэгчдээс худалдан авах

Компани жил бүр 2900-3000 га-д улаанбуудай тариалж, га-аас 12-16 центр ургац авахаар төлөвлөж, гурилын үйлдвэрийн түүхий эдийн 2018 оны хэрэгцээний 40%-ийг хангах бол 2022 оны хэрэгцээний 20.5%-ийг хангахаар тооцоолсон.



“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж хувьцаа гарган 3,7 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлж, улмаас гурилын үйлдвэрлэлийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Бүтээгдэхүүн, тонн	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
	гүйцэтгэл			төсөөлөл				
Тээрэмдэх буудай, тн	4,653	4,066	2,293	8,000	10,800	13,800	17,300	18,050
1-р ба дээд гурил, тн	3,525	3,040	1,742	5,400	7,290	9,314	11,677	12,183
3-р гурил, 25 кг, тн	232	176	100	360	486	621	779	812
Хивэг, 25 кг, тн	866	849	449	1,440	1,944	2,484	3,114	3,249
Бүхэл үрийн гурил, тн				800	1,080	1,380	1,730	1,805

Үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдлын талаар

Улаан буудай тариалалт

Монгол Улс сүүлийн 5 жилийн дундажаар 350 орчим мянган га талбайд үр тариа тариалсан бөгөөд үүний 330 мянган га орчим талбайд улаан буудай тариалж, га-гаас дунджаар 10.8 орчим центнер буудай хураан авсан байна. Ургац сайн байсан 2008-2014 онд буудайн га-ийн ургац дунджаар 14.8 байсан ба 2015, 2017 онуудад улсын хэмжээнд ургац алдсан нь сүүлийн 5 жилийн га-ийн ургацын үзүүлэлт буурахад нөлөөлжээ. Буудай боловсрох үед газар тариалангийн бүс нутгуудаар хур тунадас бага орж ган болсон нь ургац алдахад хүргэсэн байна. Ургац алдсаны улмаас 2018 оны дотоодын буудайн хэрэгцээний 50 орчим хувийг импортоор хангахад хүрсэн.





	Үр тариа тариалалт	2013	2014	2015	2016	2017*	Дундаж
1	Нийт тариалсан талбай, мян.га	293.3	315.0	390.7	377.8	390.9	353.5
2	Нийт хураасан ургац, мян.тн	387.0	518.8	216.3	483.5	238.1	368.7
3	Үүнд: Улаанбуудай тариалсан талбай, мян.га	275.6	291.2	361.2	355.1	365.7	329.8
4	Улаанбуудайн нийт ургац, мян.тн	368.5	488.3	203.9	467.1	231.4	351.8
6	Нийт импортолсон улаанбуудай, мян.тн	0.1	34.2	21.1	158.5	13.6	

Гурил үйлдвэрлэл


Монгол Улсын гурилын жилийн нийт хэрэглээ 270.9 мянган тонн бөгөөд үүний 43 хувийг Улаанбаатар хотын зах зээл, 57 хувийг орон нутгийн зах зээл эзэлдэг байна. Улсын хэмжээнд жилийн нийт хэрэгцээт гурилын 60%-80%-ийг дотоодын үйлдвэрлэлээс, 20%-40%-ийг импортоор хангадаг. МУ-ын импортын нийт гурилын 90% орчмыг Оросын холбооны улсаас авдаг байна. Улсын хэмжээнд нийт үйлдвэрлэж буй гурилын 60-70%-ийг нэгдүгээр гурил, 20-30 хувийг дээд гурил, 10 орчим хувийг хоёрдугаар гурил эзэлж байна. Нийт 70 орчим компани гурил үйлдвэрлэж буй гэдэг мэдээлэл байгаа бөгөөд суурилагдсан хүчин чадал болон үйлдвэрлэлээр Алтантариа, Улаанбаатар, Од, Милл Хаус, Өег, Өгөөж, Дорнод гурил, Нүүдэлчин групп, Хөвсгөл Алтан Дуулга, Гацуурт зэрэг компанийн үйлдвэрүүд (хоногт 100-300 тн) тэргүүлдэг. Гурилын үйлдвэрүүд нь нийтдээ жилд 1700 орчим мянган тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд хангайн бүсийн гурилын үйлдвэрүүдийн жилийн нийт хүчин чадал 80 мянган тонн юм. Хөвсгөл аймагт 2017 оны байдлаар 3-4 гурилын үйлдвэр байгаагаас Хөвсгөл Алтан Дуулга ХК-ийн үйлдвэр хамгийн өндөр хүчин чадалтай бөгөөд тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Хүн амын хэрэгцээ	253.8	258.7	263.3	267.4	270.9
Дотоодын үйлдвэрлэл	246.5	228.3	206.5	209.7	208.5
Гурилын импорт	23.90	17.50	20.51	30.00	-

Эх сурвалж : Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

2017 онд гурилын үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 1% буурсан бол борлуулалтын орлого өмнөх оноос 21% өссөн байна. Хүн амын гурилын хэрэгцээ нь хүн амын өсөлттэй уялдан жил тутам 1.6% орчим өсдөг байна.





Компанийн хувьцаа талаар

Хөвсгөл аймгийн Тариалан САА-г 1994 онд хувьчилж, төрийн өмч давамгайлсан алтан дуулга хувьцаат компани байгуулагдсан ба 1998 онд компанийн төрийн мэдлийн 70.7 хувийг “Тэс трейд” ХХК хувьчилж авснаар компани 100% хувийн өмчит компани болсон байна. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн гурван удаа хувьцааны тоо, ширхэгт өөрчлөлт оруулаад байна. Үүнд:

- 1994 оны өмч хувьчлалын комиссын хүрээнд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 128,253 ширхэг энгийн хувьцаатайгаар хувьцаат компани байгуулагдсан.
- Үнэт цаасны хорооны 2000 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот тогтоолоор үнэт цаасны бүртгэл өөрчлөлт оруулж “Хөвсгөл алтан дуулга” ХК нь нийт 113,286 ширхэг энгийн хувьцаатай болсон.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 170 тоот тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэгж хувьцааг 100 хуваахыг зөвшөөрч, “Хөвсгөл алтан дуулга” ХК нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,328,600 ширхэг хувьцаатай болж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлтийг оруулсан.

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр болох 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 171 хувьцаа эзэмшигчтэй байна. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч дараах этгээдүүд байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистр	Хувьцааны тоо, хувь эзэмшил	Үйл ажиллагааны чиглэл	Оршин байгаа хаяг
М.Золзаяа	РЭ90012503	886,100 ширхэг 7.82%		УБ, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 6 хэсэг, хатан туул в байр 3 тоот
“Тэс трейд” ХХК	2034948	7,997,200 ширхэг 70.59%	Гадаад худалдаа, хүнсний бөөний худалдаа, талх нарийн боовны үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх, гурилын үйлдвэрлэл,	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж 24-33





Үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компани 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, дараах хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

Зориулалт	Хэрэгцээ, сая төг	Тайлбар
Газар тариалангийн тоног төхөөрөмж авах	538.0	Өөрөө явагч бодис цацагчийн үлдэгдэл төлбөр 70% - 420.4 сая Чулуу түүгчийн үлдэгдэл төлбөр 70% - 117.6 сая
Гурил тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг	40.0	Гурил савлах төхөөрөмж болон дагалдах бусад сэлбэг – 40 сая
Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх	3,167	Зээл төлөх – 950 сая Буудай худалдан авах – 2,217 сая
Нийт	3,745	

Үнэт цаас гаргагч нь II ангилалын шалгуур, шаардлага хангаж буй эсэх талаар

Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “ҮЦБЖ” гэх)-ын 10 дугаар зүйлийн 2-т “Шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх, нэгдэж, нийлэх ба хуваах, тусгаарлах замаар үнэт цаас болон компани бүртгүүлэхэд энэ бүлэгт заасан тухайн ангиллын шалгуурыг хангасан байна” гэж заасан байдаг.




МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 5-д заасны дагуу үнэт цаас гаргагч нь ангилал тус бүрт тогтоосон шалгуураас гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.1 Үнэт цаас гаргагч, түүний хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хяналтын багцыг эзэмшигч нь Монгол Улсын хуулийн этгээд “Тэс трейд” ХХК /Улсын бүртгэлийн дугаар: 9011688108, регистрийн дугаар: 2034948/ байна. Тэс трейд ХХК нь татварын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлын өр төлбөртэй эсэх мэдээлэл:

№	Нэр	Регистрийн дугаар	Албан тушаал	Шүүхийн гүйцэтгэх тодорхойлолт	шийдвэр газрын шийдвэр
1	Н.Ерөөгэрэл	ЧЕ74092708	ТУЗ-ийн гишүүн, дарга	Шүүхийн иргэн, ТУЗ-ийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд ХК






2	Д.Дуламсүрэн	РП71012506	ТУЗ-ийн гишүүн, захирал	ердийн Гүйцэтгэх	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
3	Д.Ганхуяг	РП78111012	ТУЗ-ийн гишүүн,	ердийн	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
4	М.Зулзаяа	ЧЕ84122805	ТУЗ-ийн гишүүн	ердийн	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
5	Т.Мөнхгэрэл	РЮ66082503	ТУЗ-ийн гишүүн	ердийн	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
6	О.Тунгалаг	ЧТ58031508	ТУЗ-ийн ердийн гишүүн		Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
7	Л.Даваа	ЖИ65030116	ТУЗ-ийн гишүүн	хараат бус	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
8	З.Батсүх	ХП69061112	ТУЗ-ийн гишүүн	хараат бус	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд
9	Д.Энхтогтох	М362073107	ТУЗ-ийн гишүүн	хараат бус	Шүүхийн иргэн, хуулийн төлбөргүй байна.	шийдвэрээр этгээдэд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг үнэт цаасны танилцуулгын хавсарлтаас үзнэ үү.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь бүхэлдээ эсхүл дийлэнх хэсэг нь мөнгөн хөрөнгө болон богино хугацаат үнэт цааснаас бүрддэггүй байх.

Нийт хөрөнгө



2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллийн дагуу уг шалгуурыг хангаж байна. Санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгын хавсарлтаас үзнэ үү.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.3. Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахас өмнөх сүүлийн санхүүгийн жилийн үеэр санхүүгийн тайлагналын хугацаагаар бүртгүүлж байх.





“Хөвсгөл алтан дуулга” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1 -д зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.” мөн тус хуулийн 10.3-д “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.” гэж заасны дагуу санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь тайлагнадаг байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.4. Үнэт цаас гаргагчийн биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх санхүүгийн тайлангийн сүүлийн хугацаа нь 6 сараас ихгүй байх ба заасан хугацаанаас их байгаа тохиолдолд хамгийн сүүлийн улирлын тайланг аудитаар баталгаажуулах эсхүл уг тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх, 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “БДО Аудит” ХХК-аар аудит хийсэн бол 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “Од бүртгэл Аудит” ХХК нь аудит хийсэн байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрддөг байх


“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн компанийн засаглалын кодексын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Хөвсгөл алтан дуулга ХК-ийн сангийн хуримтлал, ногдол ашиг хуваарилах журам”, “Хөвсгөл алтан дуулга ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах журам”, “Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам”, “Хөвсгөл алтан дуулга ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам” зэргийг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.6. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь үнэнч шударга, ес зүйтэй байх

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн а-18-185 тоот албан бичгээр үнэт цаас гаргагчийн ТУЗ гишүүд болон гүйцэтгэх удирдлага үнэнч шударга, ёс зүйтэй ажиллах мэдэгдсэн байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.7. Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Ердийн гишүүд: Доржпүрэв овогтой ГАНХУЯГ	1985-1995 онд БГД-ийн 18-р сургууль, 2001-2005 онд Бизнесийн дээд сургуулийг	“Тэс трейд” ХХК-ийн захирлаар 2005 оноос хойш ажиллаж байна. Мөн МКМ, Хотол шим ХХК-уудын



СЭХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018.06.29 өдөр

	бизнесийн удирдлагын захирлаар 2012 он, 2015 онуудаас бакалавр зэрэгтэй төгссөн. тус тус ажиллаж байна. "Хөвсгөл 2016-2018 онд ШУТИС уул дуулга" ХК-ийн ТУЗ-ийн уурхайн менежментийн даргаар 2012 оноос 2018 оны 2 сар факультетыг уул уурхайн хүртэл ажиллаж байсан. магистр зэрэгтэй төгссөн.
Доржпүрэв овогтой Д.ДУЛАМСҮРЭН	1989 -1994 онуудад гадаад хэлний дээд сургууль багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. ХБНГУ-д зах зээлийн эдийн засгийн менежментийн 1 жилийн сургалтад 2003-2004 онд хамрагдсан, СЭЗДС-ийн мастериин хөтөлбөрийг 2003 онд дүүргэсэн.
Ноов овогтой ЕРӨӨГЭРЭЛ	1982-1992 онд Нийслэлийн 62-р сургуульд суралцан төгссөн. 1992-1998 онуудад МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжилтэй магистр зэрэгтэй төгссөн. 2010-2011 онуудад Австрали улс Маккуари их сургуулийг актуарч магистр зэрэгтэй төгссөн.
Очирхүрээ овогтой ТУНГАЛАГ	1966-1976 онд Нийслэлийн 10 жилийн 6-р сургууль, 1976-1977 онд ОХУ-ын Эрхүү хотын их сургуулийн хэлний бэлтгэл, 1977-1982 онд ОХУ-ын Воронеж хотын их сургуулийг хуульч мэргэжлээр тус тус төгссөн. Хууль зүйн ухааны магистр.
Мандшир овогтой ЗУЛЗАЯА	1999-2002 онуудад Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургууль, 2002-2006 онуудад Их засаг их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.
Төмөр овогтой МӨНХГЭРЭЛ	1974-1984 онд Хөвсгөл аймаг Мөрөн сум 10 жилийн 1-р сургууль, 1984-1989 онд ОХУ-ын Москва хот Ахуйн 2000-2005 оны хооронд Сангийн яаманд мэргэжилтэн, 2006-2012 онд БСШУЯ-нд мэргэжилтэн, 2012-2013 онуудад Хөвсгөл аймгийн газарын

1998 оноос хойш "Хөвсгөл алтан дуулга" ХК-д нярав, боловсон хүчин ажиллаж байсан. 2012 оноос тус компанийн гүйцэтгэхээр захирлаар ажиллаж байна.

1998-2001 оны хооронд Үндэсний статистикийн газар мэргэжилтэн, 2001-2003 онуудад Кредит Монгол ХХК –д төслийн зохицуулагч, 2003-2009 оны хооронд Ачид финанс ХХК-д гүйцэтгэх захирлаар, 2011-2017 онд М Си Эс холдинг ХХК-д эрсдлийн ахлах шинжээчээр, 2017 оны 10 сараас "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байна.

1982-1988 онд Баянзүрх дүүргийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд зохион байгуулагч, 1988-1992 онд УБ хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд референт, 1992-2005 онд Нийслэлийн ИТХ-ын ажлын албаны дарга, 2005-2014 онд УИХ-ын Тамгын газарт төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх, 2014 оноос Тунгаамал ТББ-ын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Монголын өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн нарийн бичгийн дарга 2006 оноос хойш 5 жил, Өмгөөллийн Сувдпартнерс ХХН гишүүн хуульчаар 6 жил ажилласан, Өмгөөллийн "И Эл Си" ХХН-д хуульчаар 2016 оноос хойш ажиллаж байна.

2000-2005 оны хооронд Сангийн яаманд мэргэжилтэн, 2006-2012 онд БСШУЯ-нд мэргэжилтэн, 2012-2013 онуудад Хөвсгөл аймгийн газарын

Төмөр овогтой
МӨНХГЭРЭЛ
2087103
ПЮНС330

ХӨВСГӨЛ
БСШУЯ
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТБ3216 ш. 2034565

СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018 он 06 сар 18 өдөр

үйлчилгээний технологийн хэлтэст даргын албан үүргийг түр дээд сургуулийг бүртгэлийн орлон гүйцэтгэгч, 2013-2017 онд эдийн засагч мэргэжлээр Сангийн яамны ахлах төгссөн. Эдийн засгийн мэргэжилтнээр, 2018 оноос ухааны магистр зэрэгтэй. хувиараа ажиллаж байгаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

Лхам овогтой ДАВАА 1972-1982 онд 10 жилийн 1-р сургууль, 1982-1987 ХААДС-ыг агрономич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 1998 онд ХААИС-ыг ХААУхааны магистр зэрэгтэй, 2000-2004 онд ХААИС МДС-ийг ХААУхааны докторын зэрэгтэй төгссөн. Дорнод талын бүсийн ХААЭШХ-д эрдэм шинжилгээний ажилтнаар 8 жил, ХААИС, Агроэкологийн сургуульд дэд профессороор 19 жил ажиллаж байна.

Заяат овогтой БАТСҮХ 1977-1987 онд Хөвсгөл аймгийн 10 жилийн 1-р сургууль, 1987-1992 онд ХААИС-ыг малын эмч мэргэжилтээр төгссөн. 1993-1996 онд ХААИС-ыг боловсролын доктор (Phd), 2009 онд шинжлэх ухааны доктор(ScD)-ын зэрэг хамгаалсан. 1992-2001 онд Мал эмнэлгийн хүрээлэнд ЭША, 2001-2006 онд Мал эмнэлгийн хүрээлэнгийн ЭНБДарга, 2006-2008 онд Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал, 2010-2013 онд ЗГХЭ, МЭҮ-ийн газрын дэд даргаар, 2013 оноос хойш Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн эхрлэгчээр ажиллаж байна.


Даваажав овогтой ЭНХТОГТОХ 1975-1985 онд Сэлэнгэ аймаг Зүүн хараагийн 10 жил, 1980-1982 онд СЭЗДС банкны нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр, 1985-1989 онд МУИС ЭЗФ -ыг статистикч, эдийн засагч мэргэжлээр төгссөн. Хөрөө Хөвч Хангай ХХК-д санхүүгийн ерөнхий зөвлөхөөр 4 жил, Хас банк ББГ-т бүтээгдэхүүн хариуцсан менежер, Төв салбарын захирал, УБ бүсийн менежерээр 7 жил, ХХБ -д СУГ-ын захирал, салбарын захирал, ахлах ня бо-г 11 жил, ҮСХ-нд макро эдийн засгийн газарт эдийн засагч 1 жил, Нэг болон хоёр шатлалт банкны системд эдийн засагч, ерөнхий нягтлан бодогчоор 5 жил тус тус ажилласан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Сэрээтэр овогтой ОЮУНГЭРЭЛ 1966-1976 онуудад Хөвсгөл аймаг Мөрөн сумын 10 жилийн сургуульд суралцан төгссөн. 1976-1977 онуудад ОХУ-ын Эрхүүгийн сургуулийн хэлний бэлтгэл, 1977-1982 онуудад ОХУ-ын Краснодар хот, Кубаний их сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн. 1982 оноос 1988 он хүртэл Хөвсгөл аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд дотоод ажил хариуцсан зохион байгуулагч, 1988-1992 онд УБ хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хуулийн хэлтэст болон төрийн байгуулалтын хэлтэст мэргэжилтэн, 1992-2013 онд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд зохион байгуулагч, ахлах зохион байгуулагчаар, 2013 оноос тэтгэвэрт гаргасан бөгөөд 2017

2087103
П.ЮН-330

ИГЭРЭЭНИЙ!
ГТБ3216 2034565



оноос “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.8. Компанийн удирдлага болон хяналтын багц эзэмшигчид бүртгэгдсэнээс хойш 6 -аас доошгүй сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх.

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн нийт гаргасан хувьцааны 70.59%-ийн хувьцаа эзэмшигч “Тэс трейд” ХХК 1998 онд төрийн өмчийн дуудлага худалдаагаар хувьчилж авсан. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааг худалдаж авснаас хойш хувьцаагаа худалдан борлуулаагүй байна.

МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 12 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангилалын шалгуур

Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.1. Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 1943 онд Хөвсгөл аймгийн тариалангийн сангийн аж ахуй (САА)-н суурин дээр үүсгэн байгуулагдсан байна. Тус САА нь өмч хувьчлалын хүрээнд 1994 онд төрийн өмч давамгайлсан Хөвсгөл алтан дуулга хувьцаат компани байгуулагдсан ба 1998 онд компанийн төрийн өмчид байсан 70.59 хувийг “Тэс трейд” ХХК хувьчилж авсан байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 1710001001,

Регистрийн дугаар: 2034565,

Үйл ажиллагааны чиглэл: үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэл, хүнсний ногоо тарилах, гадаад дотоод худалдаа, мал аж ахуй, хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.

Тус компани нь 1994 оноос хойш 24 жилийн туршид тасралтгүй үйл ажиллагааг эрхлэн явуулж ирсэн байна.



МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.2. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “БДО Аудит ХХК” нь аудит хийсэн байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “Од бүртгэл Аудит ХХК” нь аудит хийсэн байна.

Аудитын дүгнэлтээр:

2016 оны санхүүгийн тайланд аудит хийснээр “БДО Аудит” ХХК-ийн “Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон





мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

“Од бүртгэл-аудит” ХХК 2017 оны санхүүгийн тайланд “Бидний дүгнэлтээр, Компанийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна” гэсэн дүгнэлтийг гаргасан.

2015, 2016 болон 2017 оны аудитын тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.3.Компани бүртгэгдснээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капитал /эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн/-тай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 36,843 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 3,220,887 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 4,042,603 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна.


МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.4. Дотоод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь компанийн засаглалын кодексын дагуу дараах журмыг батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ТУ/12-03 тоот тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батласан байна.
- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн хурлын то-17-08 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Ногдол ашгийн бодлого”, 2 дугаар хавсралтаар “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, 3 дугаар хавсралтаар “Компанийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны журам”, 4 дүгээр хавсралтаар “Мэдээллийн үйл ажиллагааны журам”, 5- дугаар хавсралтаар “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг батласан байна.
- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 07 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам”, 2 дугаар хавсралтаар “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам”, 3 дугаар хавсралтаар “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам” -ыг батласан байна.
- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2012 оны 7 сарын 16-ны өдрийн ту/12-10 тоот тушаалаар батлагдсан “Хөвсгөл алтан дуулга” ХК-ны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамд 2018 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн ту/18-08 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаасны дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:





МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.1. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг гаргасан хувьцаатай бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор 4,405,600 ширхэг хувьцааг нэмж гарган, ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн то-18-18 тоот тогтоолоор нэмж гаргаж буй хувьцааг нэг бүрийг 850 төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулахаар шийдвэрлэсэн байна. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 4,405,600 ширхэг хувьцааг нэмж гаргасны дараа нийт 15,734,200 ширхэг энгийн хувьцаатай болно. Иймд тус компанийн зах зээлийн үнэлгээ нэмж хувьцаа гаргасны дараах байдлаар 13,374,070,000 төгрөг болохоор байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.2. Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах


“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нийт хувьцааны 28% буюу 4,405,600 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 3 тоот тогтоолоор компанийн нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг энгийн хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Нэмж хувьцаа гаргаснаар хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах өөрчлөлт орно. Үүнд:

Хувьцаа эзэмшигчдийн нэрс:	Хувьцааны тоо, ширхэг	Хувь	Нэмж хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо	Эзэмших хувь
5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч:				
М.Золзаяа	886,100	7.82%	886,100	5.63%
Нэгдмэл сонирхолтой этгээдүүд:				
“Тэс трейд” ХХК	7,997,200	70.59%	7,997,200	50.83%
Д.Дуламсүрэн	523,800	4.62%	523,800	3.33%
Бусад:				
Бусад хувьцаа эзэмшигч	1,921,500	16.96%	1,921,500	12.21%
Шинэ хувьцаа эзэмшигч			4,405,600	28%
Нийт	11,328,600		15,734,200	

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаандаа хэвээр хадгалах

“Хөвсгөл алтан дуулга” ХК –ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрийн байдлаар нийт 11,328,600 хувьцаа эзэмшигчтэй байв. Нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг энгийн хувьцааг одоогийн





хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлсэн тул 3,228,600 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох бөгөөд үлдэх 1,177,000 ширхэг хувьцааг МХБ-ээр дамжуулан нийтэд худалдан борлуулна. Иймд компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байна гэж үзэж байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.4. Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд альваа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцаа нь барьцаалагдаагүй, үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжиж, арилжаалагдах боломжтой.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.5.1-10.5.8 шаардлагууд, хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагчийн шалгуур 12.1.1, 12.1.2, 12.1.4 хангаж байна. Мөн үнэт цаасны шалгуурын 12.2.1- 12.2.4 тус тус хангаж байна.

Хувьцааны үнэ тогтоосон үндэслэл

Компанийн бизнесийн үнэлгээ



Компани 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон бизнесийн үнэлгээг “БДО Аудит” ХХК-иар хийлгэсэн. “БДО Аудит” ХХК орлогын хандлагаарх үнэлгээ буюу хорогдуулсан мөнгөн гүйлгээний загварын үр дүнг манай бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж үзсэн ба үнэлгээгээр компанийн бизнесийн өмчид хамаарах үнэ цэнэ нь 18,228,596 – 21,244,239 мянган тэрбум төгрөгт үнэлэгдсэн байна. Бизнесийн үнэлгээгээр нэгж хувьцаа 1159-1350 төгрөгийн үнэ цэнээр үнэлэгдэж байна.

Компанийн хөрөнгийн үнэлгээ

Компани 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон биет ба биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг “БДО Аудит” ХХК-иар хийлгэсэн. Энэ нь компани хувьчлагдсанаас хойш анх удаа хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж байгаа онцлог үйл ажиллагаа байв. Хөрөнгийн үнэлгээ нь компанийн үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, газар эзэмших эрх болон барааны тэмдгүүдийг хамарсан. Компанийн биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнэ 11,157,252 мянган төгрөгт үнэлэгдсэн. Энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаснаар компанийн хувьцаа эзэмшигчдийн өмчид хамаарах хөрөнгө буюу өөрийн хөрөнгө нь 10,448,530 мянган төгрөг болж байна. Ингэснээр компанийн нэгж хувьцааны дансны бүртгэлийн үнэ 922 төгрөгтэй байна.

Хувьцааны зах зээлийн үнэ

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай МХБ-ийн 3-р самбарт бүртгэлтэй, хувьцаа нь үнэлгээтэй арилжаалагддаг билээ. 2018 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн байдлаар компанийн






хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш хувьцаа хуваагдахаас өмнөх байдлаар 5017 төгрөг байна. Хувьцаа хуваагдахаас өмнө хамгийн сүүлийн арилжаа хийгдсэн өдөр буюу 2018 оны 5-р сарын 4-ний өдрийн хувьцааны ханш нь 9305 төгрөг байв. Компанийн хувьцаа хуваагдсан байдлаар тооцож үзэхэд хувьцааны зах зээлийн ханш нь 93.05 төгрөг болж байгаа нь хувьцааны бүртгэлийн үнээс 10 дахин доогуур байгаа ба энэ нь дараах шалтгаануудтай холбоотой гэж үзэж байна.

- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн энгийн хувьцаа МХБ-д анх бүртгэгдсэн үнэ 100 төгрөг байсан нь компанийн хувьцаат капиталын дүнг зөв илэрхийлээгүй байсныг хөндлөнгийн аудитын байгууллагууд тодорхойлсон. Энэ үнэ нь 1996 оны Төрийн өмчийн хорооны тооллогоор тогтоосон хувьцаат капиталын дүнг 9 дахин бууруулсан үнэ байсан ба энэхүү зөрүүг залруулах хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргаж 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдөр шийдвэрлүүлээд байна. Ингэснээр манай хувьцааны нэрлэсэн үнэ хувьцаа хуваагдахаас өмнөх 1000 төгрөг байсан ба хувьцааг 100 хувааснаар хувьцааны нэрлэсэн үнэ 10 төгрөг болсон.
- Компанийн хувьцааны 70.59%-ийг “Тэс трейд” ХХК-д 1998 онд төрийн өмчийн дуудлага худалдаагаар худалдан авч хувьцааны 70,59% төвлөрсөн бөгөөд бусад хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь хөдөө алслагдмал амьдардгаас хувьцааны арилжаанд идэвхтэй оролцдоггүй. Энэ нь МХБ-д анх бүртгэгдсэнээс хойших 24 жилийн хугацаанд дөнгөж 38 удаагийн арилжаа хийгдсэнээс харагдаж байгаа юм. Ийнхүү хувьцааны нийлүүлэлт бага, арилжаа идэвхгүй байгаагаас үүдэн хувьцааны зах зээлийн үнэ 2017 оныг хүртэл удаан өсөлттэй явж компанийн бизнесийн бодит өсөлтийг тусгаж чадахгүй байсан.
- Компани хувьчлагдсанаас хойш техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинэ гурилын үйлдвэр барих зэргээр үйл ажиллагаагаа тогтмол өргөжүүлж, хуримтлагдсан ашгаасаа өөртөө хөрөнгө оруулалт хийж ирсэн. Ингэснээр ногдол ашиг хуваарилах боломж бага байсан, түүнчлэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгээгүй олон жил болсон нь компанийн бизнесийн өсөлтийн талаарх зөв төсөөллийг олон нийтэд хүргэж чадаагүй байж болзошгүй. Энэ нь хувьцааны эрэлт талд сөргөөр нөлөөлсөн байх талтай.

Хувьцааны мэдээлэл:

Үнэт цаасны нэр:	Хөвсгөл алтан дуулга
Үнэт цаасны төрөл:	Энгийн
Үнэт цаасны үсгэн болон тоон код:	ADU/402
Нийт гаргасан хувьцааны тоо:	11,328,600
Хувьцааны нэрлэсэн үнэ:	10 төгрөг
52 долоо хоногийн доод, дээд ханш:	1005-9305 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
6 сарын жигнэсэн дундаж ханш (5/09/2018):	5017 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
Хувьцааны ханш (5/09/2018):	9305 төгрөг (Хувьцаа хуваахаас өмнө)
Зах зээлийн үнэлгээ (5/09/2018):	1,054,126,230 төгрөг





“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн МХБ дээр арилжаалагдаж буй хувьцааны арилжааны идэвхигүй, арилжаа явагдаггүйгээс үүдэн хувьцааны үнэ ханш компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлаас зөрүүтэй байна. Жишээ нь: МХБ дээр компанийн зах зээлийн үнэлгээ 1,054,126,230 төгрөг байгаа бол 2017 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлангаар компанийн нийт хөрөнгө 14,692,944,048 төгрөгтэй, үүнээс эргэлтийн хөрөнгө 3,220,887,172 төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 11,472,056,876 төгрөг байна. Компанийн эзний өмч буюу өөрийн хөрөнгө 10,448,530,056 төгрөг байна. Иймээс нэмж гаргаж буй хувьцааны үнийг тогтоохдоо ТУЗ компанийн тухай хуулийн 55.6 заасны дагуу хараат бус үнэлгээний байгууллагын дүнг үндэслэн тогтоосон байна.

Хувьцааны үнэ

Үнэ тогтоох үндэслэл	Нэгж хувьцааны үнэ	Бүртгэлийн үнэтэй харьцуулсан харьцаа
Компанийн бизнесийн үнэлгээ	1159-1350	125.7%-146.4%
Компанийн хөрөнгийн үнэлгээ	922	100%
Хувьцааны зах зээлийн үнэ /увьц	93.05	10.1%
Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ ба нэмж гаргах хувьцааны нийт хувьцаат капиталын дүнд эзлэх хувь	908	98.5%
Санал болгох доод үнэ	850	92.2%



Нэмж гаргаж буй хувьцааны санал болгох доод үнэ нь хувьцааны бүртгэлийн үнээс 7.8% доогуур буюу 7.8%-ийн хямдруулалттайгаар шинэ хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж буй хувьцааг 850 төгрөгийн худалдах үнээр санал болгохоор шийдвэрлэсэн байна. Энэ нэмж гаргах хувьцааны үнийн санал нь хувьцааны бүртгэлийн үнээс хэт доогуур байх нь компанийн сүүлийн 20 жилд бүтээж бий болгосон хөрөнгийн үнэ цэнэ, одоогийн хувьцаа эзэмшигчдийн 24 жил хүлээсэн өгөөжийн үнэ цэнийг бууруулж үнэлэх сөрөг талтай гэж ТУЗ-өөс үзэж компанийн нэмж гаргах нэгж хувьцааны худалдах доод үнийг 850 төгрөгөөр тогтоож, хөрөнгө оруулагчдад санал болгохоор ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн №то-18-18 тоот тогтоолоор шийдвэрлэсэн байна.

ДҮГНЭЛТ

“Бумбат Алтай ҮЦК” ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа, шинжилгээ, тооцоолол, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан “Од Бүртгэл Аудит” ХХК-н дүгнэлт, “БДО-Аудит” ХХК-н хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан болон өмгөөллийн “Эм ди эс энд Хаанлекс” ХХН-н гаргасан хууль зүйн дүгнэлтүүдэд үндэслэн “Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах бүрэн боломжтой гэж үзсэн болно.

Хувьцааны анхдагч зах зээлийн нэг бүрийн үнийг 850 төгрөгөөр, нийт 4,405,600 ширхэг хувьцааг олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг 3,744,760,000 байх боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Энэхүү дүгнэлтэнд ашигласан тооцоолол болон компанийн ирээдүйн төсвөлөл нь бодит биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд компанийн хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны үнэлгээнд нөлөөлж болох гаднаад дотоод эрсдэлийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.




СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
2018.06.29 өдөр

"Хөвсгөл Алтан Дуулга" ХК-ны менежментийн баг нь 1998 оноос хойш өнөөдрийг хүртэлх 20 жилийн хугацаанд 10 төгрөгийн нэрлэсэн үнэлгээтэй нэгж хувьцааг 922 төгрөгийн үнэ цэнэтэй болгон тасралтгүй өсгөн нэмэгдүүлж чадсан байна. Мөн түүнчлэн "Монголын хөрөнгийн бирж"-д бүртгэлтэй газар тариалан болон гурилын үйлдвэрлэл амжилттай хослуулан эрхэлж буй цорын ганц хувьцаат компани юм.

Бид үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээ, бизнесийн үнэлгээнээс хямдруулж олон нийтэд санал болгож байгаа учраас хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлөөр "Хөвсгөл Алтан Дуулга" ХК-н хувьцаа эзэмшигч болох боломжтой гэж үзлээ.


Дүгнэлтийг гаргасан:


Б.Амарбаясгалан
Хөрөнгө оруулалтын ахлах менежер


Ц.Наран-Учрал
Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал

Хянаж баталгаажуулсан:

Ш.Энхмэнд
Бүийцэтгэх Захирал



Ш.Батжаргал
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга




ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХК
/ГЭРЭЭНИЙ/
ТТБ3216 ш. 2034565

СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018.06.29 10

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2005.10.28

№ 000075664

1710001001

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

/ Улсын бүртгэлийн дугаар /

2034565

/ Регистрийн дугаар /

Хөвсгөл алтан дуулга

Хувьцаат компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Д Дуламсүрэн

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

001

1996.04.25

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

0111

Үр тариа болон бусад ургамал тариалалт

/ код /

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

1061

Үр тарианы гурил үйлдвэрлэл

0141

Үхэр, сарлаг өсгөх үйл ажиллагаа

0142

Адуу (адууны төрлийн бусад амьтан) өсгөх үйл ажиллагаа

0144

Хонь, ямаа өсгөх үйл ажиллагаа

1080

Малын тэжээлийн үйлдвэрлэл

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

230

102,225.17

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Хөвсгөл, Тариалан, 1-р баг, Мандал, ,, Утас1: 70386030, Утас2: 70386055, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

2018.06.25 өдөр Бүртгэлийн № 778
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
гойргийн нотариалт П.Н эрэлмаа би
эж хуулбарын үнэн дүрийг гэрчилнэ.
Үйлчилгээний хөлсөнд хэргийн хураав
Нотариатч

Хөвсгөл аймгийн улсын
бүртгэлийн хэлтэс

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2014 он 5 сар 19 өдөр

PKA00650 5296732

2018.06.29
2087103
ПЮМ-330

Хөвсгөл аймгийн
улсын бүртгэлийн
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216.ш.2034565

СЗХ
 2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
 2018.06.29 өдөр

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
ХААН банк	Төгрөгийн	5900013986	Ш.Пүрэвжав

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэл	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Доржпүрэв овогтой Дуламсүрэн-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2012.05.22	11517
2	Дахин гэрчилгээ олгов.	2014.05.19	Д.Насанбуян
3	Өөрийн хөрөнгийн хэмжээ 11060.83 м.тн.төг-р нэмэгдэж нийт 113286 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.05.08	Д.Насанбуян

ХААН
 138

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
 Бүртгэсэн ажилтан
 Д.Насанбуян

ХӨРӨНГИЙН БИРЖ
 2987103
 ПУОНС 330

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцаж, Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

ХӨВӨГӨЛ АЙМАГ
 ХӨВӨГӨЛ
 АСАН ДУУЦА
 ХК
 /ГЭРЭЭНИЙ/
 ТТБ3216 ш. 2034565



ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№2

Улаанбаатар хот

Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, Төлөөлөн удирдах зөвлөлд зарим бүрэн эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,3,8 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат компанийн дүрмийн 7.7.1, 7.7.3, 7.8.2, 7.8.8 дахь заалтыг удирдлага болгон 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөвсгөл алтан дуулга” ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргасугай.

2.“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа нэмж гаргах төслийг хавсралт 1-р баталсугай.

3.“Хөвсгөл алтан дуулга” ХК -ийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдож буй тул хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, нэмж гаргах хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

4.“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай харилцах ажлыг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

5.Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай болсон тохиолдолд дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 2019 онд боловсруулан, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Н.ЕРӨӨГЭРЭЛ





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК. Утас: 70386030. Факс: 70386031

Огноо 2018.06.16

№ 10-18-18



Компанийн нэмж гаргаж буй хувьцааны худалдах үнийг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 55.2, 55.6, 55.9, 76.1.6 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн дүрмийн 7.31.21 дэх заалт, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит хурлын 02 тоот тогтоолыг тус, тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй нэгж хувьцааны худалдах доод үнийг 850 төгрөгөөр тогтоосугай.

2. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцаанаас 1,177,000 ширхэг хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3-т заасны дагуу захиалгын бүртгэлийн аргаар байршуулан арилжихаар олон нийтэд санал болгон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-аар дамжуулан арилжааг зохион байгуулсугай.


3. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй 3,228,600 ширхэг хувьцааг 850 төгрөгийн тогтоосон үнээр, 6 сараас доошгүй хугацаанд худалдахгүй байх нөхцөлтэйгээр стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгон хуваарилалт хийж, арилжааг зохих журмын дагуу зохион байгуулахыг андеррайтерт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын 2 болон 3-т дурдсан арилжаагаар хамгийн багадаа 3,744,760,000 төгрөг, түүнээс дээш хэмжээний санхүүжилтыг татан төвлөрүүлэхийн төлөө дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллахыг Гүйцэтгэх удирдлага, андеррайтерын компанид мэдэгдсүгэй.

5. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийг хавсралтад заасны дагуу компанийн зээлийн эх үүсвэрийг бууруулах болон эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсугай.

6. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх, олон нийтэд санал болгон арилжаалах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-р заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.5, 8.10.11-р заалт, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3-р заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн шинээр үнэт цаас нэмж бүртгүүлэх хүсэлтийн дагуу хийгдсэн шалгалтын тайланг үндэслэн тус тус ТУШААХ НЬ:

1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,405,600 /дөрвөн сая дөрвөн зуун таван мянга зургаан зуу/ ширхэг хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгэж, нийт 15,734,200 /арван таван сая долоон зуун гучин дөрвөн мянга хоёр зуу/ ширхэг хувьцаатай болгон бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн үнэт цаасыг нэмж бүртгэсэн тухай тушаалын хувийг түүнд хавсаргах баримт материалын хамт Санхүүгийн Зохицуулах хороонд, холбогдох мэдэгдлийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүргүүлэх, тус компанитай “Бүртгэлийн гэрээ” байгуулахыг Хяналт, зохицуулалтын газар /А.Мөнхбаясгалан/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалаар бүртгэгдсэн компани, түүний үнэт цаасны талаар мэдээллийг холбогдох мэдээлийн санд бүртгэж, цахим хуудсанд оруулах ажлыг хийж гүйцэтгэхийг Үйл ажиллагааны газар /Д.Энхзул/-т үүрэг болгосугай.
4. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн шинээр нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хороо бүртгэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийг эхлүүлэх зөвшөөрөл олгосны дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах, тус компанийн үнэт цаасыг арилжихтай холбоотой мэдээлэл, үнэт цаасны танилцуулгыг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээн ажиллахыг Үйл ажиллагааны газар /Д.Энхзул/-т үүрэг болгосугай.
5. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компани /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар /А.Мөнхбаясгалан/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ





**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

**“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргах
энгийн хувьцааг бүртгэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргах нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,405,600 /дөрвөн сая дөрвөн зуун таван мянга зургаан зуу/ ширхэг хувьцааг бүртгэн тус компанийн нийт гаргасан хувьцааг 15,734,200 /арван таван сая долоон зуун гучин дөрвөн мянга хоёр зуу/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.



2. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 3,328,600 /гурван сая гурван зуун хорин найман мянга зургаан зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 850 /найман зуун тавь/ төгрөгөөр “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 1,177,000 /нэг сая нэг зуун далан долоон мянга/ ширхэг хувьцааг олон нийтэд захиалгын бүртгэл хийх аргаар анхдагч зах зээлд байршуулж, захиалгын доод үнийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 850 /найман зуун тавь/ төгрөгөөр тогтоохыг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Нэмж гаргаж буй хувьцааг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ болох 3,744,760,000 /гурван тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая долоон зуун жаран мянга/ төгрөгийг бүрэн татан төвлөрүүлсэн тохиолдолд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтосугай.

5. Хороо анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын 4-т заасан татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг хангах чиглэлээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжааг хангах ажиллагааг зохион байгуулах, арилжигдаагүй үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авахыг Бумбаат-Алтай ҮЦК ХХК /Ш.Энхмэнд/-д үүрэг болгосугай.



СЗХ
2018.06.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
№ 01
01

7. Энэ тогтоолын 6-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/-д хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдсүгэй.

8. Хороо анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзэх хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/, “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Одбүртгэл аудит” ХХК /Н.Мягмаржав/-д тус тус анхааруулсугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА
2018.06.29
Ш.Энхмэнд

С.ДАВААСҮРЭН

Хөвсгөл Аймаг
Хөвсгөл Аймаг
2087103
ПОН-330

ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ АЙМАГ ДУУЛИН
ХК
/ГЭРЭЭНИЙ/
ГТБ3216 2034565